

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, БААСН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-12
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	13-155
<hr/>	
<i>1. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	13-17
<i>2.Хуулийн төслийг эцэслэн батлах</i>	17-20
<i>3.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>	20-35
<i>4.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	36-155

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 18-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Т.Аубакир, Д.Батлут, Х.Булгантуяа, Ш.Бямбасүрэн, Л.Гантөмөр, Б.Дэлгэрсайхан, М.Мандхай, Ц.Мөнхбат, Ч.Номин, О.Номинчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, А.Ундраа, Ч.Ундрэм, Г.Хосбаяр, Ж.Чинбүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Ж.Энхбаяр, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Болормаа, А.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан, Д.Энхтүвшин;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Х.Баттулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-09 минут, О.Алтангэрэл-06 минут, Б.Батцэцэг-18 минут, Э.Батиугар-04 минут, Э.Болормаа-10 минут, Д.Ганбат-28 минут, Ц.Даваасүрэн-03 минут, Б.Заяабал-06 минут, С.Лүндэг-04 минут, Б.Мөнхсоёл-01 минут, П.Мөнхтулга-17 минут, З.Мэндсайхан-02 минут, Б.Найдалаа-05 минут, Н.Номтойбаяр-09 минут, С.Одонтуяа-09 минут, Ц.Сандаг-Очир-02 минут, М.Сарнай-01 минут, Г.Уянгахушиг-05 минут, Б.Хэрлэн-08 минут, Б.Чойжилсүрэн-01 минут.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын

Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Очирбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа, мөн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй зарчмын зөрүүтэй 1 дэх саналын томъёоллын санал хураалтын үеэр Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргасныг танилцуулж, горимын саналаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	51
Татгалзсан	31
Бүгд	82

62.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.2.2.Орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинээр болон шинэчлэх төслийг хэрэгжүүлэх /Төв, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот

түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 33
Бүгд: 84
60.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.3.7.Дархан-Уул аймагт малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах болон дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн цогцолбор байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Дэд бүтцийн бүтээн байгуулалт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Санхүүжилт”-д “100,000.0” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 35
Бүгд: 84
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.6.Хөдөө, аж ахуйн /газар тариалан/ гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, боловсруулалтын түвшинг ахиулах төслийг орон нутагт хэрэгжүүлэх /Төв, Дархан, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “9,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 35
Бүгд: 88
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.7.Дунд хоршооны хөгжлийг дэмжих газар тариалангийн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, хадгалах зорь байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “5,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 33
Бүгд: 90
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.4.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.4.1.3.Уул уурхайн хайгуул, ашиглалт, олборлолт, сонгон шалгаруулалтын програм, техник хангамжийг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “80” гэж, “Санхүүжилт”-д “15,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90

65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.2.21 .Мандал сумаас Түнхэл тосгон хүртэлх 35 км хатуу хучилттай замын төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “16,250.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 37
Бүгд: 91

59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “1.5.2.22.Улаан-Уул, Баянзүрх, Ринчинлхүмбэ, Цагааннуур сумдыг холбосон гүүрэн байгууламжийг шинэчлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 36
Бүгд: 94

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.17.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “121,600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн Байнгын хорооны дэмжээгүй санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 41
Бүгд: 95

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Даланзадгадад 50МВт-ын хүчин чадалтай дулааны станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн бэлтгэл ажлын явц” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “405,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 44

Бүгд: 95

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.2.1.11.Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэж, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Эрчим хүчний аудитын үнэлгээ хийлгэсэн, сургалтын байгууллагын тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-нд “10” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “500.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн дэд заалтын “Шалгуур үзүүлэлт”-д “Пассив барилгын шаардлагад нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй технологи бүхий сургууль, цэцэрлэгийн нэг маягийн барилгын зураг төсөв” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-нд “0” гэж, “Зорилтот түвшин”-д “5” гэж, “Санхүүжилт”-д “400.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боловсролын яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 80

Бүгд: 95

15.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.2.14 дэх дэд заалтын “хяналтыг боловсронгуй болгох” гэснийг “хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 69

Бүгд: 95

27.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан хуралдах тухай мэдэгдэж, чуулганы нэгдсэн хуралдаан 10 цаг 15 минутаас 12 цаг 16 минутад завсарлав.

Хоёр.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт А.Хонгорзул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/-ийг эцэслэн батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 29

Бүгд: 98

70.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн,

Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Очирбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа, мөн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Баярмаа, М.Нарантуяа-Нара, Д.Ганбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ч.Лодойсамбуу, С.Ганбаатар, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын дөрөв дэх чиглэл “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн хэсгийн 4.3.8 дахь заалтыг “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.” гэж өөрчлөн найруулж, мөн хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
 Татгалзсан: 36
 Бүгд: 98
 63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ /Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван чиглэлийн үндсэн чиглэл/-8.1.2, ЗГҮАХ /Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр/-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ /Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван чиглэлийн үндсэн чиглэл/-8.1.2, ЗГҮАХ /Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр/-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
 Татгалзсан: 34
 Бүгд: 98
 65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь дэд заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл, арга хэмжээ”-нд “1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34,927.9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
 Татгалзсан: 32
 Бүгд: 98
 67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “төсөл хэрэгжүүлэх хорооны тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Хорооны тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтод түвшин”-д “15” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж,

“Шалгуур үзүүлэлт”-д “Шинээр боловсруулах төлөвлөгөөний бичиг” гэж, “Хэмжих нэгж”-д “Төлөвлөгөөний тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтод түвшин”-д “5” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 27
Бүгд: 98
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 32
Бүгд: 98
67.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Авлигатай тэмцэх газрын дарга З.Баасаням, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Чулуунбат, Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын

захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Л.Мөнхцацрал, Ю.Энхтуяа, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Санхүү, төрийн сангийн газрын дарга Ж.Отгонбат, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Очирбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв./13:28/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан чуулганы нэгдсэн хуралдааны цагийг сунган хуралдах тухай мэдэгдэв./13:40/

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 15 цаг 23 минутаас 20 цаг 23 минутад хуралдааныг удирдав.

Илтгэл болон төрийн аудитын төв байгууллагын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Галбадрах, Н.Наранбаатар, Дам.Цогтбаатар, Г.Дамдинням, Б.Бат-Эрдэнэ, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн, Х.Ганхуяг, П.Батчимэг, Ц.Идэрбат, П.Ганзориг, С.Ганбаатар, Б.Уянга, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, А.Ариунзаяа, М.Энхцэцэг, Б.Пунсалмаа, Л.Энхнасан, Б.Бейсен, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Б.Жаргалан, Г.Очирбат, Р.Сэддорж, Г.Лувсанжамц, Ж.Золжаргал, С.Замира, Б.Мөнхсоёл, Ц.Сандаг-Очир, Б.Найдалаа, Г.Уянгахишиг, Б.Заяабал, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын

сайд Л.Энх-Амгалан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Д.Цогтбаатар, С.Цэнгүүн, П.Батчимэг, А.Ариунзаяа, Ө.Шижир, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, Б.Жаргалан, Б.Мөнхсоёл, Б.Найдалаа нар үг хэлэв.

Уг асуудлыг 20 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 30 минут үргэлжилж, 126 гишүүнээс 98 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 20 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ
2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 00 минут
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Нийт 66 гишүүн ирсэн ирц 52.4 хувьтай байна. Өнөөдрийн чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье. Өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Гуравдугаарт, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ. Ингээд хэлэлцэх асуудалдаа орбё.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Одоо” Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна.

Эдийн засгийн байнгын хорооноос дэмжээгүй зарчмын зөрүүтэй эхний саналын томьёоллоор хураасан санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг горимын санал гаргасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийн гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулна.

Горимын санал нь эхний санал хураалт төхөөрөмж саатсан учраас санал хураалтыг хүчингүй болгож өгөх горимын санал гаргасан байгаа. Санал хураалтыг явуулъя. Ганхүлэгийн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт.

62.2 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал үргэлжилж байна. Нэг дэх саналын санал хураалтын хүчингүйд тооцлоо. Тэгэхээр нэг дэх саналыг би дахиж уншиж танилцуулъя.

1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.2.2.Орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинээр болон шинэчлэх төслийг хэрэгжүүлэх /Төв, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”- д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх. . Санал гаргасан Их Хурлын гишүүн Туваан. Санал хураалт.

60.7 хувиар санал дэмжигдсэн.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.3.7.Дархан-Уул аймагт малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах болон дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн цогцолбор байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Дэд бүтцийн бүтээн байгуулалт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Санхүүжилт”-д “100,000.0” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Д.Батбаяр. Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.6.Хөдөө, аж ахуйн /газар тариалан/ гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, боловсруулалтын түвшинг ахиулах төслийг орон нутагт хэрэгжүүлэх /Төв, Дархан, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “9,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн. Санал хураалт.

Цуцлагдсан байна. Хонх дуугараагүй байна. Шууд явах уу?Санал хураалт цуцлагдсан. Дахин санал хураалт.

60.2 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж дарга давхар ярихгүй ээ.

4.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.7. , Ганбаатар, Дамдинням гуай дэг сахина шүү.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.7.Дунд хоршооны хөгжлийг дэмжих газар тариалангийн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, хадгалах зорь байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “5,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Туваан. Санал хураалт.

63.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.4.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.4.1.3.Уул уурхайн хайгуул, ашиглалт, олборлолт, сонгон шалгаруулалтын програм,

техник хангамжийг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “80” гэж, “Санхүүжилт”-д “15,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Туваан. Санал хураалт.

65.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.2.21 .Мандал сумаас Түнхэл тосгон хүртэлх 35 км хатуу хучилттай замын төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “16,250.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Туваан. Санал хураалт.

59.3 хувиар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “1.5.2.22.Улаан-Уул, Баянзүрх, Ринчинлхүмбэ, Цагааннуур сумдыг холбосон гүүрэн байгууламжийг шинэчлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ. Санал хураалт.

61.7 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.17.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “121,600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт.

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Даланзадгадад 50МВт-ын хүчин чадалтай дулааны станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн бэлтгэл ажлын явц” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “405,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Сэддорж. Санал хураалт.

53.7 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.2.1.11.Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэж, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Эрчим хүчний аудитын үнэлгээ хийлгэсэн,

сургалтын байгууллагын тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-нд “10” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “500.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн дэд заалтын “Шалгуур үзүүлэлт”-д “Пассив барилгын шаардлагад нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй технологи бүхий сургууль, цэцэрлэгийн нэг маягийн барилгын зураг төсөв” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-нд “0” гэж, “Зорилтот түвшин”-д “5” гэж, “Санхүүжилт”-д “400.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боловсролын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Лувсанжамц гишүүн үг авъя гэсэн. Үг өгье.

Г.Лувсанжамц: Өглөөний мэнд хүргэе. Энэ ажлын хэсэг дээр би өөрөө орж ажиллахдаа оруулаад дэмжигдсэн санал юм байгаа юм. Гэхдээ тэр өдөр нь эцсийн найруулгыг гүйцээж найруулъя гээд дахиж засаад найруулаад, уржигдар Эдийн засгийн байнгын хороон дээр орсон боловч гишүүдийн тоо нь хүрэхгүйгээр татгалзсан болоод уначихсан санал байгаа.

Дараагийн 11 нь бас адилхан. Тэгээд хийх гэж байгаа гол агуулга нь болохлоор сумын төвүүдийн сургуулиуд ялангуяа урсгал зардлынх нь 80 хувь нь нүүрсэнд зарж байгаа буюу халаалтын зардал болчхоод байгаа. Энийгээ багасгая. Үе шаттайгаар аймаг, сумын төвийн сургуулиудын эрчим хүчний үнэлгээг нь хийгээд, пассив барилгын шаардлага хангасан 2 цэцэрлэгийн барилга, 2 сургуулийн барилга, МСҮТ-ийн барилгын зураг төслийг хийе гэсэн тийм санал байгаа.

11 нь бас адилхан. Газрын төлөвлөлтийг боловсронгуй болгоно гэж байгаа боловч энэ ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гээд хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах ёстой зүйлийг гээчихсэн байсан болохлоор найруулгыг нь засаж оруулсан тийм саналууд байгаа болохлоор та бүхнээс татгалзаж өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

15.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.2.14 дэх дэд заалтын “хяналтыг боловсронгуй болгох” гэснийг “хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Лувсанжамц. Санал хураалт.

Санал 27.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Чуулганы хуралдаан түр завсарлаад, Байнгын хороон дарга цаг хэд вэ? 11.30? Байнгын хороо Сэддорж даргаа 12 цагт чуулганы хуралдаан үргэлжлэхэд амжих уу? 12 цаг хүртэл чуулганы хуралдаан түр завсарлалаа.

10.15 цаг

Баасан гараг, 18 Аравдугаар сар 2024
Төрийн ордон “Их хуралдай” танхим
12 цаг 16 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Өдрийн мэнд хүргэе.ингээд дараагийн асуудалд орно.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д долоо хоногийн баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хороо хуулийн төслийг эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байгаа.

Одоо төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулах ёстой. Чуулганы танхимд гишүүдийг орж ирэхийг урьж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн батлагдсанд тооцно гэж заасан байгаа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар даргыг дуудъя. Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимд орж ирье.

Санал хураалт явагдах гэж байна долоо хоног бүрийн Баасан гаргийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг эцэслэн баталдаг. Эцэслэн батлах нь өөрөө нийт гишүүдийн олонхоор шийдэгддэг учраас чуулганы танхимд орж ирж санал хураалтад оролцохыг дуудаж байна.

Цогтбаатар гишүүн Хууль зүйн байнгын хорооны даргаас гишүүд бас асуулт асууж байх шиг байна. Цагдаагийн албаны тухай хуулийг өмнөх хэлэлцүүлэг дээр зарим редакцын саналуудыг хэлсэн. Тэр саналууд тусгагдсан уу гэдэг асуултыг асууж байна. Эцэслэн батлахаас өмнө бас тодруулж асууж байна.

Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Тийм. Бид нар юу эхний хэлэлцүүлгээрээ баталъя гээд тухайн үедээ яг гишүүдтэйгээ ярьж байгаад тэр томъёоллыг анх оруулж ирснээ өөрчлөөд гишүүдийн саналыг тусгаад оруулсан байгаа. Тэр дээр гишүүд маань өшөө бүр ингээд нарийвчилж би түрүүний хурал дээр хэлж байсан. “Саатуулах” гэдгийг бүр илүү бараг Монгол хэлний

тайлбар шиг юм болгохгүй. Ингэхийнхээ оронд би тэгэхлээр бас гишүүдийгээ ойлгож байгаа тэр яриад байгаа юмыг.

Тэгэхлээр ерөөсөө энэ дээр ерөөсөө нэг л юм хэлж байгаа юм. Одоо энэ хуулийг хэрэглэхдээ бид нар хууль тогтоогчид энэ үг, өгүүлбэрийг ямар санаатайгаар оруулсан бэ гэдгээ хууль хэрэглэх гэж байгаа хүмүүст яг энэ микрофон дээр ингээд хэлж байгаа, цаашдаа ингэж хэрэглэх ёстой. Юу гэвэл хэрэв яг саатуулж байгаа яг тэр саатуулж байгаа мөчөөсөө цагаа тооцож эхэлнэ. Нөгөө Миранда хууль буюу тэр өөрийнх нь эрхтэйг сануулахыг тэр даруйгаа хэлэх ёстой.

Өөрөөр хэлбэл, яг саатуулаагүй байхдаа эс үгүй бол шууд хэлээд саатуулах ажиллагаа эхэлж болно. Зарим үед хэлэх боломжгүйгээр саатуулах үе гарч байгаа бол саатуулаад нэн даруй тэрийгээ залгаад хэлнэ. Энэ хоёрын аль нь түрүүлж болсноос саатуулах хугацаа тооцогдоно. л гэж байгаа юм. Тэгээд ийм ойлголтоор цаашаа хэрэглээд явах ёстой. Тэгээд ер нь үг, өгүүлбэрийг уг нь яг энэ ойлголцлоороо оруулсан байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Тэмүүжин гишүүн микрофон өгье, тодруулья.

Х.Тэмүүжин: Саатуулснаас хугацаа тоолно. Ингэж саатуулсан тохиолдолд 22-ын гээд өмнө нь танилцуулах ёстой мэдээллүүдийг танилцуулна гэсэн үг байгаа юм. Тэн дотор “нэн даруй” гэдэг үг нь орохгүй бол саатуулчхаад гаргахдаа танилцуулсныгаа “танилцуулсан” гэж хэлээд байх магадлал өндөр байхгүй юу.

Тийм учраас хуульд одоо хэрэглэгдэж байгаа “нэн даруй” гэдэг үгээ тэнд нь бичээрэй гэж чуулганы үед хэлсэн. Тийм, тэгж байж боломжит нөхцөл үүсэнгүүт танилцуулагдсан байх ёстой шүү. Тэгснээс биш 3 хоног саатуулж, зөөж явж байснаа яг тавиад гаргахдаа танд энийг танилцуулах ёстой шүү дээ гээд танилцуулаад, тэрийгээ биднүүс танилцуулаад байгаа шүү дээ, хууль дээр чинь нэн даруй гэдэг үг нь байхгүй шүү дээ гэдэг хэрэглээн дээр ийм маргаан гарах эрсдэл өндөр байгаа учраас “нэн даруй” гэдэг тэр үгээ танилцуулахынхаа урьд ингээд хэдүүлээ найруулгаараа хийе гэж эхний тэр хэлэлцүүлгийн үед яриад протокол дээр улам тэмдэглэгдсэн байх ёстой.

Д.Амарбаясгалан: Тайлбар хэлье. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Тэгээд яг энэ яриа гараад тэр үед би гишүүдэд энэ саналуудаа ингээд оруул аа гээд бид нар ярьж байгаад оруулсан байгаа. Тэгээд энэ дээр зүгээр “нэн даруй” гэдэг дээр асуудал бас гарсан юм. “Нэн даруй” гэдэг чинь өөрөө бас хуульд тайлбарлагдсан байгаа үг бөгөөд боломжит хугацаа гээд бас тодорхойгүй юм байж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ дээр бид нар одоо яг энийг хэрэглэхдээ энэ дээрээ, харин тийм энийг хэрэглэхдээ “нэн даруй” энийгээ өөрөөр хэлбэл, энэ хоёрын аль нь түрүүлж болсноос хэрэв түрүүлээд саатуулах юу гарч байгаа бол тэрийгээ нэн даруй танилцуулаад явна шүү.

Тэгэхгүй бол энд “нэн даруй” гэхлээр заавал саатуулж байж хэлэх болчих гээд байгаа байхгүй юу. Энэ үгийг чинь оруулахлаар. Тэгэхлээр саатуулахаасаа өмнө хэлчхээд саатуулах нөхцөл бүүр ихэнх тохиолдол гарах ёстой учраас энэ дээр нь энүүгээрээ бид нар тэр үедээ яг ярьж байгаад оруулсан. Хэрэв түрүүлж саатуулж байгаа бол нэн даруй

хэрэглэнэ шүү гэдэг одоо энэ үгийг яг эндээ хэлээд бид нар хэрэглээд тэгж явах ёстой. Тэр үедээ бид нар яриад гишүүд яг энүүгээрээ томьёолоод тэгээд л оруулж ирсэн.

Д.Амарбаясгалан: Тэгээд харин тийм. чуулган дээр ярьсан сүүлд. Хоёр, гурван гишүүн санал хэлсэн. Баасанжаргал гишүүн, Тэмүүжин гишүүн хэлж байсан. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье. Нэмэлт тайлбар.

Д.Цогтбаатар: Харин наад үг чинь энэ зөвхөн чуулганы үеэр биш тэндээ хамгийн их яриад тэгээд гишүүддээ та нар энийгээ томьёолоод оруулаад ирээч гээд тэндээ гишүүдтэйгээ хамт томьёолоод бид нар саналаа хурааж оруулж ирсэн. Тэгээд хамгийн гол нь энд ингээд “нэн даруй” гэдэг үгийг оруулчихлаар жинхэнээсээ юу болох гээд байгаа гэхлээр заавал эхэлж саатуулж байж, дараа нь нэн даруй чинь үүсэх гээд байхгүй юу.

Тэгсэн чинь энд “нэн даруй” байхгүй шууд танилцуулаад, саатуулах ажиллагаа эхлэх тохиолдлууд ихэнх тохиолдолтой байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Тамгын газрынхан бас энэ эцэслэн баталж гаргахдаа бас редакц дээрээ их сайн анхаараарай, протоколоо бас сайн шалгаарай гэдгийг бас хэлье.

Ингээд Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Үүний өмнө бүртгэлийн санал хураалтыг явуулъя. Бүртгэлийн бүртгэлийн санал хураалтыг явуулъя. Хэдэн гишүүн танхимд байна вэ бүртгээдэхье. Санал хураалт.

Санал хураалтад ороогүй гишүүн гараа өргөөлөх үү? Сэддорж Уянгахишиг, Бат-Эрдэнэ, Учрал 4 гишүүн, Мөнхсоёл, Батчимэг.

Дахиад нэг бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Гишүүд идэвхтэй санал хураалтад оролцъё. Хуулийг эцэслэн батлах гэж байгаа, хариуцлагатай байхыг хүсье. Санал хураалт.

Ирцэд бүртгэлтэй орж ирээгүй байгаа гишүүдийн нэрсийг дуудъя. Алдаржавхлан, Норовын Алтанхуяг, Очирбатын Амгаланбаатар, Анар Баасанжаргал, Хүрэлбаатарын Цэндийн Баатархүү, Батын Батбаатар Далайн Батбаяр, Нацагдоржийн Батсүмбэрэл, Батмөнхийн Батцэцэг, Баярмагнай Баярбаатар, Жудгийн Баярмаа, Сандагийн Бямбацогт, Гомбын Ганбаатар, Жамбалын Ганбаатар, Дашдондогийн Ганбат, Мөнгөнцогийн Ганхүлэг, Хассуурийн Ганхуяг. Энд ирц дээр гарахгүй байна шүү дээ. Тогмидын Доржханд, Батбаярын Жаргалан, Жаргалсайхан, Заяавал, Мөнхсайхан, Мөнхтулга, Наранбаатар, Одонтуяа, Пүрэвдорж, Сайнзориг, Сарнай, Түвшин, Тэмүүлэн, Уянга, Чойжилсүрэн, Энхтуяа, Эрдэнэболд гэсэн гишүүд санал хураалтад оръё.

Тэгээд санал хураалтад яагаад орж, бүртгэлийн санал хураалтад орохгүй байгаад байна? Үгүй тэгээд энэ дээр энэ дэлгэц дээр өгөөгүй гээд гарчихсан байна.

Тэгвэл ахиад бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад орж чадаагүй гишүүд гараа өргөө. Энхцэцэг гишүүн, Ганхуяг гишүүн, Ж Бат-Эрдэнэ гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн. Энэ залуу гишүүд яагаад хоцроод байна? Чуулганы хуралдаан 12 цагт үргэлжилнэ гээд зар явчхаад байхад ингэж хоцорч болохгүй. Санал хураалт явуулъя.

1.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

69 гишүүн буюу 70.4 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье. Дараагийн асуудалд орёе.

12.32 цаг

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай “Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 17-ны, 18-ны өдрүүдийн нэгдсэн чуулганы хуралдаанаар явуулж төслийг гурав дахь хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас санал хураалгахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн Байнгын хороонд шилжүүлсэн зарчим зөрүүтэй 2 санал болон нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч ажлын хэсгийн зүгээс шалгуур үзүүлэлт зорилгыг тодорхой болгох шаардлагатай гэж үзсэн зарчмын зөрүүтэй 2 саналын томьёоллыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.3-д заасныг баримтлан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Чуулганы нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал жигдлэх, хууль зүйн техникийн засваруудыг хийж, тогтоолын төслийн эцсийн эцсийн хуулбар болон зар зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёолоог хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Тогмидын Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрдэнэбилигийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Эрдэнэбүрэн гишүүн чинь өнөөдөр чөлөө авчихсан байгаа шүү дээ. Энд нэр нь явж байх юм.

Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Жамбын Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пушагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Бат-Очирын Болд Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Чулуунбуурын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Найдангийн Цэвэлмаа Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга,

Зоригсайханы Тулга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Жудгийн Баярмаа гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууна.

С.Бямбацогт: Бид нар ингээд 25 оны төлөвлөгөө үндсэндээ эцэслээд батлах гэж байна. Монгол төрийн бодлого тодорхой байх ёстой, тогтвортой байх ёстой, харилцан уялдаатай байх ёстой. Урьд нь бол тэгж явж чаддаггүй байсан. Ийм болгохын тулд 2019 онд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Монгол төрийн хөгжлийн бодлого урт хугацаандаа, урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байна. Салбар дундын уялдаатай байна, харилцан тогтвортой байх энэ заалтыг Үндсэн хуульд хийсэн. Үүний дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг 2020 онд баталсан.

Үүгээрээ бид нар урт хугацааны бодлого нь Алсын хараа-2050, дунд хугацааны бодлого нь хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд, 8 зорилтот хөтөлбөр, дээрээс нь 5 жилийн төлөвлөгөө дунд хугацааных, мөн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 4 жилээр, дээрээс нь жилийн төлөвлөгөө жилээр батлаад үүнийгээ хэрэгжүүлэх гэж жилийн төсөв баталдаг ийм хуультай болсон. Энэ хуулийн дагуу төлөвлөгөөг нь бол 6 дугаар сард багтаагаад бид нар баталсан байх ёстой. Төлөвлөгөө баталсандаа, төлөвлөгөө дээрээ үндэслээд төсөв маань батлагдах ёстой байсан. Энэ жил сонгуулийн жил, дээрээс нь төлөвлөгөө өнгөрсөн Их Хурал маань баталж чадаагүй учраас төсөв өргөн барьсны дараа өнөөдөр бид нар төлөвлөгөө батлах гэж байна. Тийм болохоор бас төсөв, төлөвлөгөө хоёр маань хоорондоо уялдах энэ асуудал дээр бас жаахан асуудал үүсэж магадгүй. Энэ дээр бас Улсын Их Хурал бас онцгой анхаарч ажиллах ёстой бид нар бас. Аль болох төлөвлөгөөндөө тусгасан асуудлуудыг төсөвлөж хэрэгжүүлэх ингэж явах ёстой.

Урьд нь төлөвлөгөөг тоодоггүй, зөвхөн төсвөө ярьдаг байсан бол төлөвлөгөө дээр тулгуурлаж төсөв батлагдаж байх ёстой. Төлөвлөж байж төсөвлөлт хийгдэх ёстой ийм болсон байгаа. Тэгээд энийгээ бас баримтлаад явчих юм сан. Тэгэхээр манай ажлын хэсэг маань нэлээн сайн ажилласан байх ёстой, найдаж байна.

Мөн үүнтэй уялдуулаад бас хэлэх зүйл бол 2024 оныг бид нар Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгож зарласан. Бүсүүдийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлнэ гэж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт суулгасан. Энэ асуудлыг бас Засгийн газраас өргөн барьсан, төлөвлөгөөнд тусгасан. Мөн бас өргөн барьсан төсөвтөө тодорхой хэмжээгээр тусгасан байгаа.

Гэхдээ миний хувьд харьцангуй юу гэдэг юм нэлээн тийм бөөрөнхийдүү туссан байгаа гэж харж байгаа. Тийм болохоор төлөвлөгөө болон төсвийг энэ батлахдаа бид нар ялангуяа төсөв батлахдаа энэ бүсчилсэн татвар, бүсийн ялгаатай татварын бодлого энийг бас онцгой анхаарчих юм сан. Өнөөдөр Улаанбаатар хотоос алслагдах тусмаа бараа, бүтээгдэхүүний үнэ өсдөг. Бензин өндөр үнэтэй, шатахуун өндөр үнэтэй, тог цахилгаан өндөр үнэтэй, гурил, будаа өндөр үнэтэй, хувцас хунар нь өндөр үнэтэй байдаг.

Нөгөө талдаа зардал нь ийм өндөр үнэтэй, орлого нь бага байдаг. Цалин багатай, малын гаралтай түүхий эд нь хямдхан, мах нь хямдхан, сүү нь хямдхан, ноос ноолуур нь

хямдхан, төмс, хүнсний ногоо нь хямдхан. Орлого багатай, зардал өндөртэй байгаад байдаг. Түүнээсээ болоод л Улаанбаатар хот руу төвлөрөөд байгаа юм. Улаанбаатар хотын төвлөрлийг түгжрэлийг сааруулахын тулд тэр өссөн, төрсөн нутагтаа алслагдсан бүс нутагтаа аятай тухтай амьдрах боломжийг л бий болгох ёстой. Үүн рүү чиглэсэн татварын бодлогыг бид нар энэ Их Хурал хийчих юм бол энэ бас маш том дэвшил болно. Маш том дэвшил. Зөвхөн татварыг хураах гэж биш тийм үү тэр нь өссөн, төрсөн алслагдсан тэр бүс нутагтаа аятай, тухтай амьдрах бололцоо, боломжийг бүрдүүлэхийн тулд Аж ахуйн нэгжийн албан татварыг миний хувьд 17 онд санаачлаад 1000-аас дээш алслагдсан бол 1 хувь болгосон, 500-аас 1000 бол 5 хувь болгосон байгаа.

Үүнтэй адилхан хүн амын орлогын албан татварыг бас 1000-аас дээш км-т алслагдсан бол 1 хувь, 500-аас мянгаас 5 хувь иймэрхүү байдлаар бас оруулчих юм сан. Яг өргөн барьсан төсөл дээр яг ингэж тодорхой ороогүй байгаа. Үүнийг бас Улсын Их Хурал төлөвлөгөө батлаад, төлөвлөгөөтэйгөө уялдуулж төсөв батлах үедээ бас анхааралдаа аваад энэ бүсчилсэн хөгжлийг дэмжих жил, дээрээс нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт суусан мөрийн хөтөлбөрийнхөө бас бүсийн ялгаатай татварын бодлогыг хэрэгжүүлэх энэ хүрээндээ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн асуулт асууна.

Ч.Лодойсамбуу: Энэ ээлжит бус чуулганаас авхуулаад л Их Хурлын даргаа хэлж байгаа даа. Энэ жоохон, Их Хурлыг жоохон хариуцлагатай байлгамаар байна. Хариуцлагыг нь сахиулж бас удирдмаар байна. Энэ 4, 5 дахь удаагийн асуудал болсон. Өчигдрийн санал хураалт юу болж байгаа юм? Их Хурлын гишүүд өөрсдийнхөөрөө санал өгч болох юм уу, болохгүй юм уу? Өчигдөр бид нар ингээд үндсэн асуудал нь 1 удаа унаад, араас нь горимын санал төхөөрөмжөөр шалтаглаад 2 удаа оруулаад, унагаагаад эцэст нь маргааш санал хураах гэж ингэж тарж байна шүү дээ. Та алх цохио биз дээ, цаг сунгаад? Өнөөдөр энэ асуудлаа хөгжлийн төлөвлөгөөгөө батлаад гаръя гээд алх цохисон. Энэ алх цохиж байгаа шийдвэрээ би баталгаажуулж байгаа хэрэг, тамгалж байгаа хэрэг гэж ойлгож байгаа. Алх цохичхоод араас нь ч тэр шийдвэрээ үгүйсгэдэг, маргааш үргэлжлүүлбэ гэдэг. Орж ирж байгаа асуудалд асуудал байгаа бол тэрийг Засгийн газрынхаа бодлогыг сөрж сайд нь тусдаа буруу санал гаргаж ирж байгаа бол тэрийг Засгийн газар нь дотроо ярь л даа. Тэрийг нь ярьдаг болго л доо. Энэ Их Хурал нь шийдвэрээ гаргая л даа. Одоо тэгээд ер нь татгалзсан санал өгч болох юм уу, болохгүй юм уу? Энэ дэлгэцэн дээр чинь сонголт байгаа. Тэр сонголтыг ашиглаж болох юм уу. болохгүй юм уу энэ парламентын гишүүн? Юм л бол энэ төхөөрөмжид буруу өгөөд л энэ бол 4, 5 дахь удаагаа давтагдаж байгаа. Парламентын төгөлдөршил, Парламент 2.0 сүртэй сүртэй гарчиг өгөөд л, нэр өгөөд л яваад байгаа. Эндээс л эхэлнэ шүү дээ. Тэгээд асуудал байгаа тэр буруу зарчимгүй юм явж байгаа бол тэрийг нь.

Д.Амарбаясгалан: Хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбоотой ярь. Дэг байна шүү.

Ч.Лодойсамбуу: Унагаагаад засдаг болгоё гэж байна шүү дээ. Хөгжлийн төлөвлөгөө ярьж байна. Хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой өчигдөр санал хураалт явсан. Тэрний тухай ярьж байна. Ингэж болохгүй шүү дээ.

Д.Амарбаясгалан: Дэг байна шүү. Дэгээ барина.

Ч.Лодойсамбуу: Хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой юм ярьж байна. Хөгжлийн төлөвлөгөө дээр зарчимгүй юм орж ирсэн бол тэрийг унагаах эрхийг нь парламентад нь үлдээ.

Д.Амарбаясгалан: Үндсэн асуудал руугаа ороё.

Ч.Лодойсамбуу: Тийм байна.

Д.Амарбаясгалан: Болсон уу? Санал хураалтад Улсын Их Хурлын гишүүн өөрийнхөө итгэл үнэмшлээр асуудалд хандана. Тэр ойлгомжтой. Санал хураалтын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын гишүүдийг хариуцлагатай оролц гэж байнга хэлж байгаа. Санал хураалтын дүн гарсны дараа төхөөрөмж ажилласангүй, саналаа өгч амжсангүй, горимын санал гаргаж байна, дахин санал хураалт явуулаач гэж санал гаргах эрх нь Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Энэнийх нь дагуу асуудалд хандаж санал хураалтыг зохион байгуулж байгаа юм. Нэг дэх зүйл.

Хоёр дахь зүйл Улсын Их Хурал, Улсын Их Хурлын бүтцийн байгууллага болох Байнгын хороо. Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа асуудлаар гаргасан ажлын хэсэг эдгээр бүгд бүх шатдаа саналаа хураагаад, асуудлаа шийдвэрлээд Их Хурал дээр орж ирдэг.

Сүүлийн үед мэдээж Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хорооны ажилласан, түүнээс гарсан ажлын хэсгийн гаргасан шийдвэрүүд, Байнгын хороон дээр өгсөн саналынхаа эсрэг Байнгын хорооны гишүүн ахиад өөр байр суурь илэрхийлж байгаа байдал зэрэг бол энэ улс төрийн намын бүлгийн дотоод асуудал, бүлэг хоорондын харилцааны асуудал шүү гэдгийг хариуцлагатайгаар хэлэх нь зүйтэй. Энэ үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын үйл ажиллагаатай хутгах, хутган ойлгох ямар ч шаардлагагүй гэдгийг бас Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хариуцлагатай ойлгоорой. “Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино” гэж үг байдаг. Өнөөдөр Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг Улсын Их Хурлын гишүүд бид өөрсдөө муухай харагдуулж байгаа юм. 126 гишүүнтэй байгуулагдсан парламентад ард иргэд итгэл хүлээлгэж байгаа. Яг энэ боломж, нөхцөлийг зөв дайчилж ашиглахын төлөө биш, харин хариуцлагагүй, Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг хойш нь татсан ийм байдлаар асуудалд хандах нь өөрөө Улсын Их Хурлын гишүүдийн байж болохгүй үг, үйлдэл шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Би өчигдөр асуусан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай энэ дээр 1.7.1.1 дээр эрчим хүчний өртгийг, цахилгааныг, дулааныг өсгөх, цахилгааны тарифыг 64 хувиар өсгөх, хэрэглэгчдэд дулааны үнийг 28 хувиар өсгөнө гэж байгаа юм. Энэ дээр ганцхан Чойжилсүрэн сайдын асуудал биш шүү дээ. Энэ парламентад байгаа бүх гишүүд, энэ эрх баригчид болон хамтарч байгаа бүх улсууд энэ дээр анхаарлаа хандуулаач. Энэ төрийн үндсэн зарчим бол аливаа шийдвэр төрийн шийдвэр гарахаасаа өмнө тухайн шийдвэрт өртөгдөх магадлалтай, эрх ашиг нь зөрчигдөх магадлалтай, даах уу, даахгүй юу гэдэг нь маргаантай байгаа тэр сегментүүдээсээ, тэр секторуудаасаа заавал консалт хийж асуугаад, зөвлөлдөөд ярьдаг энэ төрийн зарчим байна. Та нар энийгээ хийсэн үү? Нэгдүгээр асуулт.

Үндсэндээ иргэд өнөөдөр энэ дулааны, цахилгааны үнийг даах юм уу? Та нар төсөвт орж ирэхдээ 216 тэрбум төгрөг төрийн албан газруудын дулааныг нэмэхэд

оруулаад ирсэн байгаа. Цахилгаан дээр бас 26 тэрбум оруулаад ирсэн байгаа. Одоо яг ард иргэд, ЖДҮ-лэгч, аж үйлдвэрлэгчид энэ дээр элгээрээ хэвтэх магадлалтай. Энийгээ яг баталгаажуулсан юм уу? Тэдний орлого, ашгийг нь нэмэгдүүлэх боломжийг нь олгочоод энийг ярих ёстой. Ямар ч экспорт байхгүй. Тэр орчныг нь бүрдүүлээгүй. Бид ганцхан нүүрс зарж байгаа. Нэг орноос, ганцхан бүтээгдэхүүнээс 100 хувь хараат байгаа. Энэ орны тусгаар тогтносон ч аюултай болчихсон. Тэрийг ярихаа больё. Зүгээр бусад аж үйлдвэрлэгч нар, ЖДҮ-лэгч нар өнөөдөр энэ дээр боломжтой гэж үзэж байгаа юм уу? Энийг даах юм уу? Хамгийн гол нь би энийг эсэргүүцээгүй. Зүгээр даах юм уу? Үе шаттайгаар хийх боломж байгаагүй юу? Хамгийн гол нь эдийн засгийн, амьжиргааны энэ техникийн асуудлыг улс төржсөн маягаар харин та нар шийдээд байгаа байхгүй юу. Шууд хүчиндэж байгаа байхгүй юу. Шууд шийдвэр гаргаж байгаа юм. Хамгийн гол нь энэ шийдвэр чинь биелэх юм уу? Тэгээд ард иргэд яг тэр хугараагүй ноёны нуруу гэдэг шиг энэ дийлэх юм уу? 2 зүйл дээр цөхөрч байна шүү дээ. Мөнгө хүүлэлт нь будаа болж байгаа. Өнөөдөр мөнгө хүүлэгчдийн диваажин болчихсон Монгол орон. Өнөөдөр Монголбанкны хэдэн дарга нар нь мөнгө хүүлэгчдийн төлөөллийн байгууллага шиг ажиллаж байгаа. Энэ байдлыг ярихаа больё. Дээр нь нэмээд цахилгаан, дулаан гэдэг асуудлыг өнөөдөр ярьсан уу тэдэнтэй? 1.8 их наяд төгрөгийг дамжуулан зээлэлт гээд авчихсан. 93 оноос эхлээд авсан. Тэрний долларын ханшийн зөрүүг өнөөдөр ард иргэдийн нуруун дээр тавьж байгаа. Ханшаа бариагүй Монголбанк, Засгийн газар энэ дээр хариуцлага байхгүй юу? Ямар ч хамаагүй юу?

Хоёрт нь тендерийн, энэ эрчим хүчний тендерүүдийг ямар их будилаан гардаг билээ. Энэ асуудлаа шийдэхгүйгээр энэ зоолсон мөнгөнийхөө энэ дарамтыг шууд ард иргэдийн нуруун дээр, аж үйлдвэрлэгчдийн нуруун дээр, ЖДҮ-лэгчдийн нуруун дээр тавихад болж байгаа юм уу? Энэ цахилгаан дулаан чинь өслөө. Маргааш талх, тариа, будаа, боорцог, хуушуур бүгд өснө. Энийг дийлэх юм уу? Энэ дээр судалгаа хийсэн үү? Тэр холбогдох хүмүүстэй нь энэ яг энэ ачааллыг үүрэх нуруун дээр үүрэх хүмүүстэй зөвлөлдсөн үү? Тэднүүс окэй гээд хэлчихсэн юм уу. Би ийм 2 асуултдаа хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг Ганхуяг гишүүн хариулья. Нэмж салбарын сайд Чойжилсүрэн сайд хариулна.

Х.Ганхуяг: Ганбаатар гишүүнтэй яг санал нийлж байгаа. Бид нар бас яг энэ цахилгаан, дулааны үнэ нэмэхтэй холбоотой асуудлаар бол тэр хувийн хэвшилтэй зөвлөлдөх ёстой. Мөн тэр иргэдтэйгээ зөвлөлдөх ёстой гэвэл таны зөв. Мөн бага багаар нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй чинь бас санал нийлж байгаа. Тэгээд үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гадна бид нар бас төсөв хэлэлцэх ёстой. Төсөв дээр энэний татаасны асуудал, үнэ нэмэгдэж байгаа асуудал орсон байгаа тэгээд яг тэр үед нь.

Яг өнөөдрийн байдлаар эрчим хүчний систем өөрөө 47 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа. Алдагдлыг нь тэгэхдээ бид нар бас менежментийг сайжруулах замаар, мөн компаниудыг нь хооронд нь нийлүүлэх замаар бас шийдэх боломж бол бий гэж харж байгаа. Өнөөдөр Монголоос бусад бүх орон тэр гол түүхий эдтэйгээ цахилгаан үйлдвэрлэгч нь 1 компанийн бүтцээр ажилладаг. Манайх шиг ингэж тус тусдаа олон мянган хүмүүс ингээд тус тусад нь явуулж бүтцээр ажиллуулдаг ийм систем маш ховор.

Тийм ч учраас бас алдагдал байдаг байх, мөн хулгай ч их байдаг байх. Энэ тал дээр яг төсөв хэлэлцэж байх үе дээр бол Чойжилсүрэн сайдаас бид нар бас тайлбар авч, нарийн мэдээллийг нь авах ёстой. Бид нарын өнөөдрийн асуудал бол төлөвлөгөө хэлэлцэж байгаа

асуудал байгаа. Тэгэхээр төсөв дээр бас яг энэ асуудлыг илүү мэдээлэл авах нь зүйтэй гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар даргын асуултад хариулъя. Ганбаатар дарга уул нь та бид нар олон жил хамт Их Хуралд сууж байгаа. Уул нь хариуцлагатай хүн. Хэлсэн ярианаасаа буцдаггүй, бас бодит байдлыг гуйвуулж улс төр хийдэггүй гайгүй хүн гэж би таныг дүгнэлттэй явдаг. Харамсалтай нь энэ эрчим хүчний үнэ тариф сүүлийн 34 жилийн хугацаанд үе үеийн Засгийн газар л, үе үеийн эрх баригчид л, үе үеийн Эрчим хүчний зохицуулах хорооны гишүүд маань цаг тухайд нь нэмэгдүүлэхгүй явсаар байгаад таны хэлээд байгаа хүндрэлүүд үүсчихсэн.

1.8 их наяд төгрөгийн урт хугацаатай зээл байгаа нь үнэн. Яг өнөөдрийн байдлаар 539.6 тэрбум төгрөгийн богино хугацаатай өр төлбөртэй байгаа нь бас үнэн. 285 төгрөгөөр үйлдвэрлээд, дамжуулаад, түгээх хангах зардалд нь гарч байгаа юуг иргэдэд ид нар 130, 140 орчим төгрөгөөр борлуулж байгаа нь бас үнэн. Дулааны тухайд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Улаанбаатар хотын дулаан хангамжийн тухайд айл өрхүүдийн 1м2-ыг бид нар 506 төгрөгөөр борлуулж байгаа. 1 м2 сарын төлбөр. Яг өөрийнх нь өртөг бол 1300 орчим төгрөгтэй байна. Янз бүрийн шалтгаанууд бий. Зовлон яривал яриад байх юм бий. Гэхдээ яах юм? Ингээд ингээд юу цахилгаан эрчим хүчийг нь тодорхой нэмэгдүүлэхгүй бол одоо байгаа дулаанд холбогдсон айлуудад нь холбогдоод, нэмж байгаа гэр хороололд байгаа айлуудыг гэр хороололдоо бай, энэ салбар нэмж нэмэлт дулаанд холбохгүй, цахилгаан эрчим хүчинд холбохгүй, бусад улс ардын аж ахуйн салбаруудыг дэмжихгүй, боомилоод байгаад байна. гэдэг энэ шийдлийн өмнө л ирчихсэн байгаа юм.

Тийм учраас Эрчим хүчний зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд ойрын өдрүүдэд эрчим хүч, дулааны үнийг бол Улаанбаатар хотын дулаан улсын хэмжээнд эрчим хүчний үнийг нэмэгдүүлэх талаар Эрчим хүчний үндэсний хороонд танилцуулга хийнэ. Шаардлагатай тохиолдолд Засгийн газар, Улсын Их Хурал дахь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энэ дээр бас ажлын хэсэг, мөн салбарын сайд их зөв ойлголт мэдээлэл өгөх ёстой. Өнөөдөр бид аливаа асуудлыг ярихдаа зөвхөн өнөөдрөөр харж яриад болохгүй байна. Өнгөрсөн хугацаанд гарсан алдаа дутагдал, хүндрэл бэрхшээл юу юм. Энийг өнөөдөр бид яаж шийдэх юм, ирээдүйд энэ үнэ өртөг, тариф зах зээлийн зарчмаараа бас эргэж буурах нөхцөл боломж нь яаж үүсэх юм гэдгийг жоохон алсын хараатай ярих нь зүйтэй шүү. Зөвхөн өнөөдөр шийдэгдэж байгаа, өнөөдөр үнэ нэмээд зогсох гэж байгаа юм шиг ойлголт олон нийтэд бас өгч болохгүй. Цахилгаан хангамжийн хувьд, дулаан хангамжийн хувьд Монгол Улс бүх түвшиндээ дутагдалтай байгаа. Энэ дутагдлыг нөхөхийн тулд бидний алхам нэг дэх нь энэ байх юм. Ирээдүйд энэ дутагдал нөхөгдсөний дараах нөхцөл байдал ийм болох юм гэдгийг бодитой тайлбарлаж ярих нь зүйтэй.

Гэхдээ эдгээр асуудал шийдэгдэхдээ парламентын түвшинд улс төрийн намын бүлгүүд хоорондын зөвшилцлийн үндсэн дээр эцэслэн шийдэгдэх ёстой шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулга, тодруулж асууя.

С.Ганбаатар: Тийм энэ дээр Ганхуяг дарга. энэ дээр юу ороод ирсэн байна лээ шүү. Бүүр 9 дүгээр хуудсан дээр 64 хувиар цахилгаан нэмнэ, 28 хувиар дулаан нэмнэ гээд. Тэгээд улсын төсөв дээр төсөвт байгууллагуудын дулаан цахилгааныг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн төслийг нь оруулаад ирсэн байгаа. Энэ бол бүүр хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө ярьж байгаа ч гэсэндээ төсөвт ингээд мөнгөөрөө ороод ирсэн.

Хоёрдугаарт, яах вэ хариуцаж байгаа сайдтай ярихаас илүү би яг энэ дээр хурлын даргын хэлдэг шиг энэ дээр ингээд зөвшилцөл бий болох ёстой. Би ард иргэдийн зовлон бэрхшээлийг л төлөөлж ярих ёстой, үүрэгтэй хүн шүү дээ. Тэгэхлээр энэ дээр 1.8 их наяд төгрөгийн тэр дамжуулан зээлдэлтийн тэр ханшийн зөрүүг өнөөдөр ард түмний нуруун дээр шууд тавьж болох уу? Эндээс ихэнхийг нь 80 хувийг нь төрийн өмчийн компаниуд авсан байгаа. Тэднүүсийн менежментийн алдаануудыг өнөөдөр ард иргэдээр шууд тавьж болох уу гэдэг асуултыг яриад, энэ болгоныгоо цэгцэлж ярьж байж дараа нь үе шаттай ярина.

Хоёрдугаар хамгийн гол зүйл гэвэл ард иргэдийг бизнестэй, орлоготой болчихоод энэ тухай.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Надад редакцын саналууд байна. Өчигдөр би чуулганы дараа ажлын хэсэгт энэ саналуудаа хэлсэн. Гэхдээ өнөөдөр орж ирж байгаа материал дотор засагдаагүй байна.

Нэгдүгээрт, 25 оны энэ төлөвлөгөөний 1.4.3.2 Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын ил уурхайн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл шинэчлэл гэж байгаа юм. Тэгээд ил уурхайн баяжуулах үйлдвэр гэж байхгүй л дээ. Ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводтой холбоотой 5 төсөл тусгагдсан байна лээ.

Тийм учраас ил уурхайн баяжуулах үйлдвэр гэх юм бол энэ агуулгын хувьд маш том алдаа болчихно. Нэгдүгээрт, редакцын энэ саналыг засах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт санхүүжилтийг ер нь яаж тооцож тавиад байгаа юм бэ? Ард нь санхүүжилт гэсэн нэг хүснэгт байгаад байгаа юм. Зөвхөн энэ 25 оны зорилтот түвшнээ тавиад, 25 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тавиад байна уу, эсвэл төсөвт өрт өртгөөр нь тавиад байна уу? Төсөвт өртгөөр нь тавиад байгаа юм уу гээд харахаар хоорондоо зөрүүтэй. Тухайн 25 онд санхүүжих дүнгээр тавиад байгаа юм уу гэхээр төсөл, хөтөлбөрүүд нь хоорондоо бусад төслүүдийн хувьд нийцэхгүй ийм юм харагдаад байна.

Тухайлах юм бол, жишээ болгоод аваад хэлэхэд Эрдэнэт үйлдвэрт хэрэгжүүлэх гэж байгаа энэ 5 төсөл 1.4.3.2 дээр байгаа 5 төсөл бүгд ТЭЗҮ-ээсээ хүрэх үр дүн, зорилтот түвшин, үзүүлэлтүүд нь санхүүжилтийн дүнгүүд зөрүүтэй байгаа юм. Энэ 27-28 онд дуусах ажлууд байгаад байгаа байхгүй юу. Гэтэл 25 онд дуусна гээд оруулчихсан. Зарим нь санхүүжилтийн дүн байхгүй, зарим нь санхүүжилтийн тоо зөрөөтэй.

Гүйцэтгэлээр нь тооцоод байгаа юм уу гээд үзэнгүүт 1.5.2.9 дээр Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат гэдэг дээр Улиастай-Алтай чиглэлийн 40км авто замын хэрэгжилт зорилтот түвшин дээрээ 60 хувь гэнгүүтээ санхүүжилт нь 10 сая төгрөг гэж байгаа. Тэгэхээр энэ чинь ерөөсөө тийм үл ойлгогдсон ийм байдал үүсээд байна. Энэ санхүүжилтийг ер нь ямар байдлаар нь авч тооцоод байгаа юм бэ? Энэ

редакцынхаа асуудлыг засаж залруулж оруулахгүй бол бид нар ийм зүйл баталчих юм бол хоорондоо уялдаагүй нэгдүгээрт, хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд төлөвлөсөн хугацаандаа дуусах боломжгүй.

Хоёрдугаарт, төсөвт өртөг тавьж байгаа санхүүжилтийн дүн нь өөр хоорондоо зөрүүтэй, ТЭЗҮ-ээсээ зөрчихсөн ийм нөхцөл байдалтай зүйлийг баталчих гээд байна. Тэгээд өчигдөр бол Эдийн засгийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам энэ асуудлыг оруулж ирсэн. Тийм учраас Эдийн засгийн хөгжлийн яамны холбогдох хүмүүсийг тантай уулзуулаад нэг бүрчлэн бас ярья гэсэн. Би бас чуулган дээр яриад яах вэ гэж энийг өчигдөр ажлын хэсэгт хэлсэн. Эдийн засгийн хөгжлийн яам эндээс оруулж ирсэнгүй.

Ер нь энэ Эдийн засгийн хөгжлийн яаман дээр орж ирж байгаа тэндээс бэлтгэгдэж орж ирж байгаа энэ мэдээллүүд хоорондоо их зөрүүтэй байгаад, их зөрүүтэй байгаад байгаад байгааг цаашдаа бас ажлын хэс даг нэлээн сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна гэдэг саналыг бас давхар хэлье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль бол урт болон богино хугацааны ийм бодлогын баримт бичиг байгаа. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гээд 4 жилээр гарч байгаа. Энэ болохоор ингээд 1 жилийн Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр гээд гарч байгаа юм. Тэгээд энэ хавсралт 2 дээр нь энэ арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр, санхүүжилтийн дүн ингээд ороод яваад байгаа юм. Тэгэнгүүт төсөв маань бас байгаа, төсвийн төсөл маань. Тэгэхээр энэ энэ хавсралт 2, энэ төсөв 2 ер нь яаж уялддаг юм болоо?

Жишээлбэл, энэ арга зарим арга хэмжээнийх нь энэ санхүүжих эх үүсвэр энэ тэр энэ арынхаа хавсралт 2 дээр байхгүй. Тэгэхээр одоо яг яана гэсэн үг юм бол? Эсвэл энүүгээрээ ингээд зарим нь ороод батлагдчихаар нэгэнт энэ чинь хууль болоод тогтоолын төсөл батлагдчихаар заавал ч үгүй хэрэгжүүлнэ гэсэн үг юм уу? Нөгөө төсөв хэлэлцэх үед бид нар чинь бас хасах байх гэж бодоод, горьдоод, найдаад байгаа шүү дээ.

Жишээлбэл, нэг жишээ хэлье л дээ. Энэ эрүүл идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ гэнэ үү. Хүний хөгжлийн бодлого гээд. Тэгээд энэ өвлийн спортын ордны барилга барина гэх юм 12 тэрбум төгрөгөөр. Үгүй энэ чинь ийм спортын ордон барьж хүний эрүүл мэндийг хангадаг болчихсон юм уу. Өчигдөрхөн фэйсээр явж байна шүү дээ нэг эмэгтэй Хан-Уул дүүрэгт юун энэ ордон барьж эрүүлжүүлэх нь байтугай эмэгтэйчүүдийнхээ үзлэгийг хийх багаж нь байхгүй болчихсон байна шүү дээ. Хогийн уут тайраад бөгсөн доор нь тавьдаг гэж байна шүү дээ. Тэгж эрүүл мэндээ хангачхаад энд юун спортын ордон барьж эрүүл хүнийг хүн эрүүлжүүлнэ гэж бичээд байгаа юм бэ? Тэгээд бид нар энийг баталчих юм бол энэ төсөвт ороод явна гэсэн үг үү?

Нөгөө нэг айхтар хиймэл дагуул. Одоо энэ чинь одоо Тесла чинь гар утас гаргах гэж байна гэж байна шүү дээ. Хаанаас бүүр ерөөсөө аль өнцөг бүүр хаана бараг арай л далай дотор хамаагүй бариад ярьдаг гээд. Тэр утас гарч байхад энэ 7, 800 тэрбумын өртөгтэй энэ хиймэл дагуулыг энэ дотор ингээд ороод баталчихвал нэгэнт төлөвлөгөө батлагдсан учир хэрэгжүүлэх ёстой гээд ингээд заавал ч үгүй бас төсөвт суулгах гээд дайраад унах юм биш биз дээ? Энэ хиймэл дагуул яах вэ нэгэнт боломж олдсоных Анар гээд мэргэжлийн гишүүн маш тодорхой хэлсэн шүү дээ. Би ч гэсэн бас хувиараа ганц, хоёр хүмүүстэй уулзаж ярилцаж үзэхэд энэ ерөөсөө асар буруу гэж ингээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ийм юм гарч байна. Үндэсний аюулгүй байдал гэдэг нэрийн доор аливаа асуудлыг нууцалж байгаад хулгай хийдэг болсон. Нөгөө ногоон автобус.

Ногоон автобус чинь ямар балдуучных нь үндэсний аюулгүй байдал байсан юм бэ? Нэг ийм малгай дотор ингээд баахан янз бүрийн хулгай юм чихдэг ийм юм газар авч байгаа юм биш үү? Тэгээд энэ том төсөл чинь бүр ингээд бүр бүр аймаар болж байна шүү дээ. Одоо бүр 7, 800 тэрбумаараа үндэсний аюулгүй байдлын нэрийн дор нууцалж байгаад яах гэж байгааг нь би мэдэхгүй л дээ. Шууд хулгай гэж хэлэх нь хаашаа юм. Ийм юм руу явах гэж байна шүү дээ. Тэртээ тэргүй эсвэл тэр хил хамгаалах заставууддаа тэр Старлинк аваад өгчхөөч. Энэ чинь хамаагүй бага өртгөөр энэ холбогдох хүмүүсээ тэр шаардлагатай сүлжээгээр нь хангачихна шүү дээ. Энэ бол мэргэжлийн хүмүүс маш их ярьж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ ингээд одоо бид нар яаж ч чадахгүй ингээд батлангуут төсөвт ордог ёстой гээд ингээд суучих юм биш байгаа гэдэгт би маш их санаа зовж байна. Яг энэ хиймэл дагуул дээр энэ Африкийн орнууд бас дампуурсан юм байна лээ шүү дээ, фэйлдсэн/failed/. Нигери улс та нар судлаад үзээрэй. Бас Бангладеш бол яг энэ Францын энэ компаниар хийлгэсэн юм байна лээ. Бас л тэр ер нь судалсан юм болов уу яасан юм бол? Бас хугацаатай байдаг юм байна. 10 жил гээд. Тэгээд энэ 10 жил нь дуусахаар яах юм гээд. Тэгэхээр миний хайгаад байгаа юм энэ төлөвлөгөө ингээд батлагдчихдаг ,тэгээд хууль болчихсон юм. гээд төсөвт суулгах гээд бас дайрчих юм биш биз дээ гээд. Тэгсэн мөртөө яг энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулт өгье. Учрал сайд нэмээд хариулчихна биз.

Х.Ганхуяг: Хөгжлийн төлөвлөгөө туссан зүйл болгон төсөвт бас суух албагүй. Заавал ч үгүй төсвөөр хэрэгжүүлэх албагүй. Тэр нь бол Засгийн газрын, тухайн үед засгийн Засгийн газрын төлөвлөгөөнд батлагдсан зүйлсээсээ өөрснөө эрэмбэлээд оруулж ирдэг. Та саяын ярьсан төсөлтэй холбоотойгоор Учрал сайдаас мэдээлэл авах нь зөв байх. Тэрнээс биш сураг ажиг сонсох нь гэдгээр ямар нэгэн дүгнэлт хийх нь би өрөөсгөл болов уу гэж бодож байна. Тийм сураг ажиг сонссоноор гэдгээр төсвийг унагаах, төслийг унагаах нь өөрөө зохимжгүй байх. Бид нар бодитой үндэслэл дээр, судалгаан дээр үндэслэж шийдвэрүүдээ гаргаад явах нь зөв болов уу. Тэгээд дараагийн удаадаа судалгаатай юмнууд дээр илүү дөрөөлөх нь зөв байх.

Үндсэндээ бол энэ хөгжлийн төлөвлөгөөндөө 26 төсөл, арга хэмжээ ямар нэгэн эх үүсвэрүүд тавигдсан байгаа. 26 төсөл, арга хэмжээ. Нийтдээ 1.3 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ байгаа. Тэгээд эх үүсвэргүй болохоор тэр төсөв дээр ч байхгүй байгаа. Тэгэхээрээ бүгдээрээ төлөвлөгөөнд орсноор бүгдээрээ хэрэгжинэ гэсэн бас үг биш. Энийг Засгийн газар өөрөө эрэмбэлдэг.

Мөн түрүүн бас Үүрийнтуяа гишүүн ярьж байна лээ ингээд эцсийн хэлэлцүүлэг дээр ийм найруулгын алдаа байсан гээд. Энэ Байнгын хорооны хурал өнөөдөр 3 дахиа хуралдаж байна. Ажлын хэсэг 3 удаа хуралдсан. Яг тэр Байнгын хороогоор хэлэлцэх үеэр уг нь саналуудаа оруулж ирэх, эсвэл ажлын хэсэг дээр саналуудаа оруулж ирэх бүрэн боломжтой байсан гэж бас хэлэх нь зүйтэй. Тэгээд Учрал сайд нэмээд хариулчих уу? Хиймэл дагуулын асуудал дээр.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Энэ үндэсний хиймэл дагуулын төсөл бол, нэг зүгээр зүйлийг би хэлэх ёстой гэж бодож байна. Энэ 100 хувийн 15 жилийн хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсад Францын Засгийн газраас хамтарч хэрэгжүүлэх гэж байгаа төсөл юм. 100 хувь OECD өөрөө зээл авч байгаа тохиолдолд 15 хувийн баталгаа гарга гэдэг учраас төсвөөс 15 хувийг нь шийдэж байгаа юм. Тэрнээс биш бусад зардал нь 15 жил хөнгөлөлттэй зээл. 100 хувь шүү. Дээрээс нь энэ 2 орны найрамдал, хамтын ажиллагаа, цаашлаад энэ өөрөө их нарийн асуудал учраас ингэж бас хамаагүй ярьж болохгүй шүү. Италийн оролцоотой, төрийн өмчтэй, нээлттэй, дэлхийд 31 хиймэл дагуул бүтээсэн, гаднын орнуудад 6-хан орон л хиймэл дагуул бүтээдэг. Энэ орнуудын энэ Франц байхгүй юу. Тийм учраас энэ бол.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Учрал гишүүн нэмж хариулъя.

Н.Учрал: Тэгээд энэ 30 жилийн хугацаанд дэлхийн ямар ч оронд зээлээр үндэсний хиймэл дагуул бүтээж байсан тохиолдол байгаагүй. Энэ удаа Францын Засгийн газар ийм шийдвэр гаргасан. Гуравдагч хөршдөө хөрөнгө оруулалтыг татаж байгаа хамгийн том алхам.

Хоёрт энэ бол 2019 онд тоон системд шилжсэн. Үндэсний хиймэл дагуул гэдэг таны яриад байгаа Старлинкээс шал өөр. Энэ бол өндрийн хиймэл дагуул, үндэсний аюулгүй байдлын асуудал.

Старлинкийг бол харилцаа холбооны хуульд өөрчлөлт оруулаад тухайн үед би цахимын сайдаар ажиллаж байхдаа энийг оруулж ирсэн. Жилийн хугацаанд 1500 хүн л Старлинк хэрэглэж байгаа. Малчин бүрд боломж байхгүй тийм өндөр төлбөртэй.

Хоёрт бол энэ гаднын нам орбитод явж байгаа хиймэл дагуул шүү дээ. Тэгэхээр та бид 2 энэ мэргэжлийн юмыг нарийн ярихаас илүүтэйгээр энэ бол 100 хувийн зээл шүү. 15 хувь нь зөвхөн Ой Си Ди-гийн үүрэг л хүлээж байгаа. Дээрээс нь энэ ТЭЗҮ байгаа юм. Японы энэ ПАДЕКО-гийн ТЭЗҮ-гийн тооцоолол дээр 15 жилд 356.4 сая долларыг манай дотоодоос гаднын хиймэл дагуулуудад төлөх ийм тооцоололтой байгаа юм одоо. Энэ хиймэл дагуул бүтсэнээрээ энэ компаниуд дотоодынхоо хиймэл.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Үгүй яах вэ тэгээд бид нар чинь хаширчхаад байна шүү дээ. Үндэсний аюулгүй байдал нэрийн доор янз бүрийн хулгай хийсээр байгаад, гэрээгээ нууцлаад нэгд.

Хоёрт, яах вэ та бид 2 мэргэжлийн бус. Гэхдээ мэргэжлийн гишүүн Анар хэлээд байна шүү дээ. Маш тодорхой. Тэрийг чинь эрх биш бид нар мэргэжлийн бус ч гэсэн ойлгож байна шүү дээ. Асар өндөр өртөгтэй байна гээд. Тэгээд энэ чинь өөр хувилбарууд байгаагүй юм уу? Хятадаар хийлгэх ёстой юм уу байсан юм уу гээд л байх шиг байна лээ. Тэгээд ер нь судалгаанууд хийгдээд хэдэн энэ юу гэдэг юм бэ дээ яагаад сонгосон юм гэдэг юм уу, эсвэл цаана нь нууц байгаа юм уу, эс үгүй бол ямар учиртайг чинь бид нар мэддэггүй шүү дээ. Энэ чинь асар өндөр дүн шүү дээ. 800 тэрбум төгрөг гэдэг чинь. Тэгээд үгүй ээ бүгд санаж байгаа шүү дээ. Анар гишүүний хэлсэн юмыг бүгд санаж байгаа шүү дээ. Энэ чинь асар өндөр өртөгтэй байна л гээд байгаа шүү дээ. Одоо тэр үндэсний аюулгүй байдалдаа чухал юм байна гэж үзэхэд тэгэхээр энэний талтай тэнцэх хэмжээний мөн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя Учрал сайд.

Н.Учрал: Энэ ингээд байгаа юм. 15 жилд 356 сая доллар төлөхөөр байгаа юм. Гаднын хиймэл дагуулд. Одоо Korean sat шиг гаднын хиймэл дагуулд төлдөг. Хэрвээ дотооддоо энэ хиймэл дагуулыг төлөх юм бол энэ зардлыг 15 жилд нөхөх юм. Зүгээр зүгээр энэ бол зүгээр шууд орж ирэхээр нь шүү дээ. Нөхчих байхгүй юу. Нэг ёсондоо гадагшаа гарч байгаа валют дотооддоо үлдэнэ.

Тэгэхээр 2.5 өсөлтийн ийм динамик тоо байгаа юм. Энэ өсөлт нь. Бүр ингээд харах юм бол энэ тоо бүр өснө. Тийм учраас энэ бол нэг талаасаа шууд гадагшаа валютын урсгалыг зогсох, нөгөө талаасаа тэр яриад байгаа үндэсний аюулгүй байдлын асуудал.

Хоёрт, энэ бол гуравдагч хөршийн том бодлого явж байгаа юм мэдээж. Дээрээс нь нэг макро талаас нь бол бид нар бас харах ёстой гэдгийг бол та бас ойлгоорой гэж би хүсмээр байна. Тэгээд энэ бол гадаад харилцааны бас гаднын гуравдагч хөршийн бас бодлого шүү.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр өчигдөр гаргасан зарчмын шүүмжийг хүлээж аваад хуралдаа сууж байгаа сөрөг хүчний дарга нартаа баярлалаа. Харагдаж байх шиг байна.

Тэгэхээр 25 оны хөгжлийн төлөвлөгөөнд хүний эрүүл мэнд, амьдрах орчин, боловсрол гээд ийм хүний эрхийг дээдэлсэн нарийн юуг тусгаж өгсөнд их олзуурхаж байгаа. Энэ их зөв хөтөлбөр байгаа. Гэхдээ энэ дунд эрүүл мэндээр хангагдах, боловсролоор хангагдахад хамгийн том дайсан болдог аливаа бүхий л төрлийн хүчирхийллийн асуудлыг нарийвчлан тусгаж өгөөгүйд жаахан эмзэглэж байна.

Тэгээд хүчирхийллийн асуудлыг би бүр хайлаа. Яах вэ хүүхдийн хүчирхийллийг тусгасан байна. Тэр нь болохоороо зэрэг нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллана гэж тусгасан байгаа.

Гэтэл хүүхдийн хүчирхийллийн асуудал бол зөвхөн гэр бүлийн орчинд байгаад байгаа хүчирхийллийн асуудал биш, сургуулийн орчинд байна, үе тэнгийнхний дундах хүчирхийллийн асуудал байна, сэтгэл санааны хүчирхийлэл байна, цахим орчин дахь хүчирхийлэл байна, маш олон төрлийн хүчирхийлэл байгаа. Тэгээд манай Монгол Улс зөвхөн хүүхдийн хүчирхийлэлтэй улс юм уу гэхээр эмэгтэйчүүдийн хүчирхийлэл бас буцалж байдаг улс. Мөн түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл буцалж байдаг улс. Тэгээд энэ бол манай Монгол Улсын бас нэгэн маш том тулгамдсан, зайлшгүй нарийвчлан тусгаж өгөөд шийдвэрлэх ёстой асуудлын нэг байдаг.

Тэгэхээр энэ дээр нарийвчилж тусгаж өгөөгүй ингээд оруулсан байгаад би эмзэглэж байна. Тэгэхээр энэ жил бид нар аливаа төрлийн хүчирхийллээс яаж урьдчилан сэргийлж, болзошгүй эрсдэлээс хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийг аврах ийм төлөвлөгөө байгаа юм бэ? Энд хэн хариул лах вэ? Энийг яагаад бид нар ингээд тусгайлан салбар хоорондын уялдаа холбоотой ажил болгоод тусгаад оруулж болдоггүй юм бэ? Би уг нь Хүний эрхийн Комисс дээр очихдоо ядаж хүүхдийн орчин, сургуулийн орчин дахь хүчирхийллийн асуудлыг боловсролын салбар, нийгмийн яам, цагдаагийн байгууллага хамтраад зохион байгуулдаг Хүний эрхийн Комисс хамтраад зохион байгуулах ийм ажлыг

хийвэл яасан юм бэ гэсэн саналыг дэвшүүлсэн. Тийм. Тэгэхээр энэ дээр анхаар юу, хариулт авмаар байна.

Одоо бид нар хэн нэгэн хүүхэд, хэн нэгэн эмэгтэй хүчирхийллийн улмаас амь нас, эрүүл мэндийн асар том гарз хохирол учрахад гаслаад сууж байх уу? Тэрэнд ууланд тийм юм даатгасан гээд сууж байх уу, яах вэ? Энэ хүчирхийллээс яаж хамгаалах бодлого, төлөвлөгөө байна?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганхуяг гишүүн хариулъя. Нэмж Энх-Амгалан сайд.

Х.Ганхуяг: Энх-Амгалан сайд нэмээд хариулна биз. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүний эрхтэй холбоотой 28 зорилт, арга хэмжээ орсон байгаа.

Хүчирхийлэлтэй холбоотой асуудал ингээд деталь нь ороогүй байна гэдэгтэй асуудлыг л яриад байх шиг байна л даа. Ингээд бүх арга хэмжээг оруул л гэж та бодоод байх шиг байна. Төлөвлөгөө дээр онцлох арга хэмжээ нь л ордог. Ороогүй байна гэснээрээ тухайн тэр ажил хийгдэхгүй гэсэн үг биш. Тэр ажлууд нь үргэлжилдгээрээ үргэлжлээд л явна. Тэр хууль, эрх зүйн орчноор явдгаараа л явна. Зүгээр энэ дээр нэмэлт хийгдэх, тухайн жилдээ онцлох ажлуудаа л оруулж байгаа гэсэн үг. Энх-Амгалан сайд нэмээд хариулах уу?

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Нараа гишүүнээ энэ одоо бид нар чинь 25 оныхоо төлөвлөгөө, хөгжлийн төлөвлөгөөг баталж байгаа тиймээ? Хөгжлийн төлөвлөгөө. Тэгээд 25 онд бодлогын ямархуу арга хэмжээнүүд хийх вэ гэдгээ бол ингээд хөгжлийнхөө төлөвлөгөөгөөр баталчихна. Ингээд залгуулаад бид нар 25 оныхоо төсвийг бид нар хэлэлцээд эхэлнэ. 25 оны төсвийн бас онцлог илүү тэр хүчирхийлэлтэй тэмцэх онцлогтой төсөв гэх юм бол бид нар энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийг чинь баталчихсан шүү дээ Улсын Их Хурал баталсан. Одоо 9 сарын 1-нээс ингээд хэрэгжээд эхэлж байгаа. Ямар ч байсан энэ өмнө бол бид нар ийм хуульгүй байсан. Одоо бол бид нар Хүүхэд хамгааллын тухай хуультай болсон. Хүүхдийг яг гэр бүлийн орчинд, хүүхдийг сургуулийн орчинд урьдчилан сэргийлэх болон тодорхой эрсдэлд орсон тохиолдолд бол тэр эрсдэлээс аврах ийм үндэсний тогтолцоог бий болгох нь өнөөдөр энэ 25 оныхоо төсвөөр бид нар явах юм байгаа юм.

Тийм учраас сумд хүртэл бид нар чинь Хүүхэд, гэр бүл хариуцсан юутай болох гэж байна шүү дээ. Ийм зөвлөхийн тогтолцоонд Үндэсний зөвлөхийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ингээд бид нар чинь төлөвлөгөөгөө ингээд баталчих юм байна л даа 25 оныхоо. Батална л даа. Тэгээд тэгээд хөгжих л байлгүй дээ, айн? Гэхдээ бас хэд хэдэн юмыг бас жоохон тодруулъя хэдүүлээ. Бид нар ингээд агаар сансрын юм яриад байдаг. Тэгээд сансрын гүрэн болох юм болох юм шиг байна. Тэгээд болох л юм байгаа юм байлгүй.

Тэгээд зарчмын юм байна. Ийм маягийн төлөвлөгөөгөөр яваад үнэхээр улс орон хөгжих юм уу? Нөгөө л одоо яг социализм байгуулж байгаа юм шиг л юмаа яриад байна шүү дээ.

Тухайлбал, тэр 14 мега төслийг яах вэ ерөнхийд нь ярья л даа. 140 их наядын эх үүсвэр хэрэгтэй гэж байгаа юм. Эхлэх нь ч яах вэ эхлэх байх. Тэгээд мөнгө төгрөг идэж уугаад л ингээд л ёстой шамшигдаад л, тэгээд бид нар чинь авлигаараа хэдэд байгаа билээ? Ард түмний амьдрал ямар байгаа билээ? Тэгээд гоё гоё нэр өгч байна л даа. Богд уулын нүхэлнэ, ган татлагатай гүүр, энэ чинь юу билээ Зоригтой хөгжлийн Засгийн газар билүү? Нэг их зоригтой юм нь хаана байгаа юм? Нөгөө яг энэ асуудлыг хариуцах Ерөнхий сайд нь, 2 Шадар сайд нь хаана байгаа юм? Харагдахгүй л байна л даа. Тэгээд сонгууль явдаг, сонгуулийнх нь үр дүн нь ард түмний бодол, санал нь тусгагддаггүй энэ Улсын Их Хурал Засгийн газартаа. Тэгээд энэ юмыг чинь хянадаггүй. Энэ их мөнгө чинь 3 юм эргэж олддоггүй л дээ. Нэгдүгээрт, боломж, хоёрдугаарт цаг хугацаа, гуравдугаарт хэлсэн үг, амлалт. Энийг эргүүлж болдоггүй. Ийм юмаа бид нар алдаж байна. Энэ их мөнгө төгрөгөөсөө гадна.

Тэгээд яг дуустал санхүүжүүлээд дуустал хэрэгжүүлэх тийм боломж, бололцоо байгаа гэж үнэхээр бодоод байгаа юм уу? Энэ бүх юмнууд чинь дандаа л дампуурч байсан шүү дээ. Энэ хувийн хэвشلүүд маань хаана явах вэ? Орон зай нь жилээс жилд хумигдаж байна. Бид нар бараг тэр ганц намтай энэ коммунист засаглалтай улс орноос долоон дор болчихлоо шүү дээ. Амьдрал дээрээ ингээд үзэх юм бол. Нэр төдий нэг ардчилсан улс орон биш ийм болчихоод байна. Тэгэхээр энэ төлөвлөгөө чинь биелэгдээд тэгээд анхнаасаа яахаараа ч ийм Засгийн газар байдаг юм, энийг яахаараа ч анзаардаггүй юм. Эхлээд төлөвлөгөөгөө батлах ёстой байтал, дараа нь төсвөө ярих ёстой байтал төсөв нь эхлээд л орж ирнэ. Дараа нь төлөвлөгөө нь орж ирнэ.

Үгүй тэгээд ийм юмаа хүртэл хянаад хойно, өмнө нь оруулаад ингэж явж чадахгүй ийм хэдэн будилсан л хэдэн улсууд л энд суугаад байна л даа. Тэгээд энд агаар, сансрын юм яриад суугаад байдаг. Ард түмний амьдрал болохоор улны болчихоод байдаг. Тэгээд энэ ард түмнийг чинь харах шиг байлгах гээд байдаг. Харах яах вэ ингээд гарчихна. Энэ монголчууд чинь болохгүй шүү дээ энэ чинь. Хүмүүсийг ингэж амьдруулж, ийм байлгаж, бас жоохон сэтгэлтэй баймаар байна. Ийм их боломж, бололцооны хажуугаар ийм бүтэхгүй юм яриад, баахан цаг хугацаагаа алдаад гэсэн ийм бодолтой байна. Энэ дээр нөхдүүд ямар санал, бодолтой байгаа юм байгаа юм? Энэ Засгийн газар нь юу гэж бодож байгаа юм? Худлаа үнэн баахан гоё гоё нэр өгөөд яваад байдаг. Амьдрал дээр өмнө нь хийсэн юмнууд нь ч гэж байхгүй. Мухар төмөр замтай, өшөө авлига нь ингээд хачин болчихсон. 5 шувуу ажиллагаа нь ч юу болсон юм? Тэгээд юу билээ бас төгөлдөршил, өшөө шинэ юу билээ шинэ хөдөө, шинэ хот.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүний асуултад хариулах 2025 оны хөгжлийн төлөвлөгөө өргөн барьсан Тэргүүн Шадар сайд өнөөдөр байхгүй байгаа. Тэгэхээр агуулга, бодлогын асуудлыг чинь ажлын хэсэг хариулж чадах уу Ганхуяг гишүүн? Гантөмөр сайд гадаадад томилолттой ажиллаж байгаа. Яах уу? Ингээд санал хэллээ. Хэнээс тодруулах юм? Тодруулга асуулт Ганбат гишүүн.

Д.Ганбат: Бид нар асуудалд ингэж хандаж болохгүй. Энэ асуудлыг бид нар энд яриад, бас ард түмэндээ зөв ойлголт өгөөд, үнэхээрийн энэ төлөвлөгөө чинь хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу яриад, энэ эрчим хүчний эх үүсвэр яриу даа. Тэр хиймэл дагуул зүгээр л нэг хэсэг нь шүү дээ. Бусад юмыг нь ингээд ярих юм бол зөндөө л цаг хугацаа шаардаад үнэхээр засаж сайжруулмаар юм зөндөө байгаа байхгүй юу. Тэгээд манай охин намын дагуул намын 2 даргыг тэгээд арай ч дээ нэг Ардын намынхан сонин юм аа та нар. Баахан чадваргүй хүмүүсийг хажуудаа байлгадаг, өөрсдөө чадваргүй. Тийм л байдалтай байх юм. Тэгээд 2 цүнх баригч дагуулаад яваа юм шиг. Овоо охин намынхаа нэрээс гарах

гэж байсан чинь байхгүй одоо. Энэ сонгуулиар тэгээд байхгүй болчихлоо шүү дээ. Ийм бас Монголын ард түмний бас итгэж найдаж хүлээлгэж өгсөн Улсын Их Хурал маань, энэ Засгийн газар маань ийм байж болохгүй л дээ. Тэр асуултад

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Хөгжлийн төлөвлөгөөг бол Эдийн засгийн хөгжлийн сайд, Шадар сайд ахалж Засгийн газарт өргөн барьж, бид нарт танилцуулагдсан байгаа. Та тэгэхээр саяын асуултуудаа намынх нь дарга Гантөмөр сайдаас тодруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Мухар төмөр замтай холбоотой асуудал бол яг хажууд суудаг хүнээсээ асуух нь зүйтэй болов уу гэж бодож байна. Одоо ирээгүй л байна л даа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Нийт 4 санал байгаа.

“Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын дөрөв дэх чиглэл “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн хэсгийн 4.3.8 дахь заалтыг “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.” гэж өөрчлөн найруулж, мөн хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дахь мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

63.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ /Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван чиглэлийн үндсэн чиглэл/-8.1.2, ЗГҮАХ /Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр/-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ /Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван чиглэлийн үндсэн чиглэл/-8.1.2, ЗГҮАХ /Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр/-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэж тус тус нэмэх. Санал гаргасан. Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

65.3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал.

1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь дэд заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл, арга хэмжээ”-нд “1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34,927.9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах. Санал гаргасан. Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

67.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “төсөл хэрэгжүүлэх хорооны тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Хорооны тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтод түвшин”-д “15” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Шинээр боловсруулах төлөвлөгөөний бичиг” гэж, “Хэмжих нэгж”-д “Төлөвлөгөөний тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтод түвшин”-д “5” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

72.4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай “Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

67.3 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Монгол Улсын 2020, дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиудын хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар ажлын 5 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан үг хэлэх үү?

Үг хэлэхгүй байна. Завсарлага дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17-д улсын төсвийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж заасны дагуу илтгэл, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Гишүүд нэрээ өгье.

Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилигийн Лодойсамбуугаар тасаллаа. Нийт 33 гишүүн нэр өглөө.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн бүрэн ирсэн үү? Улсын Их Хурлын гишүүн Галбадрах, Замира, Энхнасан 3 гишүүний нэрийг нэрсийн жагсаалтад нэмье. Нийт 36 гишүүн асуулт асууна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танхимд суудалдаа сууя.

Монгол Улсын Ерөнхий сайд, мөн Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Лувсаннъямын Гантөмөр, мөн Монгол Улсын Шадар сайд Амарсайхан нар гадаадад томилолттой явж байгаа учраас өнөөдрийн хэлэлцүүлэгт Засгийн газрын бусад гишүүд оролцож байгаа. Мөн Засгийн газрын гишүүн Чинбатын Номин бас гадаадад томилолттой явж байгаа. Бусад Засгийн газрын гишүүд болон ажлын хэсгийн гишүүдийг танхимд бүрэн цугларахыг хүсье.

Ингээд нэр өгсөн дарааллаар Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: 2025 оны нэгдсэн төсвийн төсөл орж ирлээ. Бид бүхэн бас үзээд танилцаж байна. Энэ дотор би зүгээр онцлох хэд хэдэн зүйлүүдийг бас хэлье гэж бодож байна. Ирэх оны төсөвтэй холбоотойгоор 2024 оноос төсвийн орлогыг 6.2 их наядаар бол нэмэгдүүлж орж ирж байна. Төсвийн зарлагыг 5.3 их наядаар бол нэмэгдүүлж орж ирж байгаа. Зарлагыг магадгүй өмнөх онтой нь авч үзэх юм бол 17.4 хувиар төсвийн зарлага маань өөрөө нэмэгдэж байна. ДНБ-ээ 95 их наядаар бас нэмэгдүүлж орж ирж байгаа. Өмнөх онтой харьцуулж үзэх юм бол 19.9 хувиар буюу бараг 20 хувиар бол нэмэгдэж орж ирж байна. Эдийн засгийн өсөлтийг 8 хувиар тооцлоо. Нүүрсний үнийг 129 ам.доллаар бол тооцсон байна.

Би эргээд зүгээр аваад үзэхээр яг Олон улсын валютын сан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн чинь яг бодитой юм уу? 6.6 хувь бол эдийн засгийн өсөлт байна гэдэг тооцооллыг хийж орж ирж байгаа юм. Нүүрсний үнэ энэ жил 115 ам.доллар байсан. Одоо 129 ам.доллар болгосон. Ирэх жил яг олон улсын шинжээчид болоод олон улсын

байгууллагуудын зүгээс авч үзэхээр үндсэндээ нүүрсний үнэ бол унах төлөв байна гэж харж байгаа. Төлөв байна гэж харж байгаа.

Тэгэхээр би нэг талдаа бас энэ яг бодитой та нарт тооцож байгаа юм уу? Бодитойд тооцож байгаа юм уу? Төсвөө бид нар сүүлийн 10 жил магадгүй хязгааргүй их нэмж ирлээ, зээл нэмэгдэж байна. Магадгүй 2025 оны төсөв бол бараг түүхийн рекорд эвдэх гэж байгаа ийм төсөл болж байгаа. Хамгийн өндөр зарлагатай түүхэндээ байгаагүй, хамгийн том төсвийг бол бид нар хэлэлцэж эхлэх гэж байна, батлах гэж байна. Би бол нэг талдаа бас Сангийн яамны энэ албан хаагч нарт бас баяр хүргэе гэж байгаа юм. Яг асуудалд мэргэжлийн өнцгөөс хандаж байна уу, үгүй юу? Төсвийн зарлагыг маш эрчимтэйгээр сайн нэмж байна. 8 жилийн дотор төсвийн зарлагыг 11.5 хувь, 11.5 дахин нэмсэн байгаа. Тэгээд одоо төсөөлж оруулж ирж байгаа нүүрснийх нь үнэ болоод, эдийн засгийнх нь өсөлт, мөн орлогынх нь тооцооллоос нь аваад үзэхээр даруй бараг тус бүрдээ 20 хувиар нэмэгдэж орж ирж байгаа. Тэгээд Их манай Сангийн яам бол уг нь бол харьцангуй хамгийн эдийн засгийн доод хувилбараар нь тооцож, хамгийн магадгүй эрсдэлийг хамгийн зөвөөр тооцож орж ирж байх ёстой яам маань хамгийн магадгүй гэгээлэг яам бол болж орж ирж байгаа юм. Гэгээлэг яам. Магадгүй өөдрөг төсөөллийн яам бол болж орж ирж таарч байгаа юм. Тооцоолол дээр.

Тэгэхээр би энэ өөрөө зарчмын хувьд их буруу л ажиллаж байна даа. Эргээд энэ төсвийн мөнгөнд бид нар бас ингэж ийм.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Тэмүүлэн гишүүний асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү хариулна. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

И.Батхүү: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамнаас эдийн засгийн өсөлтийг 25 онд 8 хувиар тооцсон байгаа. Энэ өсөлтөөр ДНБ 95 их наяд төгрөгт хүрнэ гэж тооцоолж байгаа. Эдийн засгийн өсөлтийг голлох олон улсын байгууллагуудын тооцоолол, Монгол Улсын эдийн засгийг Олон улсын валютын сан жишээ нь, өмнөх тооцоолол дээр 6, 6.5 хувь гэж байсан бол уржигдар ажлын хэсэг буцаж очоод зарласан, нийтэлсэн тайлан дээрээ Монгол Улсын эдийн засгийг 25 онд 7 хувь болгоно гэж, болж өснө гэж зарласан байна лээ.

Валютын сангийн зүгээс ер нь өнгөрсөн хугацаанд Монгол Улсын эдийн засгийг ингэж 7 хувьд өндрөөр тооцоолж байсан удаа байхгүй байгаа. Бусад олон улсын байгууллагуудын хувьд ч гэсэн өсөлт нь дандаа 6-аас дээш хувьд тооцооллын ирэх онд авч үзэж байгаа.

Биднүүсийн хувьд ирэх оны эдийн засгийн голлох өсөлт маань уул уурхайн салбар дээр экспортын хэмжээ үргэлжлэн нэмэгдэх хандлагатай байгаа. Ялангуяа Оюу толгойн гүний уурхай ашиглалтад орсноор баяжмалын үйлдвэрлэл болон зэс, алтны агууламж нэмэгдсэнтэй холбоотой нэлээн их ДНБ нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

Энэ уул уурхайг дэмжсэн тээврийн, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд үргэлжлэн явагдана. Эрчим хүч тээврийн салбарт бас эдийн засгийн бодит өсөлт өндөр түвшинд хадгалагдах төлөв байдал байгаа. Хөдөө аж ахуйн салбар өнгөрсөн 2 жилийн хугацаанд уналттай байсан. Энэ суурь уналтаасаа эргээд сэргэлт нь бас 25 онд эдийн засгийн өсөлтөд үйлдвэрлэл талаасаа нэлээн том хувь нэмэр оруулна. Аялал жуулчлалын салбарыг дэмжих бодлого бол 3 жил амжилттай хэрэгжсэн байгаа. Энэ бодлогыг 28 он хүртэл бас

үргэлжлүүлээд явуулна. Аялал жуулчлалын салбар дээр бас нэлээн их орлого уул уурхайн бус салбар дээр орлого нэмэгдэх төлөвтэй байгаа.

Нүүрсний үнийн хувьд биднүүс ирэх оны төсөөллийг 105 гэж авч байгаа. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 107-130 ам.доллар гэсэнтэй харьцуулахад харин ч бууруулж илүү болгоомжтой байдлаар тооцоолсон. Энэ 24 оны байдлаар биднүүс зуун арван, таван доллар гэж тооцоолж байсан. Эхний, оны эхнээс эхлээд өнөөдрийг хүртэл гүйцэтгэлээр дунджаар 111 долларын ханштай байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Сүүлийн 5 жилийн энэ динамикийг харах юм бол бид 2020, 2021 он буюу яг КОВИД-ын хамгийн тэр хүндрэлтэй үед орлогын өсөлт бол бүүр 35 хувьтай ингэж болж байсан. Ингээд шат дараатай мэдээж энэ өсөлтүүд бол тодорхой хэмжээнд буурч ирж байна. Ирэх оны төсвийн орлого талдаа 33.9 их наяд буюу энэ жилийнхээс 17 хувиар өсөж байгаа. Аливаа төсвийг дунд шатын ч бай, доод шатын ч бай улсын төсвийг бид төлөвлөхдөө ямар нэг тийм хийсвэр төсөөллөөр биш хуулийн дагуу тавьдаг шаардлага, дүрмийн хүрээнд ингэж төлөвлөдөг байгаа. Тэгэхээр зарчим бол эхлээд бид бодит орлогоо төлөвлөх ёстой. Орлогоо мөн төлөвлөхдөө ч энд хуулийн дүрэмтэй. Одоо манай төсвийн орлогыг бүрдүүлж байгаа гол түүхий эдүүдийн экспорт.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Эдгээр үнүүдийнхээ тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийнхээ аль багаар нь аваад, түүнээс хэрвээ давах юм бол энийгээ тогтворжуулалтын сандаа бид багтааж хадгалаад, өөрөөр хэлбэл үнэ болон биет хэмжээн дээр эрсдэл үүсвэл тэндээс хаагаад, алдагдлаа хаагаад явдаг ийм л зарчмаараа төлөвлөж орж ирсэн байгаа.

Зардлын өсөлтийн хувьд урсгал зардал жишээ нь, 3.5 их наяд байгаа. Түүний 2.5 буюу 70 хувь нь ерөөсөө дангаараа статистик өсөлт, инфляц, тарифын өсөлтөөс шууд гарч ирж байгаа гэсэн үг. Автомат шууд тавигдаж байгаа ийм өсөлт. Мөн үлдсэн 30 хувь нь бол одоо батлагдаж байгаа салбар салбарын хууль тогтоомжийн хүрээнд 595 тэрбум төгрөг, мөн Цагаан алт, Тэрбум мод, мөн, энэ хөдөө аж ахуйн чиглэлийн хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөрүүд дээр нийтдээ 457 тэрбум төгрөг гээд ерөөсөө маш тодорхой ийм 3 эдийн засгийн ангиллаар нийтдээ 3.5 их наядаар.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үдийн цайны завсарлага болоод өнгөрчихсөн байгаа. Тэгээд цайны завсарлагагүйгээр хурлаа үргэлжлүүлье. Мөн гишүүд танхимд байгаа гишүүдээс өнөөдөр 40 гишүүн асуулт асууна, хариулт авна. Тэгэхээр энэ асуудлаа өнөөдөртөө хэлэлцэж дуусгая гээд санал асуучихъя.

Уянгахишиг гишүүн юун дээр горимын санал гаргах билээ? Одоо хэлэлцэж байгаа асуудалтай. Тэгвэл өнөөдөртөө энэ асуудлаа хэлэлцээд дуусъя гээд гишүүдээс санал асууж байна.

Уянгахишиг гишүүнд микрофон өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр бид нар өмнө нь бас яг төсвийн тодотгол хэлэлцэхэд гарч байсан асуудал гараад байна. Тэгэхээр өнөөдөр бид нар төсвөө оруулаад ирчихсэн, өргөн барьчихсан, өргөн мэдүүлчихсэн төсвийн нэгдүгээр хэлэлцүүлгийг хийж байна. Тэгэхээр

нэгдүгээр хэлэлцүүлгийн үр дүнд Их Хурлын, Их Хурлаас чуулганы дэгийн тухай хуулийн дагуу энэ зүйлд заасны дагуу асуулт асууж, үг хэлсний дараа Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар өнөөдөр энэ санал хураалтыг хийх ёстой болчихоод байна. Гэтэл яг өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлагад төсөв нийцээгүй байгаа, дүн нь өөр байгаа. Мөн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань сая л дөнгөж яригдаад дуусаж байна шүү дээ. Тэгэхээр энэнд нийцсэн эсэх талаар бид нар өнөөдөр яаж санал өгөх юм бэ? Тэгэхээр энэ дээр горимын санал, төсөв хэлэлцэхийг хойшлуулах горимын саналтай байна. Ямар ч байсан энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөгөө эцсийн найруулгаар нь бид нар харж байж, энэндээ нийцэж байна уу, үгүй юу гэдгээ бид нар шалгаж үзмээр байна.

Дээрээс нь одоогийн байгаа энэ дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдэл нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу нийцсэн байдлаар төсвөө ер нь бол бид нар харах ёстой шүү гэдгээ бас анхаарч үзмээр байна. Тодотгол дээр бид нар алдаа гаргасан шүү дээ ээлжит бусаар.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр нэгдүгээрт, өнгөрсөн долоо хоногт буюу төсвийн хэлэлцүүлгийн анхны танилцуулга дээр Монгол Ардын намын бүлэг таны сая хөндсөн асуудлыг хөндөж, хөгжлийн төлөвлөгөө баталсны үндсэн дээр төсвөө хэлэлцэж эхэлье гэдэг санал гаргаж, 5 хоногийн завсарлага авсан. Энэ хооронд хөгжлийн төлөвлөгөөг бид хэлэлцээд баталлаа сая. Тэгээд өнөөдөр завсарлагын хугацаа дуусаад хэлэлцэгдэж эхэлж байгаа, нэг дэх.

Хоёр дахь асуудал нь энэ дэгийн тухай хуулийн 6.9 дээр нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-нд заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж ирүүлнэ гэж ингэж заасан байгаа юм.

Тэгэхээр таны гаргасан горимын саналыг хүлээж авах боломжгүй байна.

Ингээд өнөөдрийн хуралдааныг асуулт асууж, хариулт өгч өнөөдөртөө хэлэлцээд дуусгая гэсэн санал оруулж байна. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. Тэгвэл өнөөдрийн чуулганы хуралдаан асуудлаа хэлэлцэж дуустал үргэлжилнэ.

Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Тодруулах зүйл гээд аваад үзэхээр ерөөсөө үндсэндээ эдийн засгийн өсөлтийг хувийн сектор л бий болгодог. Тэгэхээр би зүгээр хэлэх гээд байгаа зүйл нь ерөөсөө төрийн оролцоогоо багасгах, эргээд энэ ДНБ болоод эдийн засаг дахь төрийн оролцооны хувь, хэмжээг бууруулах л асуудал байгаад байгаа юм. Эргээд бид нар сая оруулж ирсэн төсвөөр нь аваад үзэхээр нийт ДНБ-ий чинь 37.7 хувь нь ерөөсөө төсөв болчихлоо. Төрийн оролцоо чинь энэ хэмжээгээр нэмэгдчихлээ. Хувийн хэвшил яах вэ? Засгийн газар ерөөсөө сүүлийн 10 жилийн түүхээр аваад үзэх юм бол хамгийн их татвар цуглуулах чиглэл рүүгээ явж ирлээ. Одоо үндсэндээ өнгөрсөн жилийнх нь өмнөх онтой нь

харьцуулаад аваад үзэх юм бол бараг 23 хувиар ард иргэд болоод татвар төлөгчдөөс төвлөрүүлэх татварын орлого өөрөө нэмэгдэж байна. Энэ өөрөө зөв юм уу?

Хоёрт, би эрх ашгийн эрэмбийн хүрээнд энэ асуудлуудаа 14 мега төсөл гэж байгаа боловч энэ дотроо эрх ашгийн эрэмбийн хүрээнд хандаж чадаж байгаа юм уу? нэмүү өртөг бий болгохгүй, дээрээс нь нийгмийн шинж чанартай зөрчлүүдийг оруулж ирж байгаа нь зөв юм уу? Налайх.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариул.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Бид сарын өмнө хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө хуулийн дагуу 4 жилийнхээ Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө баталсан. Мөн 2050 он хүртэл урт хугацааныхаа төлөвлөгөөг ч баталчихсан байгаа. Ингээд жил жилээр нь бид нар жил жилийнхээ төлөвлөгөөг батлаад явдаг. Ингээд өнөөдөр бид нар ирэх оныхоо жилийн төлөвлөгөөг нь таслаад баталсан байгаа, хөтөлбөр. Тэгээд тэрэнд таарсан бид нийцсэн, чиглүүлсэн төсвөө оруулж ирж байгаа. Тэгэхээр 14 мега төслийг бид хөтөлбөрийн хүрээнд аль хэдийн батлаад ингээд явчихсан. Энийгээ бид жил жилийнхээ төлөвлөгөөндөө төсвийнхөө боломжоор, төлөвлөлтийнхөө хэмжээнд ингээд багтаагаад төлөвлөөд явах учиртай юм.

Тэгэхээр 14 дээр, 14 төсөл, 14 бодлогын арга хэмжээн дээр аль аль жилд нь алийг яаж хийх вэ гэдгийг бол мэдээж эцсийн байдлаар Улсын Их Хурал дээрээ ингээд эцэслээд батлаад явна.

Ирэх жилийн хувьд бол төсөв дээр 14 мега төсөл 14-үүлээ байхгүй шүү дээ, боломж, ямар ч боломж байхгүй. Эндээс төсөв дээр орж ирж байгаа нь бол 3-4 төсөл л байгаа. Ихэнх төслүүд нь бол зураг, төсөв, ТЭЗҮ, бэлтгэл ажил хангах ийм шатан дээрээ явж байгаа зүйлүүд байгаа. Ер нь сүүлийн 20-оод жилийн хугацаанд Монгол Улсын төсөв, ДНБ-ий харьцаа ер нь 34-37-гийн хооронд ингэж явж ирсээр байгаа.

Төсвөө задлаад харах юм бол харин, би Тэмүүлэн гишүүнтэй нэг зүйл дээр санал нийлж байна 100 хувь. Олон ч хүн санал нийлэх байх. Ер нь энэ харьцааг аль болох багасгах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл, төсвийн эдийн засгийн хөгжлөө дэмжих хүчийг нь нэмэгдүүлэх, хэмжээг нь багасгах энэ бол бид нарын эцсийн л зорилго.

Одоо байгаа энэ боломж дотроо харин оролцоогоо ямар чиглэл дээр нь Засгийн газар илүү их үүрэг хүлээх вэ гэдэг л эрэмбэлэх асуудал байгаа юм. Тийм учраас аль болох хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх, салбар салбарыг либералчлах, одоо энэ ингээд л эрчим хүчний салбараасаа ч бид нар ирж байна.

Д.Амарбаясгалан: Жанчивын Галбадрах гишүүн асуултаа асууна.

Ж.Галбадрах: Сайн байцгаана уу? Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлтэй танилцлаа. Дүгнээд хэлэхэд ирээдүйдээ, хүүхдүүддээ амласан амлалтаасаа ухарсан төсөв болжээ гэж хэлэхээр байна.

Яагаад гэвэл төсвийн тэлэлт, инфляцтай уялдаж салбарын нийт төсөв мэдээж 4.6 их наяд гэсэн ийм том тоо харагдаж байгаа ч энэ дотор нь задлаад үзэх юм бол ДНБ-д эзлэх хувь нь багассан. 5 хувиас 4.8 хувь болж буурсан. Хамгийн гол нь зардалд эзлэх хувь 14.3

гэсэн ийм их бага дүнд хүрчээ. Уг нь Засгийн газар боловсролоор тэргүүлэх салбар болгоод, мөн тогтвортой хөгжлийн бодлогоор боловсролын бодит зардлыг жил бүр хувиа 20 хувиас бууруулахгүй байх үүрэг хүлээж, зорилго тавьсан байдаг.

Гэтэл өнөөдөр 14.3 хувьд хүрсэн байгаа нь энэ амлалтаасаа ухарчээ гэж дүгнэхэд хүргэж байна. Үүнтэй холбоотойгоор төсвийг ингээд задлаад үзэх юм бол өнгөрсөн жилээс хөрөнгө оруулалт маш багассан байна. Өнгөрсөн жил 2024 онд 714 тэрбум байснаа энэ жил 506 буюу даруй 200 тэрбумаар хөрөнгө оруулалт нь багассан байна. Эсрэгээрээ бид боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг нэмж, энэ 14 мега төсөл ярьж байгаа бол 15 дахь мега төсөл гэж боловсролыг ярих хэрэгтэй гэдгийг би боловсролын салбарын төлөөллийн хувьд байнга үг хэлэх боломж олдох бүрд хэлж ирж байгаа.

Манайхан бүгд л ярьдаг салбарын чанараас бүх салбар хамаарна, үр дүн өгөөж нь хамаарна гэж дээр дооргүй ярьдаг. Ийм ч учраас боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг хасаж ерөөсөө болохгүй, ийм байж болохгүй. Энэнтэй холбоотой ингээд би 4 асуулт асууя гэж бодож байна. 2024 оны төсөвт 385 төсөл, арга хэмжээ төсөвлөгдөж байсан.

Гэтэл 2025 оны төсөвт нэг ч тэнд шинэ төсөл тусгагдаагүй. Ердөө 90 сургууль, 62 цэцэрлэг гэх мэт 186-хан өөрөөр хэлбэл, 2 дахин багассан ийм төсөл, арга хэмжээнүүд зөвхөн шилжихээр төсөвлөгдсөн байгаа. Энэ нь улсын хөгжилтэй нийцэж байна уу, тулгамдсан асуудлууд энүүгээр ингээд бүрэн шийдэгдэх үү? Одоо ганцхан хамгийн том тулгамдсан асуудал гэж ярьдаг Нийслэл, орон нутагт 3 ээлжээр хичээллэдэг 8 сургууль бий гэдэг.

Тэгвэл энэ 8 сургууль багасах юм уу? Эсрэгээрээ нэмэгдэх байх гэсэн ийм тооцоолол байна. Өнөөдрийн байдлаар 3 ээлжид ороход бэлэн байгаа олон сургууль байгаа. Тэнд бид нар хөрөнгө оруулалт хийхгүй нь байна. Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт 40 давсан. 45, 50, 55, 60 давсан 4860 бүлэг. Эдгээрт 210 гаруй мянган хүүхэд сурч байна. Ингээд 40 даваад ирсэн бүлэгт суралцагчийн эрх маш их ноцтойгоор зөрчигдөж байгаа. Энийг хүн болгон мэддэг. Анги, танхим, дэд бүтэц хүрэлцээгүйгээс ингэж хүний эрх зөрчигдөж байгааг арилгах нь бид нарын төсвийн горил зорилго биш гэж үү? Гэтэл хүний эрх зөрчигдсөөр байгааг мэдсээр байж ийм төсвийг баталсаар байх уу? Энийг асуумаар байна.

Дараагийн ээлжид өнөөдөр ЕБС-д 850 мянга гаруй хүүхэд сурч байгаа. Үүнийг зарим хүмүүс ирээдүйд 27 оноос эхлээд багасна гэж ингэж андуурч буруу ярьдаг. Манай улсын хүн ам ойрын жилүүдэд ингээд өсөж ирсэн. 2030 онд 910 мянган хүүхэд болно гэсэн тооцоо байгаа. Эсрэгээрээ буурах биш, өсөж байгаа. Үүнд бэлэн байгаа юу? их хүүхдүүдийнхээ ирээдүйн асуудлыг бид нар ингээд шийдээд явахгүй юм уу гэдэг асуудлыг асуумаар байна. Ингээд энэ бол зөвхөн анги танхим.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Галбадрах гишүүн нэмэлт 1 минут.

Ж.Галбадрах: Энэ бол ингээд зөвхөн анги танхимтай холбоотой, дэд бүтэцтэй холбоотой л асуудлыг ярихад ийм хүний эрх зөрчсөн ийм ноцтой дутагдлууд байсаар байтал бид нар энийг ерөөсөө шинэ мега төслөө хөдөлгөхийн төлөө гэж ингэж хөрөнгө оруулалтыг нь хасаж, 200 тэрбумаар хасаж ингэж батлах ийм баталж чадаж байгаа нь зөв үү?

Дараагийн ээлжид багшийн хомсдол гэсэн маш том асуудал байгаа. Үүнийг ингээд цогцоор нь шийдэхэд бид бас тооцоо хийж байгаа. Маш том мөнгөн дүн бас яригдаж байна. Тэгэхээр бид нар ингээд энэ бүгдийг нийлүүлээд боловсролын мега төслийг ярих хэмжээнд иржээ. Яагаад бид өнөөдөр боловсролын төсвийг мега төслийн хэмжээнд авч үзэж болохгүй гэж вэ?

Эцэст нь 14 мега төсөл дээр ажиллах үндэсний инженер, техникийн ажилтнуудын нөөцийг хэрхэн тооцсон бэ? Бид нар инженерүүдээ тоолсон байгаа юу? Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Танхимд хэдэн сайд байна? Бусад сайд нар хаачихав? Засгийн газар, ажлын хэсэг энэ дээрээ анхаарлаа хандуулахгүй бол ирц бүрдтэл бид бас чуулганы хуралдааныг хойшлуулж бас болно. Удаа дараа хэлж байна. Яагаад Их Хурлын үйл ажиллагаанд ингэж хүндэтгэлгүй хандаад байна.

10 минутын хугацаа өгье. Энэ хооронд сайд нарыг дууд.

Галбадрах гишүүний асуултад Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ тавиад байгаа 4 асуулт бол зүйтэй. Бид энэ жил 14 мега төсөл гээд энэ эрчим хүч голлосон, эрчим хүчний дутлаас, дутагдал хомсдолоос Монгол Улсыг гаргах ийм төсөл рүү энэ жил орж байгаа нь үнэн.

Гэхдээ бидний яаман дээр хийсэн энэ тооцооноос харахад л ирэх 4 жилд 23250 орны хүч чадал бүхий 212 цэцэрлэг, 131812 суудлын хүчин чадал бүхий 241 сургуулийн барилга шинээр ашиглалтад орох шаардлагатай гээд л байж байгаа юм. Энэ жилийн төсөв дээр олон жил ингээд дамнуулж барьсан барилгуудыг, олон жил дамнуулж амсуулах аргаар явсан эд нарыг нь 100-н, 90 дээр нэмэх нь 61, 152 төслийг дуусгая гэсэн ийм зорилт тавьчхаад байгаа юм.

Таны хэлсэн үнэн тэр яг ноднин 714 тэрбум байж байгаад энэ жилийн төсөвт 506 тэрбум болж бууж орж ирсэн. Боловсролын яамнаас 198 төсөл, арга хэмжээг санал болгосон. 17-г нь бол бас энэ тухайн үед нь тендер зарлагдаагүй эд нар гэсэн ийм шалтгаанаар хасчхаад байж байгаа. Би боловсролын сайдын хувьд энэ төслүүдийг ч гэсэн бүгдийг нь явуулах ийм сонирхол үүнд өндөр байгаа.

Гэхдээ Засгийн газар дотор барьсан, өргөн барьсан ийм хүрээндээ бид нар бас байх ёстой гээд. Энэ бол хүүхдийн эрхийн, хүний эрхийн бас том зөрчил гэдгийг хүлээн зөвшөөрнө. 1 ангид 40-өөс дээш хүүхэдтэй ийм дүүргэлттэй үед тэгээд 3 ээлжээр бол өнөөдөр 8 сургуулиас 2-ыг нь шийдчихлээ. 5 дугаар сургууль, 14 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга нь ашиглалтад орлоо. Бусдыг нь бол түрээсний замаар алийн болгон явуулах вэ.

Гэхдээ Засгийн газраас бариад байгаа өнөөдөр боломжтой сургуулийн, цэцэрлэгийн бэлэн байгаа барилгаас санхүүгийн түрээс хийх замаар түрээсэлнэ гээд дараа нь худалдан авах арга энэ бүхэн бас зүйтэй алхам гэж хараад байгаа. Тэгэхгүй бол нэг дор орж ирж байгаа төсөвт өгч байгаа даралт, дарамт нэлээн өндөр юм байна лээ.

Багшийн хомсдолын асуудал энэ, энэ болгоныг нийтэд нь ингээд шийдвэрлэе гэхэд ийм мега төсөл санаачилж байгаад баярлалаа. Энэ асуудлаар таны байгуулсан, таны

удирдаж байгаа Улсын Их Хурал дээр байгаа ажлын хэсэгтэй бид хамтран ажиллахад бас бэлэн байна. Түүний зэрэгцээ төсвийг ирэх ирэх жилүүдэд дунд хугацаанд нь шийдвэрлэхэд нэгмөсөн ингээд шийдчихмээр байгаа юм. Манай хөрш бараг гэж хэлж болохуйц Казакстанд гэхэд жилдээ 240 сургууль барьчих юм. Ингээд бүх асуудлыг нэг доор шийдчихье гэсэн ийм санаачилга явж байх жишээтэй. Ийм байдлаар хүүхдийн сурах орчныг илүү хүртээмжтэй, илүү сайн болгохын төлөө хамтран ажиллахад бэлэн байна. Танд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Галбадрах гишүүний асуултад нэмж хариулъя. Гишүүн салбартаа санаа зовж нэлээн хурц дүгнэлт хийлээ. Зүгээр дүгнэлтээ яаран хийхээсээ өмнө таныг 4 жилийн хугацаагаар нь хараасай гэж би хүсэж байна. Бид 4 жилийнхээ хөтөлбөрийг баталчихсан. Салбар салбарынхаа хүрэх зорилтуудыг тавьчихсан. Сая салбарын сайд маань Боловсролын салбарын хүрэх зорилтыг тавилаа.

Ингэхийн тулд бид нар жил жилээр нь ингээд төсвийнхөө боломжит төлөвлөлтүүдийг хийнэ. Ирэх жил одоо эхлүүлчихсэн байгаа явж байгаа төслүүдээ энд бас чамгүй олон төслүүд байгаа, бушуухан дуусгаж авъя. Сургуулийн хувьд орон даяар төсвөөс хийж байгаа 90 сургууль, 62 цэцэрлэг байгаа. Дээрээс нь энд харагдахгүй байгаа Нийслэлийн санхүүжилтээр 37 сургуулийн төсөл явж байгаа. Энэ бас тийм чамлахаар тоонууд биш. Эд нарыгаа ашиглалтад оруулчих юм бол таны хэлж байгаа тэр коэффициентууд бол зорилтот түвшин рүүгээ нэлээн дөхнө. Улаанбаатар хотод бол тэр ээлжийн коэффициент 2 хувь руугаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сангийн сайд нэмж хариулъя. Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм орон нутагт 1.5 хувь руугаа ингээд дөхөх юм байгаа юм. Ингээд ирэх жилийн хувьд ийм байна. Ингээд 26, 27, 28 онуудад бол Наранбаяр сайдын хэлж байгаа тэр зорилт түвшиндээ хүрэх хөрөнгө оруулалтууд ингээд үргэлжлээд явах юм шүү. Тийм учраас 4 жилээр нь хараач гэж ингэж хүсэж байна.

Бусад тэр мэргэжлийн яг боловсон хүчний, хүний нөөцийн бодлогын асуудлуудыг Наранбаяр сайд ингээд хэлчихлээ. Зүгээр сүүлийн 10 жилийн хугацааны хөрөнгө оруулалтуудыг харах юм бол хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн салбар бол манай энэ боловсролын салбар байдаг. Сургууль бол 600 гаруй, цэцэрлэг 700 гаруй, бусад эрүүл мэндийн салбаруудын нийгмийн бусад суурь салбаруудыг оруулах юм бол нэлээн том дүнгүүд байгаа юм.

Өөрөөр хэлбэл, эрчим хүч замаа орхиж байгаад, хойш нь тавьж байгаад сургууль, цэцэрлэгүүдээ бид нар сүүлийн жилүүдэд түлхүү барьчихсан. Гэтэл эдгээр маань одоо цаашдаа дахиад энэ салбар дээрээ бүтээн байгуулалт хийхэд эргээд эрчим хүч маань өөрөө хүрэхгүй, зам тээвэр, тээвэр ложистик нь эндээ хязгаарлагдаад ирж байгаа. Тийм учраас.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Ер нь 4 жилээр нь харалгүй яах вэ. Тэгэхдээ энд ээлжийн коэффициент маш өндөр байна. Энэ бид нар энд ерөөсөө л хүүхдийн эрх, би өөрөө энэ ажлын хэсэг удирдаж байгаа. Энэ дотор хүүхдийн эрх, суралцагчийн эрх, багшийн эрхийг зөрчиж байгаа энэ асуудлуудыг бид нар олох Боловсролын ерөнхий хууль маань

батлагдаад удаагүй байж байгаа. Энэний хэрэгжилттэй бид нар ингээд танилцаад, энэ багшийн хомсдолыг арилгах талаар ингээд хийгээд явж байна.

Тэгэхээр боловсон хүчиндээ бид нар энэ хөрөнгө оруулалт хийж, сайн боловсон хүчнийг татах гэдэг тал дээр маш их том шинэ хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд хэрэгтэй байгаа гэдгийг энэ тооцооноос гарч ирж байгаа юм.

Би сая 40-өөс дээш хүүхэдтэй сургуулийг ингээд тоолоод үзэхэд бага бүлэг нь байж болно. Тэгтэл 275 сургууль байгаад байгаа юм. Тэгээд өнөөдөр сая тэр Казахстаны жишээ хэлж байна шүү дээ. Казахстан энэ асуудлаа шийдье, ерөөсөө тав тухтай орчин байя, тэрнээс эхэлье, хамгийн хүнд гэр орон хэрэгтэй гэдэг шиг энэ сургууль гэдгийн энийг барья гээд ингээд явбал 240 сургууль эхэлж байгаа гэдэг шиг бид нар яагаад мега төсөл болгож

Д.Амарбаясгалан: Санал хэлчихлээ. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна. Тэгэхдээ Жавхлан сайд аа Сангийн сайд ганцаараа төсөв хариуцдаггүй байх, бусад салбарын сайд нар орж ирэхгүй юм уу? Түрүүчийн төсвийн тодотгол дээр энэ асуудлаар бид удаа дараа ярьсан. Яагаад Улсын Их Хурлын үйл ажиллагаанд ингэж хүндэтгэлгүй хандаад байна. Өргөн барьж байгаа аливаа асуудлыг бодлогын түвшинд дэмжье гэдэг байр сууриас Улсын Их Хурал ажиллаад байдаг. Эргээд ингэж хүндэтгэлгүй хандах юм бол бас цаашаагаа төсвийг тогтмол хэлэлцээд явахад хүндрэл үүсэх нь байна. Хаачив энэ сайд нар? Учрал сайд? Сайд нар яав? Энэ хүмүүс бүгд цагаа зориулаад, өдрийн цайны завсарлага ч авахгүйгээр ажиллая гээд ингээд сууж байхад асуудал оруулж ирж байгаа сайд нар яагаад ийм байдлаар хандаж байна. Хууль ярих юм бол ер нь бүгд байлцах ёстой шүү. Төсвийн ерөнхийлөн захирагч байхгүйгээр тухайн салбарын төсвийг ярина гэдэг бол байж болохгүй зүйл гэдгийг ойлгох ёстой шүү.

Наранбаатар гишүүн асуултаа асууя. Наранбаатар гишүүний асуултын дараа сайд нар орж ирэхгүй бол чуулганы хуралдааныг завсарлуулна.

Н.Наранбаатар: Сангийн сайдаас энэ Засаг захиргаа, нутаг дэвс дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд орсон өөрчлөлтөөр орон нутаг бонд гаргах эрхийг нь нэгд өгсөн.

Тэгэхээр энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй аймгуудад орон нутагт нэн шаардлагатай ажлуудыг аймаг нь бонд гаргаад ингээд хөрөнгө босгоод хийчих ийм боломж нь одоогоор нээлттэй болохоор байгаа юу гэсэн ийм асуулт байна. Хэдийгээр хуульд нээсэн ч гэсэн Засгийн газраас бас журам гаргах ёстой юм байна лээ. Тэгээд энэ журам нь гарсан уу, үгүй юү? Хэрвээ энэ бололцоотой бол одоо Иргэдийн хурлаараа бас аймагтаа тулгамдсан ДЦС гэх мэт асуудлуудыг бонд гаргаад, хөрөнгө босгоод хийчих ийм бас бололцоо байгаад байгаа юм. Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Аймгууд бас энийг харж байгаа байх гэж бодож байгаа юм.

Дараа нь энэ бүсчилсэн хөгжлийн зорилготойгоо уялдуулаад энэ орон сууцын асуудал, татварын асуудлуудыг, аж ахуйн нэгжийн татварууд дээр ямар өөрчлөлтүүд хийж өгөх ёстой явж байгаа вэ? Бүсчилсэн хөгжлийг амилуулахын тулд энэ Улаанбаатарын төвлөрлийг бууруулахын тулд хүмүүсийг орон нутаг руу явуулна л гээд байдаг. Яах вэ цалингийн хувьд 40 хувь, 20 хувь гээд орон нутгийн нэмэгдэл бол олгогдоод явж байгаа томоохон бас хөшүүрэг.

Нөгөө талдаа орон сууц байхгүй байгаад байна. Хэчнээн цалин нэмэгдсэн ч гэсэн аймаг, сумд очоод ажиллахаар чинь орон сууц байхгүй байгаад байна. Тийм учраас энэ орон сууцын хөтөлбөрийг яаж явах гэж байгаа юм? Ипотекийнхээ зээлтэй уялдуулаад энэ орон сууцын төрийн албан хаагчдын болон иргэдийн энэ арилжааны орон сууцын хөтөлбөрүүдийг яаж хэрэгжүүлэхээр хэдий хэмжээний төсөв ирэх онд төсөвлөөд байгаа вэ гэсэн асуудал байна.

Дараа нь гуравт нь энэ малчдын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж байгаа. Тэгээд энэ дээр хэдий хэмжээний төсөв тавигдаж байгаа юм бэ? Энэ жил тодотголоор нэмээд их наяд шахуу төгрөг тавигдсан гэж ойлгож байгаа. Тэгээд энэ төсөв нь дууссан уу яасан? Хэдий хэмжээний хүлээлт байгаа вэ? Ирэх онд хэдий хэмжээний төсөв тавихаар байгаа вэ гэсэн асуудал байна.

Тэгээд мөнхийн сэдэв цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл инфляцтай уялдуулж жил болгон явна гэсэн тэгэхээр ирэх онд яаж тооцож байгаа вэ гэсэн ийм 4 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Нэгжийн тухай хуулиар орон нутаг үнэт цаас гаргах, бонд гаргах эрх нь бол нэгдсэн байгаа. Мэдээж журам зохицуулалтууд аль хэдийн гарсан. Энэний хүрээнд Нийслэл маань энэ жил бонд гаргаад явж байгааг бид бүгдээрээ сайн мэдэж байгаа. Монгол Улсын төсөв маань өөрөө бид аймгуудын нэгдсэн улс биш, нэгдмэл 1 улсын ийм төсвөөр явдаг.

Өөрөөр хэлбэл, Нийслэлийн бонд ч бай, орон нутаг аль нэг аймаг бонд гаргалаа ч энэ Монгол Улсын Засгийн газрын өр болон Улсын Их Хурлаар батлагдаж гарч ирдэг төсвийн хүрээний мэдэгдэл, энэ хязгаар бүх юманд нийцсэн байх учиртай юм.

Тийм учраас одоо та Өмнөговь аймагтай холбоотой асуудал яригдах байх. Тэгэхээр бондын асуудал, цахилгаан станцтай холбоотой асуудлууд яригдаж байгаа. Зүгээр энэ дээр болохгүй зүйл бол байхгүй. Энэ асуудал нь өөрөө нээлттэй.б Би Өмнөговь аймгаас сонгогдсон гишүүддээ мөн бас мэдээлэл өгөөд энэ дээр ярилцаж байгаа. Энэ дээр хэдүүлээ судалгаа хийгээд үзье. Засгийн газар дээр энэ асуудал шийдэгдээд Улсын Их Хурал руу явах ийм зохицуулалттай. Ямар ч байсан Засгийн газар дээрээ хэлэлцэх хүртлээ хамтраад, манайхаас туслаад, боломжит ямар хувилбарууд байх нь вэ энэ дээрээ судлаад, ярилцаад үзье гэж байгаа. Зүгээр анхны тохиолдол болох байх.

Орон нутаг, хөдөө орон нутаг, аймгууд дээр гадаад бонд гаргах боломж байхгүй. Зөвхөн Нийслэл дээр байдаг ийм хуулийн зохицуулалттай. Томоохон төслүүд дээр ямар нэгэн гадаад валютын эх үүсвэргүйгээр шууд төгрөгөөр бонд гаргаад ингээд явна гэхээр нэлээд ачаалалтай байгаа төлбөрийн тэнцэл, төсвийн энэ бодлогуудтайгаа хэрхэн яаж нийцүүлэх вэ гээд бидэнд бас нэлээн сорилтууд бол тулгарна. Тийм учраас энэ дээр хэдүүлээ хамтраад ажиллаад явна.

Орон сууц, орон сууц, татвар, чинээлэг малчин, цалин гээд энэ 4 асуулт. Орон сууц дээр ялангуяа хөдөө орон нутаг руу чиглэсэн энэ бодлого ирэх жил нэлээн хүчтэй тэлж үргэлжилнэ. Ялангуяа тэлнэ гэдэг маань бид орон сууц барих биш харин суурь боломжуудыг нь дэд бүтцүүдийг нь эрэмбэлж, энийг нь шийдвэрлэх, төрөөс юуг нь шийдвэрлэх вэ, төр, хувийн хэвшлийн түншлэлээр юуг нь шийдвэрлэх вэ? Харин тэр

дээрээ хувийн сектор өөрөө боломжоороо өрсөлдөхүйц, мөн төрийн албан хаагч нарт чиглэсэн үнийн бодлогоо бас Засгийн газартайгаа, орон нутагтайгаа хамтарч хэрэгжүүлж болохоор ийм төслүүдийг дэмжээд явахаар Барилга, хот байгуулалтын сайд дээр томоохон бодлогын төсвийн зардлууд тавигдсан байгаа. Энэ талаар сайд өөрөө нэлээн дэлгэрэнгүй ярих байх.

Татварын хувьд бол нэлээд тийм шинэлэг гэх юм уу даа нэлээн далайцтай ийм 3 төрлийн зохицуулалт орж ирж байгаа.

Нэгдүгээрт, мэдээж энэ Бүсчилсэн хөгжлийнхөө бодлого, суурь үзэл баримтлал.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм, нэлээн өргөн асуулт асуусан учраас багтахгүй шүү уучлаарай, 3 төрлийн том бодлогын шинэчлэл,

Нэгдүгээрт, Бүсчилсэн хөгжлийн буюу бүс бүрд ялгаа тэгээд өөрсдийнхөө давуу тал, тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэлүүдийг, технологийн үйлдвэрлэлүүдийг салбаруудыг дэмжих ийм бодлогын эрх нээгдэж байгаа.

Хоёрдугаарт, боловсруулах чиглэлийн бүхий л, өмнө нь бид нар салбар салбараар сугалж бодлого явдаг байсан бол тэгэхгүй, салбар хамаарахгүй бүх салбарт жигд боловсруулах технологийн тоног төхөөрөмжүүд дээр гаалийн албан татварыг бүрэн чөлөөлж байгаа, бүрэн чөлөөлж байгаа.

Дээрээс нь мөн 4 жилийн хугацаатай НӨАТ-ыг мөн хойшлуулах ийм боломж нээгдэж байгаа.

Гуравдугаарт, цаашдаа төсвийн ачааллыг төр, хувийн хэвшлийн түншлэл дээр энэ дээр харилцан ачаалал хуваарилах, энийг нь татварын бодлогоор дэмжих зорилгоор нийгмийн чиглэлийн үйл ажиллагаанууд дээр компаниуд, аж ахуйн нэгжүүд оролцвол гаргасан зардлыг нь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хөдөө аж ахуйн сайд алга байна. Сангийн сайд Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Нийт орлогынх нь 1 хүртэл хувиар хязгаарлаж ингэж татварын хөнгөлөлт үзүүлэх ийм нэлээн дорвитой, шинэлэг ийм татварын шинэ бодлого орж ирж байгаа.

Чинээлэг малчны хувьд сая төсвийн тодотголоор бид нэмж хүүгийн татааснуудыг тавьсан байгаа. Энэ хэмжээгээр бол жилийн эцэс хүртэл 1 их наяд хүртэл нэмэгдэх боломжтой.

Гэхдээ энэ нь өөрөө яг зээлийн эх үүсвэр маань төсвөөс биш энэ банкны эх үүсвэрээр гарч байгаа учраас бас энэ чинь төсвийн хязгаараас гадна банкны болон энэ зах зээлийн хязгаар гээд олон зүйлүүд дээр бас хязгаарлагдах ийм бас сорилтууд байгаа гэдгийг анхаараарай. Тэрнээс төсвөөс шалтгаалж байгаа зүйл энэ дээр бол бага байна. Чинээлэг малчны хувьд төслийн.

Цалингийн хувьд бид сүүлийн 2 жил бол КОВИД-оос болоод нэмж чадахгүй байсан он жилүүдээ нөхөж нэлээн дорвитой сайн нэмсэн байгаа. Ялангуяа орон нутаг руу чиглүүлж. Ирэх жилүүдээс бол бид нэгэнт хуультай болчихсон учраас тэтгэврийн, Нийгмийн даатгалын тухай хууль болон төрийн албан хаагч.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дамдины Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Энэ өдрийн мэндийг гишүүддээ хүргэе. Тэгэхээр энэ төрийн, эдийн засагт эзлэх төрийн оролцооны хувь хэмжээ, зохистой харьцаа алдагдсаныг харин маш олон гишүүд, залуу гишүүд ингээд ярьдаг болсонд би их баяртай байна. Би 2021 оноос хойш энийг тасралтгүй ярьж, тогтоол өргөн барьж, зүтгэж ирж байсан. Харин одоо олон, яг миний энэ үзэл бодлыг хуваалцаад энэ танхим дотор ярьдаг гишүүдийн тоо эрс нэмэгдсэнд баяртай байгаа.

Тэгээд гишүүддээ хандаад, залуу бас гишүүддээ хандаад хэлэхэд Их Хурлын гишүүн гэдэг чинь зүгээр засгаас царай алдаад гуйгаад суугаад байдаг хүмүүс биш, маш их Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй байгаа. Хуулийн тогтоолууд санаачлаад, санаачилга гаргаад энэ нөхцөл байдлыг өөрчлөх гээд явах маш их боломж байдаг учраас энэ дээр өөрсдөө бас санаачилгатай ажиллаарай, би бас өөрийн санаачилгыг гаргана. Тэгээд гаргаж байгаа санаачилга дээр нэгдээд ажиллах боломжтой шүү гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд ярихдаа бол энэ төсвийн талаар л ярихад байна шүү дээ 35 хувь болчихоод байгаа байхгүй юу. Төсөв чинь дангаараа. Тэгвэл төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ бид нар тооцоод үзэх юм бол эдийн засагт төрийн байгаа төрийн оролцоог бүхэлд нь аваад үзэх юм бол энэ чинь 35 хувиас чинь хамаагүй даваад явчихсан. Энэ зохистой харьцаа алдагдчихсан байгаад байгааг сая Сангийн сайд ч гэсэн энийг цохоод хэлж байна, энийг бас хүлээн зөвшөөрч ярьж байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ рүү бодлогоо нэг чиг рүүгээ гаргах нь зөв байх.

Нэг асуулт байна. Энэ юу гэвэл энэ Шүүхийн тухай хуулиар Хууль зүйн байнгын хороон дээр шүүхийн төсөв хэлэлцэгдээд нэгэнт ороод ирсэн байгаа бол энийг буулгахгүйгээр оруулж ирнэ гэсэн хуулийн заалттай байгаа. Энийг ингээд буулгасан байна. Тэгэхлээр зарим буулгасан тайлбараа зураг, төсөвгүй гэсэн байна. Зураг төсөвгүйд нь бол байгаа төсвүүдийг нь ч гэсэн хассан байгаа учраас тэр зураг, төсөвтэй хэсгүүд дээр нэгдүгээрт хасаж болохгүй.

Хоёрдугаарт, зарим дээр нь зураг, төсөв нь байхгүй гэж байгаа дээр чинь Жавхлан сайд аа ийм байгаа байхгүй юу 2 жилийн зураг, төсөв, 2 жилийн дотор хийгдсэн зураг, төсөв шаардлагатай гээд. Тэгээд энэ барилгууд чинь яг нэг стандартаар л баригдаад явна. Ахиад шинээр хийхлээр чинь ёстой төрийн мөнгө уйлахгүй гэж яг л тэр зургаа дахиж хийлгээд мөнгө гаргаад байх ийм асуудал гарч ирээд байгаа. Тэр утгаараа ингээд аваад үзвэл энэ 2 жилийн дотор хийгдсэн, өмнө нь ингээд хийгдчихсэн батлагдахгүй өдий болтол яваад ирчихсэн тэгэхдээ зураг, төсөвтэй зөндөө төслүүд энд байна.

Тэгэхлээр энийг асахгүй байх талд, яагаад гэвэл хасвал өөрөө хууль зөрчиж байгаа. Тэгээд энэ дээр та тайлбар өгөөч. Энэ хууль бол хууль шүү дээ. Энийг бид нар дагаж мөрдөж байх ёстой. Энэ талаас нь та тайлбар хийж өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гэдэг ерөнхий зарчим, зорилготой бол бүүр мянган хувь нийцэж байна. Эдийн засагт оролцооны нэг л хэсэг төсөв өөрөө.

Тэгэхээр төсвийн оролцоог багасгана гэдгийг хэдүүлээ бас задалж хармаар байгаа юм. Төсвийн оролцоо дотор багасгах хэсэг ч байна, бүр нэмэх хэсэг ч байна. Энийгээ л их сайн бид нар харж төлөвлөлтдөө зөв оруулж харах хэрэгтэй юм байна лээ.

Жишээ нь, ирэх жилээс бид нар эрчим хүч, зам тээвэр, ложистик, хувийн секторынхон маань оролцдоггүй энэ салбар. Өөрөөр хэлбэл үзүүр дээр нь хувийн секторынх бүтээн байгуулалт, оролцоог дэмждэг тэр дэд бүтцүүдээ л бид нар оруулах ёстой. Энийг бид нар төсвийн оролцоог багасгаж байна гэдэг малгайн доор энэ хэсгийг бид нар жишээ нь багасгаж болохгүй. Бусад өөр хувийн секторынх боломжийнх нь урдуур нь дайраад, өрсөлдөөд, өөр бусад зүйлтэй зөрчилдөх зүйлүүдийг бид нар хойш нь татаад аль болох яг нийгмийн зөөлөн болон бусад энэ хатуу дэд бүтэц рүүгээ л илүү анхаарах нь зүйтэй юм байна лээ. Тэрнээс тэр харьцааны хувьд бол хэд байх гэхээсээ сонин биш. Өөрөөр хэлбэл, доторх оролцооны ач холбогдлоо бид нар эрэмбэлэх нь нэгдүгээрт чухал юм байна гэж ингэж харж байгаа.

Тийм ч зорилго, агуулга дотор 4 жилийн төлөвлөгөө маань батлагдаад, жил жилийн төлөвлөгөө төсөв маань ингээд батлагдаад явна гэж ингэж бодож байгаа. Шүүхийн төсөв маань энэ жил болгон энэ асуудал яригддаг юм. Бид жил болгон л хариултаа өгдөг. Тэгэхээр хууль гэхээр таны ярьж байгаа хууль ч мөн, бид нарын баримталж байгаа Төсвийн тухай хууль маань ч бас хууль. Энийг хууль биш гэж, эсвэл энийг эрэмбэлэх асуудал байдаггүй тийм зарчим байхгүй байх гэж ингэж бодож байна.

Тэгээд Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргийнхээ дагуу төлөвлөх үүрэгтэй төсвөө. Тэгэхээр бид нар төсвийн хуулиа л барьдаг. Хэрвээ салбар салбарын хууль барина гэх юм бол энд бараг 40-өөд салбарын яг тантай, таны ярьж байгаатай ижилхэн өөр өөрсдийнхөө салбарын хуульд оруулчихсан ийм төсвийн хуультай зөрчилдсөн маш олон заалтууд байгаа.

Тийм учраас бид Төсвийн хуулиа л суурь эрх зүйн орчин болгож ингэж явдаг ийм зарчмууд явж ирсэн гэдгээ хэлье. Тэр зураг төсвийн хувьд бол янз янз байгаа. Харин 2025 оны хувьд бид ийм зарчим барьсан байгаа. Аль ч төсвийн ерөнхийлөн захирагч дээр 2025 онд шинээр эхлэх бүтээн байгуулалтын ажлууд байхгүй, 1 жил энэ дээр завсарлаж байгаа.

Өрөөр хэлбэл, явж байгаа, үргэлжилж байгаа бүх төсөл, хөтөлбөрүүдийгээ бушуухан дуусгая гэдэг ийм зарчмаа барьж байгаа.

Дээрээс нь мэдээж эрчим хүч, тээвэр ложистик руугаа түлхүү тавиад ийм зарчим юм байгаа юм шүү. Тэрнээс биш тэр зураг, төсөвтэй холбоотой бас асуудлууд маань эхний шаардлага биш. Харин 26 оноос эхлээд таны яригдаж байгаа энэ асуудлууд бол өмнөх зарчмаараа ингээд үргэлжлээд хөрөнгө оруулалтууд, шинэ зүйлүүд яваад эхэлнэ гэж ингэж.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дамдины Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр ийм юу байгаа шүү Жавхлан сайдаа энэ бусад тэр салбар нь яг энэ шиг ийм тодорхой хуульгүй байхгүй юу. Энэ чинь маш тодорхой, одоо миний хариуцаж байгаа зөндөө өөр салбарууд байна шүү дээ ийм хуульгүй байхгүй юу. Шүүх

дээр яг тодорхой заагаад өгчихсөн хуультай байхгүй юу. Тэгээд ийм тодорхой хууль дээр би тантай урьд нь ч ярьж байсан “specialibus generalis non derogant” гэдэг зарчим үйлчилдэг юм байна. Тэр нь нарийвчлан зохицуулж байгаа хууль нь ерөнхий хуулиа давамгайлдаг.

Тэгэхлээр төсвийн асуудал дээр өргөн бүх улс даяар хамарсан ерөнхий асуудал байхад яг энэ дээр тусгайлан хууль гаргаад өгчихсөн байж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр тэр хууль чинь давамгайлна шүү нэгд.

Хоёрт, энийгээ ярихдаа би бол ингэж яриад байгаа байхгүй юу. Бид нар шүүхийг шинэчилнэ гээд зөндөө шинэ хуулиуд ингээд гаргаад өгчихсөн. Энийг чинь хийхгүй болохлоор тэр асуудал чинь л гагцхиад байгаа дээр та нар маань анхаарч үзээрэй гэж хэлмээр байгаа юм.

Д.Амарбаясгалан: Энд ийм логикийн алдаатай юм хариулчих шиг болох юм Жавхлан сайд. Өөрөө юун дээрээ яана биз.

Нэгдүгээрт, Цогтбаатар гишүүний асууж байгаа асуулт бол Шүүхийн тухай хуулиар асуудалд хандаж ярьж байгаа юм тийм ээ? Шүүхийн төсвийг Хууль зүйн байнгын хороо батална гэж байгаа юм. Таны хариултад болохоороо зураг, төсөлгүй бол Төсвийн тухай хуулиараа төсөвт тусгах боломжгүй гэдэг хариулт өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр энд зураг, төсөвгүй бол хасаад, зураг төсөвтэй бол энэ Шүүхийн тухай хуулиа барьж төсөвт тусгагдана гэдэг ойлголт энд байна гэдгийг бас та хэд маань бас бодох нь зүйтэй болов уу гэж нэг талдаа бодож байгаа юм.

Тэгэхээр энэ Улсын Их Хурал нэг л зүйлийг бид эцэслэх ёстой. Хууль зүйн сайд, Хууль зүйн байнгын хорооны дарга хоёр өмнөх ээлжит бус чуулган дээр нэг зүйлийг хэлсэн шүү дээ. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өмчлөлд байгаа Тавантолгой түлшийг улсын өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхдээ Компанийн тухай хуулийг зөрчиж байгаа учраас эцсийн найруулгыг сонсохгүйгээр процесс явагдсаны дараа эцсийн найруулгыг сонсоо гэж хэлж байгаа юм. Яг тэрэнтэй адилхан Улсын Их Хурал аливаа хуулийн зөрчилтэй асуултыг эцэслэж батлахад хүндрэл үүснэ.

Тэгэхээр энэ асуудлыг яг та бүхэн маань хуулийн зөрчилгүй болгож ярих нь зүйтэй шүү гэдгийг бас тодруулж хэлье. Тэх, ингээд Цогтбаатар гишүүний тодруулга асуултад нэмж хариулах уу? Энэ асуудал дээрээ анхаарлаа хандуулъя.

Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: Асуултын өмнө тэгээд л ээлжит бус чуулган, тэгээд л дараа нь энэ сая хөгжлийн төлөвлөгөөг бид нар өнөөдөр баталлаа. Энэ Монгол Улсын ерөнхий сайд, Шадар сайдууд энэ ШХАБ-ын хуралд яваад ингээд явж байгааг ойлгож байна. Энэ бусад сайд нар нь ер нь яагаад орж ирдэггүй юм? Хэнээсээ юу асуух юм? Далайн эргээр төсвийн мөнгөөр зугаалга хийгээд алга болчхоогүй бол энэ хуралдаа суух хэрэгтэй шүү дээ. Хуралдаа суухгүй бол бид нар, та нар юунаас юуг нь асуугаад ингээд улс болж тоолоод, бид нар Их Хурал болж тоолоод сууж байдаг юм. Энийг нэхэхтэй зэрэг тэгээд л элдвийн юм яриад л явцгаадаг юм. Болих хэрэгтэй шүү дээ. Их Хурлын дарга бол их л тэвчээртэй хэлж байна даа. Тэгээд үйлийн үртэй шаварт унасан шарын эзэн гэж энэ Сангийн сайд, Хэрэг эрхлэхийн сайд хоёр нь л хөөрхий л ингээд сууж байх юм. Тэгээд бүх сайдын ажлыг ярина, бүх сайдын ажлыг ярина. Болих хэрэгтэй шүү дээ.

Нэгдүгээрт, энэ Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуулт байна. Танай яам төсөв төсөвлөхөд зөвшөөрөл өгч, төсөв хийгддэг. Тэгээд танай яам эрэмбэлдэг гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр одоо ирэх оны улсын төсөв дээр бол нийт хөрөнгө оруулалтын 40 хувь илүүг Улаанбаатар хотод тавьчихсан байна. Бүсүүдэд гээд хөдөө, орон нутгуудад том төслүүд тавьж байна. Ойлгож байна зөв. Ялангуяа Засгийн газраас явуулах гээд байгаа тэр 4 том төслийг бол гараа өргөөд дэмжиж байгаа. Энэ монгол орны хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа 330 сум, суурин газар зөвхөн миний сонгогдсон тойрог гэхэд 54 сум суурин нэгж байдаг. Энд байгаа хүмүүсийн сургууль, цэцэрлэгийн засвар, эмнэлгийн засвар гээд л, тэгээд шинэ барилга, байгууламж гээд л юмнууд байх юм. Та нар энийг ямар шалгуураар эрэмбэлсэн юм бэ? Энэ орон нутгуудад яагаад бага ч гэсэн төсөв ер нь тавьчихаж болоогүй юм? Зөвшөөрлийг нь өгөөд танай яамны л эрэмбэлсэн асуудал байх ёстой шүү дээ.

Хоёрдугаарт энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээс нэг асуулт байна. Засгийн газрын өрийн нийт хэмжээ дээд түвшнээр гэж оруулж ирсэн байгаа байхгүй юу. Уг нь бол бид нар хамгийн доод түвшнээр нь буулгах гэж л зорьж орох гэж ирэх ёстой л доо. Тэгэхээр энийг нэг тайлбарлаач.

Яагаад ийм оптимистик/optimistic/ өөдрөгөөр оруулж ирээд байгаа юм бэ? Эдийн засгийн нөхцөл байдал бол хүндэрнэ, хүндэрч магадгүй, бидний хамгийн гол орлого болох уул уурхайн бараа, бүтээгдэхүүний үнэ бууна гэсэн таамгийг л яриад байна л даа. Тэгэхээр энэ дээр та нар маань тайлбар хэлээд өгөөч.

Гуравдугаарт, төсвийг тэлэх орон зайн тухайд бол 20 хувь орчим байхаар тооцоолсон нь бас л өнөөгийн байдалтай уялдуулахад их өндөр байна гээд байгаа байхгүй юу. Төсвийн тэлэлт 20 хувь байна гэдэг бол хэт их байна л гээд байгаа юм. Тэгэхээр энэ төсвийн энэ ирээдүйн төсөөлөл дээр бид нарын барьдаг үндсэн байгууллагуудын энэ дүгнэлтүүд дээр хариулт өгөөч.

Дөрөвдүгээрт, энэ аудитын байгууллагын нэг дүгнэлт байгаа юм. Аудитын дүгнэлт. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай, үлдсэн 30 хувийг нь та нар ер нь яагаад зарладаггүй юм? Яагаад ийм шүдгүй арслан шиг мөлийсөн үг хэллэгтэй дүгнэлтүүд оруулж ирээд л тэгээд л бид нар тэрийг нь дахин дахин давтаад суугаад байдаг юм. Төсөв болгон дээр л ийм мөлийсөн дүгнэлт орж ирэх юм. Энийгээ тайлбарлаад өгөөч та нар. Энэ 10 дугаар зүйл дээр заасан байгаа энэ өмнөх оноос шилжин ирэх хөрөнгө оруулалтын барилгуудын төсөв бас тусаагүй байна гэж байна. Энэ ямар учиртай юм эд нарыг хэлж өгөөч?

Д.Амарбаясгалан: Хэн хариулах вэ? Дамдинням гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг Батхүү.

И.Батхүү: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамнаас улсын төсвийн төсөл нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдаатай зөвшөөрөл олгодог байгаа. Яг одоо яригдаж байгаа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл нь яг “”Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 21-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон сая батлагдсан Монгол Улсын хөгжлийн 25 оны төлөвлөгөө зэрэг Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн баримт бичигтэй уялдаатай байгаа.

Тухайлбал, 2025 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнд нийт 318 төсөл, арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхэд тусгасан байгаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 5.2 их наяд төгрөг, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр 4.2 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэхээр орсон байгаа.

Энэ нь бол улсын төсөв гадаад зээлийн, тусламжийн эх үүсвэртэй төсөвтэйгөө 92 хувьтай нийцэж байгаа.

Улсын хөгжлийн төлөвлөгөө зөвхөн төсвийн эх үүсвэрээс гадна бас бодлогын арга хэмжээнүүд тэргүүлэх чиглэлд туссан байдаг. Тэгээд энэ уялдаа, хуульд заасан уялдаа нь хангагдаж байгаа учраас Эдийн засаг, хөгжлийн сайдаас зөвшөөрлийг нь өгсөн байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Дамдинням гишүүний асуулт Эдийн засаг, хөгжлийн яамны асуулт дээр нэмэлт мэдээлэл. Гишүүд энийг нэлээн асуудаг юм Төсвийн хүрээний мэдэгдэл дээр байгаа энэ тоонууд чинь ямар учиртай юм бэ гээд. Тэгэхээр энэ бол төсвийн хүрээний энэ тоо бүр маань төсөвт тусгагддаг бодлогын арга хэмжээнүүдийн болон үйл ажиллагаануудын дандаа хязгаар тоонууд нь байдаг. Энэнээс хэтэрч болохгүй шүү гээд. Оруулж ирж байгаа төсвийн тоонууд маань энэ тоон дотроо багтаад ингээд орж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл, өрийн дээд хэмжээг хуулиараа бол 60 хувь хязгаар давж болохгүй гэдэг. Бид нарын оруулж ирж байгаа энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаар бол Эдийн засаг, хөгжлийн яамнаас 55 хувь гээд дахиад 5 хувийн нөөцтэй хязгаар орж ирж байгаа.

Сангийн яамнаас, Засгийн газраас оруулж ирж байгаа гүйцэтгэлийн дүн бол 42.6 буюу цаанаа дахиад 13 хувийн нөөцтэйгөөр төсөв.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Байз танхимд яг хэдэн сайд байна гараа өргөөдөх дөө. Тоолоодохъё.

Сангийн сайд Жавхлан, Хэрэг эрхлэхийн дарга Учрал, Боловсролын сайд Наранбаяр, Хууль зүйн сайд Алтангэрэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа, Засгийн газрын хяналтын асуудал эрхэлсэн сайд Одбаяр, Гадаад харилцааны сайд Батцэцэг, Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан, Боомтын асуудал эрхэлсэн сайд Тулга гэж. Бусад сайд нар яах вэ? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан байна.

Батсуурь сайд түр гарсан байна. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Тэргүүн Шадар сайд Гантөмөр, Шадар сайд Амарсайхан, Зам, тээврийн сайд Дэлгэрсайхан, Соёл, спорт, залуучуудын сайд Номин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан, 20 минутын хот асуудал эрхэлсэн сайд Эрдэнэбүрэн нар гадаад томилолттой байгаа тийм ээ? Бусад сайд нар орж ирэх ёстой. Эрчим хүчний сайд хаана байна? Батлан хамгаалахын сайд хаана байна? Одоо жилд ганц удаа хэлэлцэж байгаа улсын төсөвт сайд нар хүндэтгэлтэй хандана шүү. Салбарын асуудлууд ярина, эс үгүй бол энэ салбарын төсвийг танах ёстой юм уу? Ирэхгүй байгаа салбарын сайд нарын төсвийг танах ёстой юм уу? Учрал сайдаа би түрүүн хэлсэн 10 минут гэсэн. Яах вэ тал сайд нар орж ирэх шиг боллоо. Гэхдээ 10 сайдтайгаар төсөв хэлэлцэх хангалтгүй шүү. Энэ сайд нарыг дууд.

Хариулт өгье. Аудит хариулт өгөх үү? Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Я.Самбууням: Үндэсний аудитын газар Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Самбууням байна. Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд Үндэсний аудитын газраас дүгнэлт өгөхдөө нийт 15 зөвлөмжийг хүргүүлсэн байдаг. Үүнээс хэрэгжилтийг үнэлээд үзэхэд бол төсвийн ерөнхийлөн захирагчдад өгсөн төсвийн хязгаарыг хэтрүүлэхгүй байх, төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, хөтөлбөрийг тусгахгүй байх гэсэн зөвлөмж хэрэгжээгүйтэй холбогдуулаад нийт үнэлгээг бол 69 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байгаа.

Мөн хоёр дахь асуултад өмнөх оноос шилжин хэрэгжих дуусаагүй 130 төсөл, арга хэмжээнээс 2025 оны төсвийн төсөлд тусгаагүй дараах шалтгаантай төсөл хөтөлбөрүүд байна.

Нэгдүгээрт нь худалдан авах ажиллагааны тендер зарлаагүй, гүйцэтгэгч шалгараагүй 48 төсөл, арга хэмжээ.

Хоёрдугаарт, батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлэх санал ирүүлсэн 46 төсөл, арга хэмжээ.

Гуравдугаарт, санхүүжих дүн нь өмнөх онд батлагдаж, төсвийг нь оны эцэст барьцаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмж гүйцээж хариулъя. 3 дугаар микрофон.

Я.Самбууням: Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 13 төсөл, арга хэмжээ.

Дөрөвдүгээрт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан болон бусад шалтгаантай 23 төсөл, арга хэмжээ байна. Хариулт дууслаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дамдинням гишүүн тодруулж асууя.

Г.Дамдинням: Энэ аудитын дүгнэлтийн 3 дээр байгаа төсвийн төсөөллийн хамт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна гэсэн ийм дүгнэлт хийгээд байгаа байхгүй юу. Тодотгол дээр чиг л ийм байсан, энэ оны төсөв дээр чиг л бас ингээд орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яах ёстой юм бэ? Дахин дахин ингээд урт, дунд хугацааны болон богино хугацааны төсвийн сахилга батыг алдагдуулаад байна гэсэн дүгнэлтийг л танай байгууллага өгөөд байгаа юм. Энийг сахилга батыг нь сайжруулахад ер нь ямар арга хэмжээнүүд хийгдэж байгаа юм бэ? Яах ёстой юм? Нэг бол зүгээр л ийм мөр байх ёстой юм уу энэ тайлан дээр, дүгнэлт дээр, аудитын дүгнэлт дээр? Бид нар аудитын дүгнэлт л барина, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт барина, төсвийн шинжилгээ л барина шүү.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Ц.Наранчимэг: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Таны хэлснээр бид нар Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, төсвийн төсвийн дүгнэлтээр энэ асуудлуудыг дахин дахин дүгнээд байгаа нь Улсын Их Хурлаар тухайн нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийн төслийг хэлэлцэж батлахдаа, ингээд батлаад байгаа нь төсвийн удирдлагын зарчмыг алдагдуулаад байгаа тул бас анхаарах шаардлага байна гэдгийг тодотгож дүгнэж байгаа юм. Үгүй, үгүй ер нь энэ дээр анхаараач л гэдэг.

Д.Амарбаясгалан: Энэ аудитын дүгнэлтийн талаар бас Дамдинням гишүүн чухал зүйл хөндөж байгаа юм. Тэгээд аудит жил болгон л дүгнэлт гаргаж байдаг. Яг хэрэгжилт нь хэдэн хувьтай байна вэ гэдэг дээр эргээд дүгнэхгүй байгаад байгаа тал гарч байгаа. Тэгээд би бас өмнөх ээлжит бус чуулганы хуралдааны үеэр хэлж байсан Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байгаа аудитын байгууллага, Төрийн албаны зөвлөл, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллага үндсэн чиг үүргээ гүйцэтгэх чиглэл рүүгээ илүү ажиллана. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана гэсэн үг.

Тэгэхээр аудитын байгууллага ч гэсэн энэ дээрээ маш хариуцлагатай нэгдүгээрт,

Хоёрдугаарт, асуултад хариулахдаа тодорхой хариул. Одоо энэ Улсын Их Хурал нэг зүйлийг шаардаж байгаа шүү дээ. Илүү бөөрөнхий, ерөнхий байдлаар асуудалд хандахыг эсрэг явна. Бидэнд хаанаа ямар алдаа, дутагдал байна тэр бүгдийг засаж, залруулж асуудлыг нэг талд нь шийдвэрлэж явахын төлөө үүрэг хариуцлагатай ажиллана шүү.

Ялангуяа төрийн албан хаагчид Улсын Их Хурлын өмнө хүлээсэн чиг үүргийнхээ дагуу Улсын Их Хурал дотор үнэн, бодитой мэдээллийг өгөх үүргээ хангалттай биелүүлэх ёстой шүү гэдгийг бас хатуу шаардлага тавьж хэлж байгаа.

Ингээд Дамдинням гишүүний асуулт дууслаа. Сандагийн Бямбацогт сайд асуулт асуухаар байсан алга байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд, гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. 3, 4 асуулт байна. Энэ Үндэсний Баялгийн сангийн хүүгийн орлогыг яаж бүртгэж зарцуулж байгаа юм бэ? Үндэсний баялгийн сангийн тухай хууль гэж бий. Төсвийн төсөл дээр 55 тэрбумын хүүгийн орлого болохоор туссан байна л даа. Гэтэл Баялгийн сангийн хуулиар хүүгийн орлогын талаар тодорхой зохицуулалт тусгаагүй байгаа. Энэ 55 тэрбумаа хаана яаж ном журмаар нь бүртгэх вэ гэдгийг асуух гэж байгаа юм.

Хоёрдугаар асуудал, хоёр юм байна. Жишээлбэл, Шинээр барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ноогдох эсэх нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгасан эсэхийг шинжлээд үзэхээр нийт 21 төсөл байна. 21 төсөл, арга хэмжээ дээрх шаардлагын дагуу тооцоогүй тусгасан буюу Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь гэсэн заалтыг зөрчиж байна гэж үзэж байгаа юм. Энийг яаж та бүхэн маань ойлгож байгаа юм?

Нөгөө талдаа 2024 онд төсвийн тодотгол явсан. Гишүүд ээлжит бус чуулганы хуралдаад төсвийн тодотголтой холбоотой асуудлуудыг хөндсөн. 2028 онд хэрэгжүүлэхээр төсвийн тодотголд 48 төсөл оруулж өгсөн. Яах вэ эргээд харахаар одоо 2025 онд энэ 48 төсөл байхгүй. Энийг яах ёстой вэ? Энийг яагаад оруулаагүй бэ? Төсвийн

тодотголтоор оруулж өгсөн мөртөө 2025 оны төсөв дээрээ оруулж өгөөгүй байдлаар явсан бэ?

Дараагийнх нь асуулт. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн алдагдлыг 2 хувиас ихгүй байхаар зоож өгсөн. Яг одоо та бүхний оруулж ирсэн төсөл дээр 2.03 хувь гэж орж ирж байгаа юм. 2.03 хувь гэдэг бол бараг 30 гаран тэрбум төгрөгийн асуудал энд хөндөгдөж байна гэж ойлгож байгаа. Тэгээд энийгээ та бүхэн яаж ойлгож байгаа юм бэ?

Нэг том асуудал байна манай хуучин Барилга, хот байгуулалтын яам одоо Орон сууцжуулалтын яам гэж явж байгаа. Энэ сумууд чинь ерөөсөө сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө байхгүй байна. Тэрэнд зарцуулах мөнгө ч гэж алга. Энэнээс болоод газар олголтууд нь бүгд зогсчихсон, сумын хөгжлийн төлөвлөгөөнөөс улбаатай тухайн сумын хөгжил бүгд байхгүй болчихсон. Энийг 2025 оны төсөв дээр тусгаж өгөхгүй байсан юм уу? Одоо тэнд малчин иргэд газаргүй байна, тухайн сумд амьдарч байгаа иргэд чинь өөрсдөө газаргүй байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд ногоон тэжээл тарихаас авхуулаад олон асуудлуудыг бид нар шийдвэрлэхээр ажиллаж байгаа.

Гэтэл газар олголт нь байхгүй. Одоо энэ хавраас хойш ярьж байгаа асуудал. Энэ жил ахиад л ногоон тэжээлгүй болж байна. Энэ жилийн зуд, турхан дахиж үргэлжлэхээр шинжтэй байгаа. Энэ сумууд дээрээ бид нар сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг нь баталж өгөхөд, гаргахад тодорхой төсөв мөнгийг тухайн хариуцсан яамнаас нь тооцоод суулгаад өгчих боломж байгаагүй юм уу? Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам бид нар зуд турхан энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон асуудлуудыг бид нар өнөөдрийг хүртэл хөндөж ярьж байгаа. Өнгөрсөн 2024 онд томоохон үерүүд болсон, 23 онд бас үер болсон, дээрээс нь энэ жилийн зуд турхантай холбоотой асуудал. Радар-аа бид нар Монгол Улсын Засгийн газар дээр ярьж байсан. Хоёр ч радар-ыг Монгол Улсын баруун хэсэг, хойд хэсэг дээр байрлуулъя гээд. Ингэж байж өнөөдөр энэ уур амьсгалын өөрчлөлт, дээрээс нь цаг агаарын нөхцөл байдлыг урьдчилан мэдэхтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэе гэж яригдаж байсан. Шийдвэрлэж өгье гээд тухайн үедээ бол асуудлуудыг оруулж байсан.

Тэгээд энэ 2025 оны төсөв дээр байхгүй байна. Радар-аа бид нар байрлуулахгүйгээр цаашдаа энэ цаг уурын өөрчлөлттэй холбоотой асуудлууд, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлууд, урьдчилсан мэдээлэхтэй холбоотой асуудлуудаа бид нар мэдэж чадахгүй шүү дээ. Гамшиг нь урьдчилан сэргийлэх ажил дээр зарцуулагдсан 1 доллар, сүүлд үүсэх 7-8 доллартой тэнцдэг гэдэг үг байдаг. Тэгээд энэ радар-аа асуудлуудаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Батсуурь сайд хариулт өгөх үү? Хурууныхаа юуг уншуулсан юм уу? Батсуурь сайдын микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Монгол Улсын хэмжээнд 300 гаруй сумаас шинэ сумын төсөл хэрэгжсэн 3, сумын төвийн шинэчлэл, зураг хийгдсэн сумд бол 30 гаруй хувь байна. Бид бүхэн 90 суурин газрыг хүн амын тоогоороо 5000-аас дээш ч гэдэг юм уу, 69 сум, 21 аймаг гээд энэ төлөвлөгөөг энэ 4 жилд нь хийж дуусгана гэсэн ийм зүйлүүд байж байгаа.

Мөн энэ сумын төвийн шинэчлэл бол инженерийн дэд бүтцийн шугам хийгдсэн гэдгээрээ явах юм уу, бүүр иж бүрэн төлөвлөгөө гэдгээ ер нь асууж байгаа юм уу гэдгийг нь би бас танаас лавлаж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд хариулья.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ үер усны аюул бол жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь үнэн. Тэгэхээр энэ үерийн уснаас хамгаалах чиглэлээр бид 333 хөв цөөрөм байгуулах энэ санаачилгыг өрнүүлээд ажиллаж байна. Энэ ондоо багтаад ТЭЗҮ-нүүд, ерөнхий ТЭЗҮ-үүд гарна. Тэгэхээр энэ ТЭЗҮ-гийн дагуу бид нар бас энэ хөв цөөрөм байгуулах, сум болгонд хөв цөөрөм байгуулах, ялангуяа үерийн эрсдэлтэй газруудад энэ хөв цөөрөм байгуулах асуудлыг бол шийдвэрлэнэ. Энэ дээр манайх төсөв, хөрөнгө ер нь бага байгаа учраас олон улсын байгууллагад хандаж бас энэ хөв цөөрмийн асуудал дээр нэлээд асуудлуудыг шийдүүлж байгаа.

Ялангуяа энэ суурин газар, аймгийн төвүүд бас үер усанд нэрвэгдэх ийм их аюултай байгаа. Энийг сая би бас өөрөө газар дээр нь хэд хэдэн газар очиж үзсэн. Тэгэхээр энэний чиглэлийн дагуу бид энэ 25 он.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья.

С.Одонтуяа: Радар-ын хувьд бол бид энэ жил төсвөө бол бас Сангийн яаманд саналуудаа өгсөн. Гэхдээ энэ жил энэ том мега төслүүдэд анхаарна гэсний дагуу энэ жижиг хөрөнгө оруулалтууд бүгд хасагдсан байгаа. Энэ жил Өвөрхангай аймгийн Арвайхээр сумд яг энэ таны хэлсэн ус, цаг уурын радар-ын төсөв бол суусан байгаа.

Д.Амарбаясгалан: Санжаа дарга хариулья. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Үндэсний баялгийн сангийн тухай хуультай холбоотойгоор бол 3 сан байгаа. 3 сантай холбоотой бол мөнгийг Монголбанканд байршуулахаар бол хуульчилчихсан байгаа. Ингээд Монголбанкттай бол Замгийн газрын хувьд бол бас гэрээ байгуулчихсан байгаа. Энэ гэрээнийхээ хүрээнд бол бид нар бол 2025 онд тэр байршуулж байгаа хөрөнгөтэй холбоотойгоор 55 тэрбум төгрөгийн орлого орохоор бол тооцоолсон байгаа. Тэгээд энэ тооцоолсон орлогыг бол та Баялгийн сангийн тухай хуулийн төслийг харах юм бол 5 дугаар зүйл дээр тусчихсан байгаа. Энэ нь өөрөө яг тэр Монголбанкин дээр хуулийнх нь дагуу байршдагаараа тэр үндсэн данс дээрээ нэмэгдээд л ингээд явахаар бол тооцогдсон байгаа.

Төсвийн алдагдалтай холбоотой асуулт хариулсан. 2.03 гэдэг нь бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар бол 2025, 19.9 дээр 2025 оны төсвийн жилээс эхлэн төсвийн алдагдал ДНБ-ий 2 хувиас илүү

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

М.Санжаадорж: 2 хувиас илүүгүй алдагдалтай байна гэхихсэн байгаа. 2.03 гэдгийг бол бид нар бол төсөв дээрээ яаж явдаг вэ гэхлээр энэ Төсвийн тусгай шаардлагыг мөрдөх журам гэж байдаг. Журмыг Засгийн газар баталдаг, мөн төсвийг төсөвлөхтэй нь нэгжлэх тийм журам байдаг. Үүний дагуу жишээ нь сая төгрөгөөр бол бид нар тооцоонууд явдаг.

Яг төсвийн хууль дээр тэрбумчилсан төгрөгөөр явдаг. Өөрөөр хэлбэл хойд талын орнууд нь урагшаагаа ахидаг гэсэн үг. Тэгээд ахихлаар 2, 0 гэдэг тоонд бол ингээд барьж байна гэж үздэг.

Өмнөх жилүүд дээр бол бас яг ийм кэйсүүд байдаг. Яг энэ бол мөрдөөд явдаг ийм практик байгаа.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Хэдүүлээ хэд хэдэн төсөв хамтарч бас батлуулж байсан. Тэгэхээр ганцхан энэ төсвийн алдагдлын 2 хувь биш юм байгаа юм. Төсвийн хуулийн мэдэгдэл дээр байгаа 10-н тоо, хувь хэмжээ, абсолют дүн байгаа. Тэрийг бид бүхэлчилдэг ийм зарчмаар явдаг.

Өөрөөр хэлбэл, энийг бас өмнө нь нэг гиш гишүүн асууж байсан юм. 2 цэг 100-ны 3 гэдэг маш бага хэлбэлзэл. Өөрөөр хэлбэл 1.6-аас 2.4 ийм депозам дотор бол голчоороо 2 хувь гэж авч явна гэсэн үг. Тийм учраас зээлийн, өрийн хязгаар болон бусад хөрөнгө оруулалт, зардлын хязгаар, энэ тоон хувь хэмжээнүүд дээр бүгд дээр нь яг энэ сая Санжаадорж даргын хэлдэг ийм зарчмаар явдаг байгаа. Тийм учраас энэ бол тийм арифметик ойлголт гэх юм уу даа. Ийм зүйл байгаа.

Тэр хөрөнгө оруулалтын, хөрөнгө оруулалт дээр гарсан өөрчлөлт тоонууд дээр Дэлгэржаргал дарга нэмээд хариулаадах уу. Хойш хойштойгоо бас гишүүд асуудлууд давхардаж магадгүй учраас бүрэн мэдээлэл өгөөд явчихъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 17 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар. Дэлгэржаргал.

Төсвийн тухай хуулийн 29.3.5 дээр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг 3 жилд багтаан дуусгахаар санхүүжих дүнг хэрэгжих хугацаа нь тэнцүү хуваарилснаас багагүй байхаар тусгах хуулийн заалт байгаа. Аудитын дүгнэлтээр тусгасан төслүүдийн хувьд зарим томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд яг тэнцүү хуваарилаад тавьчихаар эхний жил бэлтгэл ажлууд худалдан авах, тендерээс шалтгаалаад тухайн жилийн дүнгээ бүтэн авахгүй ийм судалгаанууд гарч байгаа учраас ирэх жилийн зарим томоохон бүсчилсэн хөгжлийн эрчим хүч болон авто замын төслүүдээр бид нар хамгийн багадаа гэхдээ 20 хувиас багагүй байхаар, цаад талын хугацаа 27 онд ашиглалтад буюу 3 жилдээ багтаан дуусахаар тусгасан байгаа.

Тодотголоор нэмэгдсэн төслүүдийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд ТЭЗҮ, зураг, төсөвтэй холбоотой 9 төсөл, арга хэмжээ тусгагдсан. Тэдгээр төслүүдийн хувьд 24 ондоо бүтэн хэрэгжихээр буюу 25 он руу хуулиар шилжихгүй төслүүд байгаа учраас 24 ондоо хэрэгжиж дуусахаар батлагдсан. Тийм учраас 25 оны.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Нэг ийм л юм байна л даа. Өөрийн чинь хэлсэн Үндэсний баялгийн сангийн тухай 7 дугаар зүйл бол Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой асуудал байгаа юм. Монголбанк юу энд ямар хамаатай юм? Баялгийн сангийн тухай

хуулийн 10 дугаар зүйлээр Баялгийн сангийн хөрөнгийн зориулалтыг зоож өгсөн байдаг юм шүү дээ. Хүүгийн орлого гэдгээ та нар мөнгөн хөрөнгөд тооцож байгаа юм уу? Хүүгийн орлого гэдгийг та нар аягүй бөөрөнхийлж хариулаад байна гэж би харж байна. Тэгэхээр хүүгийн орлого гэдгийг мөнгөн хөрөнгөд тооцож байгаа бол Баялгийн сангийн 10 дугаар зүйлээрээ тодорхойлогдоод явах, үгүй бол яах юм бэ л гэдэг асуудал байгаад байгаа юм.

Хоёрдугаарт, Батсуурь гишүүний хувьд сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө байхгүй, Энхманлай дарга бас байгаа байх. Энд хариулах байх. Газар зохион байгуулалт ерөөсөө хийгдэхгүй байна л гэж хэлээд байгаа юм. Энийг яаж зохицуулах вэ? Радар-ын хувьд Өвөрхангай аймгаас илүүтэй баруун хойд аймгууд дээрээ тавьж байж Одонтуяа сайдаа энэ чинь та нар мэдээллээ авна шүү дээ. Хаа байсан Өвөрхангай аймаг тэр радар-аар ер нь ямар хамаа байна. Ний нуугүй.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Төв банкин дээр бид нар эрсдэлээ тооцож бидний Монгол Улсын маань хамгийн найдвартай л ийм санхүүгийн институт юм байгаа юм. Тийм учраас тэндээ хадгалуулдаг, байршуулдаг. Хуулийнхаа зарчим шаардлагуудыг биелүүлж байна гэсэн үг.

Хүүгийн хувьд Бат-Эрдэнэ гишүүнээ ийм шүү. 24 оны хүүгийн орлого 25 оны баялгийн сангийн дансны суурь үлдэгдэл болоод явна. 25 онд орж ирэх хүүгийн орлого 26 оны Баялгийн сангийн дансны суурь үлдэгдэл болоод явна. Өөрөөр хэлбэл, ирэх жил орох орлогын хүүгийн орлогыг бид нар зарлагадаа бол тусгадаггүй гэсэн үг. Тийм. Ийм зарчмаар явах нь зөв. Энэ нь ч өөрөө эрсдэл багатай гэсэн үг. Баялгийн сангийн хэмжээ бас өсөж, буурдаг. Өөрөө энэ бол тогтмол тийм үзүүлэлт биш. Дүн байдаггүй. Тийм учраас орж ирэх орлого нь ч гэсэндээ энийгээ дагаад мөн л бас хэлбэлзэлтэй байдаг учраас энд тааруулж зарлага тавина гэдэг маань өөрөө бас эрсдэлтэй. Тийм уч.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд нэмж хариулъя.

С.Одонтуяа: Энэ жил манай салбарын төсөв бол нэлээд хасагдсан. Хасагдсан нэн том шалтгаан байгаа. Энэ нь юу вэ гэхээр та сайд байхдаа НҮБ-ын цөлжилтийн хурлыг Монголд хийнэ гээд тохирчихсон. Энэний дагуу Монгол Улсын Засгийн газар дээр маш том ачаа ирж байна. Энэний зардал ер нь бараг 100 тэрбумаар хэмжигдэх байх. Тэгээд энэ бол үнэхээр Засгийн газрын хамгийн том толгойны өвчин. Энийг хийхээс аргагүй. Нэгэнтээ л та очоод тохирчихсон юм чинь. Тэгэнгүүт одоо Засгийн газар дээр энэ хурлын бэлтгэл ажиллаад л одоо бараг төсвөө гаргавал их юм болчхоод байна. Манай салбарын бүх төсөв хасагдсан. Тэгээд л тэр чи тэр НҮБ-ынхаа хурлыг л нэг яаж ийгээд хийгээд, тэгээд энэ жил тэр хурлын бэлтгэл гээд 50 тэрбум төгрөг тавигдсан байж байгаа.

Тэгэхээр энэ гол хүндрэл болоод байна. Тэрнээс биш бид бол тэр хэчнээн радар-аар маш олон юм бол авах боломж байсан. Тэгээд энэнээс болоод манай салбарын хамаг төсөв хасагдсан байгаа. Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайдаа наад радар-ын асуудал чинь Засгийн газрын нөөц хөрөнгөөс өнгөрсөн хугацаанд шийдэгдсэн санагдаад байх юм. Жавхлан сайд энэ дээр та тодруулж хариулж өгөөч. Энэ цаг агаарын мэдээллээ урьдчилан мэдээлэх радар-

ын асуудлыг Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс шийдсэн байгаа. Дэгээ барина шүү. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм. Одоо бид нар ер нь жил ирэх тусам л энэ гамшгийн асуудал, энэнээс урьдчилан сэргийлэх асуудлууд нэлээн хурц асуудал болж ирж байна тийм. Тэгээд энэ дээр Засгийн газар одоо нэлээн онцгой анхаарч байгаа. Өмнөх Засгийн газрын үед ч гэсэн энэ асуудал нэлээн хурц яригдаад тухайн үед төсөв дээр байгаагүй хэдий ч Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаад ингээд эхлүүлсэн байгаа. Энэ маань ирэх 24 онд ч тэр, 25 онд ч тэр үргэлжлэх төслүүд нь явж байгаа. Харин шинээр барих асуудлууд бол ирэх жил Бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлал, хөрөнгө оруулалтынхаа зарчмаар аль ч ерөнхийлөн захирагч нар дээр шинэ зүйлүүдийгээ 1 жил хойшлуулъя гэдэг энэ зарчмын хүрээнд хойшилсон байгаа. Эхэлсэн зүйлүүд бол явж байгаа. Эхэлсэн радар-аар явж байгаа шүү. Бат-Эрдэнэ сайдын үед бас нэлээн санаачилж ингэж гаргасан төслүүд, эхэлсэн зүйлүүд явж байгаа.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна. Алга байна.

Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн асуултаа асууна.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Төсөв өөрөө тэлж ерөөсөө болохгүй. Монгол Улсын төсөв 10 их наяд орчимд байх ёстой гэдэг зүйл байхгүй л дээ. Тэлж болно. Гэхдээ тэлэхдээ үр ашгаа үзүүлдэг л байх ёстой. Сангийн сайд Жавхлан сайд томилогдсоноос хойш одоо Монгол Улсын төсөв даблдаад олон дахин нэмэгдсэн. Төсвийн үр ашгийнхаа дүн шинжилгээг ер нь хийсэн юм болов уу гэж? Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-д төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтгээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүрэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг төсвийн бусад байгууллагад 3-аас 5 жил тутамд 1 удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж үр дүнг Засгийн газарт танилцуулна гэдэг ийм заалттай. Энэ ерөөсөө хэрэгждэггүй нэг ийм заалт байгаа. Одоо би энд сууж байгаа яг сайд нараас тухай бүрд нь Их Хурлын даргаа яг сайд нараас хариулт авмаар байгаа юм. Эрүүл мэндийн сайд одоо сууж байна. Бид 2 Хан-Уул дүүргээс сонгогдсон. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв дээр чинь хамгийн сүүлийн үеийн жишээ бээлий ч үгүй байна шүү дээ тэнд эмч нар. Тэнд яг юу болоод байгаа юм? Тэгээд тэр төсвийн зарцуулалт, үр ашиг нь яг хаана очоод байгаа юм? Энэ тухай Эрүүл мэндийн яаман дээр тэр харьяа агентлагууд, төсвийн байгууллагууддаа дүн шинжилгээ хийгээд энийгээ Засгийн газарт танилцуулсан зүйл байдаг юм уу? Энд байгаа бүх сайд нарыг хариулаад өгөөсэй гэж бодож байгаа юм.

Сангийн сайдын хувьд яг энэ Монгол Улсын үүцний үүдэнд нь сууж байгаа хүний хувьд таны үед гарсан энэ том том хулгайнууд энэ дээр ер нь хаана асуудал үүсээд байна? Энэ төсвийн сахилга батын асуудал? Энэ дээр дүн шинжилгээ ер нь хийж үзсэн байдаг юм уу? Хэрхэн сэргийлэх вэ, яах вэ гэж.

Яагаад гэхээр ингээд төсөв тэлээд төсвийг нэмж болно. Бид нар том том зорилго тавиад, том том асуудлуудаа шийдье гээд явж болно. Тэгэхдээ бид нар энэ таны үед болсон том том хулгайнууд их олон хулгайнууд байгаа шүү дээ. Энэ дээр ямар дүн шинжилгээ хийсэн бэ? Дахиад 35 их наяд төгрөг, хулгай гарсныхаа дараа сонгогд хийдэг улс болчихоод байна л даа.

Тэгэхээр энэ дээр Сангийн сайдын хувьд ямар дүн шинжилгээ хийсэн? Тэгээд энэ одоо яг байгаа сайд нараас бүгдээс нь асуумаар байгаа юм. Яг энэ дүн шинжилгээ хийгээд Засгийн газартаа танилцуулсан түүх байна уу, тэгэх үү? Тэгэх бол хэзээ, яаж гэдгээ бас тодорхой хэлмээр байна. Яг энэ үр ашгийнх нь, үр ашгийг нь дүн шинжилгээ хийсэн. Төсөвт тэлээд тэр чинь томроод л байдаг, томроод л байдаг ямар ч үр ашиггүй байдал байж болохгүй шүү дээ.

Тэгээд энийгээ дүгнэдэг байх хэрэгтэй. Дүгнэсэн юм уу гэдэг нэг асуудал. Дүгнэх юм уу, хэзээ гэдгээ яг тодорхой сайд нар хэлээд өгөөч. Тэгээд байхгүй, танхимд байхгүй байгаа сайд нарыг дуудаж бас асуумаар байна. Их Хурлын дарга яг сайд болгоноос асуугаад өгөөрэй. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Мөнхсайхан сайд.

Т.Мөнхсайхан: Гишүүний асуултад хариулъя.

Тэр Хан-Уул дүүрэгт, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв дээр үүсээд байгаа асуудал бол төсөв мөнгө гэхээсээ илүү байгууллагын удирдлага зохион байгуулалттай холбоотой үүсэж байгаа асуудал юм билээ. Тэгээд санхүү, төсөв мөнгөний хувьд Эрүүл мэндийн даатгалын сан хүнд байдалд байгаа гэдгийг энэ Эрүүл мэндийн сайдаар томилогдсон өдрөөс хойш л ярьж байгаа.

Гэхдээ өнөөдрийн байдлаар ямар нэгэн байдлаар эмнэлгийн эмч, ажилчдын цалин мөнгө, урамшууллыг тавьж чадахгүй хэмжээнд өнөөдөр нөхцөл байдал тийм дээрээ хүрээгүй байгаа. Тэгэхээр энэ бол илүү их байгууллагын удирдлагын санхүүгийн сахилга бат, дотоод менежмент зохион байгуулалттай холбоотой үүсэж байгаа асуудал болов уу гэж бодож байгаа. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн удирдлагыг шууд томилдог, шууд эрх мэдэл нь байдаг газар Нийслэлийн эрүүл мэндийн газар шүү дээ.

Тэгээд Нийслэлийн эрүүл мэндийн газар нь Нийслэлийн захирагчдаа захирагддаг. Тэгэхээр бид нар Эрүүл мэндийн яамнаас бол Нийслэлийн эрүүл мэндийн газарт энэ Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв дээр хурдан шуурхай ажил дээр, нөхцөл байдал дээр нь, газар дээр нь очиж танилцаж хурдан шуурхай арга хэмжээ авч, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна гэдэг энэ албан тоот бичиг юмаа хүргүүлчихсэн байж байгаа. Тэгэхээр энэ дээр Нийслэлийн эрүүл мэндийн газрынхан арга хэмжээгээ авч ажиллах болов уу гэж ингэж харж байна.

Эрүүл мэндийн яамны хувьд бол эрүүл мэндийн салбарын төсөв мөнгөний хувьд одоо бид нар байнгын энэ төсөв мөнгөн дээрээ хяналт, үнэлэлт, дүгнэлт хийж ажиллаж байна. Ингээд өнгөрсөн 3 жилийн хугацаанд төвлөрөх ёстой байсан 218 тэрбум төвлөрөөгүйгээс үүдэлтэй оны төгсгөл рүү ер нь цалин мөнгөө тавьж чадахгүй байх хэмжээний ийм эрсдэл учрахаар байгаа гэдгийг бол байнгын Засгийн газрын хурал дээр хэлж, танилцуулж явж байгаа.

Цаашдаа ч ер нь энэ төсөв мөнгийг хамгийн гол нь үр ашигтай зарцуулах талаас нь бид нар оновчтой бодлого хэрэгжилтүүдийг хийж, ялангуяа Эрүүл мэндийн даатгалын сангийн энэ зарцуулалтыг бид нар илүү их үр өгөөжтэй болгох дээр даатгалын сан болон эрүүл мэндийн байгууллагууд дээр бид нар тодорхой бодлого, арга хэмжээнүүдийг авч ажиллавал үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж байгаа юм байна лээ.

Нөгөө талдаа бид нар энэ салбарт зарцуулагдах гол санхүүжилтийг хийдэг даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, дээшлүүлэх бодлого Эрүүл мэндийн даатгалын тухай хууль дээрээ бид шинэчилсэн найруулга хийж, ингэж бодлогын томоохон арга хэмжээ авч явахгүй бол энэ орлого, эх үүсвэр талдаа байнгын дутагдалтай яваад байгаа учраас өнөөдөр эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө нь, урамшууллын асуудал ер нь шийдэгдэхээргүй байгаа.

Тэгэхээр бид нар хоёр талаас нэгдүгээрт, санг зузаатгах, орлого талаас нь, нөгөө талаасаа даатгалын сангийн үр, өгөөжтэй зарцуулалт талаас нь бодлогын түвшинд маш сайн хэмнэлт, зохицуулалтыг хийж ажиллавал бид нарт их боломжууд байна л гэж харж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулья.

Б.Жавхлан: Лодойсүрэн гишүүний асуултад хариулья.

Эхний асуудалтай санал нийлж байна. Ер нь төсөв өөрөө энэ эдийн засгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн өсөлтийн үржүүлэгч нь байх ёстой төсвийн өөрийнх нь бас суурь хоёр зарчмын нэг нь,

Нэгдүгээрт, төрийн үйл ажиллагааг таслалгүй байх, санхүүжүүлэх бүрэн үүрэгтэй. Ийм үндсэн 2 үүрэгтэй гэсэн үг. Харин дотроо бид нар алийг нь урагш нь түлхэх вэ, алийг нь багасгах вэ, алийг нь оролцоог нь зохистой хэмжээнд байлгах вэ гэдэг бол төлөвлөлт, энэ урт хугацааны бидний алсын хараа энэ бүх зүйлүүдтэйгээ уялдаж байх ёстой ингэж. Эхний асуулт.

Хоёрдугаарт, ийм байгаа шүү Төсвийн тухай хуулийн 14.2.11 дээр байгаа таны тэрүүний хэлдэг заалт. Энэ дээр Засгийн газар өөрөө дотроо маш том функцтэй. Энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, дээрээс нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бид нар бүр бие даасан сайдтай болсон Лодойсамбуу гишүүнээ, сайдтай болсон байгаа. Тэн дээр бүх хяналт тавих.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья Жавхлан сайд.

Б.Жавхлан: Инженерчлэлийн энэ хяналт тавих загварчлалын асуудлууд, процесс өөрөө яг ингээд шинэчлэл нь явагдаж байгаа. Өөрөөр хэлбэл, бүх сайд, төсвийн ерөнхийлөн захирагч нарын үүрэг функц дотор ард, олон нийтэд ээлгүй, давхардал ихтэй, үр ашиггүй зардал гаргаж байгаа ийм ямар функц, үүргүүд байна? Энийг нь арилгах, танах, хязгаарлах энэ процессууд яг ингээд хийгдээд явж байгаа. Сайд бүрийн хувьд Засгийн газар дээрээ тайлагнах үр дүнгээ тооцуулах энэ бүх зүйл жил бүр хийгддэг Лодойсамбуу гишүүнээ, жил бүр хийгдээд энийг ингээд бүр сайд бүрээр нь үнэлгээг нь гаргаад, бүр ингээд дарааллыг нь тавиад, хамгийн үр дүнтэй ажилласан нь энэ яам байна, энэ төсвийн ерөнхийлөн захирагч байна гээд бүх зүйл ингээд энэ ном журмынхаа дагуу энэ хууль хяналт, хяналт шалгалтынхаа хүрээнд явагддаг байгаа гэдгийг хэлье. Шаардлагатай гэвэл энэ мэдээллүүдийг бас хүргүүлж болно.

Сүүлийн 4-5 жилийн хугацаанд гарсан энэ нийгмийг цочроосон.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья Жавхлан сайд.

Б.Жавхлан: Томоохон энэ хэрэг ялангуяа уул уурхай чиглэлийн, нүүрсний чиглэлийн болон Хөгжлийн банк гээд энэ бүх зүйлүүд дээр Засгийн газар өөрсдөө шүгэл үлээгч үүрэг гүйцэтгэсэн гэдгийг би бүүр тодруулж хэлье. Бүх зүйл дээр шүү. Хөгжлийн банкныг Засгийн газар энийг өөрсдөө асуудлуудаа гаргаж тавьсан. Бүх энэ нүүрстэй холбоотой болон бусад олон зүйлүүд дээр шаардлагатай, хатуу ч гэсэн шат дараатай арга хэмжээнүүдийг авсны үр дүнд өнөөдрийн энэ эдийн засгийн бас хонгилын үзүүрт гэрэл харагдаж байгаа энэ тогтвортой байдал бий болсон.

Ялангуяа Хөгжлийн банкин дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хэдхэн алхмын цаана байсан Монгол Улс өөрөө Хөгжлийн банкаа дагаад дефолт зарлах энэ эрсдэлээсээ бид нар гарч чадсан. Бид 25, 26 онуудад хуваарьт томоохон өр төлбөрүүдээсээ бид зохицуулалтаа амжилттай хийж чадсан. Тэрний үр дүнд өнөөдөр бид зээлжих зэрэглэлийнх нь 3 компанийнхаа 2 дээр нь ямар ч байсан үнэлгээ маань тодорхой хэмжээнд бас.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн. Одоо хэн Бямбацогт сайд, хариулъя.

С.Бямбацогт: Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя. Батлан хамгаалах салбарын хувьд үндсэндээ төлөвлөсөн зорилт арга хэмжээгээ хэрэгжүүлэхэд хуваарилагдаж байгаа төсөв бол дөнгөж 5 хувийг нь хангахаар байгаа. Бид 100 хувь гэж үзэх юм бол үндсэндээ хийх ажлынхаа. Дэлхийн батлан хамгаалах, улс орнуудын батлан хамгаалах салбартаа зарцуулж байгаа зардлуудыг энхийг сахиулах судалгааны хүрээлэлд гаргасан байдаг юм. 145 орноос Монгол Улс 140-д ордог. ДНБ-ийхээ 0.6-аас 0.7 хувийг л батлан хамгаалах салбартаа зарцуулж байгаа Монгол Улс. Дэлхий бол тэгвэл үндсэндээ хамгийн багадаа 2 хувь, дээшлээд үндсэндээ Израил, Орос гээд улсууд 10, 15 хувиа батлан хамгаалах салбартаа зарцуулж байна. Ийм л байдалд байгаа.

Тэгээд үндсэндээ бол үндсэндээ манай батлан хамгаалахын салбарын зардал зүгээр дусааж байгаа төдий л байдаг юм байна лээ. Хууль сахиулах салбартай харьцуулахад 400 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт 24 онд хийгдсэн бол.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Маш товчхон хариулъя. Ер нь жил бүр энэ төсвийн ерөнхийлөн захирагч буюу сайд тухайн жилийнхээ төсвийн гүйцэтгэлийн тайланд Үндэсний аудитын газраар заавал дүгнүүлж дүгнэлт гаргуулдаг, түүний дагуу сайжруулах төлөвлөгөөнийх нь дагуу ажилладаг. Үүнийхээ дагуу арга хэмжээ авч явдаг.

Боловсролын салбарын тухайд бас гүйцэтгэлд суурилсан, мөн хувьсах зардлын ийм тогтолцоонд шилжчихсэн байгаа. Тэгээд гүйцэтгэлд суурилсан энэ үнэлгээ бол боловсролын салбартаа ингээд ороод бүх ажиллаж байгаа хүмүүсийнхээ ажлын гүйцэтгэл дээр нь үнэлсэн ийм урамшууллын тогтолцоонд орсон байдаг юм. Тэгээд түүрүүнд бас бас хариулсанчлан Засгийн газрын өмнө сайд болгон өөрийнхөө хийсэн ажлыг тайлагнаж ингэж явдаг.

Чиг үүргийн шинжилгээ юмыг бол үнэхээрийн Төрийн албаны зөвлөлтэй хамтран эд нар хийх ийм шаардлага байгаа гэж харж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулъя. Бүх сайд хариулах нь байна тийм ээ.

О.Алтангэрэл: Сангийн яаман дээр бодлогоор шинжилгээ хийж байгаа. Дээрээс нь бидний хувьд өнгөрсөн жилийн гүйцэтгэл дээрээ суурилж төсвөө төлөвлөдөг. Түрүүний тэр харин өнгөрсөн жилүүдэд гарсан хулгайтай холбоотой асуудал дээр Засгийн газар авлигатай тэмцэх чиглэлээр бодлогоо гаргаж байгаа. Авлигын эсрэг багц хуулиудын төслүүдийг Засгийн газарт танилцуулчихсан байгаа.

Тэгэхээр эдгээр хуулиудын хэрэгжилт, эдгээр хуулиуд хэрэгжээд эхэлбэл Монгол Улс авлигатай тэмцэх, сая гишүүний хөнддөг энэ асуудлууд цэгцрэх, яг энэ хууль бус хөрөнгүүд улсын төсөвт төвлөрдөг болох ийм нөхцөл бололцоо нээгдэнэ гэж үзэж байгаа учраас бас гишүүнийг энэ асуудал дээр дэмжиж ажиллахыг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батсуурь сайд хариулья.

Ж.Батсуурь: Манай яамны нэр хуучин Барилга, хот байгуулалтын яам байсан. Одоо Хот, байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам болсон. Тийм болохоор одоогийн барилга хотын чиглэлийн асуудлуудыг бид нар өнөөдрийн түвшнийг нь бүгдээрээ мэдэж байгаа. Ирэх 4 жилд бол хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын чиглэл дээр хамгийн өндөр өөрчлөлт гарсан ийм салбар байх болно. Хүрээгээ тэлсэн ийм салбар байх болно гэж хариулья.

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд хариулья. Бүх сайд нараас асууж өг гэсэн чиг үүрэг, процесс, төсөв санхүүжилт.

С.Одонтуяа: Тэгэхээр ер нь 3 үндсэн чиг үүргээр ажиллаж байгаа. Нэгдүгээрт, энэ уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж биднээс хамаарахгүй маш том хүчин зүйлүүд байгаа. Энэ дээр Монгол Улс яаж дасан зохицох юм бэ, энэ ирж буй гай гамшгийг бид яаж гэтлэх юм бэ гэдэг дээр асуудал байна.

Хоёр дахь нь хүний хүчин зүйлээс шалтгаалж байгаа энэ асуудал дээр бол онцгой анхаарч ажиллана.

Гурав дахь нь яаралтай ногоон эдийн засаг руу, ногоон эрчим хүч рүү шилжих гэсэн ийм гол 3 үндсэн чиглэл рүү ажиллаж байна.

Энэ жилийн хувьд манайх би түрүүн бас зовлонгоо хэлсэн. Хөрөнгө оруулалт дээр юм тавигдаж чадаагүй. Энэ радар-аар жишээлэхэд 9 арав.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Баатархүү сайд хариулья.

Ц.Баатархүү: Лодойсамбуу гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Төсөв бол тоогоор илэрхийлж байгаа хөгжлийн бодлого, баримт бичиг гэж ойлгодог. Хамгийн гол нь манай яам төрийн энэ үйлчилгээг иргэдэд ямар ч чирэгдэлгүй, орон зайн ялгаатай байдлаасаа болж ялгаатай үйлчилгээ авдаг биш, гэрээсээ гэрт ойрхон цахимаар авах энэ үйлчилгээг хүргэх чиглэлдээ үндсэндээ ажилладаг.

Хоёрдугаар гол чиглэл энэ цахим буюу дижитал эдийн засгийг бий болгох, эдийн засгийн бүтцийг солонгоруулах ийм зорилготой ажиллаж байгаа. Дэлхийн нийт улсуудын эдийн засгийн бүтцийг авахад технологид суурьтай бүтээгдэхүүн үйлчилгээний эзлэх хувь 10 хувьтай байгаа бол Монгол Улс ДНБ-д эзэлж байгаа хувь 2-оос 3 хувь байна. Энэ эко системийг бүрдүүлэхийн төлөө яамны зүгээс ажиллаж байгаа.

Төсвийн үр ашгийн шинжилгээг тогтмол хийж байгаа. Шуудхан хэлэх юм бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хөрөнгө оруулалтын төсөв.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Тулга сайд хариулъя.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхлээр төсвийн үр ашгийн шинжилгээ манай салбарт хэрхэн яаж хийгдэх вэ гэж асууж байх шиг байна. Тэгэхлээр бид бол бас харьцангуй шинээр байгуулагдсан ийм Үндэсний Хороо. Нэг агентлагтаа ажилладаг.

Тэгэхлээр энэ дээр гарч байгаа зардлыг аудит орж хянаж, тухай бүрд нь графикт аудитын дүгнэлт гардаг. Энэний дагуу ажилладаг. Ер нь жилээс жилд бас энэ боомтын сэргэлтийн хүрээнд бас энэ боомтын үйл ажиллагааг өргөжүүлэхэд бол бас боловсон хүчин, энэний дутагдал байгаа.

Тэгэхлээр одоо байгаа боловсон хүчний зардал мөнгөө илүү үр дүнтэй ашиглах тал дээр бол бид нар бас санаачилга гаргаж ажиллаж байгаа.

Ер нь цаашдаа энэ боомт дээр явагдаж байгаа үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог түлхүү дэмжих ийм эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар төсөв дээр ирэх дарамтыг харьцангуй бууруулж, эргээд яах вэ гэхлээр боомтын үйлчилгээг сайжруулах, худалдааг хөнгөвчлөх, нэмэгдүүлэх энэ чиглэлд бол бас хувийн хэвшлийн оролцоотойгоор сайжруулахаар ажиллаж байгаа .../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Болсон уу? Лодойсамбуу гишүүн тодруулъя гэж байна. Зарим сайд нар хариулаагүй байгаа шүү дээ.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Энэ нөгөө үг дамжиж тоглодог тоглоом шиг сүүлдээ юу ч болоод явчихна. Төсвийн гүйцэтгэл биш энэ үр ашгийг л асуугаад байгаа юм л даа. Үр ашигт нь дүн шинжилгээ хийсэн юм уу, үр ашигтай байна уу энэ хөрөнгө оруулалт чинь эдийн засаг, нийгэмдээ? Энийг л тодорхойлсон юм уу гэж асуусан.

Тэгээд цаашдаа яаж тодорхойлох юм бэ гэж асуусан. Тэгээд Сангийн сайдаас дахиад тодруулаад асууя. Одоо энэ яг энэ үр ашигтай байна гэж үзэж байгаа юу үгүй юү? Одоо энэ төсвийн тэлэлт чинь хулгайн тэлэлт болчих вий дээ гэдэгт л санаа зовоод байгаа юм л даа. Энэ их төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдээд, төр нь өөрөө хариуцах мөнгө нь нэмэгдэхээр чинь. Эдийн засгийн асуудлаас гадна энэ чинь ингээд бөөн авлига, хулгайн л эх үүсвэр бий болчих вий дээ. Энэ дээрээ бодитой дүн шинжилгээ хийсэн юм уу? Тэгсэн бол ямар хариу гарсан бэ, тэгээд яаж энийгээ шийдэж сэргийлье гэж байгаа юм бэ л гэдэг юм? Маш тодорхой асуугаад байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Одоо жишээ нь энэ жил 5.3 их наядар төсвийн зардал талдаа нэмэгдэж байгаа юм. Задлаад харах юм бол 3.5 их наяд нь урсгал зардал байгаа юм. 3.5.2.5 нь ерөөсөө яг статистик, үнэ, тариф, инфляцтай холбоотой шууд нэмэгдэл. Урсгал зардал шууд нэмэгдэл

автомат тавигдана. Хэрвээ энийг багасгах юм уу, танах юм бол төрийн үйл ажиллагаа хаа нэг газар тасалдана гэсэн үг. Энэ нь нийт 3.5-ын чинь бараг 70 хувь нь, үлдсэн 30 хувь нь 2 зүйл дээр байгаа юм.

Нэгдүгээрт, энэ салбар салбарын хууль тогтоомжууд дээр орсон заалтуудтай холбоотой, бас шууд төсвөөс хамаарч чаддаггүй, бид нар бас хязгаарлах гээд дийлдэггүй. Тэр нь голцуу жоохон нийгмийн, нийгмийн хангамж, яг хүний нөөцийн чиглэлийн цалин хөлс болон бусад тусламж, тэтгэмж гээд ийм зардлууд байдаг. Тэр нь шууд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья.

Б.Жавхлан: Энэ нь ингээд 15 хувь. 15 хувь нь энэ үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөрүүд байгаа юм. Одоо Тэрбум мод, эрүүл мэндийн салбарын, хүнсний аюулгүй байдал, Цагаан алт гээд. Эдгээр зүйлүүд шууд холбоотой зардлууд нь ингээд 15 хувь. Ингээд 100 хувь нэмэгдэж байгаа яг хувиар харах юм бол ийм зүйл байгаа.

Тэрнээс биш энэ дээр ямар нэг Сангийн яам төсөв өөрөө энэ дээр нэмэлт зардлууд зохиогоод юм уу хийсвэрлэж тавьдаг зүйлүүд огт байхгүй. Хөрөнгө оруулалт тал дээр 1.7 их наядаар нэмэгдэж байгаа 24 оноос. Түүний 1.2 хувь нь жишээ нь Нийслэл дээр, орон даяар нэмэгдэж байгаа нь 500 тэрбум байх жишээний. 1.2 нь их наяд шүү. 500 нь орон даяар.

Тэгэхээр үр ашигтай байна уу, үгүй юу гэдгийг нь төсөл, хөтөлбөр бүрээр нь харах юм бол бас тусдаа нэлээн цаг авахаар ийм асуудлууд.

4 жилийн хөтөлбөр. жилийн төлөвлөгөө, төлөвлөгөө дотроо дахиад эрэмбэлэх асуудлууд байна. Хөтөлбөр.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр ер нь энэ улсын төсвийг ингээд хараад үзэхээр Монгол Улс маш хурдтайгаар доошоо уруудаж байгаа юм шиг мэдрэмж надад төрөөд байна. Тэгээд бүх сайд нар, гишүүдийн яриаг нь харахаар бүгдээрээ л төрийн өмчит энэ том төсвийг багасгая, тэгээд бизнесийнхэндээ эрх чөлөө олгоё гэж ингэж яриад байгаа юм. Тэгсэн хэр нь яагаад яг начир дээрээ Сангийн сайд ийм том төсөв ахиад бариад орж ирж байгаа юм бэ? Тэгээд 1 зүйлийг бас ингээд харахаар би сая 19 аймгаар ер нь явж орон нутгуудтай бас ингээд яг ажил хэрэг болгож танилцаж үзлээ. Тэгээд эндээс ингээд харахаар сайд нарын төсөвт дандаа барилга, байгууламж барина. гэсэн байдлаар ороод ирчихсэн байгаа юм. Тэгээд ганц барилгаа бариад энэ чинь дуусчихгүйгээр урсгал зардал нь ахиад дараа жил нэмэгдээд ороод ирдэг.

Тэгэхээр энэ урсгал зардлыг бид нар яаж тооцох ёстой юм бэ? Бид нар ингээд бүтээмжийг нь харахгүйгээр зүгээр л ийм хүслийн жагсаалт шигээр, жил болгон ёс юм шигээр энэ асуудлуудыг байнга оруулж ирээд байгаад байна.

Тэгэхээр одоо улсын төсөвт байгаа бид нарын энэ урсгал зардалтай холбоотой асуудлуудыг хумих боломж нь ер нь юу байгаад байгаа юм? Таны саяын ингээд тайлбар дээрээс харж байхаар бид нар дараа жилээс л энийгээ цэгцэлж чадах юм шиг юм ярьж

байна шүү дээ. Одоо дөнгөж тэр бүтээмжийн тухай асуудлуудыг нь шийдвэрлээд явж болно гээд.

Гэхдээ өнөөдөр бид нар харсаар байж байж, бөөндөө ингэж сууж байж энэ асуудлыг батлаад явуулчихна гэж үү? Бид нарт зогсох боломж байхгүй байгаа юм уу? Анхны хэлэлцүүлэг учраас энийг танаас асууя гэж бодож байна.

Хоёрдугаар нэг асуудал бас байна. Утааны тухай асуудал ер нь бүх гишүүд ярьж байгаа юм. Тэгээд энэ дээр нэг зүйл зайлшгүй ярих ёстой юм нь утаа бол өөрөө эрчим хүчний хомсдоллоо. Тэгэхээр энэ эрчим хүчний хомсдолтой холбоотойгоор ерөөсөө дулаан болон халаалтын тухай асуудал бид нар зайлшгүй ярих ёстой.

Тэгэхээр сая 24 оны 8 сард болохоор Тавантолгой түлш компанийг Нийслэлийн өмчит болгосон. Энэнтэй хамт 1.2 их наяд өр төлбөр нь Нийслэл рүү шилжээд явсан. Ер нь энэ өөрөө өр төлбөртэй ямар ч бүтээмжгүй ажилладаг энэ компанийг бид нар ингэж амьтай байлгаад байх ёстой юм уу? Энэний жишээ нь өр төлбөр нь Нийслэл дээр шилжсэн гэж байгаа ч гэсэн цаашдаа энийг ер нь яаж барагдуулах юм?

Ер нь энэ Тавантолгой түлш гэдэг компанитай холбоотой гарсан ганц санхүүгийн гэхээсээ илүү хүний амь эрсэдсэн том асуудлууд байгаад байна. 2023 он гэхэд 3000 хүн угаартаад, 61 хүн амь насаа алдсан. Энийг хэн ч ерөөсөө ярьдаггүй шүү дээ. Тэгээд бид нар цаашдаа энийг яах юм гэдэг асуудал дээр тулгараад байгаа юм.

Тэгэхээр эрчим хүчний реформ хийхтэйгээ хамт ер нь энэ дулааны асуудал, халаалтын асуудлыг яаж шийдэх юм, түлшээ бид нар яадаг байх юм гэдгийг зайлшгүй ярих шаардлага байгаад байгаа юм.

Ер нь ингээд хараад үзэхээр энэ халаалтын бид нар зах зээл гэж ойлгох хэрэгтэй байгаад байгаа юм. 1 их наяд төгрөг жил болгон энэ дотор эргэлддэг. Зөвхөн тэрийг төр зохицуулж байгаа юм. Бид нар энэ салбарыг чөлөөлөөд өгөх юм бол энэ чинь зах зээлээрээ, жамаараа өөрийгөө аваад явчих боломжтой салбар байгаа.

Тэгэхээр тэр боломжийг нь л бид нар нээж өгмөөр байгаад байгаа юм. Энэ асуудал дээр би Сангийн сайдаас бас асуумаар байгаад байгаа юм. Ер нь энэ ийм халамжийн бодлого явуулснаас болж маш олон гарах гарцгүйгээр бид нар өөрсдийгөө түгжихсэн байдал бий болчихоод байгаа юм. Одоо энэ шөнийн тариф хөнгөлөлт бас байж байгаа. Хавтгайрсан халамж шүү дээ энэ бол өөрөө.

Тэгээд энэтэй холбоотойгоор төр нь өөрөө цахилгааны халаалтыг шийднэ гэж шийдвэр гаргаад 5, 6 жил явснаас болж иргэд нь цахилгаан халаалтаар халаалтаа шийднэ гээд 10, 20 сая төгрөгөөр үнэтэй халаалтын зуухнууд тавьчихсан. Тэгээд байж байтал одоо төр нь ахиад бодлогоо өөрчлөөд цахилгааныг өртөгт нь хүргэнэ гэхээр одоо тэр айлууд маань хохирох гээд байж байна. Тэгэхээр энийг хэн хариуцах ёстой юм? Яагаад ийм халамжийн бодлого гаргаж явсан төр хариуцлагаа үүрэхгүйгээр иргэд нь эндээс хохироод байгаад байх ёстой юм бэ? Энэ дээр асуулт байна.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье. Дараад нь Чойжилсүрэн сайд.

Б.Жавхлан: Цэнгүүн гишүүний асуултад хариулья. Эхлээд макро агуулга ярилаа. Сүүлийн жилүүдэд ДНБ маань нэлээдгүй бас чамлахааргүй өсөж байна, 1 хүнд ноогдох үндэсний орлого маань өсөж байна, Монгол Улсын валютын нөөц өсөж байна, төсвийн

алдагдал болон төлбөрийн тэнцлийн алдагдал хоёулаа л буурч ирж байна. Сүүлийн 2 жил төсөв нэмэх гарлаа. Төлбөрийн тэнцэл маань сүүлийн 20-иод жилийн хугацаанд анх удаа төсөвтэйгөө зэрэгцээд нэмэх гарлаа. Тэгэхээр эдийн засаг маань жил бүр уруудан доройтож байна гэдэг таны дүгнэлттэй санал нийлэхгүй байна. Үзүүлэлтүүд, бодит үзүүлэлтүүд ийм байгаа учраас би энэ дээр тулгуурлаж хэллээ шүү.

Урсгал зардлын хувьд Улсын Их Хурал дээр төсвийн хөрөнгө оруулалтын асуудлууд нэлээн яригдаад энэ урсгал зардлын асуудлууд бас орхигдоод байдаг юм. Энэ та бүхнээс энэ асуудлыг хөндөж байгаа нь их сайн хэрэг. Тэгээд ер нь бол одоо манай төсвийн бүтцийн хувьд харах юм бол ер нь дөнгөж 20 хувь нь л энэ хөрөнгө оруулалтын асуудал, 80 хувь нь урсгал зардал байдаг. Тэгэхээр төсвийн аливаа шинэчлэл, төсвийн шинэчлэл 1 жилд хийдэг асуудал биш. Үе үеийн Сангийн сайд нар, үе үеийн Засгийн газрын бодлогод заавал байж байдаг ийм зүйл. Тэгэхээр төсвийн шинэчлэл бол энэ урсгал зардал дээрээсээ бид эхлэх ёстой юм байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ... одоо өмч бодлогууд тодорхой хэмжээнд их бага хэмжээгээр орж ирлээ. Цаашдаа ч тууштай баримтлах чиглэл юу вэ гэхээр төсвийн төрийн оролцоог багасгана гэдэг маань хувийн хэвшлийн хийж болох төрийн үйлчилгээг тийш нь шилжүүлэх замаар төсвийн ачааллыг төрийн оролцоог бууруулах энэ зарчмаасаа бид нар ухарч болохгүй.

Цаашаагаа хөрөнгө оруулалт дээр ч тэр, төрийн үйлчилгээ дээр ч тэр аль болох энийг, шилжилтийг амжилттай хийгээд явах ёстой юм. Ирэх жил мөн энэ талаар бид нэг том шинэчлэл хийж байгаа нь энэ боловсролын салбар дээр байгаа. Шинээр орж ирж байгаа сургууль, цэцэрлэг энэ боловсролын байгууллагын байгууламжууд дээр хийх нийтлэг үйлчилгээг жишээ нь хувийн хэвшлээр хийлгэе гээд энэ дээр тарифт үйлчилгээний төлбөрүүд мөн төсөв дээр суусан байх жишээтэй. Ингээд алхам алхмаар явна. Өмнөх 4 жил ч гэсэн бас хийх гэж оролдсон боловч бас амжилтгүй болсон зүйлүүд байгаа. Тэр алдаан дээрээ бид дүгнэлт хийж, дараагийн удаа илүү их бэлтгэл ажлаа сайн хангаж энэ шилжилтүүдийг хийх зүйлүүд нэлээдгүй байгаа.

Эрчим хүчний салбарын асуудал бол ер нь 34 жилийн асуудал байгаа. Энэ салбар дээр бид маш хатуу тариф барьж, энэ салбарыг бүүр нэг зогсоохгүй арай хийж төсөв дээр авч явж татаасаар өнөөдөр авч яваад ингээд асуудал нь хуримтлагдчихсан, асуудал нь хуримтлагдчихсан. Энийг хуримтлуулаад цааш нь яваад байх уу? Одоо энэ бодит байдалтайгаа эвлэрч энэ асуудлаа хэрхэн, яаж шийдэх вэ хэзээ, яаж вэ гэдэг л ийм л.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулья.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулья.

Цэнгүүн гишүүн маань бас энэ эрчим хүчний салбарын либералчлал, энэ бодлогыг дэмжиж байгаад талархаж байна. Энэ сая Сангийн сайд хэллээ 34 жилийн хуримтлагдсан асуудлууд байгаа учраас яг 1, 2 жилдээ багтаагаад бүх асуудлыг шийдэхэд төвөгтэй.

Гэхдээ энэ Засгийн газар бол энэ эрчим хүчний салбарыг ямар ч байсан өөрийг нь татаасгүй болгох ийм бодлогыг эхлүүлж байгаа. Энэ эрчим хүчний салбарт гадаад, гадна, дотоодын хөрөнгө оруулалтууд орж ирэх бас нөхцөлийг бүрдүүлэх гэж байгаа, өрсөлдөөн бий болгож байгаа гэх мэт ийм өөрчлөлтүүд хийж байгаа. Энэ салбар дээр тантай цуг

Эрчим хүчний Үндэсний хороон дээр цуг ажиллаж байгаа. Бид ижил, ойролцоо мэдээлэлтэй байгаа гэдгийг хэлье.

“Тавантолгой” түлш компанийн тухайд бол төрийн өмчөөс орон нутгийн өмчид ингээд шилжсэн байгаа Нийслэлийн Засаг дарга илүү тодорхой илүү хариулт өгөх байх.

Д.Амарбаясгалан: Нийслэлээс хэн байна? Нямбаатар дарга чөлөө аваад орлогчоо суулгана гэсэн. Орлогч нь ирж суугаагүй юу? Нийслэлийн Засаг даргын орлогч? Өчигдөр сууж харагдаж байсан. Хүн байна уу? Түүрүүн тэр Мөнхсайхан сайдын хариулт бас Нийслэлээс тодруулж өгөөрэй. Нийслэлийн эрүүл мэндийн газраас, тэр Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвтэй холбоотой асуудал дээр Нийслэл өөрөө асуудлаа хариуцаж ажиллаж байгаа юм чинь. Тэр дээр бас нэмэлт тайлбар өгөх ёстой шүү.

Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: Энэ Тавантолгой түлштэй холбоотой асуудлыг бид нар ер нь ингээд сайд нар нь ч тэр, юу нь ч тэр ингээд бүгдээрээ холддог ийм аймшигтай том тэсрэх бөмбөг байгаа юм шигээр л ер нь хүн болгон хол байдаг ийм сэдэв болчихоод байна л даа. Тэгээд ер нь ингээд ийм байгаа юмыг бид нар байхгүй юм шигээр зүгээр харахгүй байгаа юм шигээр бүүр өнгөрөөд байж болохгүй. Ер нь энэ Тавантолгой түлштэй холбоотой асуудлаа нэг талдаа бид нар зайлшгүй гаргахаас өөр аргагүй, бодит байдалтайгаа нүүр тулахаас өөр аргагүй байдал үүсэж байгаа.

Тэгэхээр энэ би бол аль нэг ТӨК байж байгаад Нийслэл рүү шилжээд энэ байдал өөрчлөгдөнө гэж ерөөсөө харахгүй байна. Тэгэхээр энэ алдагдал бид нар одоо алдагдалтай дараа жил ахиад алдагдал гарч ирнэ. Дээрээс нь хүмүүс энд амь насаараа хохироод байгаа аймшигтай том зүйл байна шүү дээ гишүүд ээ. Та бүх хүн энэ дээр бас зоригтой хамт дуугарч яваарай гэж бас хүсмээр байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу Чойжилсүрэн сайд? Зүгээр үү.

Гомбын Ганбаатар гишүүн асуулт. Алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээр асуулт бид нар сая Хөгжлийн төлөвлөгөөгөө баталсан. Хөгжлийн төлөвлөгөөнд тусаагүй нэгжгээд олон төсөл байгаа харагдана. Тэр нь бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн жагсаалтад орсон байгаа.

Тухайлбал, хөдөө аж ахуй, Хөдөөгийн хөгжил 2 гэдэг төсөл 193 тэрбум, ногоон өрсөлдөх чадвартай аж ахуй төсөл 338 тэрбум, эмзэг бүлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжээ...хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2 дугаар үе шатны төсөл 4 их наяд төгрөгөө, төгрөг 4 их наяд төгрөг шүү. Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр гээд 126 тэрбум гээд. Энэ хөтөлбөр, төслүүд чинь юу нь байхгүй шүү дээ. Хөгжлийн төлөвлөгөөнд байхгүй. Энэ гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлнэ гэдэг жагсаалтад орчихсон байгаа. Тэгээд энийг ямар эрэмбээр, яагаад энэ төслүүд орж ирснийг надад тайлбар өгчихмөөр байна.

Хоёрдугаар асуудал Нийгэм, хамгааллын сайдаас асуух гэж байгаа юм. Эрүүл мэндийн сайд тэр банкнуудад алдсан мөнгөө олж авна гээд энэ төсөвт оруулчихсан байна

л даа. Тэгээд Нийгэм, хамгааллын яам яагаад тэр Нийгмийн даатгалын алдсан мөнгөө оруулж ирэхээр тусгаагүй юм бэ гэдгийг нь хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт болохоор Эрүүл мэндийн сайдаас асуух гэж байгаа юм. Энэ төсөвт эмийн үнийн хөнгөлөлт гээд 171 тэрбум төгрөг туссан байгаа юм. Тэгээд бид нар эрчим хүчний салбараа либералчилна, үнээ дийлэхгүй байна гээд. Энэ чинь Эрүүл мэндийн даатгалаараа л шийдэх ёстой асуудал шүү дээ. Бид нар энэ болохгүй эрүүл мэнд даатгалын тогтолцоогоо шинэчлэх ёстой. Тэгээд одоо ингээд дахиад үнийн зөрүү өгнө гэсэн ийм асуудал орж ирсэн байна.

Тэгээд энэ Боловсролын зээлийн сантай холбоотой ингээд энэ Батнайрамдал гишүүн яриад л байдаг яриад л байдаг ямар ч үр дүн байдаггүй. Өмнөх сайд нарын тушаалууд нь бүгдээрээ хүчингүй юм байна, хууль бус юм байна гээд гараад ирчихсэн байдаг. Яг ирэх жил энэ боловсролын энэ зээлийн сангаас хэдэн төгрөг буцааж олж ирэх вэ гэдгийг Боловсролын сайдаас асуучихмаар байна.

Мөн ирэх жил энэ 226 мянган төрийн албан хаагчийг жигд бүгдийг нь 6 хувиар цалинг нь нэмнэ гээд ороод ирчихсэн. Энэ чинь ингээд хувийн хэвшилээ хөлдөө чирэгдэж байгаа байхгүй юу. Хувийн хэвшил яах юм бэ энэ чинь инфляцыг шууд өдөөнө шүү дээ. Энэ чинь ядаж тэр төрийн үйлчилгээний салбарынхаа ч байдаг юм уу, эсвэл болохгүй байгаа түвшнээ нэмэгдүүлэх асуудал яахгүй ингээд л жил болгон ингээд л инфляцын түвшинтэй ингээд цалин өсөөд л яваад байх юм уу? Бид нар үр бүтээмжийн хойноос явахгүй бол зүгээр ингээд жил болгон цалин, хөлс нэмээд л яваад байдаг ийм байдалтай байж болохгүй л дээ. Тэгээд энэ асуултууд дээр хариу авчхаад тодруулья.

Б.Пүрэвдорж: Эхний асуултад Сангийн сайд Жавхлан хариулна.

Монгол Улсын төсөв дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр 3 эдийн засгийн ангилал байгаа.

Нэгдүгээрт, Монгол Улсын төсвөөр 4.3 их наяд, гадаадын зээл, тусламжаар 2.6 их наяд, орон нутгийн төсвөөр 3.5 их наяд гээд. Үүнээс гадаадын зээл, тусламжийн 2.6 их наяд дотор багтсан төслүүдийг Ганхуяг гишүүн сая асуулаа. Тэнд 117 төсөл байгаа. 93 төсөл, үлдсэн нь бол тусламж. Эдгээр төслүүд нь бол сүүлийн 34 жилийн хугацаанд үргэлжилж байгаа төслүүд ч байгаа, сүүлийн жилүүдэд ч эхлүүлсэн ийм төслүүд байгаа юм. Тэгэхээр энэ бол өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал дээр соёрхон батлаад хууль тогтоомж болж гараад Засгийн газарт, үе үеийн Засгийн газарт үүрэг болгоод энийг хэрэгжүүл гэхчигсэн ийм төслүүд байгаа юм.

Тэгэхээр энэ төлөвлөгөөнд туссан эсэхээс үл хамаараад Улсын Их Хурлаас гаргасан хууль, тогтоолын хүрээнд бид үргэлжлүүлээд, аль болох хугацаанд нь дуусгаад үр шим дээр нь бид нар очих ёстой юм байгаа юм. Энэ дотроо томоохон төслүүд байгаа. Сая заримаас нь Ганхуяг гишүүнд дурдлаа. Одоо бид нарын хамгийн том жишээ нь хүлээгдэж байгаа төсөл гэх юм бол нефть боловсруулах үйлдвэрийн төслүүд байж байна. Саяын таны хэлдэг тэр аймаг, сумын ногоон хөгжлийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл гээд маш чухал төслүүд байгаа.

Эдгээр төслүүдээ бол ингээд жил бүрийн төсөвтөө аль болох ингээд багтаагаад, түлхүү багтаагаад явахыг хичээдэг. Гэсэн хэдий ч энэ маань өөрөө бас Засгийн газрын өрийн хэмжээг бас нэмэгдүүлээд тоолуур нь эхлээд явчихдаг учраас энэ дээр бас нэлээн тооцоололтой оруулж ирдэг байгаа. Энэ жил бол яг зээл ашиглалтын дүн бол 2.2 их наяд,

тусламж нь 400 тэрбум ингээд нийлээд 2.6 байгаа юм. Бусад нь сайд нарыг цохож асуусан учраас хариулах байх.

Б.Пүрэвдорж: Дараагийн асуултад Мөнхсайхан сайд хариулна.

Т.Мөнхсайхан: Энэ хөнгөлөлттэй эмд зарцуулах 180 тэрбумыг ярьж байгаа юм. Энэ угаасаа Эрүүл мэндийн даатгалын сангаас. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эм дээр зарцуулах гээд салгаад тавьчихсан байгаа юм. Тэгэхээр та энийг даатгалаас зарцуулна гэж ойлгох хэрэгтэй.

Өмнө нь та санаж байгаа бол 20 онд хүмүүс хөнгөлөлттэй эмээ авах гээд сар болгоны эхний 3, 4 хоног эмийн санд очерлодог байсан энэ асуудлыг бид бид нар цэгцлээд ямар ч байсан сар болгон бүх эмийн сангаас очер дугааргүй авдаг болгосон. Тэгвэл одоо бид нар харин энэ хөнгөлөлттэй эмд зарцуулах энэ санхүүжилтийг илүү үр өгөөжтэй болгоод, өнөөдрийг хүртэл энэ олгогдож байгаа энэ хүмүүсийнхээ хамрагдалтыг 2 дахин бид нар хэмнэлтийг хийгээд 2 дахин илүү хүнд ингээд энэ хөнгөлөлттэй эмийг хүргэх боломж байна. гэдэг бодлого боловсруулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр одоо цаашдаа энэ хөнгөлөлттэй эм маань янз бүрийн үнэтэй, эмийн сан болгонд өөр үнэтэй өндөр үнэтэй байдаг энэ асуудлуудыг.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Наранбаяр сайд Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

П.Наранбаяр: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Гадаадын зээлийн авлага нийтдээ хүү нь 10 тэрбум гарчхаад байгаа юм. Авлага нь өөрөө 209 тэрбум. Ингээд 220.08 тэрбум төгрөг нийтдээ байгаа. 25 оны төсвийн тухай хуулийн төсөлд жилдээ 30 тэрбум буцааж байгаа төлүүлэхээр, төвлөрүүлэхээр тусгагдсан байгаа. 30 тэрбум. 23 онд 14 тэрбум, өнөөдөр 24 оны эхний 10 сарын байдлаар 7 тэрбум төгрөг төлөгдөөд байна. Авлигатай тэмцэх газраас бичиг ирсэн. Энэнтэй холбоотойгоор бас Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдалын ахалсан ажлын хэсэг бас мэдээлэл хийсэн байгаа. Үүнтэй холбоотой холбогдох арга хэмжээг бид аваад явна. Эргэн төлөлтийг ч сайжруулна. Ер нь энэ 30 тэрбумд нь хүргээд, үе шаттайгаар энийг нөхөн төлүүлэхээр.

Б.Пүрэвдорж: Одоо л Энх-Амгалан сайд Ганхуяг гишүүний асуултад хариулна.

Л.Энх-Амгалан: Ганхуяг гишүүн ээ Нийгмийн даатгалын сангаас Чингис хаан банк, Капитрон банканд ингээд нийт 100, 160 тэрбум төгрөгийн авлага. Энэ бол авлага тэгэхдээ эрсдэлтэй авлага гэж үзэж байгаа. Ямар ч байсан Чингис хаан банк бол дампуураагүй, дампуурлаа зарлаагүй ийм банк. Монгол банкны өгч байгаа юугаар. Капитрон банк бол үндсэндээ дампуурлаа зарлаад энэ Нийгмийн даатгалын сан

Б.Пүрэвдорж: Андуураад байна шүү Капитрон гэж андуураад байна шүү.

Л.Энх-Амгалан: Капитал, Капитал тийм Капитал банк уучлаарай тийм Капитал банк. Ингээд энэ дээр бол бид нар бас нэлээн эрх хүлээн авагчтай нь бас уулзсан. Цаашдаа яаж энэ үүссэн авлагуудаа яаж барагдуулах вэ гэдэг асуудал дээр бас нэлээн томоохон асуудлуудыг авч хэрэгжүүлье гэж бодож байгаа. Тэгээд би бас сайд болоод Үндэсний хороогоо хуралдуулаад, анхны Үндэсний хорооны хурлаас бас шийдвэр гарч Нийгмийн даатгалын даатгалын ерөнхий газар чинь ерөөсөө яг юу.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайдаа бодож байна гэж ярихгүй. Яг юу хийх гэж байгаа талаараа тодорхой яриарай. Дахиад 1 минут өгье.

Л.Энх-Амгалан: Бодож байгаа биш л дээ хийж байгаа. Тэгээд Үндэсний хороогоо хуралдуулж бид нар шийдвэрээ гаргасан. Нийгмийн даатгалын ерөнхий газар бол өмнө бол ингээд прокурорт гомдол гаргаж байгаа юм байна лээ. Тэгээд энэ гомдлыг албан ёсоор гаргуулсан Пүрэвдорж даргаа, Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн. Энэ 25 оны төсөв дээр бид нар Байнгын хорооныхоо даргад бас би хүсэж хүсэж байгаа, Байнгын хорооны гишүүдээсээ бас дэмжлэг хүсэж байгаа. Ямар ч байсан бид нар энэ хууль өмгөөлөгчдийн баг авч ажиллуулах энэ зардлыг тодорхой зардлуудыг яг энэ 25 оны төсөв дээр энэ төсвийн хэлэлцүүлгийн үеэр суулгаж өгөөч гэсэн ийм хүсэлтүүдийг гаргасан. Тэгээд энэ дээр бид нар ер нь ийм хуульчдаа өмгөөлөгчдийн томоохон баг авч ажиллуулахгүй бол ингээд өдөр өнгөрөөсөн иймэрхүү л нөхцөл байдал байгаад байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр бас манай Улсын Их Хурлын гишүүд бас дэмжиж өгөх болов уу гэж бас би бодож байна.

Б.Пүрэвдорж: Ганхуяг гишүүн тодруулья.

Х.Ганхуяг: Миний асуултад хангалттай хариулахгүй л байна л даа. Энэ дээр гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслүүд гээд нийтдээ 30-аад төсөл байна. Бүүр 25 онд эхлэх. Тэгээд би асуулаа шүү дээ. Энэ ногоон өрсөлдөх чадвартай аж ахуйн төсөл гээд 338 тэрбум, энэ одоо яг юу байх вэ? Хөдөө аж ахуй, Хөдөөгийн төсөл 2 гээд 193 тэрбум, эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2 дугаар үе шатны төсөв гээд 4 их наяд төгрөг. Энэ бид нар Засгийн газрын төлөвлөгөө гээд баталсан 25 онд. Би өөрөө тэрийгээ ахалж ажилласан. Энэ төслүүд тэнд байхгүй байхгүй юу. Бид нар тэгээд төлөвлөгөө тэгвэл баталж яах юм? Зүгээр ганцхан төсвөө хийгээд л явдаг болъё. Төлөвлөгөө, төсөв 2 хоорондоо уялдахгүй юм бол бид нар тус тусдаа энийг хэлэлцээд явах цаг барах ямар шаардлагатай юм?

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Ганхуяг гишүүний асуултад нэмж хариулья. Тэр яг тодорхой төслүүд дээр Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариулчхаарай. Би зүгээр 2 хуулийн хоорондын уялдаа холбоо суурь зарчмын талаар хууль дээрээ байдаг заалтын хүрээнд тайлбарлая.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, бид нар өмнө 2021 он хүртэл бид үндсэн чиглэл ингээд батлаад явдаг байсан. Энэ шинэ хуультай болсноосоо хойш бид урт хугацааны, дунд хугацааны, жилийн төлөвлөгөө батлаад явдаг болсон байгаа. Тэгэхээр төлөвлөгөө маань өөрөө ер нь Засгийн газрын болон төрийн үйл ажиллагааны төлөвлөлтийн үндсэн суурь зарчим, залгамж чанар, үндэсний хэмжээний хөгжлийн төлөвлөлтийг хийдэг. Хөгжлийн төлөвлөлтийг хийдэг. Төсөв маань өөрөө юу гэж байдаг вэ гэхээр одоо энэ төлөвлөлтийн хууль дээр энэ харилцааг маш ойлгомжтой заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, төсөв нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чиглэсэн байна гэж байгаа юм. Чиглэсэн байна. Өөрөөр хэлбэл.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дэгийн тухай хууль, хангалтгүй гэж үзвэл дахин тодруулж болно. Ингээд Хассуурийн Ганхуяг гишүүн дахин тодруулья.

Х.Ганхуяг: Тийм, би маш тодорхой асуугаад байгаа юм л даа. Энэ яг шинээр эхлэх төсөл, хөтөлбөр гээд нийтдээ 13 их наяд төгрөгийн төсөл, хөтөлбөр байгаа юм. Энэний яг хагас нь хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа 7 тэрбум, 7 их наяд төгрөг нь, 6 гаруй их наяд төгрөг нь хөгжлийн төлөвлөгөөтэй ерөөсөө уялдаагүй. Би энийг л асуугаад байгаа юм. Энэ чинь 600 тэрбум биш, 60 тэрбум биш, 6 их наяд төгрөг хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй шинээр орж ирсэн төсөл, хөтөлбөр байна гэдгийг асуугаад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Б.Жавхлан: Хөгжлийн төлөвлөгөөнд орсон төсөл, хөтөлбөрүүдийг харах юм бол нийтдээ энд бараг 19 их наядын төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалт шаардсан ийм төслүүд байгаа. Тэрний төсөвтэй холбоотой улсын төсвөөс санхүүжих нь зөвхөн нэг хэсэг нь шүү дээ. Энэ дээр 4.3 их наядар төсвөөс 2.6 их наядар гадаад зээл, тусламжаар санхүүжих энэ дүнгүүд бол өргөн барьсан төлөвлөгөө дотор яг энэ тоотойгоо уялдаж байгаа, нийцэж байгаа. Нэмэлт цаашаа гарах энд хэлэлцэгдээд нэмсэн хэргээ зүйлүүд байгаа бол тэр нь төр, хувийн хэвшлийн түншлэл ч юм уу, өөр бусад эх үүсвэрүүдээр зохицуулагдаад явах ийм л зүйлүүд байгаа болов уу гэж би ингэж харж байна. Яг тэр тодорхой төслүүд дээр Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариулаадхаач. Яг сая энэ 3 төсөл хэллээ шүү дээ.

Өөрөөр хэлбэл, төсөв маань өөрөө төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө л чиглэх юм байгаа юм, чармайж ажиллана л гэсэн үг. Төсөв төсөв өөрөө хязгаартай. Энэ дотор жишээ нь.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Эдийн засаг, хөгжлийн яам 8 номер. Ганхуяг гишүүний асуултад хариулья.

И.Батхүү: Ганхуяг гишүүний асуултад хариулья.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөндөө бодлогын тэргүүлэх чиглэлтэй нийцсэн томоохон төсөл, арга хэмжээг голчлон авч үзэж байгаа.

Дээр нь нэмээд хэлэхэд гадаад зээл, тусламжаар эхлүүлэх төслүүд маань хөгжлийн түнш олон улсын байгууллага Засгийн газруудтай хэлэлцээний явцаас хамаараад улсын төсвийн циклтэй яг зэрэгцэхгүйгээр бас хэлэлцээ нь явагддаг учраас тухай бүр бас тусгах боломжгүй байдаг.

Дээр нь нэмээд улсын төсөв дээр гадаад зээл, тусламжийн төслүүдийн санхүүжилтийг нь Сангийн сайдын багц дээр нэг дор суулгадаг. Тухайн төслүүдийн хэрэгжилт сайн явж байгаагаасаа эхлүүлээд санхүүжилт нь гарахаар нийт дүнгээр нь суулгадаг учраас ингэж харагдаж байгаа гэж ойлгож байна.

Б.Пүрэвдорж: Одоо Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд 2025 оны хөгжлийн төлөвлөгөөгөө баталж дууслаа. Төлөвлөгөө, төсөв хоёр бол нэгдэж явах, нийцэж явах нь бол аль ч талаасаа бодсон энэ бол эргэлзээгүй зүйл. Түүрүүн бас Ганхуяг гишүүний ярианд гарлаа. Төлөвлөгөөнд тусгагдсан асуудал болгон, ажил болгон бас төсөвт тэр чигээрээ орохгүй тийм тохиолдол байгаа гэж хэлсэн. Энэ оны ,энэ төсөв үнэхээр төсөв хумих, төсвийн үргүй зардлыг багасгах, төсвийн алдагдлыг бууруулах гэсэн энэ үг ер нь жоохон лоозон маягтай л явчихлаа гэж харж байгаа юм.

Тэгэхээр 25 оны төсөвт ер нь хүний асуудал их орхигдсон юм шиг харагдаж байгаа. Тэр дундаа энэ 2025 оныг Засгийн газраас залуучуудын жил болгож зарласан байдаг. Энд залуучуудын асуудал ер нь байхгүй, дорвитой ажил байхгүй байгаа нь илт харагдаж байгаа юм. Тэгээд Номин сайдыг ингээд харахаар ер нь чуулганы танхимд их цөөхөн харагдах юм. Голдуу гадаад ажилтай явчихдаг юм шиг байгаа юм. Тэгээд ингээд би сая төсөв хараад ингээд үзсэн. Ер нь орон нутагт соёлын төв барих, спорт заал барих ийм асуудлаар л ер нь ажил нь энэ хязгаарлагдсан юм шиг байгаа юм энэ төсөв.

Тэгэхээр гадаад руу зорьсон энэ олон, олон мянган залуусын урсгалыг яаж буцааж эх оронд нь гэр бүлтэй нь, үр хүүхэдтэй нь амьдруулах энэ сайхан амьдруулах энэ залуусын асуудлыг хөндөх тийм төрийн бодлого үнэхээр алга байна гэж хэлэх байна. Тэгээд Эрүүл мэндийн даатгалын сан, мөн Нийгмийн даатгалын сан дахиад л бас Энх-Амгалан сайдтай холбоотой энэ Капитал банкнаас орж ирэхгүй байгаа энэ авлагуудыг сая бас л бүлэглэл гарчихлаа гэж ойлголоо.

Цаашид тэгвэл бүүр энэ асуудал энэ авлагуудыг яаж хурдан барагдуулж дуусах юм бэ? Гадаадын өмгөөллийн компанийг бас авчирч ажиллуулах ийм асуудал сая яригдаж байна. Ийм байдалдаа бүүр хүрнэ гэж үү. Энэ парламент дамжсан энэ угширсан энэ авлагыг барагдуулж дуусах болоогүй юм уу? Сая их бүдэг хариулт байна гэж бодож байна. Дахиад надаа тодруулаад өгөөч ээ.

Хүнсний аюулгүй байдал, энэ хүнсний хүртээмж, хангамж гэдэг асуудал энэ төсөвт бас ерөөсөө бараг тусгагдаагүй. Ганцхан Хан-Уул дүүрэгт байдаг лаборатори лавлагаа, лабораторийн асуудал. Энд шинэчлэл, засвар хийх энэ төсөвт суучихсан байгаа юм. Багахан хэмжээний төсөв. Энэ ганц лабораторитой байж байж бид нар өнөөдөр хүнсний аюулгүй байдал, энэ эрүүл хүнс, эрүүл монгол хүний тухай ярих ийм боломж байгаа болов уу? Миний хувьд бол би зүгээр сая бодож байгаа юм ерөөсөө энэ Нийслэлийн иргэдийн хуралд сууж байхдаа бас л олон улсын жишигт нийцсэн том лаборатори, шинжилгээний тийм хяналтын лабораторитой больё гээд тийм асуудал бас тэр хараахан бас бүтээгүй. Тэгэхээр энэ дээр ядаж 2026 онд хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын стандартад нийцсэн тийм том хэмжээний лаборатори байгуулах боломж байгаа болов уу?

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний, Батчимэг гишүүний асуултад хариулъя. Амарсайхан Шадар сайд томилолтоор байгаа учраас би өмнөөс нь хариулъя.

Асуудал эрхэлсэн шадар сайдын хувьд энэ лабораторийн хүрэлцээгүй байдал энэ дээр нэмж хийгдэх шаардлагатай олон лабораториудын ажлуудыг бидэнд ирүүлсэн. Энэ жилийн хувьд бид төсвийн гүйцэтгэлтэй холбоотой ирэх 4 жилийн бас олон салбар салбарын маш олон төлөвлөсөн ажлууд байгаа учраас гүйцэтгэлийн зохицуулалт хийж, дээрээс нь Бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтуудынх нь суурь зарчмаар явах гээд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын ирэх жилийн шинэ ажлуудыг 1 жил хойшлуулсан байгаа, түр хойшлуулсан.

Лабораторийн хувьд энд баригдаад явж байгаа ялангуяа хүнсний болон бас энэ барилгын чиглэлийн лабораториуд нэлээн хэд хэдэн ажлууд байгаа. Манайхан Дэлгэржаргал дарга тоонуудыг нь хэлээдхээрэй. Эдгээр баригдаж байгаа зүйлүүд ашиглалтад орчихвол бас багагүй хүрэх зорилгодоо нэлээн дөхөж явчих байх. Бүх лаборатори энэ асуудлууд Шадар сайд руу бүрэн шилжсэн. Тэгээд 26 оноос таны яригдаж

байгаа ялангуяа энэ хүнсний аюулгүй байдал, Цагаан алт хөтөлбөрүүдийн хүрээнд хүн ам илүү их төвлөрсөн Нийслэл болон бусад бүсчилсэн хөгжлийн ялангуяа ядаж бүс бүсийн хаана ашигтай байрлал байх нь дор хаяж тэнд нь нэг бүрчилж ийм лабораториуд баригдах ийм төлөлтүүд байгаа гэдгийг дуулгая. Тоонуудыг манайхан хэлээд өгөх үү? Хэдэн төсөл үргэлжилж байгаа вэ?

Б.Пүрэвдорж: 17 номерыг өгье.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар. Дэлгэржаргал.

Стандарт, хэмжил зүйн газар дээр яг Улаанбаатарт хот байгаа Хүнсний нэгдсэн лабораторийг ер нь сүүлийн жилүүдэд яг шинэчлэх, шинээр лаборатори барих төсвийн төлөлтүүд хийгдээд явж байгаа.

25 оны төсвийн хувьд бид нар энэ лабораториудын нэн шаардлагад сантехник болон үндсэн засваруудын хийгдэхдээ нийтдээ 10 гаруй тэрбум төгрөг тусгагдсан байгаа. Яг шинэ барилгын хувьд бол Стандарт хэмжил зүйн газар дээр газраа яг тодорхой болгох, түүн дээрээ үндэслээд зураг, төсвөө хийх ажлыг 25 онд төлөвлөөд 26 оноос яг лабораторийн барилгынхаа асуудлыг явна.

Нөгөө талдаа яг лабораторийн барилга, байгууламжуудаа их засвар хийхээс гадна шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нэлээн тусгаж өгсөн байгаа. Стандарт, хэмжил зүй дээр яг хүнсний лабораторитой холбоотой 15 тэрбум төгрөг.

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Жавхлан сайдын хариултаас харахад ер нь энэ эрүүл хүнс, эрүүл монгол хүн, тэгээд энэ хүнсний аюулгүй байдлын чиглэлээр тэгвэл 2026 онд бас үндэсний хэмжээний том хяналтын лабораторитой болох юм байна гэж бүрэн ойлголоо.

Залуучуудын талаар ер нь энэ 2025 оныг Залуучуудын жил болгосонтой холбоотой Соёл, спорт, аялал жуулчлал энэ залуучуудын яамнаас тодорхой хариулт авмаар байх юм.

Боомтын Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд Тулга хариулъя.

Б.Тулга: Хүнсний аюулгүй байдалтай холбоотой лабораториудыг барьж байгуулах асуудал дээр бол манай боомтын, боомт дээр баригдаж байгаа шалган нэвтрүүлэх цогцолборуудын, цогцолбор дотор бол дандаа хүнсний лабораториуд зураг, төсөв нь суугаад баригдаад явж байгаа. Увс аймгийн Боршоо дээр бол хүнсний лаборатори баригдсан. Алтанбулаг дээр баригдаж байгаа. Замын-Үүд дээр ашиглалтад орсон байгаа. Одоо Гашуунсухайтын цогцолбор ашиглалтад ороход мөн лабораторийн барилга тэн дотор бол баригдсан байгаа. Тэгэхэд ирэх жилээс дахин 3 боомт дээр энэ цогцолборын бүтээн байгуулалт явагдана. Энэ дээр 3 хүнсний лабораторийн барилга байгууламж баригдаад явж байгаа гэдгийг танд дуулгая.

Ер нь боловсон хүчний хувьд бэлдэх ёстой. Тэгээд Шадар сайд дээр бас энэ лабораторийн хяналтын бүх бодлого ирж байгаа учраас боловсон хүчин бэлтгэх энэ тал дээр бас бид нар ажиллах болно гэдгийг минь нэмэлт мэдээллээр өгчихье.

Батчимэг гишүүн нэг зүйлийг шүүмжлээд байна шүү. Өөрөөр хэлбэл, тэр сайд чинь ерөөсөө бас хуралдаа суухгүй байна. Тэр гадаадын соёл яах вэ монголын соёлоо сайн сурталчлах тэр ажлыг эндээ, энэ Их Хурал дээрээ, энэ Монголдоо сууж байж хий гэж хэлээрэй.

Индрийн 2 дугаар номер.

А.Даваажаргал: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Даваажаргал байна.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгон зарлахаар төлөвлөөд манай яаман дээр энэ асуудлын хүрээнд бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг гараад, бэлтгэл ажлыг хангаад ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар 2025 оны төсөв дээр бид нар залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр нийт 10 тэрбум төгрөгийн төсвийн саналыг өргөн барьж та бүхэнд хүргүүлсэн байгаа.

2024 онд 2.9 тэрбум төгрөгийг залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр тусгасан. Холбогдох ажлууд нь хийж, хэрэгжүүлээд явж байгаа.

Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа залуучуудыг Монгол Улсад эргүүлэн авчрахтай холбоотойгоор ипотекийн зээлийн хамрагдалт нь залуучуудын оролцох оролцооны хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр салбарын яамнуудтай хамтран ажиллаж байна.

Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмээд 1 минут өгчих.

А.Даваажаргал: Залуучуудын оролцооны хөтөлбөрүүдийг 2025 оны энэ залуучуудын хөгжлийн жилтэй холбогдуулан боловсруулж батлуулж байгаа. Энэ хөтөлбөрийн төсөл л дээр одоогийн байдлаар бид нарын боловсруулж явуулж байгаагаар гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа оюутан, залуучуудыг буцаад эх орондоо ирж ажиллах орчин нөхцөлийг нь сайжруулах чиглэлээр хэд хэдэн төсөл, арга хэмжээнүүдийг тусгаад ажиллаж байгаа. Хэрвээ энэ төсөл, хөтөлбөр батлагдвал та бүхэнд Байнгын хороон дээр бид нар холбогдох мэдээллүүдийг нь хүргүүлээд ажиллахад бэлэн байна.

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн дахин тодруулъя.

П.Батчимэг: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны холбогдох албаны хүний юуг сонслоо. Тэгэхдээ бас яг миний хүссэн хариулт биш байна л даа. Яг төсөвт орсон байдлаар энэ дээр харахаар үнэхээрийн сая та миний хэлж байсан юун дээр дөрөөлөөд ярьчих шиг боллоо. Гадаадад амьдарч байгаа монголчуудын гээд, залуучуудын тухай. Энд яг тэгж ерөөсөө орж ирээгүй байна лээ шүү. Би бол яг энэ асуудлын чинь араас танай яамнаас байнгын анхааралтай энэ асуудал дээр бүүр анхаарал тавьж явна гэдгээ л хэлчихье.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. 2025 оны Монгол Улсын нэгдсэн төсөв хэлэлцүүлэгдэж байна. Тэгээд эндээс бас олон шинэ зүйлүүд байна л даа. Одоо ингээд төсөв батлахад чинь 600-гаад нэр төрлийн төсөл хөтөлбөрийг ярьдаг байсан бол энэ чинь 38 төсөв, хөтөлбөр яригдаж байна. Үндсэн гол том агуулгууд руугаа бас Монгол Улсын төсвөө чиглүүллээ. Иргэд олон нийтгэй уулзахад энэ эдийн засгийг хөгжүүлэх энэ 14 мега том төслүүд, энэ улс орны энэ татвар төлөгчдийн мөнгийг улс орны эдийн засгийн цаашдын хөгжил рүү зориулах энэ том реформын шинжтэй энэ олон зүйлүүдийг бол бас сайхан дэмжиж, бас тэр хэрээрээ хүлээлт байгаад байгаа юм л даа.

Өчигдөр Төрөөс баримтлах мөнгөний бодлогын талаар баталсан. Инфляцыг 5 дээр нэмж -2 хувиар баталсан. Энэ дээр нэг л эргэлзээтэй зүйл байгаа нь бидний эдийн засгийн хөгжлийг түргэтгэх энэ явцын хажуугаар магадгүй сарын дараа ард иргэдийн амьдрал руу хаалгаар шууд ороод ирэх нэг том эрсдэлтэй зүйл бол энэ дулаан, цахилгааны үнийн асуудлын нэмэгдлийг инфляц дээр 1 хувийн нөлөөлөл үзүүлнэ л гэдэг ийм л зүйлийг бид өчигдөр ярьсан. Үнэхээр инфляцад энэ 1 хувийн нэмэгдэл байж чадах уу эсэх дээр Эдийн засаг, хөгжлийн яам ер нь ямар судалгаа шинжилгээ хийж энэ инфляцынхаа түвшнийг ер нь тооцож байгаа вэ? Монгол Улсад урьд нь юмны үнэ нэмэгдэхэд валютын үнэ жоохон хөдлөхөд нэмэгдчихдэг, бензиний үнэ нэмэгдэх сургаар маргааш нь хүнсний захууд дээр юм нэмэгдчихдэг ийм улс шүү дээ. Өнгөрсөн хугацаанд валютын нөөцийн хэмжээ нэмэгдсэн, валютын ханш бас тодорхой хэмжээнд бууж эхэлж байсан. Сайн, муу хэлүүлж байгаа эдийн Засгийн газар бас энэ шатахууныхаа үнийн өсөлтийг бас тодорхой хэмжээнд барьж чадсан. Одоо ингээд яг суурь үнэд нөлөөлөх энэ дулаан, цахилгааны үнэ маань инфляцад бидний төсөөлж байгаагаас илүү нөлөөлөл үзүүлбэл яах вэ? Инфляцын түвшинтэй уялдуулаад бид төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр тэтгэмжээ нэмдэг болсон. Энэ нь 2026 оны төсөв дээр ямар хүндрэлүүд учруулах вэ гээд олон зүйлүүд байгаа учраас би энэ инфляцтай холбоотой зүйлийг асуугаад байгаа юм. Одоо энэ дулаан, цахилгааны үнийн өсөлтийг инфляцад 0.8-аас 1 хувь нөлөөлнө л гээд ингээд үзээд байгаа юм. Энэ дээр л би тодорхой хариулт бас авъя гэж ингэж бас бодож байна.

Яагаад гэвэл ийм шийдвэр гарахад маргааш өглөө нь талхны үнэ шингээд ороод ирэх байхгүй юу. Тийм учраас Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар гэдэг энэ байгууллагын статус өнөөдөр ямар байдалтай байгаа вэ? Үндэслэлгүйгээр үнээ нэмж байгаа хэдхэн аж ахуйн нэгжүүд хуйвалдаад нэмчихэд очоод торгууль тавихад өөдөөс нь дахиад ч нэмнэ гэдэг ийм л хяналтгүй улс шүү дээ бид нар.

Тэгэхээр яг эдийн засгийн бодит судалгаан дээр үндэслээгүй, зүгээр суурь үнэ, цахилгааны үнэ төдий хувь өсчихсөн, дулааны хувь төдий хувь өсчихсөн учраас манай бүтээгдэхүүнийг ийм болгосон юм. гээд хэлээд сууж байхад төр энэ дээр ямар хяналтын механизм, ямар хариуцлагын механизм байгаа вэ гэдэг дээр энэ Эдийн засаг, хөгжлийн яамныхнаас би тодорхой асууя гэж ингэж бас бодоод байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд харж байхад дотооддоо үйлдвэрлэдэг гурилын үнээ бид хянаж чадахгүй л төрийн хяналтын механизм байхгүй. Гурилын үнээс болоод 10 хэдэн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ суга өсчихсөн ийм л хэцүү байдалтай байсан шүү.

Б.Пүрэвдорж: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү хариулна 6 номер.

И.Батхүү: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Эрчим хүчний үнэ тарифын өсөлтийн хувилбарууд нь яригдаад байгаа. Яг эцсийн хувилбар нь гаргаж танилцуулагдаагүй байгаа. Биднүүсийн хувьд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр Дэлхийн банк бусад олон улсын байгууллагатай хамтраад хувилбар бүр дээр нь тооцоолол хийж үзсэн. Инфляцын нөлөөлөл бол суурь нөлөөлөл нь 25 онд яваад 26 он гэхэд үлдэгдэл нөлөөлөл яваад тэгээд инфляцын эрчим хүчний өсөлтийн, тарифын өсөлтийн инфляц нь арилна гэж үзэж байгаа. Биднүүс анх макро эдийн засгийн төсөөлөл дээр инфляцыг 25 онд төлөвлөж байснаасаа 7.5 хувь болж нэмэгдүүлээд тооцчихсон байгаа. Эндээ салбаруудын шинэчлэл, либералчлалтай холбоотой гарч болох үнийн өсөлтийн тооцооллын оруулсан байгаа.

Тэгээд энэ инфляц маань зөвхөн яг энэ эрчим хүчний тарифын өсөлтийг дагаад нэг чиглэлдээ явах биш бас Монголбанк мөнгөний бодлогын тохируулгаар инфляцыг бууруулах чиглэлээр ажиллах ёстой. Дээр нь бас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, валютын ханшийг тогтворжуулах, нөөцийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээний үнэд, үнийн үр дүнд инфляц бас хэт өсөхгүй гэсэн тооцоололтой байгаа.

Б.Пүрэвдорж: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм. Энэ яг таны наад тайлбар бол төсөв яригдсан цагаас эхлээд л яригдаж байгаа ийм л зүйл л дээ. Өнгөрсөн Их Хурал дээр ч гэсэн гурилын үнийн өсөлтийн асуудал яригдахад яг л ийм, яам бол ийм л тайлбар ярьдаг.

Би жоохон хөрсөн дээрээ буусан юм асуугаад байгаа юм танаас. Бидний, та бүхний төсөөлж байснаас инфляцад шал өөрөөр нөлөөлөөд эхэлбэл яах юм бэ? Энийг яаж хянах юм бэ л гэдэг юм асуугаад байгаа шүү дээ. Ийм хяналтын механизм байгаа юу? Монопол, хуйвалдах ийм зүйлүүд үйлчлээд эхэлбэл яах вэ гэдэг юм асуугаад байгаа байхгүй юу. Тэрнээс яг таны энэ өсөлтийн хэмжээг барьж байгаа, тэр гадаад валютын нөөц олон зүйлүүдийг өчигдөр мөнгөний бодлого дээр ч тэр олон зүйлүүд дээр бид нар ярилцсан шүү дээ. Наадах чинь олон сонсож байгаа тайлбар байгаа.

Гэхдээ миний асуултын гол агуулга бол хэрвээ хуйвалдсан ийм нөхцөлүүд үүсээд эхэлбэл яах вэ гэдэг л ийм л зүйл байгаа шүү дээ.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Асуултад Батхүү дарга хариулъя. Ер нь Их Хурлын гишүүний асууж байгаа асуултын нюансыг нь сайн бичиж тэмдэглэж авч байгаад хариулаарай.

И.Батхүү: Идэрбат гишүүний асуултад нэмэлтээр тайлбар өгье.

Инфляцын өсөлт нь ол биднүүс тооцоолохдоо шууд болон шууд бусаар хоёр дам нөлөөг нь бас давхар тооцсон. Гэхдээ энэ хувилбарууд нь өөрсдөө, өөрөө эцэслээгүй байгаа учраас эцсийн дүнг хэлэх боломжгүй байгаа.

Инфляц энэ хуучин хэрэглэгчийн төлөө, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гэж байсан газар монополын хэсэг газар болоод Шадар сайд Доржхандын харьяанд ажиллаж байгаа. Энэ агентлаг маань яг таны хэлсэн үнийг өсгөх талаар гарч болох асуудал, сөрөг асуудлууд дээр хяналт тавьж ажиллах ёстой байгууллага байгаа. Тэр байгууллагаас хяналтыг нь тавьж ажиллана гэж ойлгож байгаа.

Б.Пүрэвдорж: Одоо болно. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна.

П.Ганзориг: Засгийн газраас ирэх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө оруулж ирэхдээ, Улсын Их Хурлаар батлуулахдаа бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ, эдийн засаг дахь бизнесийн оролцоог нэмэгдүүлнэ, төрийн оролцоог багасгана гээд сайхан сайхан заалтуудтай хөтөлбөр батлуулсан. Тэгээд 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, 2025 оны энэ төсөв орж ирэхдээ энэ бизнесийн орчныг дэмжих чиглэл дээр бас бодитой, дорвитой ийм заалтууд, төсвүүд бол орж ирэхгүй байна. Бүүр ялангуяа жижиг, дунд бизнес ажлын байрны 95 хувийг бүрдүүлж байгаа, 90 хувийг бүрдүүлж байгаа жижиг, дунд бизнесийнхэн, татварын орлогын 50 хувийг бүрдүүлж байгаа. Энэ хувийн хэвшилд ер нь дэмжлэг болох, ялангуяа энэ татварын ачааллыг бууруулах, зээлийн хүүгийн дарамтыг багасгах чиглэлд юу ч байхгүй байна.

Ер нь эдийн засаг цаашаа тогтвортой өсье гэвэл энэ хувийн хэвشلээ дэмжиж байж, ажлын байр бий болгож байж, цалин хөлс нь хувийн хэвشلээрээ дамжиж өсөж байж айл орхийн орлого өснө шүү дээ. Бүгд мэдэж байгаа.

Яагаад энэ чиглэлдээ бодлогуудаа сайн төсөв дээрээ, төлөвлөгөө дээр оруулж өгөхгүй байгаа юм бэ гэдгийг би асуумаар байна.

Тухайлбал, татварын ачаалал гээд чухал үзүүлэлт байж байгаа. ДНБ бүтээгдэхүүнд эзэлж байгаа татварын орлогын дүн 20 онд 23 хувьтай байсан. Тэгэхэд ДНБ 38 орчим их наяд байсан. Одоо 95 их наяд болчихсон. Татварын ачаалал 33 хувьтай байгаа, татварын орлого 32 орчим их наяд болж байгаа. Энэ өөрөө эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж байгааг харуулж байгаа юм. Хэмждэг нэг үзүүлэлт нь. Сүүлийн 3 жилийн дотор хувийн хэвشلүүдийн татварын хуримтлагдсан өр 3 дахин өссөн. 1.2 орчим их наяд байсан бол 3 их наяд орчим гарсан гээд Үндэсний аудитын газраас бас гаргачихсан байж байгаа. Тэгэхээр энэ чиглэлд ямар бодлогууд байна вэ?

Цаашдаа энэ яг жижиг, дунд бизнесүүдийг дэмжих дээр татварын ачааллыг бууруулах дээр ялангуяа татварын бааз суурийг өргөтгөмөөр байна. Төлдөг хэсэг дээр ачаалал овоолоод байх биш, ямар бодлого байгаа вэ гэдгийг нэгд асуумаар байна.

Хоёрт энэ өмнө нь Сангийн сайд хариулаад л байсан л даа. 1 минутаа шууд нэмээд авчихъя. Энэ татварын шинэ төрлийн дэмжлэг оруулж ирж байгаа гээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 8 сард баталсныг тайлбарлаад байгаа юм. Энэ нэгд ашигтай ажиллаж байгаа, дээр нь нэмээд хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж барих, спорт, урлаг, соёлын байгууламж барих юм бол гэж байгаа шүү дээ. Ийм компаниудад орлогын албан татвараас, борлуулалтын орлогоос 1 хүртэл чөлөөлж байгаа. Энэ жижиг дунд бизнесүүдэд яаж хамаарах юм? Цалингаа яаж тавья, зээлээ яаж төл.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: 1 минутаа нэгмөсөн авчихъя гэж байна.

П.Ганзориг: Тэгэхээр энэ бол бизнесийнхэнд ер нь хувийн хэвшлийнхэнд тэр чигээр нь хүртээмж байхгүй. Бид нар бол энэ хөгжлийн том бүтээн байгуулалт төсөл, хөтөлбөрүүдийг явуулахыг дэмжиж байгаа.

Тэгэхдээ энэ эрчим хүч, зам тээвэр, боомт гээд уул уурхай гэдэг юм уу хэдэн банкнууд эд нарыг дэмжээд явж байгаагаараа энэ хувийн хэвшил тэр чигээрээ босчихно гэж төсөөлж болохгүй. Энэ чинь бол том нэг хэсэг нь. Яах вэ энийг дагаад бас туслан

гүйцэтгэгч ажлын байр ингээд бий болох байх. Тэгэхдээ зөвхөн энэний бас үр дүнгээр хэмжиж болохгүй гэдгийг хэлмээр байна.

Хоёрт энэ төсөл, хөтөлбөрүүд ирэх оны төсвөөр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд дээр энэ Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний төв гээд 700 тэрбум төгрөгөөр барина гээд орж ирж байгаа. Ирэх жил 250 тэрбумыг нь санхүүжүүлнэ гэж байгаа. Энэ хэр хэмжээний барилга байшин байгаа юм бэ, хэр ач холбогдолтой юм бэ, нэн яаралтай барих шаардлага байна уу?

Хоёрт, 1000км зам барина гээд байгаа юм. Чухал. чухал зам.

Тэгэхдээ бид нар Дарханы 200км зам барих гэж хэдэн жил ямар асуудалтай тул.../минут дуусав.

Б.Пүрэвдорж: Асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулна. Дараа нь Чимэдсүрэн дарга бас татвартай холбоотой асуудлаар бэлтгэж байгаа.

Б.Жавхлан: Ганзориг гишүүний асуултад хариулья.

Голцуу ЖДҮ-лэлтэй холбоотой хэрхэн яаж дэмжих вэ гэж асуулаа гэж ойлголоо. Ирэх оны төсөв дээр мэдээж бид нар төсвийн хувийн хэвшлийг дэмжих үндсэн гол 2 л суваг байгаа. Татварын бодлого, бусад хөрөнгө оруулалтын чиглэлийн бодлогоор.

Татварын бодлого дээр өмнө нь би бас хариулсан. Ер нь бид нар өмнө нь оруулж ирээгүй, оруулж ирж байгаагүй нэлээн тийм зоригтой шийдлүүдийг ингэж санал болгож оруулж ирж байна. Энэ талаар уг нь танд өмнө нь нэлээн мэдээлэл өгч байсан.

Нэгдүгээрт, бүсчилсэн хөгжил, ялгаатай татварын бодлого тэргүүлэх чиглэлийнх нь баялаг бүтээгч нарыг дэмжих ийм бодлого. Саяын таны хэлдэг тэр яг нийгмийн дэд бүтцийн нийгмийн зөөлөн дэд бүтцийн салбар, соёл, спортдоо бусад ногоон байгууламжууд, ногоон хөгжлийн гээд олон боломжтой төслүүд, салбарууд байгаа. Энд өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтаас бодитой төсвийн зардлаас ачаалал авч тэнд хувийн хэвшил, аж ахуйн нэгж, компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд гэх юм уу, эсвэл бизнесийн зорилгоор хөрөнгө оруулалт хийгээд явсан бол тэгэхдээ тэр шалгууруудыг мэдээж салбар бүр, яам бүр өөр өөрсдийнхөө чиглэлээрээ гаргана. Эндээс ингээд татварынх нь хөнгөлөлтүүдийг нийт орлогынх нь1 хувьд нь хүртэл хязгаарлаад, чөлөөлөөд явъя гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ирээдүйд төсөв дээр гарах ачааллыг хувийн хэвшил дээр үүрч байна гэсэн үг. Ийм зохицуулалтаар явна. Тэгээд энэ бол нэлээн үр дүнгээ хүрэх, өгөх болов уу гэж ингэж харж байгаа юм.

Татварын өр 3 дахин нэмэгдэж байна гэж байгаа. Тэгэхээр энэ маань өөрөө эдийн засаг өөрөө тэлж байна, ДНБ үндсэндээ 19 оноос хойш ингээд 5 жилийн дотор 2 дахин нэмэгдлээ, төсвийн орлогын хэмжээ ч бас бараг 2-оос 3 дахин нэмэгдлээ. Тэрийг дагаад тэнд эзлэх хувь хэмжээний хувьд өсөөгүй. Тэгэхдээ мөн бас энэ хэд хэдэн томоохон аж ахуйн нэгжүүдийн өр байгаа. Энийг бол хуулийн хүрээнд барагдуулах чиглэлээрээ ингээд ажиллаад явна.

Тэгэхээр энэ бол татварын өрийн асуудал онцгой том хувь, хэмжээ болохоор ингээд өсчихсөн зүйл эрсдэл үүсэхээр болчихсон зүйлгүй гэж харж байна.

ЖДҮ-лэлийн бид дэмжих хэд хэдэн сувгууд байгаа. Хэд хэдэн сувгууд. Татварын асуудлуудыг би сая хэллээ. Тэгэхээр энэ ялангуяа салбар хамаарахгүйгээр тоног төхөөрөмжийн яг технологийн тоног төхөөрөмжүүдийг гаалийн татвараас бүрэн чөлөөлж байгаа юм байна. Энэ нь ЖДҮ-лэлд маш том түлхэц, дэмжлэг болно.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэд байдаг ЖДҮ-лэлийн агентлаг болон тэр корпорац өөрсдөө энэ төсөв болон төсвөөс дэмжлэг авахгүйгээр нэгэнт бий болчихсон эх үүсвэрийнхээ хүрээнд үйл ажиллагаанд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайдад нэмэлт минут өгье.

Б.Жавхлан: Улам үйл ажиллагаа нь тэлээд явна. Тэгэхдээ судалгаагаар ЖДҮ-лэлийг дэмжих хамгийн том дэмжлэг бол энэ зээл, татвар гэхээсээ илүү зах зээл нь юм байна лээ шүү. Яг борлуулалтаар нь дэмжих нь хамгийн чухал.

Тийм учраас үндэсний худалдан авалт гэж бид ингэж уриалж ярьдаг. Энэ томоохон аж ахуйн нэгж, хувийн сектор ч бай хаана ч бай энэ хувийн хэвшлийг дэмжсэн ялангуяа ЖДҮ-лэлийг дэмжсэн тэд нарыг хооронд нь холбох энэ ажлыг төр, төрөөс гадна Худалдаа аж үйлдвэрийн яам ч гэдэг юм уу хувийн хэвшил өөрсдөө санаачлаад явж байгаа ийм зүйлүүд дээр бол Засгийн газраас байнга дэмжиж хамтарч ажиллаж байгаа. Тийм учраас энэ нь асуудлууд бол ирэх жилийн төсөвт бол бас тодорхой хэмжээнд сайн тусгагдсан гэж харж байгаа.

Нэг цэгийн үйлчилгээ энэ бол шууд Улаанбаатар хотын түгжрэлтэй л холбоотой асуудал. Хэдүүлээ энд түгжрээд ингээд байгаад байх уу, эсвэл энэ 25-аас 30 хувийн түгжрэлийг энэ уулын цаана, цааш ийшийгээ шилжүүлэх, зөвхөн төрийн үйлчилгээ биш энэ хооронд хийгдэх.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Татварын ерөнхий газрын дарга байна уу? 21 үү? 21 номер.

Ч.Чимидсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газар Чимэдсүрэн.

Монгол Улсад бүртгэлтэй 254 мянган аж ахуйн нэгжүүд байгаа. Түүнээс үйл ажиллагаа явуулж байгаа ашигтай буюу ноогдолтой 158 мянган аж ахуйн нэгж байгаа. Тэгээд энэ судалгаанаас үзэхэд бол түрүүний хэлснээр татварын ачаалал аж ахуйн нэгжийн албан татвар, НӨАТ-ын татвар, хувь хүний орлогын албан татвар, ингээд бүгд ороод бол 10.3 хувь гэсэн судалгаа байна. Уул уурхайн салбарт арай өндөр 19.2 хувийн ийм ачаалалтай байгаа.

Түрүүний хэлсэн 1 хувийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар орсон нэмэлт, өөрчлөлт бол нийт аж ахуйн нэгжид бол бас хамаарагдахгүй гэдэг нь үнэн. Ашигтай ажиллаж байгаа компаниудын хувьд борлуулалтын орлогын 1 хувь хүртэл нь оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивыг бол төлөх татвараас нь тэр дүнгээр нь бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Хамгийн гол нь татварын бааз суурийг нэмэгдүүлэх талаар асуугаад байгаа шүү дээ.

Өөрөөр хэлбэл, энэ аж ахуйн нэгжээс гадна дахиад хувиараа хөдөлмөр эрхэлдэг 250 мянган хүн байгаа. Тэр хүмүүсийн яг татварыг, орлогыг бүрэн авах талаар ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Яг энэ дээр Чимэдсүрэн даргын минутыг, наадах чинь арай өөр микрофон байх шиг байх юм. Индрийн 2 номер руу гарч очоод ярьчих. Хэн хариулах юм? Номероо? 1 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Ганзориг гишүүний асуултад хариулья.

Татварын бодлогын хувьд бид сүүлийн жилүүдэд татварын хувь хэмжээг нэмэх гэхээс илүү дандаа ийм Шинэ сэргэлтийн бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан чиглэл рүү дандаа татварын дэмжлэгүүдийг их хэмжээгээр нэмэгдүүлж байгаа.

Тухайлах юм бол өнгөрсөн жилээс орон нутаг шинээр орон сууц барих ч гэдэг юм уу, үнэт цаасны зах зээл ч гэдэг юм уу, аялал жуулчлал ч гэдэг юм уу. Тэгэхээр бид нар татварын хэмжээг ерөөсөө нэмэгдүүлэх бодлого барихгүй байгаа. Татварын хэмжээг нэмэхээсээ илүүтэйгээр бид нар энэ татварын бүртгэл, цахим бүртгэл, татварын үйл ажиллагааг цахимжуулснаар төрд байгаа мэдээллийн уялдаа, холбоог сайжруулснаар татварын бааз суурийг нэмэгдүүлэх, ингэснээрээ бүх нийтээрээ бага татвартай орчинд ажиллах ийм боломж бүрдэнэ.

Тэгэхээр бид нар энэ бодлогоо цаашдаа баримтална. Энэ дээр жишээлэх юм бол и-баримтын хамрах хүрээг бид нар жил болгон эрс.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дахиад 1 минут сунгаад өгчих.

Б.Тэлмүүн: Тийм. Тэгээд хоёр дахь асуудал нь татварын бааз суурийг нэмэгдүүлэхтэй холбоотой энэ далд эдийн засгийн асуудал яригддаг. Тэгэхээр таны хэлж байгаа статистикаар ингээд татварын ачаалал буюу ДНБ-д эзлэх татварын орлого нэмэгдэж байгаа нь ерөөсөө энэ далд эдийн засаг буурч байгаатай шууд холбоотой. Бид нар нэг талдаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлж байна.

Нөгөө талдаа татварын орлого нэмэгдэж байгаа. Энэ дээр жишээлэх юм бол уул уурхайн салбарын орлого бол, орлогод эзлэх уул уурхайн салбарын орлогын хувь хэмжээ бол өмнөх жилүүдэд 7, 8 хувьтай байсан бол 24, 25 онд 11 орчим хувьд хүрэхээр байгаа.

Тэгэхээр уул уурхайн салбарыг дагаж явж байсан энэ орлогуудыг ил болгож, татварт хамрагдуулснаар энэ татварын бааз суурь нэмэгдэж байгаа. Тэгээд далд эдийн засаг буурч, ингэснээрээ бид бүх нийтээрээ бага татвартай татварын ачаалал бага.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Ганзориг гишүүн тодруулья.

Ц.Ганзориг: Энэ жижиг дунд бизнесүүдэд бол тэр Бүсчилсэн хөгжил тэр чигээрээ хамаатай биш. Нийт аж ахуйн нэгжүүдийн чинь 70, 80 хувь нь Улаанбаатарт байгаа. Хэд нь орон нутаг руу шилжээд энэ бүсчилсэн хөгжлийн татварын хөнгөлөлтөд хамрагдана гэж тооцоод байгаа юм бэ?

Хоёрт, аж ахуйн нэгжийн орлогын татварын хөнгөлөлт бол үндсэн үйл ажиллагаагаа хангалттай аваад явж байгаа ашигтай компаниуд хамаатай. Чи жижиг, дунд бизнесүүд чинь цалингаа, зээлээ, татвараа яаж төлье гэж байгаа шүү дээ. Тэр хүмүүс

үндсэн үйл ажиллагаанаасаа гадна яаж цэцэрлэгт хүрээлэн барьж, ногоон байгууламж барьж байж татварын хөнгөлөлтөд яаж хамрагдах юм бэ? Спорт, урлаг, соёлын байгууламж барьж байж яаж татварын хөнгөлөлтөд хамрагдах юм бэ?

Тэгэхээр иймэрхүү бас шууд хамааралгүй хүртээмжгүй тайлбаруудыг бол бас нэлээн хэлээд байгаа. Энийг бас бодолцмоор байгаа юм. Нийтэд нь хамаатай зүйл дээр бас анхаарахгүй бол болохгүй байна.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Ганзориг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Хэдхэн жилийн өмнө 2021 онд төсвийн орлого маань 14-өөс 17 их наядын хооронд байсан бол 33.6 их наяд үндсэндээ бараг 2.5 дахин нэмэгдэж байгаа юм. Энэ хугацаанд татварын нэг ч хувь хэмжээг бид оролдоогүй. Тэгэхээр энэ татварыг илүү их либералчлах, ил тод байлгах, татварын тайлагналыг хялбаршуулах, далд эдийн засгийг бүртгэлтэй болгох энэ бүх үйл ажиллагааны үр дүнд татварын суурь нь нэмэгдээд, орлого нэмэгдэх ийм боломж бий болж байна гэж ингэж дүгнэж байгаа. Тэгэхээр энэ бодлого бол цаашаа ингээд үргэлжлээд явна.

Бүсчилсэн хөгжлийн энэ татварын ялгаатай бодлогын асуудлууд мэдээж тэргүүлэх чиглэл гэхээр мэдээж томоохон хөрөнгө оруулалт, томоохон салбарууд байгаа. ЖДҮ-лэл өөрөө хөгжих нэг суурь нь том салбар өөрөө хөгжиж байж тэрийг дагасан ЖДҮ-лэлүүд хөгжих нь хамгийн одоо.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: 1 минут нэмээд өгье.

Б.Жавхлан: Оновчтой загвар байдаг. Тэгэхээр хүртээмжгүй гэж бас хэлэхгүй л болов уу гэж ингэж бодож байна. Хотод хөдөөд ч энэ жигд үйлчилнэ, үр дүнгээ өгнө гэж ингэж бодож байна.

Тэр нийгмийн чиглэлийн ийм хөрөнгө оруулалт, хандив, тусламж гэдэг бол энэ сайн дурын асуудал шүү дээ. Аль аж ахуйн нэгж, аль институт өөрөө боломжтой байна тэр хэмжээгээр нийгмийн хариуцлага гэдэг юм уу, эсвэл бизнесийн зорилгоор ийм хөрөнгө оруулалт хийгээд явбал гэж байгаа юм. Тэрнээс энэ чинь бүгд шууд хамааралтай, бүгд нэг шууд хүртээмжтэй байдлаар явна гэсэн зүйл биш. Ямар ч байсан төсвийн хариуцлагаас, төсвийн дарамтаас тэнд үнэхээр бодитойгоор уваалцаж байгаа бол тэр хэмжээгээр төсвөөр заавал дамжуулж эргээд хөрөнгө оруулалт хийдэг зарчмаар биш, шууд үр дүнгээ өгөх энэ замаар нь харилцан төр, хувийн хэвшил ингээд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Манай үйлдвэрчнийхэн ороод ирчихсэн байна. Их сайхан байна. Боловсролын үйлдвэрчнийхэн орж ирсэн байна.

Би асуултаа төсөвтэй холбогдуулж төсөвтэй холбогдуулж би асуулт асууя. Ерөнхийгөөс нь нарийвчилж асууя. Хүн ээжээс төрдөг болохоос биш эсрэгээрээ биш, ард түмнээс Улсын Их Хурлын гишүүдийг сонгодог. Улсын Их Хурлын гишүүд ард түмнээс сонгогддог, сайд нар ерөөсөө ард түмнээс сонгогддоггүй үүнтэй адилхнаар төсөв дагаж төсвийн хүрээний мэдэгдлийг оруулж ирж өөрчилдөг байдлыг хэзээ зогсоох вэ? Энэ чинь Улсын Их Хурал Засгийн газрын мөнгөнд их улайрсан дур зоргыг хазаарлах гэж төсвийн

хүрээний мэдэгдэл болон бусад хуулиудыг бий болгосон тэр хуулиудыг энэ Улсын Их Хурал ийм байдлаар ингэж өөгшүүлж болохгүй гэдэг байр суурьтай байна. Энэ хэзээ өөрчлөгдөх вэ?

Хоёрдугаар асуулт өнөөдөр ганцхан орноос, ганцхан бүтээгдэхүүнээс нийт төсөв хамааралтай байна. Энэ дээр тэр улсын тусгаар тогтнол том юм ярихаа больё. Төсөв эрсдэлд орох уу? Одоо олон улсын судалгаанууд дээр ганцхан зэс л гайгүй байх магадлалтай бусдууд нь унана шүү гэдэг асуудал яригдаж байгаа. Энэ үед Засгийн газар үндсэндээ энэ их нүүрсний мөнгийг Засгийн газар зардлаа санхүүжүүлж байгаа. Энэ дээр эрсдэл үүсэх үү? Та нар тооцоо судалгаа хийсэн юм байгаа юу?

Гурав дахь асуулт үндсэндээ энэ дээр нэг сайн юм бий. Урьд нь арматур, цемент зуурч байгаад л баахан хөрөнгө оруулалт гээд, төсвийн хөрөнгө оруулалт гэж хийдэг байсан бол өнөөдөр зам ялангуяа эрчим хүч, дэд бүтцийн асуудал дээр гол анхаарч байгаа. Энэ их хөрөнгө оруулалт, мөнгийг өнөөдөр дандаа гадаадын зээл, тусламж дээр дулдуйдахаасаа илүү Үндэсний баялгийн санд үүсгэсэн хуримтлалыг санхүүжүүлэх тийм боломж, бололцоо, тооцоо судалгаа яагаад хийсэнгүй вэ? Гуравдугаар асуулт.

Дөрөвдүгээр асуулт. Одоо нарийвчилъя. Хөдөө аж ахуйн яамныхан ороод ирсэн байх гэж бодож байна. Хүнд үйлдвэрийнхэн байгаа байх. Төсөвтэй холбогдуулаад асууж байгаа шүү тэр гуравдугаарт, хуудас 14-өөс 15 эдийн засгийн төрөлжилт, либералчлал хэсэгт хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн бодлогыг тодорхойлоогүй гээд заачихсан байгаа. Хүнд үйлдвэр гэж юу юм, хөнгөн үйлдвэр гэж юу юм гэж ямар ч тодорхойлолт байхгүй байхад та нар төсвөөр яаж хөнгөн үйлдвэрийг, хүнд үйлдвэрийг дэмжих вэ, яаж төрийн бодлогоор хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэрлэлийг дэмжих вэ? Асуулт бол энэ тодорхойлолт байгаа юу гэж байгаа. Та нарын хариулт бол байхгүй гэвэл. Энийг дагалдах хуулиудаар оруулж ирэх боломж байгаа юу? Хэзээ энэ орж ирэх юм бэ? Монгол төр хөнгөн үйлдвэрийн, хүнд үйлдвэрийн ямар ч хууль, бодлогын баримт бичиггүй өнөөдөр хүртэл явна гэдэг та нар ажлын байран дээр үгүй гэж хэлж байгаатай адилхан. Үйлдвэрлэлийг ам болгон дээрээ, хуудас болгон дээрээ ажлын байр үйлдвэрлэл гэж ярьж байгаа. Яг энэнийхээ эсрэг байна. Энэ дээр та нар хариулт өгөөч хэзээ вэ?

Дараагийн асуулт их чухал зүйл. Аж үйлдвэржилтийн байнгын хороогоор орж ирэх үед асуухад бэлэн байгаарай гэж асууж байгаа юм. Аж үйлдвэржилтийн сэргэлтийн зорилгын хүрээнд 100 хувь тоног төхөөрөмжийг импортын татварыг 100 хувь тэглэнэ гэж байгаа юм. Хэзээ хэзээ орж ирэх вэ? ОХУ болон чөлөөт худалдааны түр хэлэлцээрийг Солонгос улстай, Хятад улстай хэлэлцээг эхлүүлнэ гэж байгаа юм. Яг хэзээ? Энэ ингээд л бухын доодхыг харж үнэг турж үхнэ гэж ямар олон жил ярьдаг юм бэ. Өнөөдөр малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүнийг экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ гэж байгаа юм. Хэзээ? Яг ямар механизмаар энийг хариуцсан яамдууд нь энэ дээр хариулт өгөх боломж байна уу?

Эцэст нь бүх юм л тэр нийлүүлэлтийн шокт орчхоод байна. Тасалдал, Тяньжин боомтоор бүх юм ингээд гацаад байна гэж байгаа юм. Үгүй Тяньжин боомтод Монгол Улсын өөрийн гэсэн эзэмшил газартай байгаа шүү дээ.

Б.Пүрэвдорж: Таны асуултад хариулах хоёр сайд байхгүй байна даа. Эхний ээлжид Жавхлан сайд хариулж байя. Тэр хооронд хариуцсан яамны ажилтан.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Төсөв эрсдэлд орох уу гэж байна. Ерөнхий утгаараа бол эрсдэл орохгүй байхаар тооцоолууд хийгдэг хуулийн заалтууд, дүрэмтэй. Тэр дүрмийнхээ хүрээнд л бид ягштал хийж чадсан бол эрсдэлд орохгүй гэсэн үг. Өөрөөр хэлбэл, эрсдэлээс хамгаалах ийм зохицуулалтуудыг төсөвт маш тодорхой ойлгомжтой суусан байдаг.

Тэгэхээр эрсдэл мэдээж орлого талтай байна. Орлогын хувьд уул уурхайгаас шууд хамааралтай болон дам хамааралтай орлого нь үндсэндээ 33.11 их наяд нь буюу гуравны нэг орчим нь байгаа юм. гуравны нэг орчим хувь нь. Ингээд бид энд Тогтворжуулалтын сан гэдэг ойлголт байдаг.

Өөрөөр хэлбэл, таны ярьж байгаа эрсдэл үүсвэл алдагдлыг хаах, үйл ажиллагааны доголдлоос урьдчилан сэргийлж байх ийм зохицуулалттай, дүрэмтэй, төсөвтэй гэсэн үг. Энэ тогтворжуулалтын санд өнөөдрийн байдлаар 1.6 их наяд хуримтлагдсан байна. Ирэх жил бидний тооцоолж байгаагаар 608 тэрбум төгрөг нэмж хуримтлагдана. Яг таны хэлж байгаагаар зэс нэлээн өсөлттэй өөдрөг байхаар ийм Эдийн засаг, хөгжлийн яамнаас төсөөлөл ирсэн.

Бид орлогоо тооцоолохдоо 2 үнэ авдаг. Зах зээлийн дундаж үнэ, тэнцвэржүүлсэн үнэ. Ингээд аль багаар нь орлогоо тооцдог гэсэн үг. Нүүрсний хувьд, зэсийн хувьд ирэх жил яг эсрэгээрээ байгаа. Тэнцвэржүүлсэн үнэ зэс дээр 7500, зах зээлийн үнэ 10000 доллар.

Өөрөөр хэлбэл, бид тэнцвэржүүлсэн орлогоо 7500-гаар тооцсон гэсэн үг. Зах зээлийн өнөөдрийн үнэ 10000-аас 7500 хүртэл унахад, унахад шүү дээ, 25 хувиар унахад бид Засгийн газрынхаа энэ үйл ажиллагаа, төсвийн бүх зардал үйл ажиллагааг бүрэн санхүүжүүлнэ. Ямар нэгэн эрсдэлгүйгээр. Ингэж тооцсон.

Юуны хувьд, нүүрсний хувьд эсрэгээрээ байгаа. Зах зээлийн үнэ 105 доллар жигнэсэн дундаж нь. Тэнцвэржүүлсэн үнэ нь бол 129 доллар байгаа. 129 доллароос давах үнэтэй коксожсон төрлийн нүүрснүүд ч байна. Тэндээс бид 80-аад тэрбум төгрөгийн нэмэлт орлого олоод тогтворжуулалтын сандаа оруулна гэсэн үг.

Тогтворжуулалтын санг хэзээ бид нар ашигладаг вэ гэхээр одоо голлох түүхий эдүүдийн үнэ буюу бидэнд ерөөсөө хоёрхон л түүхий эд байдаг, 3 түүхий эд байгаа. Зэс, нүүрс, алт гээд. Эдгээр түүхий эдүүдийн үнэ нь болон биет хэмжээ нь төлөвлөснөөс 20 хувиар унавал тогтворжуулалтын сангаа ашиглана. Дээрээс нь төсвийн алдагдал өнөөдөр 2 хувь гэж байна, бид нар төсөвлөж байна. Хэрэв 4 хувиас давбал тогтворжуулалтын санг ашиглана гэсэн бид нар ийм хуулийн заалтуудтай.

Тэгэхээр энэ дээр бид төсвийн дүрмээ яг баримталж ингэж төсвөө би төлөвлөж оруулж ирж байгаа учраас төсөвт ямар нэгэн эрсдэл үүсэж, төрийн үйл ажиллагаа доголдох, тасалдах ийм зүйл огт бий болохгүй гэж ингэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. 1, 6 номер.

И.Батхүү: Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Төсвийн хүрээний мэдэгдэл 2025 оноос эхлээд энэ төсөв дагаж өөрчлөгдөх явдал нь зогсож байгаа. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон 2023 оны өөрчлөлтийн дагуу. Энэ удаагийнх нь 8 сарын 30-нд Төсвийн тогтвортой байдлын тухай

хуульд орсон өөрчлөлтийн дагуу Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд нь өөрчлөгдсөн учраас зайлшгүй энэ удаагийн өөрчлөлт орсон юм гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь ОХУ, Солонгос улстай хийж байгаа хэлэлцээрүүдийн явцын талаар мэдээлэл өгье. Евроазийн эдийн засгийн холбоотой Эдийн засаг, хөгжлийн яам ахлаад хэлэлцээ 1 жилийн хугацаанд маш эрчтэй явуулаад 2 удаагийн албан ёсны хэлэлцээ бусад ажлын хэлэлцээрүүдийг хийгээд энэ ондоо эцэслэж 375 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг экспортын Орос талаасаа импортын татваргүй, квотгүйгээр оруулах боломжийг бүрдүүлж байгаа. Хоёр талын соёрхон батлуулах, албажуулах процессын дагуу ирэх онд яг хэзээ хүчин төгөлдөр болох нь тодорхой болно. БНСУ-тай бас.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмээд 1 минут өгчих.

И.Батхүү: БНСУ-тай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг явуулаад гурван шатын хэлэлцээ амжилттай дууссан. Дөрөв дэх шатын хэлэлцээг энэ 11 дүгээр сарын 25-нд хийхээр ажиллаж байгаа. Энэ ондоо өмнө багтааж хэлэлцээний агуулгаа тохиролцоно. Ирэх онд соёрхон батлуулах, албажуулах ажлууд нь явагдана.

Хүнд үйлдвэрийн яамны, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Болдын Отгонцэцэг. 1 номер. Жавхланбаатар 1 номер.

Б.Пүрэвдорж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Жавхланбаатар, гишүүний асуултад хариулья.

Хүнд, хөнгөн үйлдвэрийн салбарын ялгаа тодорхойлолтыг асууж байх шиг байна. Хүнд үйлдвэр, аж үйлдвэрийн яг тодорхойлсон одоогоор бол хуулийн нэр томъёолол бол байхгүй. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого байгаа 15 оноос. Энэ бодлого дээр бичсэн хэллэгүүд болон манай мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар бол бид нар хүнд үйлдвэр гэдгийг юу гэж ойлгож байна вэ гэхээр эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүд дээр суурилж боловсруулалт хийн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хүнд үйлдвэрлэл гэж ойлгоно гэсэн ийм ойлголттой. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулья.

С.Ганбаатар: Дарга их гоё юм ярилаа, баярлалаа.

Ямар ч тодорхойлолт байхгүй. Тэгэхдээ гишүүдэд бас энэ тодорхойлолтын тухай ойлголт өгч ухааны маань сүвийг нээж өгсөнд баярлалаа. Энэ арчаагүй байдлаа засаад албан ёсоор тодорхойлолттой болно. Хамгийн гол нь хүнд үйлдвэрийн, хөнгөн үйлдвэрийн хуультай болох ёстой. Яамнууд нь хүн шиг ажиллаарай. Монголын ард түмний татвараар та нар цалинждаг шүү.

Хоёрдугаарт, нарийвчилж асууя. Энэ төсөв дагаж орж ирж байгаа Засгийн газрын үнэт цаас гаргах, эрх олгох тухай хууль дээр Ерөнхий сайд ингэ Оюун-Эрдэнэд гадаад, дотоодын үнэт цаас гаргах эрх ингээд өгсөн байна. 25 оны 1 дүгээр сарын 1-нээс өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэж байгаа. Энэ ингээд хязгааргүй ингээд л үнэт цаас гаргаад байж болох уу, зээл аваад байж болох уу гэсэн үг үү? Би их нарийвчилсан юм асуучихлаа.

Нийгмийн даатгалын сангийн орлого нь зөрчөөд байна. 4 их наяд 438, нөгөө.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тэр үнэт цаасны, Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Тэр үнэт цаасны эрх авч байгаа нь бол бид төсвийн орон зайгаа авч байгаа байхгүй юу. Ирэх жилүүдэд ингээд мега төслүүд, томоохон төсөл, хөтөлбөрүүд явна. Тэрэнд шаардлагатай тохиолдолд Засгийн газрын үнэт цаас мөн баталгаа гаргах эрхээ авч байна гэсэн үг.

Харин ямар төсөлд ямар хэмжээний баталгаа гаргах вэ, үнэт цаас гаргах вэ гэдгийг эцэст нь энд шийднэ. Тухайлан төсөл бүрээр нь энд оруулж ирж Их Хурал дээр шийддэг ийм зарчмаар явна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл дотор чинь 55 хувийн хязгаартай байгаа тийм ээ. Өрийн хязгаар маань. Бид нарын гүйцэтгэл бол 42.6 гэж ингэж зорьж орж байгаа. Тэгэхээр энэ саяын эрх авч байгаа энэ бүх юмнуудыг тооцоолоод, багтаагаад хэмжихээр 42.6 хувь нь байгаа шүү. Бүр нэрлэсэн үнээрээ шүү. Өнөөгийн үнэ цэнээр биш, өсгөсөн үнээр гэсэн үг. Тэгэхээр энэ нөгөө 42.6 дахь хязгаар дотроо эрсдэлгүйгээр багтаж орж байгаа гэсэн үг.

Би сая тэр нийгмийн даатгалын хэмжээг, зөрүүг би ойлгосонгүй. Энх-Амгалан сайд хариулах юм уу? Манайхаас хариулчих юм уу?

Б.Пүрэвдорж: Энэ хооронд би нэг юм, Ганбаатар гишүүний асуугаад байгаа нэг зүйл байна шүү дээ. Өөрөөр хэлбэл, ирэх жил 83 сая тонн нүүрс гаргах юм байна. Тэр нүүрснийхээ үнийг 129 доллар гээд төсөөлсөн юм байна. Тэгээд тэрийгээ төсөв дээр тавьж. Гэтэл өнөөдөр 105 доллар байна. 1 тонн нүүрс.

Тэгэхээр энэ хоёрын хооронд чинь 24 доллар гарч ирж байна. Тэрийгээ 183 сая долларт, тонн нүүрсэд үржүүлэх дээр чинь 2 тэрбум долларын дутагдал гарч ирээд байна шүү дээ. Цаашдаа нүүрс унана гээд байх юм. Тэгээд тэрний чинь 2 тэрбум гэх дээр 7 их наяд төгрөгийн асуудал гарчихна.

Гэтэл танай Тогтворжуулах сан чинь дөнгөж 1.5-хан, дээрээс нь ирэх жил 500 нэмэгдэнэ гэж байна. Тэгээд 2-хон тэрбум. Тэгээд энэ юмнуудаа яаж нөхөх юм бэ л гэж Ганбаатар гишүүн асуугаад байна шүү дээ. Энэ дээр Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Асуултад нэмж хариулъя. Би дутуу ойлгуулчихсан юм уу даа. Зах зээлийн үнэ, тэнцвэржүүлсэн үнэ гэж хоёр ойлголт байдаг. Аль багаар нь бид нар орлогоо тооцоолдог гэсэн үг. Энэ жилийн хувьд зэс дээр зах зээлийн үнэ нь 10000 доллар, тэнцвэржүүлсэн үнэ 7500 доллар. Ингээд зэсийнхээ орлогыг 7500-гаар авна. Нүүрс дээр зах зээлийн үнэ нь 105, тэнцвэржүүлсэн үнэ 129 доллар. Бага нь 105 доллар байгаа учраас бид нар орлогоо бага буюу зах зээлийн үнээр нь авсан гэсэн үг. 129-өөс давах хэд хэдэн коксожсон 3 төрлийн ялангуяа коксожсон төрлийн байгаа. 129-өөс давах. Тэр давсан хэмжээгээр бид тогтворжуулалтын сандаа хийдэг гэсэн үг.

Тийм учраас бид эрсдэл 105-аас доош нүүрсний хувьд, зэс дээр бол 7500-аас доош энэ тэр депозон дотроо ярина гэсэн үг

Тэгээд Тогтворжуулалтын сан бол өөрөө хязгаар нь аль аль дээрээ биет хэмжээгээр ч тэр, үнийн хувьд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Сүүлийн тодруулга шүү. Ганбаатар гишүүн .

С.Ганбаатар: Тийм, хангалтгүй хариулж байгаа. Байнгын хороон дээр дэлгэрүүлэх боломж олдох байх. Тэгээд нийгмийн даатгалын энэ хуудасны чинь 6 дээр байгаа шүү дээ. Санжаа даргаа энэ хэн нь хариуцдаг юм бэ? Энэ орлого нь 2 тоо байна шүү. 4.4 их наяд, 5.4 их наяд, 1 их наядаар зөрсөн байна. Зүгээр тэрийг тодруулахгүй бол энэ хэрвээ редакцын алдаа бол хэлэх ёстой шүү.

Хоёрдугаарт, тэр Эрүүл мэндийн сайд ороод ирсэн байна. Хөдөөгүүр явж байхад эмийн санхүүжилт дандаа хасахтай байна. Баянхонгорын Байдраг гэхэд 30 саяар бид ингээд өрөнд орчихсон. Ингээд эмийн санхүүжилт авах гэхлээр Эрүүл мэндийн даатга төлөөгүй гээд ингээд санхүүжилт өгөхгүй байна. Эмчийн тангаргаа л зөрчих болчихоод байна гээд асуудлууд яриад байсан. Энэ төсөв дээр энэ асуудал шийдэгдсэн үү? Эрүүл мэндийн даатгал, төсөв хоёрын харьцаа эрүүл мэндийн санхүүжилт дээр хэдэн хувь байгаа вэ? Даатгал, төсөвт ачаалал хоёр гэсэн ийм хоёр асуултад.

Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан, тэрний дараа Энх-Амгалан сайд бэлтгэж байгаарай.

Т.Мөнхсайхан: Ер нь хөдөө орон нутаг гэлтгүй эрүүл мэндийн байгууллагууд дээр бас эм, эмнэлгийн хэрэгсэл дээр өртэй асуудал байгаа. Тэгээд энэ асуудлыг би түрүүнээс хойш яриад байгаа. Тэгээд ирэх оны төсөв дээр өнөө 24 оныг хүртэл хуримтлагдсан энэ 218 тэрбумын асуудал шийдэгдэж тусгагдсан байгаа.

Тэгэхээр ирэх жилээс энэ эрүүл мэндийн салбарт үүсэж байгаа асуудлууд маань тодорхой хэмжээгээр шийдэгдэх болов уу гэж ингэж харж байгаа. Яг төсөв дээр Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс орж байгаа орлого, төсвөөс орж байгаа орлого хоёрын харьцаа ер нь 40, 60 хувийн харьцаатайгаар өнөөдөр байгаа.

Даатгал нь 60.

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганбаатар гишүүн ээ яг Нийгмийн даатгалын энэ сангийн орлого, зарлага хоёр бол бас хоёулаа мөргөх юугүй шүү дээ, шаардлагагүй шүү дээ. Яагаад гэвэл орлого нь 5.6 гээд байж байхад зардал нь 4 гэдэг нь бол 4 сангийнхаа, дагасан 4 сангийнхаа гүйцэтгэлээрээ л ингээд гарч явдаг л ийм л юутай шүү дээ. Тэгээд цаашдаа бол бид нар мэдээж энэ Нийгмийн даатгалын сан чинь төсвөөс авч явж байгаа татаас чинь жил бүхэн нэмэгдэх ийм бодитой эрсдэлүүд үүсчхээд байна. Энэ жил 1.4 их наядын татаас авч байна. Хойтон бол ингээд 2 их наяд руу, тэрний дараагийн жил рүү ингээд бид нар 3 их наядын татаас авах ийм бодитой эрсдэлүүд үүсэж байгаа учраас бид нар энэ тэтгэврийн шинэчлэл, тэтгэврийнхээ реформын асуудлуудыг, тогтолцооны шинэчлэл хийж байж энэ асуудлыг дээр л тодорхой шийдэл гаргах ёстой л гэж би ойлгож байна. Сая Санжаа танд нэлээн дэлгэрэнгүй тайлбарлаж байх шиг байна тийм үү? Тийм.

Б.Пүрэвдорж: Боомтын Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд Тулга хариулна.

Б.Тулга: Ганбаатар гишүүний хөндсөн Тяньжин боомт дээрх газрын асуудлаар бас мэдээлэл хүргэчихье. Яагаад гэвэл энэ дээр бас яг логистикийн зориулалт, тээвэр логистикийн зориулалтаар ашиглагдах газар юм шиг ойлгогдоод байгаа юм байна лээ. Тэгэхлээр бид нар бас Ерөнхий сайдын айлчлалын хүрээнд 23 онд Тяньжин боомт дээр очиж ажилласан. Ингээд газар дээр нь танилцахад бол энэ Монгол Улсад санал болгоод

байгаа Тяньжин боомтын 10 га газрын асуудал байгаа. Энэ бол энэ 10 га газрыг хөрөнгө оруулаад, тэгэхдээ тэр ашиглаж байгаа компанийн 49 хувийг л эзэмших тухай ийм асуудал байгаа юм билээ. Тэр газрыг нь газар дээр нь очиж үзэхэд бол хиймлээр үүсгэсэн, тээвэр ложистикийн зориулалтаар биш харин тэнд чөлөөт худалдааны бүс байдаг юм уу, худалдааны зориулалтаар оффис барих маягаар ашиглахаар үйлдвэр, оффис маягаар ашиглахаар ийм газар юм байна лээ шүү.

Тэгээд энийг ашиглахын тулд 49, ашиглах эрхээ авахын тулд Монгол Улс тэр 49 хувийг нь эзэмшихийн тулд 8 орчим сая долларыг төлж байж ашиглах эрхээ авна. Монгол Улс тэр дээр 8 сая долларын хөрөнгө оруулалт хийгээгүй байгаа. Тээвэр ложистик.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одоо Болдын Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр өөрийн байнга хөндөж байгаа агуулгуудаараа холбогдох яамдаас нь 3 асуулт асууя. Тэгэхээр Боловсролын яамныхнаас асуулт асууя. Сайд нь өдөржингөө байсан. Одоо бол харагдахгүй байна. Тэгэхээр Монгол Улсад мега төслүүд хэрэгжих гэж байна. Тэгээд аж үйлдвэржилт бас хөгжөөд явна. Гэхдээ бид нарт инженерүүдийн эрэлт үүсэж байгаа, ер нь үүсчихсэн яваа. Тэгэхээр энэ дээр Боловсролын сайдын багцад суусан төсвөөс 2025 онд ямар ямар чиглэлийн ажил төлөвлөгдсөн байгаа вэ? Тэгэхээр 2022, 23, 24, 25 оны Боловсролын сайдын багцыг харахад ер нь ямагт өсөж яваа юм байна. Тэгэхээр энэ чиглэл рүү мэдээж тэлж үйл ажиллагаа төлөвлөж байгаа байх. Тэгэхээр энэ талаар хариулт хэлээд өгөөрэй.

Байгаль орчин, уур амьсгалын сайдад бас асуулт асууя. Тэгэхээр аж үйлдвэржилт хөгжихөд хамгийн тулгамдаж байгаа асуудал эрчим хүчний эрэлт байгаа. Эрчим хүч бид нар шаардлагатай, мөн ус бас хэрэгтэй байгаа. Тэгэхээр таны асуу, таны эрхлэх ажлын хүрээнд усны асуудал байдаг учраас энэ устай холбоотой таны багцад суусан төсөв 2025 онд ямар ямар үйл ажиллагаанд зарцуулагдах вэ? Тэгэхээр ер нь манайд нийтлэг ойлголт байгаад байдаг. Газрын доорх ус гэхээр бүгд цэнгэг юм шиг. Тийм учраас газрын доорх усыг үйлдвэрлэлд ашиглахгүй гээд байдаг.

Тэгэхдээ газрын доорх ус бол аль бүсэд байгаагаасаа шалтгаалаад ихэвчлэн бол, жишээ нь говийн бүсэд нэлээн давстай байгаа. Тэгэхээр яг энэ усны чанарын асуудал бол бид нар нэлээн их ярьж байх ёстой. Тэгэхээр усны чанар, чанарыг тогтоох, сайжруулах энэ чиглэлд бас таны багцад 2025 онд ямар ямар төслүүд суугдсан байгаа вэ?

Гуравдугаар асуултыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныханд тавья. Тэгэхээр Монгол Улс уул уурхайн салбар энэ хэрэгжиж байгаа төслүүд экспортолж байгаа бүтээгдэхүүнүүдээсээ төсвөө бүрдүүлж байгаа. Тэгэхээр бид нар хажуугаар нь хариуцлагатай байх энэ асуудлыг байнга ярьдаг. Тэгэхээр манай аж ахуйн нэгжүүд жил ирэх тусам л хариуцлагажиж байгаа.

Гэхдээ улам хурдацтай, эрчимтэй явах ёстой. Тэгэхээр таны Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны багцад суусан төсвөөс 2025 онд бас ямар ямар ажлууд туссан байгаа вэ? Мөн хууль, эрх зүйн орчинд энэ хариуцлагажих гэдгийн хүрээнд ямар ямар ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэх гэж байгаа талаар асууя.

Боловсролын яамнаас хэн байна? Сайд дөнгөж сая гараад явчих шиг болох юм. Энэ хооронд Жавхланбаатар дарга. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар индрийн 1 номер.

С.Жавхланбаатар: Гишүүний асуултад хариулья.

Уул уурхай салбарт бид нар, хариуцлагатай уул уурхайн асуудлыг та бас ажиллаж байсан мэдэж байгаа. Үндсэндээ байгаль орчин, нийгмийн хариуцлага, дээр нь засаглалын гээд ийм 3 багана дээр авч үзэж бид нар бол бодлогоо явуулж байгаа.

2018 оноос хойш эдгээр бодлогыг нэг стандартад шилжүүлэхээр Байгаль орчны яам, Уул уурхайн яам тухайн үеийн холбогдох газрууд нийлээд энэ олон улсын кодексыг энэ хариуцлагатай индексийг бол нэвтрүүлж ажиллаа гээд өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Мэдээж энэ бол уул уурхайн гол ачааллыг үүрч явдаг хувийн хэвшлүүд маань энийг хэрэгжүүлж байгаа. Хэрэгжилтийн түвшин бол мэдээж тухайн компанийн чадавхаас шалтгаалаад янз бүр байгаа.

25 онд бид нарын төлөвлөж байгаа бол саяхан бас Уул уурхайн ассоциаттайгаа хамтраад яам гэрээ байгуулсан. Канадын ахисан түвшний кодексыг нэвтрүүлэх цаг нь болжээ гэж үзээд гэрээ байгуулсан. Энийг бол төлөвлөгөөндөө тусгасан. Төсвийн хувьд бол мэдээж бид нар аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтраад төсвөөр биш улсын төсвөөр биш, хувийн хэвшлийнхээ төсвөөр мэдээж яамны зүгээс бодлого зохион байгуулалтыг зохицуулж ажиллахаар ингэж төлөвлөсөн байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Байгаль орчин, уур амьсгалын ер өөрчлөлтийн сайд Одонтуяа гишүүн хариулна. Уянга гишүүний асуултад хариулья.

С.Одонтуяа: Энэ жил урсгал төсөвт усны нөөц гол мөрний менежмент хөтөлбөрийн зардалд 3.5 тэрбумыг төсөвлөсөн байгаа.

Хөрөнгө оруулалтад усны салбарт дараах 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 19.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Энд 24 оноос он дамжин хэрэгжиж байгаа хэд хэдэн төслүүдээ дуусгана. Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах урсцыг сайжруулах төсөл, Хэрлэн голын бохирдол, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл, Өгий нуурын бохирдол, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл.

Шинээр бол гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулахад тодорхой мөнгө тавьсан 13.1 сая төгрөг. Бумбатын рашааны бохирдол, ширгэлтээс хамгаалах урсцыг сайжруулахад бас 1.5 тэрбум тавьсан.

Тэгэхээр би түрүүн бас ярьсан энэ жил манай дээр төсөв маш их танагдсан байгаа. Тэгэхээр бид дандаа гадаадын энэ тусламж, хандиваар энэ нэлээн усны асуу.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ 14 мега төсөл энэ олон төслийг яг ингээд авч явах юм бол яахын аргагүй инженерүүд, яг л энэ чиглэлийн улсууд. Тэгэхээр энэ чиглэлээр өнөөдрийг хүртэл бол Мянган инженер гээд төсөл хэрэгжиж, амжилттай хэрэгжсэн байгаа.

Коосэн сургуульд Япон маягийн инженер бэлддэг энэ сургуульд хүүхдүүд бэлтгэгдсэн ийм байна. Одоо метро барихтай холбоотой ШУТИС дээр бас энэ хамтарсан энэ сургалтуудыг явуулж байна. Түүний зэрэгцээ цаашдаа бид энэ олон улсын инженерийн их сургуулийг Хөшигтийн хөндийд ШУТИС-ийн харьяанд байгуулахаар Хятадын талтай хэлцэл хийгээд явж байна. Ер нь Коосэн төсөл буюу инженер бэлддэг энэ 5 жилийн сургалттай энэ сургуулиудыг бүсүүдэд байгуулах энэ ажлуудыг бас бид ярилцаж хийж байна.

Цаашдаа ч гэсэн энэ инженерүүдийн чиглэлээр, байгалийн ухааны чиглэлээр яв суралцаж байгаа хүмүүс бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Болчихсон уу? Наранбаяр сайдаа сая та хэлж байна. Бүсүүдэд сургууль, их, дээд сургуулиудыг байгуулах тухай асуудал. Тэгэхээр манай Ховд их сургууль бол баруун бүсийн МУИС-ийн харьяа сургууль болсон. Тэгээд эндээс очсон тэр захирлууд тэнд сэтгэлээсээ хандахгүй байна. Тийм учраас тэр хуучин бүсийн сургууль болох тэр ажлыг бас хийх нь зүйтэй шүү. Тэгж байж бид нар энэ төвлөрлөөс орон нутаг руу шилжүүлэх тэр ажлуудыг хийнэ.

Тэгээд энэ дээр бас тодорхой ажил хийгээрэй гэж танаас хүсэх байна. Ингээд Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: 25 оны төсөв яригдаж байна. Монгол Улсад өнөөдөр тулгамдаж байгаа асуудлуудыг жагсаавал асар олон л асуудал, асуулт гарна. Эдгээрийг бараг олныг нь зэрэг шийдэж чадах хамгийн чухал асуудал тэгээд л явсаар явсаар байгаад бид нар яаж баян чинээлэг болох юм гэдэг асуудал дээр тулж очих байх л даа. Хэрвээ жаахан чинээлэг болчихвол энэ ардчилсан тогтолцоо ч маань батжих, бэхжих бүхий л зүйлийн бараг шийдэл гарц болчихож.

Тэгэхээр улс орон хөгжинө, дэвшинэ, баян чинээлэг болно гэдэг чинь явсаар байгаад гадаадын хөрөнгө оруулалтыг яаж татах юм бэ? Энэ улс оронд экспорт хийж, гаднаас юу олж ирж байна вэ гэдэг зүйл бараг ганц түлхүүр нь болж хувирах байх. Тэгэхээр саяын 2 зүйлийг хангаж байгаа экспорт хийх боломж манайд өнөөдөр уул уурхайд байна. Гаднын хөрөнгө оруулалтыг яг бодитойгоороо татах боломж уул уурхайд л байна.

Тэгээд эндээс ингээд харахаар бид нар уг нь ийм байдаг. Тэгээд нийтээрээ уул уурхайг үзэн ядсан, нөгөө талдаа баян чинээлэг болж, орлоготой болохыг хүссэн ийм ард түмэн болоод бид нар хувирчихсан. Төр засаг нь ч бас энэндээ таарсан яг л ийм л бодлогоо л бид нар явуулдаг.

Тэгэхээр эндээс юуг хэлэх гээд байна вэ гэхлээр энэ төсөв дагаж орж ирсэн Баялгийн сангийн тухай хууль байгаа. Ер нь саяхан энэ хавар батлагдсан хууль. Энэ хуульд яг саяын тэр орлого олох боломж, баян, чинээлэг болох боломж, гаднын хөрөнгө оруулалтыг татах боломж, экспортыг нэмэгдүүлэх боломжийг нэлээн тийм эвгүй байдалд хаасан нэг заалт орсон. Тэр стратегийн ордын 34 хувийг төр заавал авна гэдэг заалт гэж би боддог. Энэ ашигт малтмалын байгалийн баялаг ард түмэнд дийлэнх олонх нь очих энэ зарчим бол мэдээж зөв. Энийг энэ Үндсэн хуулийн үзэл санааг бид нар хэрэгжүүлэх хэрэгтэй.

Тэгэхдээ яаж авах вэ гэдэг. Яг 34 хувийг нь албан ёсоор авна гэхчлээр энд ямар хөрөнгө оруулалт орж ирэх билээ? Хэн ийшийгээ хөрөнгө оруулж яг төртэй ойлголцож,

тэр тусмаа Монголын төртэй ойлголцож цаашаагаа явах билээ гэдэг асуудал яг энэ баялгийн сангийн тухай хуулийн энэ заалтуудаар хязгаарлагдчихсан байгаа. Тэр тусмаа эдийн засаг жоохон өсөх аядаж байсан 12 онд бид нар хөрөнгө оруулалтыг боомилсон, хаасан бас гоё нэртэй хууль гаргаад л хайж байсан. Одоо яг дахиад жоохон цонх нээгдэнгүүт бас яг ийм бодлого л явчихлаа л гэж боддог. Яг яагаад 34 хувь дээр ингээд эмзэг хандаж байна вэ гэхээр бид нарт саяхны сургамж байна шүү дээ. Оюу толгойн 34 хувийг авснаас болоод энэ буруу шийдвэр болчихлоо. Тэр өр, зээл нь хүртэл бид нарт хамаатай болчихлоо. Тэр шинээр нэмж оруулах хөрөнгө оруулалт нь хүртэл бид нарт мөнгө нь байхгүй болчихлоо гэдэг саяхны энэ сургамжаа яг энэ баялгийн сангийн энэ зүйл заалт дээр юу гэж бодож байгаа вэ? Саяхны энэ сургамж. Энэ чинь бид нарын тэр хөрөнгө оруулалт, экспорт, олон зүйлүүдийг чинь хааж, энэ төсөв? олон олон зүйлүүдийн маргаашийн боломжуудыг чинь хаагаад байна шүү дээ гэдэг.

Тэгэхээр эндээс тэгвэл энэ 34-тэй, 34 хувьтай тэр Ашигт малтмалын хууль болоод зүйлүүд дээр байгаа зүйл, заалтыг яах юм гэдэг асуудал. Тэгэхээр энэ дээр тэр давуу эрхийн хувьцаа гээд бид нарт нэн тэргүүнд ашгийн хувийг авдаг, өр, зээл олон зүйлүүдэд нь оролцдоггүй тэр боломжууд бид нарт бас байж л байгаа. Тэр боломжууд.

Тэгэхээр яг үндсэн бид нар бүгдийг нь энэ тогоогоо яаж томруулах юм гэж байгаа үндсэн асуултад энэ боомилсон төсвийг дагаж орж ирж хавархан батлагдсан Баялгийн сангийн тухай хуулийн энэ зүйл, заалт дээр би Сангийн сайдаас л энэ дээр хариулт өгөөч л гэж хэлэх гээд байна. Цаашдаа ер нь ямар бодлого баримтлах? Энэнээс гарах үр дагаврыг та ер нь юу гэж бодож байгаа юм? Маргаашийн энэ эдийн засаг, маргаашийн энэ төсвийн орлого бид нарын олон олон зүйлүүд дээр чинь энэ сөрөг нөлөө авчрах ийм нөхцөл байдал үүсчхээд байна гэсэн үүднээс л би танаас асуугаад байна л даа. Энэ дээр тодорхой хариулт өгөөч, байр сууриа.

Б.Пүрэвдорж: Цогтгэрэл гишүүний асуултад Болдын Жавхлан сайд хариулна.

Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Нэгдүгээрт, энэ хуулийн зохицуулалт өмнө нь ч тэр, одоо ч тэр, төсөв дагаж орж ирээгүй шүү. Тийм, төсөв дагаж орж ирсэн зүйл бас огт байхгүй. Тийм, өнөөдрийн хууль дээр ч байхгүй.

Яах вэ Засгийн газрын бодлого учраас би Сангийн сайдын хувьд өөрийнхөө хувьд ер нь энд сайд нарын хувьд өөрсдийн үзэл баримтлал гэж юу байх вэ дээ. Засгийн газраас шийдвэр гарсан. Бид энэ дээр л хатуу байна.

Гэхдээ энэ асуудлыг та бас 2 талаас нь хараасай гэж ингэж харж байна. Үндсэн хуулийн 6.2 дээр энэ газрын хөрсөнд байгаа энэ бидний энэ баялаг жигд, хүртээмжтэй ард түмэнд байх энэ зарчмыг хэрэгжүүлэх цөөхөн хэдэн суваг л байгаа. Цөөхөн хэдэн суваг байгаа. Үндсэн суваг маань бол энэ АМНАТ байдаг. АМНАТ байдаг. Өөр байж болох хувилбар нь бол төр хувьцаа эзэмшиж орох, тэрүүгээрээ дамжиж Баялгийн сангаараа мөн ингээд дамжиж ард түмэнд хүртээмжтэй байдлаар зохицуулалт хийх ийм сувгууд байгаа юм.

Гэхдээ тэр маань өөрөө бол бас хэлэлцээрийн зарчмаар хийгддэг ийм сонголттой хувилбар шүү дээ. Нэг талаар энэ хувийн хэвшил төртэй хамтарснаар бас нөгөө талаараа энэ чинь хамгаалалт болно. Тогтвортой байдлын урт хугацаанд үр дүнтэй байх, тэрийгээ жинхэнэ баялаг болгох энэ зарчим дээрээ төртэйгөө хамтраад явах нь бол бас тийм муу

зарчим бүх, муу зарчим гэж үзэхгүй бүх хөрөнгө оруулагч нар бас тэгж харахгүй байгаа. Энэ чинь бүр хэлэлцээр хийе, энэ 34 хувийг төрдөө эзэмшүүлье ингээд хамтраад явъя гэсэн ч хэлэлцээр хийе, хэлэлцээрийн ширээний ард суухад бэлэн байна гэсэн ч ийм төсөл, төсөл эзэмшигч нар байгаа.

Тийм учраас энийг тийм буруу зарчим болчихлоо гэж би үзэхгүй байна. Тэгээд Хэрэг эрхлэхийн сайд энэ дээр бас нэмж Засгийн газрын байр суурийг тодруулж хэлэх болов уу гэж ингэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд нэмж хариулна.

Н.Учрал: Тийм Цогтгэрэл гишүүн та бидний хамт баталсан Үндэсний баялгийн сангийн хууль л даа. Тэгэхээр Засгийн газрын үндсэн үүрэг бол хууль хэрэгжүүлэх. Энэ ч утгаараа Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх тогтоолыг баталсан. Тэгэхдээ тогтоол дээрээ тэр Ашигт малтмалын хуульд заасан 34 хүртэлх, 50 хүртэлх буюу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нөөцийг нь тогтоогдсон бол 50 хүртэлх хувь, хэрвээ хувийн зардлаар нөөцийг нь тогтоосон бол 34 хүртэлх хувь гэдэг заалтыг хэрэгжүүлэхдээ тэр стратегийн орд эзэмшиж байгаа компаниудтай хэлэлцээр хийе. Гол нь Үндсэн хуулийн 6.2 буюу газрын хэвлийн баялгийн дийлихэнхийг ард түмэн эзэмш гэсэн суурь зарчмаа барья гэсэн.

Тэгэхээр түүрүүн Жавхлан сайдын хэлж байгаа шиг АМНАТ-аар тооцох уу, эсвэл ноогдол ашгийг хуваарилаад хуримтлалын санд хуримтлуулах уу.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут хариулъя.

Н.Учрал: Тэгэхээр түүнийг бол бид нар хэлэлцээрийнхээ түвшинд л шийдээд явчхаж болно. Нэг ёсондоо энэ бол зүгээр хэлэлцээр хийе л гэдэг ийм л шийдвэр. Энэ ч утгаараа бол энэ стратегийн орд эзэмшиж байгаа одоо 2 компани гэхэд л албан байдлаар бид хэлэлцээр хийхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн.

Ер нь энэ улс төрийн тогтворгүй байдал бол хөрөнгө оруулагч нарт их сөргөөр нөлөөлдөг. Тийм ч учраас бид цаашдаа хөрөнгө оруулагч нарт ээлтэй нөхцөлийг бүрдүүлэхийн тулд яг энэ хөрөнгө оруулалтын гэрээг, эсвэл орд ашиглах гэрээг ч гэдэг юм уу Их Хурлаар оруулаад батлаад явчихвал цаашдаа энэ улс төрийн тогтворгүй байдлаас болж хөрөнгө оруулагч нарт сөргөөр нөлөөлдөг байдал бол зогсоно гэж үзэж байгаа юм. Тэгэхээр үүнийг заавал төр эзэмшлийн хувь тогтоогоод ТУЗ-д хүн суулгах гээд байхдаа биш, гол нь ноогдол ашгийг иргэдэд хуримтлуулъя, бид Баялгийн сангийн хуулиар баталсан хуримтлалын дансныхаа хуримтлалыг нэмэгдүүлье л гэдэг үндсэн зарчим.

Б.Пүрэвдорж: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулна.

О.Цогтгэрэл: Яг саяын заалтаас болж гарч болох сөрөг үр дагавар талаас нь л би хэлээд байна л даа. Жишээ нь энэ төслүүд алдагдалтай ажиллавал яах юм? 34 хувиар хариуцлага хүлээх үү? Энэ төслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр бол яах юм? 34 хувиар хөрөнгө оруулалт хийх үү? Энэ төслүүд, бүр өртэй төслүүдийг төрд шилжүүлчихвэл яах юм? Өрийг нь авах уу?

Тэгэхээр энэ бүгдээс чинь гарц, гаргалгаа нь энгийн хувьцаа биш, давуу эрхийн хувьцаа гэдэг зүйлийг эн тэргүүнд ашгийн 34 хувиар л төр давж байдаг энэ зохицуулалт

,харилцаа бид нарт асар том боломжууд энэ дээр байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ талаас бодчихвол наадах чинь гадна, дотнын хөрөнгө оруулагчдадаа ч ээлтэй олон зүйл, одоо хэлэлцээр гээд бас баахан нөхдүүд ил, далд тохироо хийе л гэсэн үг биз дээ энэ чинь?

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулья.

Н.Учрал: Би Цогтгэрэл гишүүнтэй 100 хувь санал нэг байгаа. Ер нь бол төр эзэмшлийн 34 хувийг тогтоогоод, түүн дээр нь Засгийн газар хувьцаа эзэмшиж боллоо гээд юу ч өөрчлөгдөхгүй. Гол нь ноогдол ашгаа иргэдэд л хуримтлуулах ёстой гэдэг зарчмаа л барьж байгаа.

Тийм учраас бид яг энэ Орано-гийн хөрөнгө оруулалтын гэрээн дээр хүртэл энэ асуудлыг хөндье гээд байгаа. Энэ Оюу толгой дээр гарсан алдааг бол бид дахиж давтахгүйн тулд бид тэр давуу эрхийн тодорхой хувьцаатай шаардлагатай бол орлогоосоо шалтгаалаад өсөн нэмэгдэх АМНАТ тооцдог, тэгээд газрын хэвлийн баялгийг 50 дээр нэмэх 1 иргэдэд хүртдэг үндсэн зарчмаа л барьчихъя. Тэрнээс менежментэд оролцоод бол энэ үр дүн гарахгүй. Төр заавал энэ менежментэд оролцоод явах шаардлагагүй. Зүгээр л ноогдол ашгаа эцсийн дүндээ хэлэлцээрээрээ, кэйс дээрээ суурилад тус тусдаа өөр өөр кэйс учраас ярилцаад явна.

Цаашдаа ч гэсэн энэ Ашигт малтмалын хууль дээр ч гэсэн бас энэ асуудлыг эргэж харах шаардлага үүсэж байна л гэж харж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Жигжидийн Батжаргал гишүүн алга байна.

Одоо миний үг хэлэхийн ээлж байна. Би эндээс хэлж болдог юм уу? Болох уу тээ?

Тэгэхээр 2024 оны сонгууль болсон. Ард түмэн сонголтоо хийсэн. Энэ сонголтоор эрх баригч нар эрхээ бариад яв, сөрөг хүчнийг хариуцлагаа тооцоод яв гэдэг ийм сонголтыг хийсэн. Үүнийх нь дагуу хамтарсан засагт орохгүй байх ийм хэвлэлийн хурлыг хийж байсныг та бүхэн мэдэх байх.

Тэгэхээр энэ гэвч 2024-28 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр орж ирсэн. Энэ хөтөлбөр дотор 14 том мега төслийг хөдөлгөх, 300 гаруй дэд төслүүдийг хэрэгжүүлэх ийм том зорилттой хөтөлбөр орж ирсэн. Тэгэхээр энэ урьд нь бол 2 том нам нэгнийхээ ажил дээр дэгээ тавих замаар энэ мега төслүүдийг хөдөлгөдөггүй, хөгжлөөс хойш нь татдаг ийм зүйл байсан бол энэ хамтарсан засагт ийн үед энэ том том төслүүдийг хөдөлгөх ийм зорилго агуулж байгаа нь бас энэ Засгийн газрыг дэмжих бас шалтгаан болсон.

Тэгэхээр яг энэ 25 оны төсөв орж ирж байна. Яг энэ 24-28 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй бас уялдаж байна. Урьд нь бид нар яадаг байсан бэ гэх дээр Жавхлан сайд мэдэж байгаа байх. Нэг сум дээр жалгын нэг хөрөнгө оруулалт тавьдаг, сум болгонд хөрөнгө оруулалт тавьдаг. 1 сум дээр сургууль барилаа гэхэд 25 онд нь 1 тэрбум тавиад, 26 онд нь 2 тэрбум, 27 онд нь 2 тэрбум гээд эхний жилээ бага тавьчхаад хойшоо ингээд данхайлгаад байдаг, тэр нь олон жил хэрэгждэг. Тэр болгоноороо ингээд данхайсан төсөв дээрээ зээл авч хэрэгжүүлдэг ийм л болчхоод байсан. Өр тавьдаг байсан.

Тийм учраас энэ 2025 оны энэ төсөв дээр нийтдээ 38 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх юм байна. Тэрний айн? Тийм ээ тийм шинэ шинэ. 38 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх юм байна. Тэрний зам, дэд бүтцийнх нь ажил бол энэ ялангуяа энэ улс орны хөгжилд маш их чухал. Эрчим хүчний найдвартай байдлаа хангах юм байна. Тэгээд

үлдсэн төслүүд нь бүгдээрээ мөнгө олдог, цаашдаа Монгол Улсын эдийн засагт хэрэгтэй ийм том том төслүүд байх юм байна л гэж би харж байгаа.

Тийм учраас энэ 25 оны төсвийг дэмжиж байгаа юм. Тэгээд энэ дээр бид бүхэн бас яг хамгийн гол нь нэг зүйлийг л хэлэхэд манай Монгол Ардын нам бол өнгөрсөн хугацаанд бас нэлээн том цавчаа хийдэг нам шүү. 8 жилийн туршид янз янзын хулгай хийсэн нам. Оффтейк гэрээ энэ тэр гээд одоо идээгүй, уугаагүй хүн байхгүй.

Тийм учраас энэ Ардчилсан намынхан хэдийгээр хамтарсан засагт орсон ч гэлээ бид нар энэ том том төслүүдийн үр ашигтай байдал, тэндээс одоо янз бүрийн байдлаар завшдаг энэ явдал дээр нэлээн хатуу хараа хяналттай байна. Хариуцлага, энэ дээр маш хариуцлагатай байна л гэдгээ бас хэлмээр байна. Тэгээд энэ дээр бүгдээрээ хамтдаа, одоо бол энэ улс орныхоо хөгжил дэвшлийн төлөө ажиллах цаг болсон л гэдгийг бүгдээрээ ухаарч, энд ажиллах хэрэгтэй л гэж хэлмээр байна. Би асуулт асуугаагүй шүү дээ.

Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тийм, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танд их баярлалаа. Тийм шинэ Их Хурал, шинэ Засгийн газрын хувьд анхны бүтэн төсвөө оруулж ирж байгаа. Яг суурь зарчмыг та хэллээ. Бид бүтцийн хөгжлийн үзэл баримтлал, дараагийн 30 жилийн эдийн засаг ,нийгмийн хөгжлийнхөө суурийг тавих гэж байгаа энэ төсөв маань өөрөө өндөр ач холбогдолтой юм.

Тийм учраас Улсын Их Хурлын даргын индэр дээрээс төсвийг дэмжиж байгаад талархал илэрхийлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд хүргэе. 2025 оны төсвийг бүхэлд нь бол ер нь зарчмын хувьд бол дэмжиж байна. Жижиг тойргийн шинэ хөрөнгө оруулалтуудаа 1 жилдээ тэсэж, эдийн засгийг тэлэх томоохон мега төслүүдийг эхний ээлждээ шийдвэрлэх энэ хөгжлийн төсөв бол бас их тийм зоригтой төсөв байна гэдгийг онцолмоор байна.

Миний хувьд жижиг асуулт асууна. Төсвийн тодотгол хэлэлцэж байхад Ахмадын сангийн талаар, Ахмадын ахмад настны хөгжлийн хуулийн талаар асуусан. Тухайн үед бол Энх-Амгалан сайд хариулахдаа 25 оны төсөвт 1 хувиар, цалингийн сангийн 1 хувиар Ахмадын санг, байгууллагууд, нэн ялангуяа төсвийн байгууллагуудад тусгаж орж ирнэ гэсэн ийм хариултыг өгч байсан. 25 оны, Бямбацогт сайдаа та дэлгэцээр дүүрэн гараад байна.

Тэгэхлээр Ахмад настны тухай хуулиар цалингийн сангийн 3 хүртэл хувиар ахмадын сан байгуулна гэсэн хууль 2017 оноос хойш хэрэгжиж байгаа. Ингэхдээ одоогийн байдлаар нийт аж ахуйн нэгж байгууллагын 8 хүрэхгүй хувь нь Ахмадын сан байгуулаад явж байна. 3 хувь хүртэл гэдэг маань бол 0.1 байсан ч болно. Зарчмын хувьд өмчийн хэлбэр үл хамаарч байгууллага бүр ахмадын сан байгуулна. Энэ Ахмадын сан ямар зориулалттай юм бэ гэхлээр тухайн аж ахуй нэгж, байгууллагад ажиллаж байгаад ахмад настны тэтгэвэртээ гарсан хүмүүст нэмэгдэл тэтгэвэр байж болно, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл урлаг, аялал, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах гэх мэтчилэн нийгмийн оролцооны маш олон төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой байгаад байгаа юм. Төр өөрөө үүнийгээ хуулиа, баталсан хуулиа өөрөө хэрэгжүүлэхгүй байгаа бол яаж хувийн хэвшлээс энэ асуудлыг нэхэн шаардах вэ

гэдэг нэг том асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр яагаад 25 оны төсөв дээр энэ цалингийн, энэ цалингийн сангийн 3 хүртэл хувиар сан байгуулагдсангүй вэ? Хэрхэн яаж байгуулах вэ гэдэг ийм том асуулт байна.

Сангийн яамнаас хариулт авсан. Цалингийн хэмнэлтээс авч үлдээд ирэх жилийн төсөвтөө авч үлдэж болно гэсэн ийм хариултыг өгсөн. Гэхдээ Ахмад настны тухай хуулиар төсөвтөө тусгаж, батлуулна гэж оруулсан байгаа учраас аудитын байгууллага тухайн жилийн тайлан, төсвийн зарцуулалтыг хянахдаа төсөвт суугаагүй зарцуулалтыг оруулсан байна гэдэг ийм дүн, үнэлгээг хийгээд байдаг, ийм сануулгыг өгдөг. Тэгэхээр яг яах ёстой юм бэ гэдгийг Сангийн яам болон аудитын байгууллагаас 25 оны хувьд төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн байгууллагууд Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх энэ заалтаа яаж биелүүлэх вэ гэдэг дээр яг тухайлсан хариултыг өгөөч. Эхлээд Сангийн яам, араас нь аудит яг Сангийн яамтай яг ижилхэн байна уу, үгүй юү гэдэг дээр яг хариултаа өгч, төсвийн ерөнхийлөн захирагч бүрд яг тэр хариултынхаа дагуу 25 онд энэ хуулийн заалтыг биелүүлэх чиглэлийг бас арга зүйн тусламжийг бас өгч явуулаач гэсэн ийм хүсэлтэй мөн асуулттай байна.

Энэ хуулийг хэрэгжүүлэхгүй бол яах вэ гэдэг хариуцлагын санкад бас хуульд тусгачихсан байгаа юм. Тэгээд энэ нь өөрөө юу юм бэ гэхлээр энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бол Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ. гэсэн заалт байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхэд төр өөрөө энэ хуулиа биелүүлдэг байх тал дээр Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн манлайлж ажиллах ёстой гэдэг үүргийнхээ хүрээнд энэ асуудлыг дахин дахин давтан асууж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тоонуудаа эхлээд хариулчихъя даа.

Б.Пүрэвдорж: Хэн Санжаа дарга хэдэн номер вэ? 5 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр төсөв дээр бол төсвөөсөө бол батлагдсан төсөвтөө багтааж байгуулахдаа бол, байгуулах ёстой 2 сан байдаг. Нэг нь, үүний нэг нь Ахмадын сан. Хуульд заасны дагуу бол цалингийн бол 3 хүртэл хувьтай бол, хувиар байгуулж болно гэсэн заасан байдаг.

Тэгээд байгууллага болгоны хувьд бол Ахмадын сангийн хэрэгцээ шаардлага өөр байдаг. Мэдээж хэрэг дөнгөж шинэ байгуулсан байгууллага, 100 жил болсон байгууллага, хэчнээн хүнтэй байгууллага, хэдэн ахмадтай байгууллагаасаа бас өөр өөр байдаг байх.

Тэгээд байгууллагуудын хувьд бол одоо нийтлэгээр ямар байдлаар Ахмадын сангаа байгуулж байна гэхлээр тухайн жилийн эцэст цалингийн сангийн хэмнэгдэж байгаа дүнгээсээ Ахмадын сангаа байгуулаад явж байгаа. Хэрвээ Ахмадын сан байгуулж байгаа тохиолдол бол манай Сангийн яамны хувьд гүйлгээг нэн даруй хийж байгаа. Мөн ахмадын санг бол бид нар татахгүй байгаа.

Өөрөөр хэлбэл, энэ сан маань эргэлтийн сан болоод, нэмэгдэж хуримтлагдаад, цаашдаа бол ингээд зарцуулаад явах бол боломжтой болж байгаа. Тэгээд Ахмадын санаасаа бол энэ ахмадын, ахмадаа зориулсан арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хөнгөлөлтийг үзүүлэх ийм боломж нь бол нээгдээд явж байгаа. Энэтэй холбоотой Сангийн яамнаас бол төсвийн ерөнхийлөн захирагчид бол 2 ч удаа арга, чиглэл бол өгсөн, арга зүйн зөвлөмж өгч байсан. Хамгийн сүүлд бол Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 9 сарын 17-ны өдрийн бичгээр бол бас чиглэл өгсөн байгаа. Тэгэхээр бүх яамнуудад хүргүүлсэн. Ийм байдлаар төсөвтөө зохицуулалт хийх, хэмнэлт үүсгэх ингээд хуулийн хэрэгжилтийг хамгийн гол нь Ахмадын тухай хуулийг хангаж ажиллах гэдэг байдлаар хийсэн.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ариунзаяа сайдын гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ ахмадын хууль, нийгмийн даатгалын сангийн, нийгмийн даатгалын тогтолцооны энэ асуудал бол энэ ойролцоо агуулгатай юм. Ер нь энэ бараг 1990 оноос хойш ярина даа энэ тогтолцооны асуудлыг. Энд маш их асуудал хуримтлагдсан. Яг л энэ эрчим хүчний салбар шиг. Жил бүр татаас нэмэгдээд яваад байгаа. Бид энд дорвитой ямар ч зөв шинэчлэл хийж чадаагүй. Одоо яг ийм цаг хугацаан дээр ирчихсэн байгаа. Улам л татаас нь нэмэгдээд, нөгөө хуримтлалын санаар явдаг энэ тогтолцооноос бид улам л алсраад байгаа. Энэ дорвитой шинэчлэлийг хийж байж энэ сан байгуулах, нөгөө хуримтлалын сангийн 2 хувийг бие даасан хэлбэрээр бүтэн мөнгөжүүлж тусад нь гаргах ч байдаг юм уу, энийг таны ярьж байгаа энэ цалингийн санг төсвийн зар

Б.Пүрэвдорж: Нэмээд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Төсвийн зардлаар хийх, шууд тусгаад хийх ийм боломжууд чинь улам л хумигдаад байгаа байхгүй юу. Одоо гишүүд маань ингээд төсөв нэмэгдэж байна, төсөв данхайж байна гээд шүүмжилж байна. Тэгвэл нөгөө урсгал зардал нэмэгдчихсэн 3.5 их наяд дотор сая энэ Ариунзаяа сайдын гишүүний шаардаж байгаа жишээ нь энэ Ахмадын тухай хуульд орсон энийг тусад нь төсвийн зардлаар бас байгуулж чадаагүй л байгаа байхгүй юу. Хэрвээ энэ мэтчилэн өөр хэд хэдэн хуулиуд байгаа. Бараг 10-аад хуулиудаар шууд зардлаар ингэж гаргах, сан байгуулах ийм зохицуулалтуудыг төсөвт багтаж чадахгүй байгаа гэсэн үг. Хуулиар шууд нэмэгдэх.

Тийм учраас энэ дээр бид тогтолцооны асуудал байгаа юм. Нийгмийн даатгал талдаа энэ асуудал бас гишүүдийн олон гишүүд асуулт асуухаар байна. Энэ хаа нэгтээ хөндөгдөж л таараа. Энэ Ахмадын энэ тухай хуульд гарсан энэ 2 хувийг бол бид шууд төсвийн зардлаар тавихаасаа ил.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дахиад 1 минут.

Б.Жавхлан: Илүүтэйгээр бид гарч болох хэмнэлтүүд сүүлийн жилүүдэд, сүүлийн жилүүдэд юу байх вэ ер нь жил бүрийн цалингийн зардал дээр хэмнэлт үүсдэг. Орон тоогоо нэлээд гүйцээж, гүйцээх мөн бусад өөр асуудлуудаас болоод энд нэлээн хэмнэлт гардаг.

Тэгэхээр ямар ч байсан хуулийн хэрэгжилтийн эцсийн үр дүн дээр сан бол байгуулагдана. Зардлаар уу, эсвэл хэмнэлтээс үү. Тэгэхээр тэр байгуулагдах эсэх дээр санаа зовохгүй. ингээд эрсдэлгүй байгуулагдана. Наана нь яригдах энэ тогтолцооны бид нар шинэчлэлийн асуудал бол нэлээн байгаа. Тийм учраас Ариунзаяа сайдаа энэ дээр бас

та нэлээн сайд байхдаа энэ дээр нэлээн ач холбогдол оруулж байсан учраас гүйцэтгэл ямар ч байсан гарна. Сан бүрдээд тэгээд ахмадууддаа зориулах энэ эх үүсвэр маань бэлэн болоод хуримтлагдаад явна гэдгийг яг баталгаатай хэлье танд. Баярлалаа, та энийг бас ойлгоно байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Ариунзаяа гишүүний асуултад Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг хариулна. 2 номер, 2 номер. 4 номер.

Ц.Наранчимэг: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Бид жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийдэг. Нийтдээ 2023 онд 4293 төсөвт байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн. Эдгээр байгууллагууд бол бүгдээрээ Ахмадын сангийн байгуулах хуулийн зохицуулалттай байгууллагууд байгаа.

2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 512 байгууллага 11.6 тэрбум төгрөгийн Ахмадын сангийн үлдэгдэлтэй байгаа. Ахмад настны тухай хуулийн 14.6, 14.7-д Ахмадын сан байгуулах журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу 2017 оны 197 дугаар тогтоолоор Засгийн газар Ахмадын сангийн журмыг баталсан байгаа.

Энэ журмын 3.1-д юу гэж заасан бэ гэхээр төсөвт байгууллагууд цалингийнхаа 3, цалингийн сангийн 3 хүртэлх хувиар Ахмадын сан байгуулж, энийгээ төсөвтөө тусгана гээд заачихсан учраас аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан хийж, хуулийн хэрэгжилтийг бас үздэг учраас төсөвтөө тусгаагүй байгууллагуудад энийг 3 хүртэлх хувиар Ахмадын сангаа төсөвтөө тусгах шаардлагатай байна гэсэн албан шаардлага өгч байгаа. Манай Төрийн аудитын тухай хуульд албан шаардлага маань заавал хэрэгжүүлэх ийм зохицуулалттай байгаа. Дараагийн удаа нь хариуцлага тооцдог.

Энийг яагаад өгч байна вэ гэхээр энэ байгууллага болгон дээр өөр өөр байгаад байгаа. Зарим байгууллагууд бол төсөвтөө 1 удаагийн тэтгэмж, урамшууллын зардал дээрээ ахмад настанд зориулах зардлаа тусгаад, жилийн эцэстээ Ахмадын сандаа 3 хүртэлх хувийнхаа хөрөнгийг төвлөрүүлээд зарцуулж байгаа. Энийг бид хуулийг хэрэгжүүлж ажиллаж байна гэж үзэж байгаа. Нэгэнт Засгийн газрын журам маань өөрөө төсөвт тусгана гээд заачихсан учраас энэ асуудлыг бол журмаа хэрэгжүүлж, хуулийн хэрэгжилтийг Ахмад настны тухай хуулийн 14-ийн 7.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Ахмадын сан байгуулах, байгуулан ажиллуулах журам байгаа 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 1.3-д төсөвт байгууллагын сая төсөвтөө жил бүр тусгана гэж байгаа юм

Хоёр дахь нь болохлоор бүрдүүлэлт гээд 2.1 дээр бол бас сангийн үйл ажиллагааны орлогоос олох орлого, сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл, гадаад, дотоод байгууллагын хандив, тусламж гээд олон боломжуудыг бас нээлттэй өгчихсөн байгаа юм. Жавхлан сайд бол сая ямар ч байсан бид нар байгуулна гэдгийг бол хэлчихлээ.

Тэгэхээр 25 оны аудитыг хийхэд зөрчилгүй байхын тулд энэ журмаа бас өөрчлөх шаардлагатай юм байна гэдгийг бол Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан сайд болон хамт олон нь сонссон байх. Та бүхэн маань

энэхүү журмаар одоо хэмнэгдсэн цалингийн сангаасаа үүсгэх санг зөрчилгүй байх тал дээр нь.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа өнөөдөр эрчим хүчний салбарт эх үүсвэрийн дутагдалд орсон, эх үүсвэрийн. Жилд цахилгаан эрчим хүчний хэрэглээ дунджаар 200мвт-аар өсөж байгаа.

Гэхдээ энэ 200мвт бол өнөөдөр бодит өсөлт биш. Яагаад гэхээр маш олон хэрэглэгч өнөөдөр би үйлдвэрээ барья, орон сууцаа барья, техник нөхцөл авья гээд хүсэлт гаргасан байгаа. Бид нар тэд нарыг холбож чаддаггүй. Хэдэн зуун хэрэглэгч өнөөдөр хүлээлттэй байгаа. Гэтэл хэрвээ энэ хүлээлттэй байгаа хэрэглэгчүүдийг холбох юм бол энэ 200мвт-ын хэрэглээ бараг 300, 400мвт хүртэл өөрөөр хэлбэл, жилд манай цахилгааны хэрэглээ бараг 300-аас 400мвт-аар өснө.

Тэгээд бид нар энэ эрчим хүчний салбарыг дутагдлаас гаргаж түрүүлж хөгжүүлэхгүй бол энэ яриад байгаа том том бүтээн байгуулалт, одоо манай хэн гишүүн ярьж байсан ингээд барилга байгууламж над дээр харьяалагдлаа. Гэтэл ерөөсөө л эрчим хүч дээр очоод тулах юм байна лээ шүү дээ. Танай эрчим хүч чинь ерөөсөө л хөгжлийн гацаа юм байна лээ шүү дээ. Үнэн.

Тийм учраас өнөөдөр бид нар энэ 2025 оны төсвийг эрчим хүчин дээр фокусласан тийм төсөв орж ирэх байх гэсэн ийм хүлээлттэй байсан. Гэтэл ерөөсөө л зам дээр фокусласан тийм төсөв орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд бүр гайхаад уч ерөөсөө олохгүй байгаа байхгүй юу. Энэ тохиолдолд эрчим хүч ерөөсөө эх үүсвэрийн дутагдлаас гарна гэсэн ойлголт байхгүй байна. Бид нар ойлгож байгаа эрчим хүчний эх үүсвэрт том хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг учраас гадаадын зээл, тусламж руу шидсэн.

Гэхдээ тодорхой хэмжээний бага оврын тархмал бага хэмжээний хөрөнгө оруулалт шаардах ийм юмыг улсын төсвөөрөө тусгаж болдоггүй юм уу? Яахаараа замд болохоор 3.2 их наяд төгрөг төсвийг зарцуулаад байдаг, эрчим хүчинд болохоор 9-хөн ширхэг шинэ төсөл орж ирж байгаа. Тэрний нь 8 нь болохоор зөвхөн дулааны шугам сүлжээг өргөтгөнө. 1 төсөл нь болохоор зөвхөн дулааны, Налайхын дулааны станцыг 180 хэдээр өргөтгөнө л гэж байгаа. Энэ төсөл дээр 1 ширхэг ч 1мвт-аар-аар цахилгаан эрчим хүчний хэрэглээ, эх үүсвэрийн хүчин чадлыг өргөтгөх ийм төсөл орж ирээгүй байгаа байхгүй юу. Энийг би гайхаад байгаа.

Яагаад одоо цахилгаанд, цахилгаан эрчим хүчний ялангуяа эрчим хүчний төслүүдийг гадаадын зээл тусламж руу шидээд байгаа юм бэ? Улаанбаатар хотод 110 станцууд нь бүгд 100 хувиар ачаалагдсан. Улаанбаатар парк гээд л Дамбадаржаа гээд л 110 станцуудыг баримаар байна гээд би эрчим хүчний салбараа буруутгаад та нар яагаад энэ юмаа тусгаж орж ирээгүй байгаа юм бэ гэхээр Сангийн яам руу бид нар явуулдаг юм. Бүгдийг нь гадаадын зээл, тусламж руу шиддэг юм гэж байгаа юм.

Тэгэхээр би нэг л үгийг хэлэх гээд байгаа юм. Өнөөдөр хэрвээ эрчим хүчний салбар та бүхний хэрэглээг хангаж чадахгүй, та бүхний хэлээд, яриад байгаа том бүтээн байгуулалтын ажлуудыг цахилгаанаар, дулаанаар хангаж чадахгүй бол энэ эдийн засгийн өсөлтийг эрчим хүчний салбар боож хаагаад, чөдөр тушаа болоод байгаа бол эрчим хүчний салбарыг битгий буруутгаарай.

Яагаад гэвэл та бүхэн өнөөдөр улсын төсөвлөсөн эрчим хүчний салбарт цахилгаан эрчим хүчнийх нь эх үүсвэрийн хэрэглээг 1мвт-аар ч өсгөх мөнгө зарцуулахгүй, тэгсэн мөртөө зам дээрээ 3.2 их наяд зарцуулсан сууж байгаа байхгүй юу. Мэдээж тийм учраас эх үүсвэрийн дутагдлаас гарахын тулд, энэ том бүтээн байгуулалтын ажлаа хийхийн тулд энэ салбарыг түрүүлж хөгжүүлэхийн тулд бид нар бүх нөөцөө ашигламаар байна шүү дээ. Улсынхаа төсвийг ч ашигламаар байна, гадаадын зээл, тусламжаа ч ашигламаар байна, тэр хувийн хөрөнгө оруулалтыг ч ашигламаар байна.

Хэрвээ энийг ингээд түрүүлж хөгжүүлэхгүй л бол үнэхээр бид нар эрчим хүчний салбарыг битгий буруутгаарай гэдгийг нь өнөөдөр би хэлмээр байгаа байхгүй юу. Тэгээд яагаад эрчим хүчний бүх төслийг гадаадын зээл, тусламж руу шидээд байгаа юм бэ? Зүгээр 110 станцыг нь хүртэл, зүгээр түгээх, дамжуулахын шугамыг нь хүртэл ерөөсөө л гадаад. Гадаадын зээл, тусламжийг бүтээх гэж хэдэн сар жил болдог. Хувийн хөрөнгө оруулалттай тарифаа тонгорох гэж хэрэлдэж хэлэлцээр хэдэн жил болдог.

Тэгэхээр бид нар үнэхээр л энэ эдийн засгаа боомилох юмыг өөрсдөө хийгээд хийгээд байна шүү гэдгийг л хэлэх гээд байна. Тэгэхээр асуулт маань яагаад эрчим хүчний бүх төслийг гадаадын зээл, тусламж руу шидээд байгаа юм бэ? Улсын төсвөөсөө жижиг оврын хөрөнгө оруулалт бага зарцуулах эх үүсвэрийг барих.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Манай байрны ,манай орцны гишүүн Энхцэцэг маш чухал асуудал хөндлөө.Чойжилсүрэн сайд хариулна. Сангийн сайд Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Би сайд даргын асуултыг хариульа, хариульа.

Энхцэцэг гишүүний асуултад хариульа.

Гишүүнд дутуу мэдээлэл өгсөн бид нарын буруу байх. Тэгэхээр ирэх онд бид 3 эх үүсвэрээр нийт төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Улсын төсвөөс, гадаадын тусламжаас, орон нутгийн төсвөөс гээд. Бид ирэх жил ямар ч байсан хуучин төслүүдээ яаралтай бушуухан дуусгая, шинэ төслүүд дээрээ бид нар яг таны хэлсэнчлэн одоо яг бид нарын хөгжлийн гацаа болоод байгаа эрчим хүч, зам тээвэр, ложистик энэ рүүгээ оруульа гэж байгаа юм.

Энэ дээр бид нар эх үүсвэрийн зохицуулалт хийх ёстой, зөв хуваарилалтаа хийх хэрэгтэй. Аль ч салбар дээр төсвийн хөрөнгө оруулалт хийх боломж байна. Гадаадын зээл, тусламжийн боломж байна, төр, хувийн хэвшлийн түншлэл байна, гадаадын шууд хөрөнгө оруулалтуудын ийм боломжууд байгаа.

Эрчим хүчний салбар бол өөрөө их онцлогтой. Зам шиг 5, 5-аар нь, 10, 10-аар нь ч юм уу таслаад хийж болдоггүй. Энэ чинь өөрөө өөрөө эдийн засгийн үр өгөөжийг нь тооцож байгаад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийх, босго мегаваттын ч дүн байна. Дээрээс нь хөрөнгө оруулалтын бас ийм дүнгүүд.

Тийм учраас энийг төсөв дээрээс шууд авч явах боломж хязгаарлагдмал Энхцэцэг гишүүн ээ. Хэрвээ ирэх жил одоо ингээд яг төсөв дээр гадаадын тусламжаас суусан 361 тэрбум байгаа юм. Үүний төсөвт өртгийг нь харах юм бол энэ 7.5 их наяд. Таны ярьж байгаа замаас чинь төсөвт өртгийг нь харах юм бол 2 дахин илүү шүү. Төсөв дээрээс зөвхөн хийж байгаа нь энэ.

Төсвөөс гадуур Эрдэнэс Тавантолгой, хувийн хэвшлийнхэн хийж байна. Эрдэнэс Тавантолгой өөрөө энэ 405 мега ватт, Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг мөн төсөвт зээлийн харилцаагаар хийж байна. Эгийн голын УЦС-ыг саяхан Одонтуяа гишүүн ОХУ руу яваад энийг бас зөв голдиролд нь оруулаад ирлээ. Мөн гаднын хөрөнгө оруулалтаар бас хийгдэж байгаа хэд хэдэн төслүүд байна. Бөөрөлжүүт тэгээд, мөн Сэлэнгэд ирэх жил бас 50 мега, 70мвт-ын төсөл эхлэх гэж байна, мөн Дарханд ч бас эхлэх гээд ингээд яригдаж байгаа зүйлүүд байна.

Тэгэхээр төсөв дээрээс хийгдэж байгаа нь зам, ТЭЗҮ, бэлтгэл ажил нь хангагдчихсан, бас ингээд таслаад хийгээд явах боломжтой нь зам арай ийм дөхүү байгаа юм. Тийм учраас цаг алдалгүйгээр ингээд аваад явна.

Харин гадаад зээл, тусламжийн тэр орон зайн дээрээ эрчим хүчээ түлхүү аваад явна гэсэн үг. Энэ 4 жилийн хугацаанд бид 1690 гэж байгаа юм. Өнөөдрийн байгаа суурилагдсан эрчим хүчнийхээ эх үүсвэрийг 2 дахин нэмчихээр ийм боломжуудаа хараад, ингээд төлөвлөгөөндөө тусгаад, энэ төлөвлөгөөнөөсөө жил бүр төсөв дээрээ боломжоороо ингээд тусгаад ингээд явж байгаа юм.

Тийм учраас эрчим хүчийг гадаад тусламж руу шидчихээд, хөрөнгө оруулалтууд нь хойшлогдоод эрэмбэлэгдээд хойшоо явж байгаа зүйл биш шүү. Харин ч эхлүүлж байгаа төсөвт өртгийг нь хар.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одоо Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа:Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бид бас түүхэндээ дахиад нэг томоохон төсөв баталж байна. Монгол Улсын төсөв, ер нь аливаа улсын төсөв бол эдийн засгийн бүхэлдээ сайн сайханд зориулагдаж батлагдаж байдаг. Тэгэхээр зэрэг төсөвт оруулж байгаа 1 төгрөг болгон эргээд эдийн засагтаа төдий хэмжээний өгөөж өгч байх ёстой юм. Энийг эдийн засагчид болохлоор төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын эргэлтийн болон урсгал зардлын урсгал өгөөж гэж тооцдог ийм коэффициентоор тооцож байгаа. Ер нь бол 2010 онд бол Монгол Улсын төсөв 3 их наяд төгрөгөөр батлагдаж байсан байна. Өнөөдөр 35 их наяд 15 жилийн дотор манай Монгол Улсын төсөв 12 дахин өссөн байна. Тус хугацаанд 2010 онд 500-аас магадгүй 700 мянган төгрөгийн цалинтай байсан ажилтан, албан хаагчдын цалин өнөөдөр 5 саяас 7 сая болсон уу? Тэтгэвэр тэтгэмж 12 дахин өссөн үү? Татвар төлөгчдийн суурь төлж байгаа татварын хэмжээ 10, 12 дахин өссөн үү? Тэгэхээр зэрэг манайх энэ төсвийнхөө өгөөж дээрээ анхаарах хэрэгтэй байна. Энэ жилийн энэ хөрөнгийн урсгал, үржүүлэгчийн нөлөө нь хэд гарч байгаа вэ гэдгийг би асууя.

Дээрээс нь Монгол Улсад энэ төсөв батлагдаж байх энэ төсвүүдийг харж байхад Улаанбаатар хотын хэмжээнд л гэхэд чинь 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулиуд байна. Манай СХД-т 4 ээлжээр бас хичээллэж эхэлж байна. Тэгэнгүүт чинь зарим үр ашиггүй хөрөнгө оруулалтууд бас энэ төсөв дээр орж ирж байна. Энэ болгоныгоо бид нар яаж эрэмбэлж, яаж энэ төсвийг баталж байгаа гишүүд энэ үр өгөөжөө тооцож байх юм бэ? Энэ эрмэлзлийг бид нар хаанаас олж харж байх вэ? Энэ үржүүлэгчийн үр нөлөө ямар байгаа вэ гэдэг энэ асуултыг асууя. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Эдийн засгийн өсөлтөд гол хөшүүрэг болох төрийн 2 бодлого байдаг. Энэ нь төсвийн бодлого, мөнгөний бодлого. Мэдээж яг гол хөшүүрэг болж байгаа хэмжигдэхүүн нь яг таны хэлдэг төсвийн үржүүлэгч, мөнгөний бодлого талдаа мөнгөний үржүүлэгч гэсэн 2 гол суурь үзүүлэлтээ бид нар харж явдаг юм байгаа юм.

Тэгэхээр жил бүр орж ирж байгаа энэ сүүлийн 34 жилийн төсөв өмнөхөөсөө буурсан тохиолдол байхгүй. Жил бүр шинэ тоо орж ирдэг. Жил бүрийн төсвийн тоо дээд хэмжээ нь болж явдаг. Хойтон 26 онд ч тэгэх байх, 27 онд ч бас тэгэх байх.

Тэр өсөлтийн хувь хэмжээ маань харин ДНБ-ийгээ хэр их дэмжиж өсгөж байсан бэ гэдгээрээ жил бүрийн төсвүүд ялгаатай. Сүүлийн 5 жилийн хувьд бол төсвийн үржүүлэгч өөрөө хөрөнгөө төсвийн хөрөнгийн зардлын үржүүлэгч ч тэр, урсгал зардлын үржүүлэгчийн хувьд ч тэр өндөр байгаа, өндөр байгаа.

Ялангуяа одоо. сүүлийн 2 жилийн энэ төсвийн үржүүлэгч маш өндөр дүнтэй байгаа. Ингээд хэрвээ салбар салбараар нь харах юм бол манай Монгол Улсын төсвийн хөрөнгийн зардлыг үржүүлэгч, хөгжиж буй буурай орнуудынхаа дунджаас өндөр байгаа. Ялангуяа дэд бүтцийн хувьд, ялангуяа эрчим хүчний хувьд. Эрчим хүчинд оруулж байгаа 100 төгрөг бүр тухайн дараа жилийнхээ ДНБ-ий 416 төгрөгийг бий болгож байгаа. 416 шүү. Зам тээвэр, холбооны салбарын үржүүлэгч нь 1 бүхэл 56 байдаг юм. Өөрөөр хэлбэл, 100 төгрөг бүр ДНБ-д 156 болж очиж байна гэсэн үг.

Нийгмийн салбарын хувьд 1 хувиас бага байдаг. Гэхдээ энэ нь урт хугацаанд өөрөө тогтвортой, дараагийн баялгийг бүтээгч нарыг бий болгодог улсын гол капитал нөөцийг бүрдүүлдэг гэдэг утгаараа хөгжлийн бас суурь том коэффициент байдаг. Эдгээр өсөлтүүд бол бид харьцуулах тоо нь бол би түрүүн хэллээ, хөгжиж буй орнуудынхаа дунджаас манайх өндөр явж байгаа. Ялангуяа сүүлийн 3 жил. Энэ тайлангууд, энэ тоонууд бол би хэлж байгаа зүйл биш энэ Олон улсын валютын сангийн судалгаан дотор дурдагддаг ийм тоонууд байгаа шүү гэдгийг хэлье.

Тийм ч учраас яг эрчим хүчний болон зам тээврийн энэ салбар дээрээ бид ирэх жилүүдэд илүү их анхааръя гэж байгаа. Ийм л зүйл байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийг хөгжүүлэхэд гол хөшүүрэг болж байна гэдэг маань одоо яг байгаа зөв оноод, энэ эдгээрийн үзүүр дээр нь хувийн хэвшлийнх нь бүтээн байгуулалт, баялаг бүтээх ажлын байрыг бий болгох, тэгээд яг гол ДНБ-ий гол нэг баялгийн бүтээн байгуулж байгаа яг хувийн хэвшлийнхнийгээ дэмжиж байгаа үржүүлэгч нь болж байгаа гэдгийг л би дахин дахин онцолж хэлээд байгаа юм шүү.

Б.Пүрэвдорж: Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүддээ оройн мэндийг дэвшүүлье. Ер нь бол төсвийг бол зарчмын хувьд энэ бүтээн байгуулалтын төслүүдийг бол би дэмжиж байгаа. Гэхдээ 2, 3 асуух асуулт байна. Энэ Олон улсын валютын сангаас энэ 2023 онд хийсэн энэ Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын менежмент, үнэлэлт, үнэлгээний тайланд төсвийн хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн үр ашгийг сайжруулахын тулд хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх ёстой гэсэн тийм тэмдэглэсэн байна. Энэ яг бодитой байдал дээр энэ олон төслүүд ингээд цуг хэрэгжихлээр зарим төслүүд удаашрах, санхүүжилтгүй болох, төслийн судалгаа бүрэн хийгдээгүйгээс болоод энэ зарим төслүүд бол гацах ийм эрсдэл байдаг.

Тэгэхээр Сангийн яам энэ 2025 оны төсөв хэрэгжүүлэхдээ энэ хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрхэн, ямар шалгуураар эрэмбэлсэн бэ? Ер нь эрэмбэлсэн үү? Энэ парламентын хугацаанд аль төслүүд бол бүүр хэрэгжих боломжтой вэ?

Хоёрдугаар асуулт нь болохлоор түрүүн манай бас Энхцэцэг, Ганхуяг гишүүн бас бас дурдаж байна. Энэ 2025 оны төсөвт оруулж байгаа ихэнх төслүүд бол улсын болон гадаадын зээлээр санхүүжүүлж байна.

Ялангуяа энэ томоохон мега төслүүдийг бол зөвхөн улсын төсөв, гадаадын зээлээр санхүүжиж байна. Ер нь бол уул нь бол бас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бол холимог санхүүжилт хийвэл энэ төсвийн дарамт буух тийм ач холбогдолтой. Энэ 25 оны энэ мега төслүүдээс аль төсөл нь холимог аргаар ийм санхүүжүүлэх вэ? Хэрвээ үгүй бол яагаад энэ холимог санхүүжилтийг сонгохгүй байна? Түрүүн эрчим хүчнийхийг бол дурдаж ярьж байсан. Бусдад, энэ бусад төслүүд нь ийм холимог санхүүжилт байгаа юу гэж асуумаар байна.

Мөн энэ та түрүүн, Жавхлан сайд бас хэлж байна энэ 600 орчим ийм төслийн санхүүжилтийн асуудлыг ингээд шийдэхээр явж ажиллаж байгаа гээд. Тэгэхэд өмнө хэрэгжсэн энэ төслүүд дээр ямар нэгэн үр дүнгийн, энэ хөрөнгийн ашиглалт, менежментийн үр дүн хийсэн ийм судалгаанууд байна уу? Яагаад бол ихэнх төслүүд нь бол хэрэгжээд, өмнө нь хэрэгжсэн төслүүд нь хэрэгжээд дууссан, санхүүжилт нь шийдэгдсэн, мөн харин энэ төслүүд одоо яг зорилт бүлгүүддээ хүрч чадсан уу? Би бол ийм тайлан хайгаад бол олоогүй. Ийм 3 асуулт асуумаар байна.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Байна уу? Энхнасан гишүүний асуултад хариулья.

Бид Төсвийн тухай хууль дээр тухайн жилийнхээ төсвийн хөрөнгө оруулалтуудыг хийхдээ эрэмбэлэх зарчим, шаардлагууд хуулийн дагуу байж байдаг. Тэрийг нэг бүрчлэн манай яамны ажлын хэсгийнхнээс дурдаад өгөөрэй хуулийн заалттай нь. Ихэнх төслүүд гадаадын зээл, тусламж бас арай биш юм байгаа юм шүү. Бас мэдээлэл дутуу өгөөд байх шиг байна бид нар. ирэх жил жишээ нь 640 төсөл, арга хэмжээ үргэлжилнэ, шинээр хийгдэнэ. Үүнээс 38 нь шинээр, 602 төсөл үргэлжилнэ. 602 дотроос 117 төсөл нь гадаад зээлийн ашиглалт болон буцалтгүй тусламжаар хэрэгжих ийм төслүүд нь юм байгаа юм. Өөрөөр хэлбэл 6-ны 1 нь гэсэн үг.

Тэгэхээр бид нар энэ эх үүсвэрийнхээ хуваарилалтыг зөв хийх нь, оновчтой хийх нь энэ төсвийн бодлого, ялангуяа хөрөнгө оруулалтын бодлогын бас гол бид нар харж явах асуудал байгаа юм. Өөрөөр хэлбэл, таны яг хэлсэнчлэн аль хэсгийг нь өөрөөр хэлбэл, цаашаа бизнес болоод өөр өөрийгөө санхүүжилт хийгээд аваад явах, хөрөнгө оруулалт татахуйц тийм төслүүдийг аль болох төр, хувийн хэвшлийн түншлэлээр, эсвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтууд дээр санал болгох зарчмаар ингээд явна.

Өмнө нь, өмнөх Засгийн газрын үед Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд нийтдээ бараг 100 гаруй их наяд төгрөгийн ийм төсөл, арга хэмжээнүүд Улсын Их Хурлаар батлагдаж байсан. Үүнээс зөвхөн 10-аад их наяд нь л стратегийн хувьд улс хийнэ, бусад нь бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх ийм зүйлүүд байсан.

Одоо энэ дотроос сугалж бид нарын ойрын төлөвлөгөөнд орж байгаа 14 мега төслийн, үндсэндээ 3 төсөл нь эхэлчихсэн, 4 төсөл нь хэрэгжихэд бэлэн болчихсон, цаад 7

төсөл нь бол ихэнх нь ер нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр явна даа. Одоо яг ТЭЗҮ нь хийгдэж байгаа ийм ажлууд байгаа.

Тийм учраас энэ өөрөө 43 их наядын хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалтын тал нь шахуу, талаас илүү нь ч байх тэр 7 төсөл дээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хийгдэх боломжит ийм зах зээл нээгдэж байна гэсэн үг юм. Эрэмбэлэхийн хувьд ямар зарчмууд барьдаг талаар Дэлгэржаргал дарга мэдээлэл өгөөдөх үү.

Б.Пүрэвдорж: 17 номер Дэлгэржаргал дарга.

Гишүүний асуултад хариулья. Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал.

Ж.Дэлгэржаргал: Бид нарын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд дээр Сангийн сайдын, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл дээр хөрөнгө оруулалтын төслүүдэд тавигдах шаардлага, мөн төсвийн төсөлд тусгахдаа тухайн төслүүд дийг баримтлах эрэмбийг хуульчилж өгсөн 2022 онд. Үүнээс гадна яг төсвийн хөрөнгө оруулалт дээр цахим шинэчлэлтийг сүүлийн 3 жил хэрэгжүүлж байгаа. Үүн дээр хөрөнгө оруулалтын төсөл болгон 3 түвшнээр, 10 шалгуур үзүүлэлтээр оноо өгч эрэмбэлдэг ийм системтэй.

Өмнө нь яг ийм аргачлал, цахим систем байгаагүй. Сүүлийн 3 жил идэвхтэй ингээд явж байгаа. Ер нь хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд аймгууд нь, салбар яамнууд нь, тэгээд Сангийн яам гэсэн 3 түвшинд 10 оноогоор эрэмбэлж байгаа.

Энэ жил нийтдээ хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд 13 их наядын санал ирсэн. Тэгээд төсвийн төсөл дээр нийт санхүүжих дүнгийн хувьд 4.3 их наяд тусгагдсан байгаа.

Олон улсын валютын сангийн үнэлгээний хувьд улсын хөрөнгө оруулалтын үнэлгээг 2016 он.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дэлгэржаргал дарга гүйцээж хариулья.

Ж.Дэлгэржаргал: Бид нарын хувьд бас олон улсын үнэлгээгээ сайжруулах талаар нэлээн ажлууд хийгдээд явж байгаа. 16 онд хийгдэхэд Монгол Улсын хөрөнгө оруулалтын үр ашгийн үзүүлэлт 41 хувь байсан. Одоо 23 онд бид нар үнэлгээгээ маш сайжруулсан буюу энэ үзүүлэлт 14 хувиар сайжирсан байна гэж зөвлөмж өгсөн байгаа. Тэгээд 23 онд өгсөн зөвлөмжийн хүрээнд бид нар 26 он хүртэлх дараагийн үнэлгээгээ сайжруулах ийм төлөвлөгөөнүүдийг гаргаад хэрэгжүүлж байгаа. Энэ дээр яг энэ үр ашгаар нь тооцох, илүү тэргүүн эрэмбийн төслүүдийг хэрэгжүүлэх ийм арга хэмжээнүүд орчихсон. Мөн дээрээс нь хөрөнгө оруулалтын төслүүд Төсвийн тухай хуульд зааснаараа хийгдэж байгаа хөрөнгө оруулалт болгон орон нутаг болон улсын өмчид бүртгэгдэх хийх ёстой. Энэ хэмжээгээр өмч бий болж байх ёстой.

Тэгэхээр бид нар өнгөрсөн хийсэн судалгаан дээрээ үндэслээд 23 онд журмаа шинэчлээд, яг бүх төслүүд өмчид заавал бүртгэгддэг байх. Түүний дараа эцсийн санхүүжилтийг олгох, энэ хүрээндээ ашиглалтын тэмдэглэгээнүүдийг бас бүх төс төслүүдээр хийгээд явж байгаа. Тэгээд Төрийн өмчийн хорооны системтэй.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Энхнасан гишүүн нэмж тодруулья.

Л.Энхнасан: Тэгэхлээр төслүүд үнэлэгдэж, эрэмбэлж байна гэж ойлгож болох уу? Тэгвэл бас энэ эрэмбэлэгдсэн 3 том төслийн нэг болох энэ Дорноговийн, Дорноговьд баригдаж байгаа энэ газрын тосны боловсруулах үйлдвэрийн төсөвт борлуулалт, тээвэрлэлт хийх, агуулах үйлдвэрлэлийн замын асуудалд төлөвлөгдсөн үү? Учир нь яагаад бол зарим сайн нягтлаад үзэхлээр энэ ложистикийн асуудлууд нь ерөөсөө төлөвлөгөөгүй харагдаж байгаа. Жишээлбэл, төмөр зам дээр бензин ачих цистерн вагон худалдаж авах борлуулалтын жигд түгээлт, Сайншандаас Улаанбаатар, Дархан хүртэл төмөр замын энэ ачаалал ер нь энэ дийлэх үү? Эс үгүй бол Сайншандаас Говьсүмбэр рүү, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий рүү ингээд бензинээ автомашинаар хүргэе гэхэд энэ машины хүнд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмээд 1 минут өгөөд тодруулья.

Л.Энхнасан: Энэ даацын автомашины зам байхгүй байгаа. Ингээд харахлаар энэ замыг ерөөсөө улсын төсөвт бас тусгагдаагүй харагдаж байсан. Энийг яаж ер нь ложистик тээврийг ер нь тусгаж байгаа юм бэ?

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Энхнасан гишүүний асуултад хариулья.

Би түрүүн зүйл дутуу хэлчхэж гэж чухал юм. Энэ удаагийн төсөв дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж дотроос олон зүйлүүдийг бид хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Эндээс яг тулчихсан ус, агаар мэт хэрэгтэй байгаа нэг чухал зөвлөмж байгаа. Тэр нь юу вэ гэхээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг Төсвийн хуулиас тусад нь салгаж ингэж бие даасан хууль болгож гарга гэж байгаа. Энэ бол маш чухал ийм бид бас олон жил яригдаж байсан, тэгээд эхлүүлж амжихгүй яваад байгаа ийм зүйл. Энд бид шууд орсон байгаа. Одоо Засгийн газрын түвшинд, мөн яаралтай өргөн барих хэмжээнд Их Хуралтай хамтраад ажлын хэсэг байгуулаад ингээд явна гэсэн ийм төлөвлөлттэй байгаа шүү. Энэ ингээд шинэ мэдээ юм шүү, мэдээлэл өгч байгаа.

Хоёрдугаарт яг таны ярьж байгаа зүйлтэй санал нэг байна. Яг тухайлан төсөл бүрийг ярих юм бол ийм дутуу зүйлүүд бол байгаа. Энэ үйлдвэрийн ТЭЗҮ бол зөвхөн яг үйлдвэрлэл, яг үйлдвэрлэл, яг боловс.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Энэ төсвийн төсөлтэй 25 оны төсвийн төсөлтэй танилцаж байна л даа. Энэ аудитын дүгнэлт дээр Засгийн газрын урсгал зардлыг өмнөх оноос 3 их наяд 565.6 тэрбум төгрөг нэмэгдүүлнэ, төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн хязгаарыг хэтрүүлэн төлөвлөсөн байна гээд ийм аудитын дүгнэлт гарсан байна.

Тэгэхээр энэ чинь аймаг бас энэ маш их мөнгө л дөө. Энэ орон тоо нэмчхээд байна гээд байна уу? Тодорхой энэ дээр хариулт авъя. Яагаад нэмэгдээд байна? Жишээлбэл энэ дээр энэ айлын хаус худалдаж аваад цэцэрлэг байгуулах ажил их болсон. Бүр заалны буланд цэцэрлэг байгуулах ажил бий болсон. Эд нарын төсөв нэмчхээд байна уу? Энэ ямар учиртай юм энэ талаар тодорхой асууя.

Хоёр дахь асуулт маань энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн эмийн хөнгөлөлт байна л даа. Энэ зүгээр хөнгөлөлт эмийн хөнгөлөлтөд яваад байна уу ,аль эсвэл эмийн компаниуд дээр тодорхой хэмжээний юм хийгээд энэ эмийг хөнгөл гэж ярьж байгаа юу? Энийг задаргааг нь тодорхой мэдмээр байх юм. 25 онд 197 тэрбум төгрөг байна л даа. 60 тэрбумаар нэмэгдсэн ноднингоос. Энэний тодорхой юуг нь мэдье.

Хоёр дахь нь Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал гэнэ. 19.8 тэрбум, 3.4 тэрбумаар нэмэгдүүлсэн. Ийм хариуцлагагүй ажиллаж байгаа тийм юунд тэр чинь төсвийг нь би шаардлага байна уу ер нь эд нарын? Сая бүр нэлээн асуудал гарлаа шүү дээ. Эд нарын төсөв нэмэх шаардлага байна уу ер нь? Ажиллахгүй тийм хяналт хийж ажиллаж чадахгүй эд нарын төсвийг хасах хэрэгтэй юм шиг байх юм.

Хоёрдугаарт энэ эрүүл мэндийн байгууллагуудын аймаг, сумын төсөв ерөөсөө алдагдалтай. Авлага гэхэд Өлгийн нэгдсэн эмнэлэг дээр 1.2 тэрбум даатгалаас, Эрүүл мэндийн даатгалаас, өглөг 1.4 тэрбум. Одоо энэ жил дараалан явж байгаа. Гэтэл энийг аймаг болгонд байгаа, аймаг болгон нэгдсэн эмнэлэг дээр байгаа. Энийг одоо яаж шийдэх юм? Тэр эрүүл мэндийн худалдан авалтын багцыг нэмэх юм уу? Энийг шийдэхгүйгээр Сангийн сайд энийг шийдэж байж юуг нэмэхгүй бол энэ ерөөсөө энэ биелэгдэх боломж тун бага байх шүү энэ чинь. Эрүүл мэндийн салбар дээр ажиллаж байсны хувьд энийг би тодорхой хэлье.

Эрүүл мэнд дээр тэр Ногооннуур сумын Ховд багийн эмнэлэг, Улаанчулуу багийн эмнэлэг гээд байгаа. Баригдаад 2 жил болчихлоо. Төсөв нь орсон уу сайд энийг асууя. Тэнд чинь сургууль, цэцэрлэг байгаа. Нэлээн хүн амтай та мэдэж байгаа. Энийг бас яахгүй бол бас болохгүй нь. Энэ төсөв яасан уу энэ машин, эмчтэйгээ байгаа шүү дээ энэ чинь. Орон тооны төсөв нь батлагдсан уу?

Дараа нь Сангийн сайдаас нэг асуух асуулт байна. Энэ газрын тосны түүхий эдийг бид нар чинь гадаадад экспортолж байгаа шүү дээ ерөөсөө. Бүтээгдэхүүн тээ? Бүтээгдэхүүн угаах дээр чинь хэчнээн тонн, тэрбум ч юм уу, их наядын хөрөнгө гаргасан юм, хэдэн хувийг нь манай Монгол Улс эзэмшдэг юм, төсөвт хэдэн хувийг нь оруулдаг юм энэ талаар тодорхой мэдээлэл сонсьё.

Б.Пүрэвдорж: 4 номер Наранчимэг дарга хариулья.

Ц.Наранчимэг: Бейсен гишүүний асуултад хариулья. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

2025 оны төсвийн төсөлд 2024 оны төсөвтэй харьцуулж аудит энэ дүгнэлтийг гаргасан байгаа. Энэ дээр урсгал зардлыг зайлшгүй шинээр бий болж байгаа байр ашиглалттай холбоотой зардал бол 21 хувийг нь эзэлж байгаа. Үүнтэй холбоотой эд хогшил, бусад зардлыг худалдаж авах энэ зардлууд бол 46 хувийг нь эзэлж байгаа. Хангамж бараа, материалын зардал бол 37 хувийн зэрэг зардлуудаас шалтгаалж өсөж байгаа.

Ер нь төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулж Сангийн яаманд ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-г заасан төсвийн жилийн хязгаарт багтааж төсвөө төсвийн төслийг боловсруулж ирүүлнэ гэсэн энэ заалтыг мөрдөж ажиллахгүй байгаа. Энийг аудитаар гаргаж тавьсан байгаа. Тэгээд бид нар энэ дүгнэлтээрээ Засгийн газарт төсвийн зардлын тэлэлтээс нийгэм, эдийн засагт үзүүлж

болзошгүй сөрөг үр үр дагаврыг үнэлж, бууруулах арга хэмжээ авах талаар Засгийн газарт зөвлөмж хүргүүлсэн байгаа.

Мөн аудитын байгууллага жил бүрийнхээ төсвийн төсөлд өгч байгаа санал дээрээ төсвийн ерөнхийлөн захирагч нарыг төсвийн төслийг боловсруулж Сангийн яаманд ирүүлэхдээ хариуцлагатай байх талын зөвлөмжийг хүргүүлж байгаа. Энэ жилээс эхлээд Төсвийн тухай хуулийн төрийн аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд гээд Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон. Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт орсон хариуцлагын механизм бол нэмэгдсэн байгаа учраас энэ жилээс эхлээд бид нар энэ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлагыг нь тооцох ийм албан шаардлагыг хүргүүлнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Б.Пүрэвдорж: Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан. Бейсен гишүүний асуултад хариулна.

Т.Мөнхсайхан: Тэр хөнгөлөлттэй эм дээр тавигдсан төсөв мөнгө маань эргээд энэ даатгалын сан дээр хөнгөлөлттэй эм нь олгож байгаа төсөв мөнгийг л яриад байгаа юм л даа. Тэгэхээр хөнгөлөлттэй эмээс болж санхүүгийн эрсдэлд орж байгаа ард иргэд маш их байгаа.

Тийм учраас энэ хөнгөлөлттэй эм дээр тавигдаж байгаа төсөв сүүлийн жилүүдэд байнгын өсөж явж байгаа. Бид нар харин энэнийхээ зарцуулалтыг өшөө үр ашигтай, өгөөжтэй болгоод чанартай, хямд үнээр даатгал өөрсдөө энэ эмээрээ хангадаг болчих юм бол эргээд энэний ашиглалт нь улам их сайжрах юм байна лээ. Өшөө ч цаашдаа энэ хөнгөлөлттэй эм дээр олгодог санхүүжилтийг нэмэгдүүлэх хамгийн гол нь зарцуулалтаа үр өгөөжтэй болгох энэ 2 чиглэлийн бодлогыг бид нар хийж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ хөнгөлөлттэй эмд олгогдож байгаа төсвийг, одоо гаргаж байгаа төсвийг л эндээс тавиад байна гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ маань өөрөө.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн, Жавхлан сайд Бейсен гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Газрын тосны экспортоос 348.2 тэрбум төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн байгаа ирэх жил. Энэ нь 5.4 сая баррель экспорт гэсэн үг. Энэ яг тухайлан энэ аж ахуйн нэгжийн хувьд бол хуримтлагдсан өр яваад байгаа, маргаан үүсчихсэн. Ер нь яах вэ энэ маргаан дээрээ бол ямар ч байсан Засгийн газар бол ялаад яваад байгаа. Нэмэлт мэдээлэл шүү тийм.

Тэгээд энэ яг газрын тосны үйлдвэрлэлтэй холбоотой илүү мэдээллүүдийг бол бас юунаас өгчихвөл их сайн байна. Уул уурхай, аж үйлдвэрийн яамнаас өгчихвөл их сайн байна.

Б.Пүрэвдорж: Бейсен гишүүн тодруулсны дараа Жавхланбаатар дарга бэлтгэж байгаарай. Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Энэ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас хүн байна уу? Одоо нэг аймагт авлага нь гэхэд 1.2 тэрбум байна шүү дээ. Бүх аймагтаа. Хотын клиникүүдээр бүр их байгаа. Тэгээд сүүлдээ Эрүүл мэндийн сайдыг муулдаг. Та нар ийм юм яалаа гээд. Тодорхой мэдээлэл өг л дөө. Аль эсвэл тэр байгууллагын нэгдсэн эмнэлгийн буруугаас болж байна уу, нэхэмжлэлээ буруу бичээд байна уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр сая сайд 2 багийн эмнэлэг барьчхаад ... 2 жил болж байна, одоо 2 дахь жилээ үзэж байна. Тэрний төсөв тавигдсан уу гээд асууж байна л даа.

Б.Пүрэвдорж: Жавхланбаатар дарга индрийн 1 номер.

С.Жавхланбаатар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Жавхланбаатар гишүүний асуултад хариулъя.

20, Газрын тосны бүтээгдэхүүн хуваах 4 гэрээ байгаа. Энэ гэрээнүүдийн хүрээнд улсын төсөвт орлого төвлөрүүлж ажиллаж байгаа. Би гэрээнийх нь 25 оны дүнг бас нягтлаад Жавхлан сайдын хэлсэн дээр нэмээд хэлээдэхье. Өнгөрсөн оны 24.

Б.Пүрэвдорж: Мөнхсайхан сайд хариулъя. Дараа нь Дэлгэржаргал тэр 2 багийн хөрөнгө оруулалтын асуудлаар бэлтгэж байгаарай.

Т.Мөнхсайхан: Энэ ер нь орон нутгийн гэлтгүй бүх эмнэлгүүдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас өгөх өр төлбөр байгаа. Энэ асуудал маань түрүүнээс хойш яриад байгаа Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрөх ёстой мөнгө 21 оноос хойш төвлөрөхгүй 218 тэрбум хүний алдагдал байна. Тийм учраас энэ өрийг бүгдийг нь энэ сард юм уу ингээд бүгдийг нь төлж барагдуулах боломжгүй байна бид нар.

Тэгэхээр нэн шаардлагатай цалин мөнгө, нийгмийн даатгал, нэмэлт урамшууллынхаа төлбөр мөнгийг шилжүүлж байгаа. Дээрээс нь эм эмнэлгийн хэрэгсэлд шаардлагатай төлбөр мөнгөнөөс тодорхой хувиудыг нь сар болгон ингээд барагдуулаад явж байгаа. Тэгэхээр энийг 100 хувь бүгдийг нь нэг дор төлчих ийм боломжгүй нөхцөл байдал өнөөдөр үүсчихсэн. Даатгалын сан хүнд нөхцөл байдалтай байгаа гэдгийг ер нь энэ сайдын ажлыг авсан цагаасаа хойш хэлж байгаа.

Тэгээд тэр 2 багийн эмнэлэг ашиглалтад орсон бол эргээд даатгалын магадландаа ороод даатгалын.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Тэр 2 багийн эмнэлэг шинээр ашиглалтад орсон тохиолдолд эрүүл мэндийнхээ магадланд ороод, Даатгалын ерөнхий газартайгаа гэрээгээ хийгээд, ингээд санхүүжилтээ аваад үйл ажиллагаагаа хэвийн явуулах 100 хувь боломж байгаа. Тэрийг төсөв дээр тусгайлан суулгах шаардлагагүй. Яагаад гэвэл санхүүжилтүүд маань бүгдээрээ өрх, сумын түвшинд нэг иргэнээрээ явж байгаа, зарим тусламж, үйлчилгээнүүд гүйцэтгэлээрээ санхүүжээд явж байгаа учраас энэ дээр тусламж, үйлчилгээгээ үзүүлээд явах боломжууд нь бүгдээрээ байгаа шүү. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Төсөвтэй холбоотой, уг нь бол бодлого нь орж ирээд л бодлоготойгоо уялдаад л төсөв нь суугдаад л явах ёстой шүү дээ. Бид нар сая 25 оны төлөвлөгөө баталсан. Сая юу гэххэв? Төлөвлөгөө нь хэрэгжиж ч магадгүй, хэрэгжихгүй ч байж магадгүй гэхихсэн үү, юу гэсэн? Тиймэрхүү утгатай л юм хэлчих шиг болно лээ.

Нэгэнт төлөвлөгөө байгаа бол яг энэнийхээ дагуу суугаад л бид нар явах ёстой шүү дээ уг нь. Энэ Эдийн засаг, хөгжлийн яамыг миний бие бас санал гаргаж байгаад Үндсэн хууль хэлэлцэж байхад ийм институт байх ёстой гэж байгуулсан юм.

Б.Пүрэвдорж: Энэ 1 минутаар өгчихсөн байна шүү. 3 минутаар асуух ёстой. Цагийг нь эхнээс нь өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр энэ төсвийг ер нь хаанаа базаж орж ирж байна? Эдийн засаг, хөгжлийн яам гол нурууг нь босгож байна уу? Тэгээд л Сангийн яам маань яг я ямар хэлбэрээр орж ирж байна? Бид нар яг энэнийхээ утга учрыг, юмыг нь гаргаж ирж чадсан уу, үгүй юу? Эдийн засаг, хөгжлийн яаман дээр том бодлого чинь гарч байх ёстой. Өнөөдөр тэр бодлого чинь энэ дотор ерөөсөө харагдахгүй байгаад байдаг. Одоо ингээд бид нар Бүсчилсэн хөгжил гэж нэг юм ярьсан. Бүсчилсэн хөгжлийн чинь дагуу өнөөдөр өнөөдөр яг төсөв дээр яаж сууж орж ирж байгаа юм? Ямар салбараа бид нар нэн тэргүүнд хийх юм? Аль салбараа явуулах юм? Эрчим хүч, зам тээвэр юу байдаг юм тэрийгээ эхэлж явуулаад явах юм уу, яах ёстой юм? Жишээ нь хэд юм 14 төсөл орж ирсэн. Тэрний нэг нь юу гэлээ? Ган татлагат гүүр эд нар гэж байна. Гайхамшигтай сайхан гүүр ингээд бид нар барьж байх ёстой юм уу, эсвэл нөгөө хөдөөгийнхөө тэр зам юмнуудыг хооронд нь холбоод, дэд бүтцийг нь хөгжүүлээд, сум, сумандаа эрчим хүч, дэд бүтэц, тэр ус, дулаан бүх хэдэн асуудлуудыг нь, хүн тэнд тав тухтай амьдрах, Улаанбаатар хот руу нүүхгүй тийм тав тухтай орчныг нь тэнд бид нар бүрдүүлэх ёстой юм уу? Энэний чинь 1 номерынх нь асуудлууд хаанаа байна гэл үү харж байж бид нар ийшээгээ хөрөнгө оруулалт оруулах ёстой шүү дээ. Хэн нэгэн шинэ сайд орж ирээд сэтгэлийн хөөрлөөр нэг юм гаргаж ирээд тэр рүү бид нар явдаг. Эсвэл 78 гишүүн тойргоосоо хэдэн саналууд оруулж ирдэг. Энэ ингэж явсаар байгаад өнөөдрийг хүртэл бид нар 30 жил яваад дууслаа шүү дээ.

Тэгэхээр энэ бодлогын асуудлууд чинь ерөөсөө энэ дотор харагдахгүй байгаад байна. Энэ дээр Хөгжлийн банк, юу Эдийн засаг, хөгжлийн яам хариулж өгөөч нэгдүгээрт, сайдаас нь уг нь бол амыг нь асуумаар байсан юм.

Хоёрдугаарт, Учрал сайд бас яг энэ дээр хэлээд өгчхөөч. Яг ямар зохицуулалтаар бид нар хийж чадаж байна энийгээ?

Гуравдугаарт, энэ сая миний хэлсэн Бүсчилсэн хөгжлийнх нь үзэл баримтлалын дагуу энэ маань яг яаж сууж байгаа юм? Жишээ нь миний гаргаж ирснээр бол хойд бүс дээр 172 тэрбум төгрөг, зүүн бүс дээр 647 тэрбум төгрөг, төвийн бүс 596, баруун бүс 470. Нөгөө хойд талын бүс чинь 172-хон тэрбум төгрөг явж байдаг. Дахиад бид нар хуучин явсан шигээ аймаг аймаг дээрээ юмаа зоогоод ингээд яваад байх юм уу? Эсвэл бүсчилсэн хөгжлөөрөө нийт Монгол Улсын хэмжээнд нөгөө аялал жуулчлалтай холбоотой асуудал, нөгөө үйлдвэржилттэй холбоотой асуудал маань энд хаана явж байгаа юм? Хойд бүс маань үйлдвэржилттэй холбоотой бүс, үйлдвэржилтийн бүс гэж байсан. Энд нөгөө үйлдвэрүүд маань хаана байгаа юм? Ямар үйлдвэр сууж байгаа юм? Ер нь тэгээд бид нар хамгийн гол зүйл бол аж ахуй нэгж дээрээ, хувийн хэвшил дээрээ түшиглэнэ гээд бүх сайд нар дуугараад л байгаа шүү дээ. Энэ дотор чинь тэр хувийн хэвшилээ дэмжиж байгаа ямар ч бодлого, ямар ч мөнгө төгрөг, юу ч орж ирээгүй байна шүү дээ. Дарханы үйлдвэр, арьс ширний үйлдвэр нэг юм эхлэх аятай болж байгаа юм шиг байна.

Гэтэл Эдийн засаг, хөгжлийн яам том мап-аар нь харж байгаад ганцхан Дарханы арьс ширний үйлдвэр биш бүс болгонд 1, 1 арьс ширний том үйлдвэр тэр хэмжээнд нь боловсруулалтаа эд нар гээд харж байх хэрэгтэй шүү дээ. Тэрний чинь хөрөнгө оруулалт хаана байж байгаа юм? Бид нар 30 жил ярьсаар байгаад л одоо өнөөдөр дахиад л 30 жил.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ удаагийн төсвийн гол онцлог бол бид Засгийн газрын үйл ажиллагааныхаа 4 жилийн хөтөлбөр, сая батлагдсан энэ жилийн төлөвлөгөө дээрээ хоорондоо уялдуулсан. Одоо жишээ нь өмнө нь бол төсвийг бид нар батлахдаа бол яг энэ 76 жижиг мажоритар тойрогтой байхад ч тэр, сүүлд томсгосон энэ мажоритар тогтолцоотой байхад ч тэр ер нь тойргийн хөрөнгө оруулалтуудыг л их анхаардаг байлаа л даа.

Тийм ч учраас төлөвлөлт, төсөвлөлт өөрөө ухаалаг биш байдаг. Тийм учраас хотод гэхэд л 20 минутын хот гээд байгаа стандарт чинь хэрэгжиж чаддаггүй. Тэгэхээр энэ удаа бол бас нэлээд бас зориг гаргаад өнөөдөр яг энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу яг энэ экспортоо нэмэгдүүлэх чиглэлийн энэ 14 мега төслийг хэрэгжүүлбэ л гээд зорилт тавьсан.

Ер нь 3 нам яагаад хамтарсан Засгийн газар байгуулсны гол шалтгаан бол яг энэ макро түвшинд эдийн засгаа тогтвортой авч явахын тулд улс төржилтөөс болоод гацаад байдаг байсан энэ төслүүдээ урагшлуулъя. Энэ 14 мега төсөл гээд байгаа зүйл чинь ерөөсөө шинэ төслүүд биш шүү дээ. Зүгээр гацчихсан, улс төржилтөөс болоод зогсчихсон байсан энэ төслүүд.

Тэгэхээр энэ төслүүдийг бид хэрвээ урагшлуулж чадах юм бол өнөөдрийн ДНБ-ийг далан аравны дөрвөн их наяд байна гэвэл бид бол цаашдаа энэ тоог ахиулах юм байна. 2028 оны хүлээлт бол 132 их наяд руу хүрэх бололцоотой юм байна. 1 хүнд ноогдох ДНБ бол бид нар 10 мянган долларт хүрье гэдэг зорилтыг л тавьсан.

Тэгэхээр энэ 14 мега төсөл бол бүхэлдээ энэ экспортын орлогыг л нэмэгдүүлэхэд л бид нар чиглээд байгаа. Тийм ч учраас өнөөдөр энэ 14 мега төслийг хэрэгжүүлэхэд гарах зардал бол төсвөөс жишээ нь юу гэдэг юм 14 мега төслийг хэрэгжүүлэхэд урьдчилсан тооцоолол 43 их наяд гэж байгаа мөртөө төсвөөс бол энэ чинь бараг 30 хувьд ч хүрэхгүй шүү дээ.

Тэгэхээр үүн дээр л энэ хувийн хэвшлийн оролцоог хангуулах гэдэг зорилгоор бол энэ 14 мега төслийг хэрэгжүүлэх, 14 эрх зүйн реформ гээд одоо бид нар тэр төрийн өмчийн компани, орон нутгийн өмчийн компанийн хуулийг барья гээд ингээд ажиллаж байгаа юм. Тэгээд ингээд өнөө Үндэсний баялгийн сангийн хууль, энэ хуримтлалын санд ноогдол ашгийг хуримтлуулах гээд бүхэлдээ мега төслийг амилуулахад энэ эрх зүйн реформ хэрхэн уялдуулах вэ л гэдэг бол хамгийн чухал зүйл гэдгийг бол бид бас хэлэх ёстой.

Тийм ч учраас эрхэм гишүүд та бүхнийг энэ томоохон төслүүдийг макро түвшинд эдийн засгаа авч явахын тулд энэ дээр улс төржилт хийхгүйгээр бид хамтдаа үүний үр дүнд нь гарья. Тийм ч учраас тэгээд эрэмбэлээд төслүүдээ ингээд танилцуулаад явж байгаа. Тэгээд энэ бол мэдээж эцэстээ Их Хурлын шийдвэр. Тэгэхээр төс.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Яах вэ дотор нь ингээд задлаад хараад байвал харах юмнууд зөндөө л байна л даа. Би нөгөө гол том зарчмаа л ярих гээд байна шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яам гээд томоор нь асуудлуудаа харж байгаад 30 жилээр, 50 жилээр харж байгаад тэрийг ямарваа нэгэн Засгийн газар орж ирснээс үл хамаараад эвслийн байна уу, эвсээгүй Засгийн газар, улаан, ногоон ямар Засгийн газар байхаас үл хамаараад энийг Монгол Улсын эрх ашиг 70 жилийн, юу 50 жилээр, 30 жилээр шууд ингээд хөгжил нь

явдаг ийм зарчим чинь ер нь цаашдаа бид нар баригдах юм уу, барихгүй юм уу? Ийм юм барихгүй бол Эдийн засаг, хөгжлийн яам гэж ер нь байх хэрэг байгаа юм уу, үгүй юу? Урд хөршид чинь бид нар өөрсдөө бол сайд дарга нар та нар бүгдээрээ очоод л бишрэн шүтээд л ирдэг шүү дээ. Хөгжил шинэтгэлийн хороо гээд л гайхалтай том бодлогыг нь барьдаг хороо байдаг юм байна. Энэний дагуу ингээд бүх яамд нь салбар салбарынхаа хөгжлийг тодорхойлоод явдаг юм байна гээд бүгдээрээ л ярьдаг шүү дээ хэдүүлээ. Тэр шиг нь яаж асуудлаа төвлөрүүлээд ингээд яагаад төлөвлөөд явж болохгүй гэж. Би энийг л асуугаад байгаа байхгүй юу даа.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: 3 намын хамтарсан Засгийн газар гээд байгаагийн гол зорилго нь юу юм бэ гэхээр яагаад ингээд тайлбарлаад байна вэ гэхээр ер нь улс төрийн намууд мөрийн хөтөлбөрт орохдоо, мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа энэ урт хугацааны бодлого дээр суурилсан. Тийм ч учраас бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 жилээр нь бичихэд бол яг Алсын хараа урт ху хугацааны бодлого дээр сууриллаад энэ 4 жилийн хөтөлбөрөө бичихэд бол ямар нэгэн тэн дээр зөрчил бол ерөөсөө гараагүй гэсэн үг. Тийм ч учраас ер нь жилийн төлөвлөгөө, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр үүнд нийцсэн төсөв гэхээр бол энэ бүгд ингээд уялдаатай явж байна.

Дээрээс нь энэ удаагийн төсвийн гол онцлог бол яг ийм индексийн үзүүлэлтүүдийг тодорхой бол бас хэмжиж байгаа. Жишээ нь эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлтийг 10 байраар ахиулна ч гэдэг юм уу. Тэр индексүүдийгээ тодорхой тавьсан учраас эргээд дүгнэх хариуцлага нь ойлгомжтой байна л гэдгийг бас эндээс харах ёстой байх л гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулаад дараа нь тодруулъя.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Яах вэ олон гишүүд асууж байгаа юм энийг. Ер нь шинэ Их Хурал шинэ эхний төсөв ярьж байгаа учраас төлөвлөгөө, төсөв хоёр хоорондоо яаж нийцэх ёстой юм бэ? Яг тэр нийцнэ гэдэг үг маань өөрөө яг юуг томьёолж байгаа юм бэ гэдгийг бүр бас бид нар ойлгоод цаашаа явчихвал хэрэгтэй юм шиг байгаа юм.

Тэгэхээр төлөвлөгөө гэдэг өөрөө энэ Үндэсний хэмжээний төлөвлөлт. Тасралтгүй шинж чанар, залгамж шинж чанар гээд энэ бүгдийг агуулсан ийм төлөвлөгөө байдаг. Төсөв бол энэ төлөвлөгөөг биелүүлэх зөвхөн нэг л хэсэг нь, нэг л хэсэг нь, нэг багц нь л гэсэн үг. Энд төсвөөр хийгдэхгүй, төсөв шаардлагагүй арга хэмжээ, зорилтууд салбар салбарын өөрсдийнх нь зорилгод хүрэх цэг ийм зүйлүүд маш олон байгаа. Тэр дотор төсөв зарлагдсан зүйлүүд дээр төр, хувийн хэвшлийн түншлэл, шууд хөрөнгө оруулалтууд, мөн төсөвтөө шууд хамааралгүйгээр төсөвт үйлдвэрийн газрууд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: 1 минут нэмчихье.

Б.Жавхлан: Тийм маш олон санхүүжүүлэх эх үүсвэрүүдийн комбинац өөрөө энэ дээр байгаа. Энийгээ бид нар зөв төлөвлөх ёстой гэдэг нь тэр төсвийн бодлогодоо оруулж, танилцуулаад байгаа нэг асуудал маань энэ юм байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яамтай болсных бид гол том макро зорилтууд, жил жилийн төсвийг бид нар ямар хүрэн дотор төлөвлөх ёстой вэ? Энэ бүгдийг энэ яамнаас хийж байгаа ,төлөвлөгөөгөө яамнаас оруулна.

Тэгээд тэгэхээр төлөвлөгөөнд тусгагдсан ажил болгон өөрөө төсөвт суух бас боломж байхгүй. Энэ дотор ямар үг, үсэг байдаг вэ гэхээр Төсвийн бодлого төлөвлөлт удирдлагын тухай хууль дээр тэр 6.10.3 гэж заалт байгаа. Төсөв нь өөрөө төлөвлөгөөг биелүүлэхэд чиглэсэн байна гэж байгаа юм. Чиглэсэн. Хэрвээ төсөв маань төлөвлөгөө ингээд 100 хувь яв цав нийцэж байвал аль нэгийг нь л бид нар энд батлах хэрэгтэй. Хоёуланг нь тусад нь ярих шаардлагагүй шүү дээ. Төлөвлөгөөг нь батлаад, тэгээд төсөв рүүгээ, яам руугаа шидчихдэг ийм л байх болно.

Б.Пүрэвдорж: Энэ Ардын намын гишүүд энэ бүлэг дотроо юмаа сайн ярина шүү. Дахин дахин танин мэдэхүйн чанартай юм битгий асуугаад бай. Сүүлийн удаа хэлье. Дахиад Бат-Эрдэнэ гишүүнд.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ танин мэдэхүйн асуудал биш шүү дээ. Хэдүүлээ ингээд ярьж байгаад асуудлуудынхаа үндсэн суурийг засах ёстой байхгүй юу. Үндсэн суурийг засах ёстой хэдүүлээ. Тэгэхгүй тэгээд жил болгон энийгээ илээд л, илээд л, илээд л явсаар байгаад өнөөдрийг хүрч байгаа шүү дээ. Өнөөдөр хэрвээ үнэхээр ийм зоригтой Засгийн газар байгуулагдсан юм бол, хамтарсан Засгийн газар, зоригт эрчүүд билүү юу билээ тиймэрхүү Засгийн газар байх аа? Тэгэхээр тэр зоригоо гаргаж асуудлыг шийдэх хэрэгтэй байна шүү дээ. Үндсэнд нь энэ хувьсгалыг хийх хэрэгтэй байна шүү дээ. Үндсээр нь, доор нь цэвэрлэх хэрэгтэй байхгүй юу даа. Өнөөдөр бид нар энийг хийж чадахгүй бол хэзээ хийх юм тийм үү? Дараа нь тэгээд хийж чадахгүй шүү дээ.

Нэг асуулт байна.Нөгөө Шинэ хоршоо дээрээ яагаад мөнгөө татчихав аа? Өнгөрсөн жил 1 их наяд төгрөг гээд л, сонгууль боллоо 1 их наяд төгрөг гэж байсан. Одоо сонгууль дууссан 500 тэрбум болчихсон уу? Яагаад татчихав аа? Энэ дээр хариулт хэлээд өгөөч.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья. Хэн хариулах юм? Хүнс, хөдөө аж ахуйн сайд Жадамбаагийн Энхбаяр өнөөдөржингөө тасалсан төлөвтэй байна шүү. Тэгээд энэ дээр харин тийм тасалсан төлөв байна. Дарханд ажиллаж байгаа юм уу? Аан за за. Тэгээд томилолт энэ тэрээ энэ ирц дээр оруулаарай.

Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья. Товчхондоо ерөөсөө огт ухраагүй шүү гишүүн. Тэгээд бас бид нар дутуу мэдээлэл өгөөд байгаа байх аа. Энэ жилдээ 500-гаад тэрбум, ирэх жилээс үргэлжлээд 1 их наяд руу хүрэх болов уу гэсэн төлөвлөлттэй байсан боловч нөгөө энэ жилийн энэ хөдөө аж ахуйн, ялангуяа мал аж ахуйн салбар дээр гарсан энэ цас, зудтай холбоотой хүндрэл нь өөрөө энэ эрэлтийг их бий болгосон байна. Ингээд одоо төсөв өргөн барих үед авсан тоогоор шууд 480-аад тэрбум төгрөгийн зээл гарчихсан байсан. Ингээд төсвийн тодотголоор одоо энэ жилдээ байгаа эрэлтийг нь хангах зорилгоор нэмээд хүүгийн татаасыг нь тавьсан. Тэрийг харах юм бол энэ жилдээ, хэрвээ банкнууд нь эх үүсвэрийн тэр хязгаарлалтын боломжууд нь хэрвээ байгаа бол, боломжтой байгаа бол төсөв талаасаа бол санхүүжилт хүүгийн татаас бол ямар ч саатах зүйлгүй.1 их наяд хүрэхэд бүрэн хүртээмжтэй байгаа. Ирэх жилийнх дээр ч гэсэн 143 тэрбум төг.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа:Сая нөгөө гацаад байсан төслүүдээ хамтарч байгаагийнхаа ачаар хэрэгжүүлье гээд хэлж байна тээ? Тэрийг маш сайн ойлгож байгаа. Тэгэхдээ яагаад гацаад байсан юм энэ чинь? Өмнөх 8 жил чинь Ардын нам дангаараа засагласан шүү дээ. Би

зүгээр нэг л жишээ хэлэхэд энэ Энэтхэгийн зээлээр баригдах ёстой нефтийн хоолой миний санаж байгаагаар бараг 2015 онд тэр Нарендра Модиирээд 1 тэрбум долларын зээл өгөх боломжтой болсон шүү дээ. Тэгээд тэрнээс хойш чинь бараг 10-аад жил болж байна шүү дээ. Яагаад энэ төсөл хэрэгжихгүй байгаа юм? Энэ чинь хамтарсан эсэхээс үл хамаарч хэрэгжвэл хэрэгжих хугацаа өнгөрсөн шүү дээ.

Тэгэхээр яах вэ ний нуугүй хэлэхэд энэ мэтчилэн ингээд 1 төсөл гэхэд чинь л одоо хэрэгжихгүй бараг 10-аад жил болчихсон байхад13 төсөл нь хэрэгжих эсэхэд эргэлзэж байгаа юм. Тэр яах вэ.

Асуух асуултууд маш их байна. Энэ Жавхлан сайдаас асууя Төсвийн хүрээний мэдэгдэл бол хүрээ хязгаар юм гэж та байнга ярьдаг тээ? Угаасаа ч зорилго нь тийм. Тэгээд түрүүчийн би юм асуухад 2.3 бол бараг 2 гэсэн үг гээд л тэгж байгаа юм. Энэ арифметик ч бай, геометр ч бай энэ чинь цаана нь мөнгөн дүн явж байдаг байлгүй дээ. Тэгэхээр би гайхаад байна энд төсвийн хүрээний мэдэгдэлд суурь зарлага байсан байх 31.9 их наяд гэж байгаа юм, ДНБ-ий 33.6 хувьтай тэнцэнэ гээд. Гэтэл одоо энэ төсвийн төсөл дээр маань, энэ суурь зарлага чинь гучин хоёр аравны зуун тавин есөн их наяд гээд ороод иржээ. 33.8 хувь ДНБ-ий.

Өөрөөр хэлбэл, энэ зөрүү чинь 204 тэрбум төгрөг байна. Тэгэхээр энэ хүрээнээсээ хэтэрчихсэн явж байгаа юм биш үү 204 тэрбумаар? Тэгээд эсвэл энэ арифметик аргаараа 204 тэрбум нь мөнгө биш юм уу?

Хоёрдугаарт, энэ аудитын дүгнэлтэд маш олон асуухуйц тийм зүйлүүд байна л даа. Бүсийн хөгжил гээд бид нар ярьж байгаа. Энд ийм зүйл байгаа юм. 558 тэрбум төгрөг бүсүүдэд, улсын хэмжээнд гээд заасан гэж байгаа юм. Гэтэл энэ чинь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиараа байршил, нэршлийг нь заасан байх ёстой. Тэгээд ийм их мөнгөн дүнг ингээд зүгээр тавьдаг юм болов уу? Тэгээд хэзээ, яаж энэ, аль бүсэд ямар, юу хэрэгжих гэж байгаа юм болоо? Улсын хэмжээнд гэхээрээ бас хаана нь хэзээ яах юм? Энэ чинь тэргэ тэр 3.3.2.6-г зөрчиж байгаа юм шиг ингэж харагдаж байх юм.

Дахиад энд бас нэг зүйл байна. Манайх чинь төрийн алба чинь 226 мянга гэж байгаа тээ? Тэгээд бүхий л бодлого ёстой бүлэг тус бүр хүртэл чухамхүү төрийн албыг бараг цомхон болгоно, хувийн хэвшлээ дэмжинэ, бизнесээ дэмжинэ гэсэн үг, өгүүлбэрүүд лоозон луугаа байгаа. Гэтэл энд 230 мянган төрийн албан хаагчдыг цалинжуулна. тэгээд 7.5 их наяд гээд орж ирсэн байна.

Өөрөөр хэлбэл, 4.1 мянган хүнээр энэ төрийн алба маань нэмэгдэх гэж байгаа юм уу? Тэгэхээр энэ чинь баримтлах гээд байгаа төс төрийн албыг цомхон байлгана гэсэн энэ бодлого чинь хэрэгжиж байгаа юм уу? 4 мянган хүнээр нэмэх гээд байгаа юм уу? Яагаад гээд? Энэнтэй холбоотой бас жишээ байна лээ л дээ. Ургамал хамгаалах төв, яах вэ би андуурч байж магадгүй Хөдөө аж ахуйн яаман дээр ургамал яах төв билээ тийм юм байгуулна гэхихсэн байгаа юм. Тэгээд энэ чинь бас л тэр бусад нэгжүүддээ хуваагаад өгч болдоггүй заавал ч үгүй байгуулах ёстой ийм алба юм уу? Магадгүй энэ мэт нийтээр ингээд 4 мянган хүн нэмэх гэж байгаа юм шиг байгаа юм.

Дахиад 1 асуулт. Шинээр барилга 298.2 тэрбумаар барих энэ барил.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя. Дэгээрээ тодруул, эхлээд юу яачхаад, хариулчхаад тодруулна.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариулъя.

Төсвийн хүрээний мэдэгдэл тэр арифметикийн асуудал биш шүү. Энэ хоёр өөр төсвийн хүрээний мэдэгдэл байна. Нэг нь батлагдсан, нэг нь өөрчлөлт орох гэж байгаа хоёр төсвийн хүрээний мэдэгдэл. тэрний зөрүүг та яриад байх шиг байна. Тэр дээр тэр зөрүүний тоонуудыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас өгчихнө биз.

Улсын хэмжээнд гэж байгаа асуудлууд жишээ нь Боловсролын сайд дээр улсын хэмжээнд хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн асуудлууд жил бүр тавигддаг. Тухайн жил хэчнээн сургууль, цэцэрлэг ашиглалтад оруулахаас хамаараад хаана, ямар тоног төхөөрөмжүүдийн хуваарилалт хийхийг сайд тушаалаараа өөрөө энийг шийдээд явдаг.

Эрчим хүчний сайд дээр ч тэр, Барилга, хот байгуулалтын сайд дээр ч тэр өөр өөрсдийнхөө чиглэлээр тухайн жил шаардлагатай энэ тоног төхөөрөмж болон бусад ийм асуудлуудаа сайд нар шийдээд явдаг байгаа шүү. Тэрнээс энэ бол байшин барилга, хөрөнгө оруулалтын ажлууд бол бас арай өөр ойлголт.

Тэр төрийн албан хаагч нарын юун дээр манай Санжаадорж дарга, эсвэл Төрийн нарийн бичгийн дарга мэдээлэл өгөөдхөөч тэр төрийн албан хаагч нарын зөрүү 4.1 мянга юу юм.

Тэр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр гарсан шинэ агентлагийн хувьд энэ хууль нь батлагдчихсан байхгүй юу. Тэгээд хууль нь батлагдсан учраас энийг бид хуулиа дагана.

Ер нь миний хэлээд байгаа тэр зардал нэмэгдэж байгаа зүйлүүд дотор ийм олон заалтууд байгаа шүү. Бүүр шууд ингээд Засгийн газраас өргөн баригдаагүй маш олон зүйлүүд байгаа. Шууд салбар салбарын хуульд хийчихдэг, эсвэл ингээд хаа нэг газраас өргөн баригдаад шууд төсөв нэмэгдэх, зардал нэмэгдэх ийм заалттай маш олон зохицуулалтууд байдаг. Бид нар багтааж оруулаагүй маш олон зүйлүүд байгаа. Бүгдийг нь оруулах юм бол энэ төсөв бол нэлээдгүй даахааргүй хэмжээний нэмэгдлүүд гарч ирнэ. Бид 3.5 их наядын урсгал зардлын нэмэгдэл байгаа. Ирсэн санал, санал бол энэнээс бүүр хэд дахин илүү байгаа шүү. Тийм учраас тэрэн дээр тоонуудыг нь задлаад яриадах.

Сүүлийн асуултаа Баярмаа гишүүн арай дууссангүй дээ тээ? Шинэ барилга 298 нь яг юу гэсэн бэ? Та микрофонгүй хэлчих юм уу? Зураг төсөвгүй ажлууд эрх биш байж болохгүй. Хэрхэвч байж болохгүй. Зүгээр яах вэ нэгэнт л энэ чинь де факто шүү дээ. Болж байгаа зүйл юу вэ гэхээр ноднин 2024 оны төсөв хэлэлцэх үед, Их Хурал дээр хэлэлцэж байх үед 200-гаад төсөл нэмэгдэж орж ирсэн. Одоо тендер зарлагдаж чадахгүй байгаа төсөвт өртөг нь дахиад магадлангаар орох шаардлагатай болчихсон, энэ жил тавигдсан хөрөнгүүд нь буцаагдах, татагдах ийм эрсдэл учирчхаад байгаа 88 төсөл жишээ нь байна. Тийм учраас одоо энэ.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Баярмаа гишүүн тодруулна. Тэрнээс гадна бас Учрал гиш сайдаа яг өнөөдрийн байдлаар Засгийн газрын агентлаг хэд байгаа юм? Тэр агентлагууд хэдэн төрийн албан хаагч ажиллаж байгаа юм тэр тоог бас дараа нь өгөөрэй.

Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тэгээд тийм зураг төсөвгүй гээд ингэж байгаа юм л даа. Тэгэхээр түрүүн энэ эрэмбэ дарааг яаж тогтоодог юм бэ гэдэг асуудал байнга яригдаж байгаа. Энэ чинь бол асар сонин. Хэн, хаана юуг, яаж барихыг шийдээд байгаа нь ерөөсөө ямар ч тодорхой юм алга. Жишээлбэл, яах вэ ингээд зураг, төсөвгүй юм төсөвт орчихсон явж байна шүү дээ 292 тэрбум төгрөг.

Гэтэл таны одоо хэлдэг зураг төсөвгүйн улмаас оруулж болохгүй байгаа юм гээд байгаа Хавдрын эмнэлэг 2 гээд. Тэгээд энэ тэгээд нэгэнт л зураг, төсөвгүй бүхэл бүтэн 298 тэрбум төгрөгийн ажил орчихсон явж байдаг юм бол тэр хавдрын эмнэлгээ оруул л даа. Яагаад гэхээр 72444 хүн 23 онд гэхэд өвдсөн байна. Тэгээд 65 хувь нь хожуу. Тэгэхээр энэ хүмүүс эмнэлэгт очиж эмчлүүлэхээс өөр зам байхгүй.

Гэтэл ингээд зураг, төсөвт суулгаагүй юуг нь болохоор оруулаад, зураг, төсөвгүй болохоор юуг нь оруулаад, юуг нь оруулдаггүй юм бэ гэдэг асуулт байна.

Түрүүчийн тэр төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөл.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья. 200 гаруй тэрбум төгрөгийн зөрөө гарсан гээд байна шүү дээ.

Ж.Баярмаа: Баярмаа гишүүний асуултыг уучлаарай сайн ойлгосонгүй. Ирэх жил 640 төсөл байгаа. 38 шинэ төсөл байгаа. Энэ 38 төсөл дотроос зураг, төсөвгүй, ТЭЗҮ-гүй 1 ч төсөл байхгүй. Та 298 гэж ямар төсөв яриад, төсөл яриад байгаа юм? Би ойлгосонгүй. Ямар төсөл юм айн? Тэгвэл аудитынхан тэр дээр хариулаадах л даа. Зураг, төсөвгүй шинээр тэр 38 төсөв, төсөл дотроос юу байгаа юм? Өнгөрсөн оныхтой нь яагаад байгаа юм биш үү, айн? Өнгөрсөн оныхтой андуураад байгаа юм байна. Аудитаас нэмэлт хариулт. өгчхөөрэй.

Энэ жил шинээр, ирэх жил шинээр эхлүүлэх 38 төсөл дотор зураг, төсөвгүй 1 ч төсөл байхгүй. Бүүр албан ёсоор хариуцлагатай хэлье. 1 ч төсөл байхгүй шүү.

Б.Пүрэвдорж: Ер нь нийтдээ ирэх оны төсвөөр 1000 гаруй төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Тэрний 38 нь шинээр орж ирж байгаа төсөл байгаа. Тэгэхээр үлдсэн тэр 1000 гаруй төсөл чинь өнгөрсөн жилүүдэд төсөв дээр тавигдсан тэр үргэлжлээд явж байгаа хөрөнгө оруулалтууд байгаа.

Тэгэхээр яг энэ нарийн тооны асуудлаар Баярмаа гишүүний асуултад Наранчимэг дарга хариулья. 2 номер.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал Энхболд. Баярмаа гишүүний асуултад хариулья.

Энэ аудитын дүгнэлтийн 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой дүгнэлт дээр байгаа юм. Энэ дээр их засварын ангиллын 298.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний магадлалаар баталгаажсан зураг, төсөл дээр нэмэлт хийгдээгүй байна гэдэг ийм дүгнэлт байгаа юм. Нэмэлт зураг, төсвийг нэмэлтээр баталгаажуулаагүй байна. Өөрчлөлт орсон боловч нэмэлтээр баталгаажуулаагүй байгаа юм. Шинээр хийх арга хэмжээ биш. Их засвар Анхан.

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Яах юм ярих юм уу?

Б.Пүрэвдорж: Жаргалан гишүүнийг цуцалъя. Дэгийн тухай хуулийн дагуу хариулт бүрэн биш бол дахин тодруулах боломжтой. Тэгээд энэ хүрээнд Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Тэгээд асуултаа асууж барагдах ч үгүй л юм байна л даа. Тэгээд мэдэхгүй би энэ зохиогоогүй шүү 398.2 тэрбум төгрөг зураг, төсөвгүй магадлангаар ороогүй гээд ингээд шинэ барилга гээд байж байгаа шүү. Тэрийгээ дахиад нягтална биз.

Тэгээд тэр төсвийн хүрээний мэдэгдэл чухамхүү хэтэрч болохгүй гээд байсан чинь төсвийн тос төсөл дээр 204 тэрбум болоод хэтрээд ороод ирсэн байх юм. Эсвэл төсвийн хүрээний мэдэгдэл чинь юу юм уу нэмэгдэж батлагдсан юм уу би анзаараагүй өнгөрчихсөн юм уу 204 тэрбумаар?

Б.Пүрэвдорж: Жавхлан гишүүн хариулъя.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариу нэмэлт мэдээлэл өгье.

Шинээр эхлэх тэр барилга байгууламж 38 төсөл, арга хэмжээн дотор эрчим хүчнийхэн, зам тээвэр ложистикийн 22 зам, бусад 9 эрчим хүчний салбарын, 5 төсөл нь бусад гээд ингээд байж байгаа. Нийтдээ 38. Энэ дотор би дахиад хэлье. Нэг ч зураг, төсөв, ТЭЗҮ-гүй төсөл байхгүй шүү. Та хаанаас ямар тоо хэлээд байгааг би сайн ойлгосонгүй.

Тэр Төсвийн хүрээний мэдэгдлийн талаар Эдийн засаг, хөгжлийн яаманд нэмэлт мэдээлэл өгчих.

Б.Пүрэвдорж: Батхүү дарга 6 номер.

И.Батхүү: Баярмаа гишүүний асуултад хариулъя.

Сая 24 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 25 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26-27 оны төсвийн төсөөллийн 6 дугаарт нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээг 31 их наяд 955 тэрбум 200 сая гээд, ДНБ-д эзлэх хувийн 33.6 хувь гээд ийм тоотой байгаад байгаа юм. Зөрүүтэй тоо энд өргөн барьсан Төсвийн хүрээний мэдэгдэл дээр байхгүй байгаад байгаа.

Б.Пүрэвдорж: Учрал сайд төрийн албан хаагч, агентлагийн тооны асуудлаар.

Н.Учрал: Засгийн газрын зүгээс бол шинэ агентлаг шинэ, ТӨК, ямар нэгэн бүтэц нэгж бол байгуулахгүй гэдэг зарчмаа бол бариад ажиллаж байгаа. Зүгээр өнгөрсөн парламентын үед батлагдчихсан хууль дээр нь тус салбар нь агентлагтай байна гээд саяын тэр ургамал хамгааллын ч юм уу, эсвэл олон улсын гэрээ конвенцод нэгдсэн ч юм уу ийм онцгой тохиолдлууд үүсэж байх шиг байна. Бараг өөр байхгүй байх. Одоо бол төрд 1 226 мянган төрийн албан хаагч, тэгээд үнэндээ бол эндээс чинь дөнгөж 21639 л төрийн захиргааны албан хаагч байгаа. Захиргааны. Тэгэхээр эндээс бол төрийн үйлчилгээ чинь 153 мянга. Тэгээд сургууль, цэцэрлэг, эмнэлэг баригдахын хэрээр ТҮ-гийн тоо өсдөг. Түүнээс болоод төрийн албан хаагч нар өсөөд байгаа юм шиг харагдаад байгаа юм.

Тийм учраас төрийн албаны шинэчлэлийг хийнэ. Төрд одоо бол нийт 38 агентлаг үйл ажиллагаа явуулж байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь ингээд салбар болгон хууль батлаад л, тэгээд тэр агентлаг нэмдэг. Жишээ нь Алтанхуягийн Засгийн газар 14 яамтай, 16 сайдтай байсан. 28 агентлагтай байсан шүү дээ. Гэтэл одоо ингээд л яамд нь ихсээд л, дахиад агентлаг нь данхайгаад л энэнээсээ болоод төрийн албан хаагчдын тоо нэмэгдээд байгаа гэдгийг хэлмээр байна.

Батбаярын Жаргалан гишүүн асууна.

Б.Жаргалан: Эрхэм гишүүд ээ өнөө шинэ 30 жилийг эхлүүлэх гээд байгаа шинэ парламент анхны төсвөө хэлэлцэж байна. Тэгэхээр та бид бүрэн эрхийнхээ хугацаанд ердөө 4 удаа энэ ажлыг хийнэ. Тэгэхээр энэ үйл ажиллагаандаа бас туйлын хариуцлагатай хандмаар байна. Тэгээд өнөөдөр бол гишүүд хэлээд л байна. Ирц хангалтгүй байгаад байна, сайд нар ерөөсөө асуултад хариулахгүй байна, сайд нар угаасаа дийлэнх нь байхгүй байна. Тэгэхээр бол энэ төсвөө бид нар их маш тийм ул суурьтай хэлэлцмээр байх юм. Тэгэхээр Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх бол төсөв батлах явдал. Үндсэн хуулиар олгогдсон эрх байгаа. Өнгөрсөн хугацаанд ер нь КОВИД-ын хууль энэ тэр гээд л ер нь Улсын Их Хурлын энэ төсөв батлах эрхэд маш ихээр халдсан байдаг. Тэгэхээр бид нар бол анхнаасаа ингэж эхэлмээргүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ төсвийн хэлэлцүүлгийг маш ул суурьтай хийгээд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, сайд нар өөрсдийнхөө салбар дээр тавигдсан зүйлүүдээ бас энэ Байнгын хороодоороо дамжуулдаг санж уу, байдаг гишүүдэд бас тусдаа танилцуулаад энэ тэр явмаар байна. Тэгээд энэ парламентад чинь цоо шинээр сонгогдсон 80 гишүүн байгаа шүү дээ. Анхны төсвөө бас хэлэлцэж байгаа. Тэгэхээр ингэж явах нь бас зөв гэж үзэж байна.

Нөгөөтээгүүр бас өмнөх парламент бол хууль тогтоох үйл ажиллагаандаа маш муу, хариуцлагагүй ханджээ гэдгийг бол онцгойлон протоколд тэмдэглүүлэхийг хүсэж байна. Яагаад вэ гэхлээр төсвийн, өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлийг ерөөсөө хэлэлцээгүй орхигдуулсан байсан. Мөн энэ 25 оны жилийн төлөвлөгөөг бас хэлэлцээгүй орхигдуулсан байсан. Энэ бүх ажил энэ дээр өнөөдөр бид нарын нуруун дээр ирээд, тэгээд энэ цаг хугацааны хувьд ч гэсэндээ цаглавар нь аягүй сонин явж байна.

Тэгэхээр би гол нь энэ хэд хэдэн сайд нараас юм асуумаар байгаад байгаа юм. Тэгээд салбар хариуцсан сайд нар нь байдаггүй. Нэгдүгээрт, эрчим хүчний салбар дээр бас нэлээн их мөнгө тавигдаж байгаа. Тэгээд сая 24 оны төсвийн тодотгол дээр эрчим хүчний үнэ, тарифыг чөлөөлөх шилжилтийн зардал гээд 131.1 тэрбум төгрөг тавигдсан. Одоо энэ шинэ төсөв дээр болохлоор эрчим хүчний шилжилт гээд бас 50 тэрбум тавигдаад ороод ирж байна. Өөрөөр хэлбэл, 181.1 тэрбумаар бас яг ямар зүйлд зарцуулж байгаа вэ гэдгийг энэ Чойжилсүрэн сайдаас асуумаар байгаад байгаа юм.

Хоёрдугаарт, төсвийн байгууллагын эрчим хүчний зардал гээд нөгөө эрчим хүчний зардал, тариф нэмэгдэнэ гэсэн хүлээлттэйгээр ийм зардлын зардлаа нэмэгдүүлээд ороод ирж байна гэж ингэж ойлголоо. Тэгэхээр Эрчим хүчний зохицуулах хороо бол тарифаа нэмэгдүүлээгүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр яахлаараа ингээд тэр үнэ нь өөрчлөгдөөгүй байхад энэ төсвөө ингээд шууд батлаад явчихдаг юм бэ? Эрчим хүчний зохицуулах хороонд тэр үнэ, тарифаа нэмэгдүүлэх нь тусдаа асуудал. Тэгээд нэмэгдүүлчихсэний ар дээр нь эсвэл тодотгодог уу, яадаг сан уу тэгээд асуудлаа шийдээд явах нь зөв гэж бодож байна.

Ер нь энэ эрчим хүчний асуудал дээр манай сайд нар маш ийм буруу бас хариуцлагагүй мэдэгдлүүд хийгээд байна. 34 жил алдагдсан салбар ч гэх шиг. Яг үнэндээ 2016 онд Монгол Ардын намд ажил хүлээлгэж өгч байх үед бол энэ салбар алдагдалгүй болчихсон байсан юм шүү дээ. Тэгэнгүүт ингээд бүх юмыг ингээд үгүйсгээд, өнгөрсөн 8 жилийн алдаа дутагдлаа ингэж ийм цайруулсан зүйл хийгээд байна.

Дараачийнх нь энэ Хүнс, хөдөө аж ахуйн сайд бас байхгүй байгаад байна. Хүнс, хөдөө аж ахуйн сайд дээр Атрын 4 дүгээр аян, Хүнсний хангамж, Аюулгүй байдал, Цагаан алт, Шинэ хоршоо гээд асар их хэмжээний ийм хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрүүд байна. Нийт 4.5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдох нь. Үүнд 377.1 тэрбум төгрөгийн хүүгийн татаас явах нь. Энэ ямар бас аргачлалаар явах юм бэ? Ер нь хэн хэн авах юм бэ гэдэг дээр бас энэ сайд маань бас хариулт өгмөөр байна.

Б.Пүрэвдорж: Чойжилсүрэн сайдыг дуудаарай. Жавхлан гишүүн хариулъя.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Тодотголоор 131 тэрбум ирэх жил Эрчим хүчний яаман дээр энэ чинь дандаа л татаас юм байгаа юм. 50 тэрбум. Өмнөх жилүүдэд ч ингэж ирсэн. Ер нь жил ирэх тусам л энэ ингээд нэмэгдээд, эрсдэл нэмэгдээд л хуримтлагдаад л байгаа юм. Тэгээд энэ салбарын түрүүн Энхцэцэг гишүүн бас хэлж байна лээ. Бид өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээгээ тооцох ямар ч боломж байхгүй юм байна лээ. Одоо суурилагдсан эх үүсвэр нь 1700мвт хүрэх үү үгүй юу? Одоо бид энэ хуримтлагдсан энэ асуудлуудыг эрт, орой хэзээ нэгэн цагт энийг шийдэхээс өөр арга байхгүй. Хойшлох тусам улам л үнэтэй болно. Эрт хийх тусмаа бид арай л бага зардалтайгаар хийх байх.

Тийм учраас энийг үнэнтэйгээ тулаад энэ 4 жилд энэ шилжилтийн арга хэмжээгээ хийе гэж байгаа. Энэ маань өөрөө ер нь энэ бүсчилсэн хөгжил ч бай ер нь цаашдаа энэ улс эх орны маань хөгжлийн бараг хамгийн зангилаа том асуудал болчихоод байгаа. Бүх асуудал энэ эрчим хүчний энэ хязгаарлалт дээр очиж ингэж зогсож байгаа. Зогсож байгаа.

Цаашдаа энэ өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний энэ хэрэгцээг төсвийн хөрөнгө оруулалтаар бид нар хэзээ ч шийдэж дийлэхгүй. Тийм учраас гадна, дотнын болон төр, хувийн хэвшлийн түншлэл, шууд хөрөнгө оруулалтаар энэ бизнес болж чадахаар, сонирхол татахуйц хөрөнгө оруулалтын салбар, энэ либерал салбар болох ёстой юм байгаа юм. Том агуулгаар, агуулгаар. Бид хийхгүй бол болохгүй. Энэ 130 тэрбум, 50 тэрбум, нийтдээ хэрвээ 180 тэрбум төгрөгөөр үнэхээр энэ шилжилтийг хийж чадах юм бол энэ хэмжээний зардлаар ингээд хийгээд зогсоод цаашаагаа энэ салбар нь өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явчихна гэх юм бол одоо цаасан дээр буусан байгаагаараа үнэхээр хэрэгжиж чадах юм бол энэ үнэхээр супер шилжилт болно. Супер шилжилт болно. Бид нар урд талын түүх энэ тэр юмыг Эрчим хүчний сайд нь өөрөө хэлэх байх. Одоо тулчихсан асуудал бол ерөөсөө энэ.

Тэгэхээр энэ одоо энэ хоорондоо гинжин өрний л асуудлууд байгаа. Энийгээ, эд нарыг чинь дагаж бэлтгэн нийлүүлж байгаа тэр нүүрсний уурхайнууд чинь бараг л бас л таг зогсчиход л хүрчихсэн. Ийм эрсдэлүүдийг л үргэлжлүүл, хааж байгаа л ийм л зардал даа.

Тэгээд яах вэ том зорилт тавиад ингэж байгаа. Хэзээ, ямар үнэтэй, яаж шат дараатай хийх вэ? Энэ бүгд бол нарийвчилж гараагүй. Үндэсний хороо байгуулагдсан

Доржханд сайд энийг ахлаад ингээд явж байгаа. Одоо бодлогуудаа мэдээж Улсын Их Хурал дээр дэлгэрэнгүй тайлбарлаад, тайлагнаад явах байх.

9 сарын 1-нд төсөв өргөн барьсан. Одоо хэлэлцээд эхэлж байна. Энэ хооронд ингээд энэ нээлттэй, олон нийтэд нээлттэй, гишүүдэд ч ингээд цахим хэлбэрээр нээлттэй оччихсон танилцах. Энэ дээрээс тодруулж хэлэлцэх асуудлууд бол бүгд нээлттэй. Энэ хооронд Улсын Их Хурал ч тэр, Засгийн газрын хүрээнд ч тэр хэд хэдэн нээлттэй хэлэлцүүлгүүд хийсэн. Олон нийтэд чадлаараа хүргэсэн.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмэлт хариулт.

Б.Жавхлан: Шинэ зохицуулалт, шинэ цаглаврын хувьд цоо шинэ зүйл байлаа. Өөр энэ жил тэгээд өнгөрсөн зун олон юм давхардлаа шүү дээ. Тэгээд хэлэлцүүлэг хийх хязгаар, цаг хугацаа, тэгээд нэлээн хязгаарлагдмал байсан байсан. Тэгэхдээ энийгээ цаашдаа улам хичээгээд хэдийгээр яг амралтын сезон төсөв төлөвлөх ийм цаг хугацаа давхардсан хэдий ч тэгээд л чадлаараа л энэ дээр төсвөө боогоод, хэлэлцүүлэг хийгээд, ингээд явах шаардлагатай гэдэг нь харагдаж байгаа.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хүн байхгүй юм уу? Ганц ч хүн байхгүй юм уу? Нэлээн энэ хэрэгжилт дээр нэлээн нарийн юм асуугаад байна шүү дээ. Ямар ч байсан яах вэ би өөрсдийнхөө мэдлийн хүрээнд, мэдлэг, юу мэдээллийн хүрээнд хариульж Жаргалан гишүүний асуултад.

Төсөв бол өөрөө үржүүлэгч. Өмнө нь бол ЖДҮ-лэлийн сан яаж явдаг байсан юм бэ гэхээр дандаа төсвөөс санхүүжигдээд тэр санхүүжигдсэн төсвийн хүрээндээ зээл.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: 1 минут дахиад.

Б.Жавхлан: Тийм учраас цаашдаа бол энийг мэргэжлийн байгууллага нь тэр чөлөөт эх үүсвэрээрээ тэр зээл олгодог байгууллагууд, банкнууд, санхүүгийн байгууллагууд өгөөд явна. Хүүгийн татаас өгөх л ийм зарчмаар бүрэн бодлогын шилжилт хийсэн. Төрийн албан хаагч аль ч яам зээл олгохгүй. Ийм том бүтэн шилжилт хийсэн. Энэ хүрээнд ингээд явна. Ирэх жил нэлээн том, томоохон Үндэсний хөтөлбөр гэх юм бол Цагаан алт хөтөлбөр нэлээд энэ жил эхэлж байгаа. Хэрэгжилт бол ирэх жил нэлээн түлхүү явж ирнэ.

Тэгэхээр мэдээж тэр яг салбарын тэр босго, нарийн шалгууруудыг яам өөрөө зарлах ёстой. Тэрэнд нь ямар аж ахуйн нэгжүүд тэнцэж байгаа юм? Банкнаас зээл авч чадах уу, үгүй юү, банкны шаардлагыг хангах уу, үгүй юү гэдэг энэ бүүр тусдаа асуудал. Тэр бол банкны өөрийнх нь шалгуур. Ийм л зарчмаар явах юм. Тэгээд уг нь яамнаас нь нарийн мэдээллүүд өгчихвөл их сайн байна. Энэ чухал асуудал.

Б.Пүрэвдорж: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хэн байна? Санхүүгийн дарга нь 2 дугаар, индрийн 2 дугаар микрофон дээр.

З.Тулга: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Санхүү хөрөнгө оруулалтын Тулга.

2025 оны төсвийн төсөлд нийт Цагаан алт, Хүнсний хувьсгал, хоршоо, Атрын 4 дүгээр аян гэж 4 хөтөлбөр арга хэмжээний хувьд төсөв дээр тусгагдсан байгаа. Атрын 4 дүгээр аяны

Б.Пүрэвдорж: Микрофон руугаа ойрхон ярь. Микрофон руугаа ойрхон ярь6

З.Тулга: За, Атрын 4 дүгээр аяны хүрээнд нийт 25 онд 650 тэрбум төгрөгийн зээл олгохоор төсөвлөгдсөн байгаа. Үүний 300 тэрбум нь эргэлтийн хөрөнгийн зээл, 350 тэрбум нь хөрөнгө оруулалтын зээл байгаа. Газар тариа, үр дэмжих зээлийн хөнгөлөлтөд 58.6 тэрбумд туссан байгаа. “Цагаан алт” хөтөлбөрийн тухайд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

З.Тулга: Цагаан алт үндэсний хөтөлбөрийн тухайд нийт төсөв 113.2 тэрбум, ноосны урамшуулалд 25.4, арьс ширний урамшуулалд 10 тэрбум, салбарын үйлдвэрүүдэд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэхэд 77 тэрбум байгаа. Мөн ноос, ноолуур, арьс ширний үйлдвэр, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээлийн хувьд 38-ны 3 тэрбум, хөрөнгө оруулалтын зээлийн хөнгөлөлт нь 38-ны 6 тэрбумаар туссан явж байгаа. Үүгээрээ дотоодын экспорт, импортын хамаарал буурч ажиглагдаж байгаа. Энэ хүрээндээ цаашдаа өдий өгөөж нь эергээр туссан харагдаж байгаа.

Б.Пүрэвдорж: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Саяын яамны төлөөллийн өгсөн тоо баримтуудаасаа энэ ирсэн цаасан дээр байгаа шүү дээ. Тэгэхээр бараг би би илүү уншаад танилцуулчих л юм байна л даа. Тэгэхээр цааш юу асуугаад байна вэ гэхлээр ер нь бол яг салбарын хөгжилд ямар тус дэмтэй байх юм? Ямар шалгуураар аль бүс нутагт олгох юм? Аль аль банкнуудтай хамтарч ажиллаж байгаа нарийн мэдээллүүдийг нь л асуусан ухаантай юм.

Тэгээд Сангийн сайд маань ганцаараа шахуу танхимд байгаа учраас энэ зээлийн үйлчилгээний төлбөртэй бас холбоотой асуулт байна. Энэ жил, ирэх жил бол 1.3 их наяд төгрөгийг зээлийн хүүд зарна гэхихсэн. Тийм гадаад зээлийн хүү тээ? Тэгээд үндсэн төлбөртөө 1.7 1 3 хувь орчим их наядыг нийтдээ зээлд зарцуулна гэж байгаа юм. Тэгэхээр ирэх жилээс энэ төлбөр чинь бас ил маш өндөр болж байгаа шүү дээ тийм үү? Тийм. Тэгэхээр 26 онд яг хэд байх вэ? 27 онд хэд байх вэ? Ер нь цаашдаа энэ дарамт ямар байх вэ гэдэг тал дээр та тайлбар өг.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.1990 оноос хойш хуримтлагдсан Засгийн газрын зээлийн жил бүрийн хүүгийн төлбөрийг Сангийн сайдын багцад ороод явдаг юм байгаа юм. Ирэх жилийн хуримтлагдаж байгаа нь бол зээлийн хүү дээр 1.3 их наяд, үндсэн зээлийн төлбөр 1.4 их наяд байгаа. Үндсэн зээлийг төлөхөд 1.4 их наяд дээр бид нар ирэх жил гаргаж байгаа эх үүсвэр маань 1.9 их наяд өөрөөр хэлбэр, 500 тэрбум төгрөгөөр давж байгаа. Энэ 500 тэрбум төгрөгөөр бид зээлүүдээс урьдчилж төлөх, бондуудаас урьдчилж төлөх ийм боломжууд байгаа.

Гэхдээ төв банкин дээрх валютынхаа нөөцийг харж байгаад урьдчилж төлөх шаардлага байна уу, үгүй юу. Үнэхээр нөөц сайн байгаад байвал урьдчилаад төлчихнө. Төлөвлөсөн хэмжээндээ нөөц маань байх юм бол заавал урьдчилж төлөөд байх шаардлагагүй ийм зохицуулалтуудыг Засгийн газар дотроо хийгээд явна.

Харин 26, 27, 28 онуудаас бол энэ хэмжээ нэг их нэмэгдэхгүй дээ нэгд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Асуулт асуухад хариултууд бүгд бөөрөнхий байдал ийм сонин л болчихсон юм байна л даа. Бүгд санаж байвал одоогоос яг 4-хөн сарын өмнө Их Хурлын сонгууль болсон. Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр, Ардчилсан намын мөрийн хөтөлбөр гээд дандаа л юу гэдэг юм чөлөөт эдийн засгаа дэмжинэ, төр цомхон байна, хэмнэнэ, тийм татвар нэмэхгүй иргэдээ бодно гээд л бүгд амлалт өгөөд л орсон. Тэгээд одоо яг ингээд 2025 оны төсвийг хараад байж байхад 20 хувиар төсвийн зарлагыг өсгөчихсөн, 2024 онд 30 их наяд байсан бол 36 орчим их наяд төгрөг болгоод оруулаад ирчихсэн. Тэгэхээр энэ байдал бол ерөнхийдөө иргэдэд нэгд их асуултууд их гарах байх. Бид нарын хувьд ч гэсэн их тийм төсөв хэтэрхий ийм үрэлгэн төсөв байна гэж харж байгаа.

Хоёрдугаарт гэх юм бол энэ Үндэсний аудитын газрынхныгаа нэг бол яадаг юм татан буулгадаг юм уу? Яах учиртай юм? Жил болгон л, түүрүүн төсвийн тодотгол дээр ч гэсэн орж ирээд л хөөрхий энэ чинь болохгүй байна, төсөв чинь тэлээд байна, инфляцад нөлөөлнө, эдийн засаг чинь хямарна шүү гээд л ингээд л сануулаад л байдаг. Тэгээд эд нарын энэ дүгнэлт, зөвлөмжийг авч байгаа манай энэ засаг төрийнхөн ер нь байна уу, байхгүй байна уу?

Жишээ нь, Үндэсний аудитын газрын энэ дүгнэлтийн 15 дээр өмнөх аудитын төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах зөрчил өмнө харьцуулахад буурсан боловч дахин давтагдаж байна гээд ингээд бичээд оруулаад ирэхэд тэгээд л ингээд л хүчээр явах гэж л байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээрээс бүр ингээд тодорхой бичээд өгчихсөн. Төсвийн зарлагын өсөлт сүүлийн жилүүдэд хэт нэмэгдэж, эдийн засаг дахь төрийн оролцоо ихээр өсөж байгаа нь төсвийн болон хөгжлийн бодлоготой нийцтэй бус, хувийн хэвшил, мөнгөний бодлогын орон зайг хязгаарлах гол нөхцөл болохоор байна. гээд ингээд Тогтвортой байдлын зөвлөл нь хүртэл зөвлөмжөө гаргачихсан байдаг. Тэгээд бид нар ингээд төсвөө 20 хувиар нэмчхээд сууж байдаг. Энэ Жавхлан сайдаас асуух гэсэн юм. Энэ зөв үү, буруу юу? Нэгд.

Хоёрт гэх юм бол бас бид өөрсдөөсөө эхлэх ёстой юм болов уу гэж төсвийг задалж харлаа. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын төсөв бол 2017 оны байдлаар 31.5 тэрбум байсан бол өнөөдөр 2025 онд 191.1 тэрбум гэж орж ирж байгаа. Өмнөх онд 142.1 тэрбум байсан бол 2025 оны энэ төсвийн төсөөлөл, төсөл дээр чинь 191.1 тэрбум гээд ороод ирж байгаа юм. Тэгээд хэдүүлээ энийг Улсын Их Хурлын гишүүд лидершип, манлайллаа өөрсдөөсөө эхлэх ёстой юм биш үү? Тэгээд энэ дээр бас хариулт авмаар байна.

Дахиад одоо та бүхэн бүгд л харж байгаа байх. Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв 2017 онд 4.6 тэрбум байсан бол өнөөдөр 2025 онд 39.8 гээд ороод ирж байгаа юм. Үндсэндээ ингээд 9 дахин өсчихсөн. Өмнөх оныхоосоо бараг 30 хувь өсчихсөн. Монгол Улсын ерөнхий сайд дээр 2017 онд 271.9 тэрбум байсан бол 2025 онд 438.5 тэрбум гээд ороод ирчихсэн. Өмнөх онд 348 байсан. Ингээд 50, 60, 70 тэрбумаар ингээд өсгөө оруулаад ирдэг. Ингээд багцлаад үзэх юм бол зөвхөн манай Их Хурал, Ерөнхий сайд,

Ерөнхийлөгчийн төсөв дээрээс түрүүн оныхтой харьцуулаад хэмнэлт хийх юм бол 120 орчим тэрбум төгрөг хэмнэж болж байгаа юм.

Хэрвээ 120 тэрбум төгрөгийг бид нар хэмнэж чадах юм бол өнөөдрийн энэ багш, эмч нарын цалинг жилдээ ядаж 3 орчим сая төгрөгөөр өсгөх ийм боломж, бололцоонууд зүгээр хамгийн наад зах нь жишээ гарч ирж байгаа.

Цаад талдаа гэх юм бол хуулийнхаа дагуу юу вэ гэх юм бол Үндэсний баялгийн сангийн хууль дээр байгаа тэр Хөгжлийн сангаа бас ажиллуулмаар байна шүү дээ. Заавал төсөв ашигтай гарч байж тэр хөгжлийн санд 50 хувь нь ордог. Тэндээс хөгжлийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн, дэд бүтцийн, нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалтыг хийнэ гээд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя.

Сонгуульд улс төрийн намуудын танилцуулсан хөтөлбөр бол зүүний чиглэл, барууны чиглэлийн намуудын хувьд өөр өөрсдийнхөө үзэл баримтлалаар л өргөн барьсан л тийм зүйлүүд. Энэ удаа хамтарсан Засгийн газар гээд энэ 2 чиглэлийн намуудын үзэл баримтлал нэгдсэн гэсэн ойлголт бол биш шүү дээ. Томоохон мега төслүүд тулгамдсан асуудлуудаа энэ эх орныхоо үндэсний хэмжээнийхээ хөгжлийн төлөө энийгээ урагшлуулья гэдэг ийм үзэл баримтлал дээр нэгдсэн, хамтарсан Засгийн газар гэж ингэж ойлгож байгаа.

Тийм ч учраас хэдүүлээ цуг сууж байгаад хөтөлбөрөө баталлаа. Хөтөлбөрийнхөө хүрээнд жилийн төлөвлөгөөгөө баталлаа. Жилийн төлөвлөгөөнийх чинь нэг хэсэг хэдүүлээ ингээд өнөөдөр төсвөө яриад ингээд сууж байна.

Татвар нэмэхгүй. Энэ хэлсэндээ байж байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ. Энэ хэлсэндээ байж байна. Жишээ нь энэ удаагийн өргөн баригдсан төсөв дотор хувийн хэвшилтэй булаацалдаад, өрсөлдөөд үйлдвэр аж ахуйн нэгж барьж байгаа зүйл огтоос байхгүй. Энэ нэмэгдэж байгаа, баригдаж байгаа зүйл чинь эрчим хүч, энэ зам хоёрын үзүүр дээр нь нөгөө хязгаарлагдчихаад байгаа эрчим хүчээ тайлж аваад тэнд хувийн хэвшлийнхэн л барилга байшин, баялаг бүтээх үйлдвэр, байгууламжуудаа барина.

Зам ч гэсэн тэр. Энэ дээгүүр хувийн хэвшлийнхэн л давхина. Энэ өөрөө төсөвт өртгийг нь бууруулдаг хамгийн том дэд бүтэц, суурь. Тэгэхээр энэ хувийн хэвшлээ дэмжиж байгаа хамгийн том энэ гацаагаа гаргаж байгаа ийм зүйл. Түрүүн би төсвийн үржүүлэгчийг хэллээ. Хамгийн том төсвийн үржүүлэгч нь одоо эрчим хүчний салбар болчихоод байгаа. Өнөөдөр эрчим хүчинд хийж байгаа 100 төгрөг, дараа жилийн ДНБ-ий 416 төгрөгийг бий болгож байгаа. Тэр 416-г хувийн хэвшил бүтээнэ. 100 төгрөгийг нь бол төсөв өөрөө хийх ёстой. Ингэж явж байна.

Аудитынхыг аудитынхан хэлнэ биз. Ер нь бол бид 2023 онд орсон хэмнэлтийн хууль, 2022 оны Хэмнэлтийн хууль, 2023 онд орсон Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлт, энэ суурь зарчмуудаараа бид нэлээн маш сайн сахилга баттай болж ирж байгаа шүү. Төсвийн хөрөнгө оруулалт дээр бол зураг, төсөвгүй юм сүүлийн 2 жил бол Засгийн газраас өргөн баригдсан төсөл дотор бол байхгүй гэдгийг бид биш аудитаас энийг дүгнэлт гаргасан байдаг.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд шинэ институт маань маш сайн, идэвхтэй ажиллаж байгаа. Бид ч цаашдаа зайлшгүй хамтарч ажиллах ёстой гэдгийгээ маш сайн ойлгож ингэж ажиллана.

Одоо Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмж дотор орсон олон зүйлүүдээс бид шууд ажил болгоод эхэлчихсэн нэг зүйл байна. Энэ бол Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуультай больё, улсын хөрөнгө оруулалтын тухай хуультай больё гээд ингээд ажлаа эхлүүлчихсэн явж байна. Очирбат гишүүнээ тэгээд өөрсдөөсөө.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нээх их хариулаад хэрэггүй дээ болно.

Ренчинбямбын Сэддорж гишүүн асуулт асууна. Ганбат гишүүн тодруулъя. Очирбат гишүүн.

Г.Очирбат: Би энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгч байгаа зөвлөмжөө дагаад өгөөч л гэж байгаа юм. Үндэсний аудитын газраас гаргаж байгаа дүгнэлтээ дагаад өгөөч л гэж байгаа юм. Хэдэн хувь дагаж байгаа вэ? Тэр дээрээ хариулт авчихъя. Нэгт.

Хоёрт гэх юм бол бид өөрсдөөсөө эхлээд энэ төсвөө хэмнэе л гэж байгаа юм. Бид нар төсвийн алдагдалгүй энэ анхны хэлэлцүүлэг шүү дээ, алдагдалгүй ингээд батлах боломж бололцоо байна. Тэгэхээр энэ дээр Их Хурлын гишүүд бүгд хараач гэж байгаа юм. Нэг бол бид нар ашигтай ч баталж болно шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас хараач гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ийм боломж, бололцоонууд нь харагдаад байхад Жавхлан сайд бас манлайлал үзүүлээд энэ чинь анхны 126 гишүүнтэй парламент, анхны том Хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд ийм том хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ийм анхны ийм Засгийн газар. Мөн дээрээс нь хамгийн анхны 126 Их Хурлын гишүүн төсвөө ингээд жил болгон алдагдалтай баталдаггүй алдагдалгүй, ашигтай баталдаг. Нэг бол алдагдалгүй.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Очирбат гишүүн тэгээд өөрсдөөсөө эхэлье гэдэгтэй 100 хувь санал нийлж байна шүү. Энэ дээр та манлайлал үзүүлж санаачилгатай байх юм байна гэж би ойлголоо. Тэр яг Улсын Их Хурлын Тамгын газрын зардал өнгөрсөн оных чинь 76 гишүүнтэй байсан. Энэ жил 126 гишүүнтэй. Хагас жил, хойтон бүтэн 126-тай явах учраас энэ нь зөрүү байгаа болов уу гэж би ингэж бодож байна.

Алдагдалгүй төсөв батлах бол сонголтын л асуудал. Үйл ажиллагааны зардал 27 их наяд, хөрөнгө оруулалтын зардал 10.3 их наяд, төсвийн алдагдал 1.9 их наяд. Үйл ажиллагааны зардлаас бид өнөөдөр 1 төгрөг танах битгий хэл бараг цаана нь санхүүжүүлэлтгүй үйл ажиллагаа нь зогсох шинэ батлагдсан өөр өөр газраас өргөн баригдаад батлагдсан хуулиудын дагуу үйл ажиллагааг нь бид санхүүжүүлэх боломжгүй маш олон ажлууд хүлээгдээд гадуур орхигдчихсон байгаа гэсэн үг. Тэгэхээр урсгал зардал дээрээс танах юу л бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дахиад нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэгэхээр алдагдалгүй баталъя гэвэл энэ бүсчилсэн хөгжлийн энэ үзэл баримтлалын дагуу тавигдаж байгаа 38 төслөөсөө, энэ мега төслүүдээсээ за энийг нь

больё, энийг нь хэрэггүй гэж байгаа бол энэ яг сонголтын л асуудал. Аягүй амархан юм. Хэдхэн төсөл бид нар хойш нь тавихад л төсөв өөрөө алдагдалгүй гараад ирнэ.

Харин энэ одоо бид нарын энэ 4 жилийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр Засгийн газраас, хамтарсан Засгийн газар өргөн барьж байгаа энэ бүтцийн хөгжлийн ирэх 30 жилийн энэ гацаануудыг гаргая гэж байгаа энэ төсөл, хөтөлбөрүүдээ бид ямар ч байсан зүтгүүлье гээд, явуулья гээд ингээд оруулж ирж байгаа л юм байгаа юм. Аягүй амархан энийг алдагдалгүй баталъя гэвэл. Энэ дээр харин бид нар манлайлал үзүүлж байна гэж бид энэ хөгжлөө хойш нь тавих уу, эсвэл бүгдээрээ санал нэгтэйгээр хамтарсан Засгийн газрын үед энэ 126 гишүүн шинэ 30 жилийн хөгжлийн гараан дээр энэ эрчим хүчнийхээ хязгаарлалтаас энэ зам тээвэр, тээвэр ложистикийнхоо хязгаарлалтуудаас энэ.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одоо болно. Ренчинбямбын Сэддорж гишүүн асуулт асууна.

Р.Сэддорж: Оройн мэнд хүргэе. Наранбаатар гишүүн маань бас бонд гаргаж энэ Өмнөговийн бүсийн дулааны станцыг барина гэдгийг ойлгож байгаа юм байна. Тэгээд 7 хоногийн өмнө бас энэ бондын тухай ойлголтыг эсэргүүцээд байсан. Тэгээд энийг барих нь зүйтэй юм байна. гэдгийг ойлгож байгаа юм байна, Засгаас бас энийг дэмжих юм байна гэж ойлголоо. Тэгээд Сангийн сайд Сангийн яамныхан маань энэ бондыг зөвшөөрч байна гэж ойлголоо. Зөв үү? Ингээд Даланзадгад бол олон удаа ярьсан. Энэ зөвхөн нэг аймгийн төвийн асуудал биш энэ говийн бүсийн цахилгаан эрчим хүчний аюулгүй байдлын асуудал. Дээрээс нь хамгийн их хүн ам нэмэгдэж байгаа энэ Даланзадгадын өвөлжилтийн аюулгүй байдлын асуудал болоод байгаа юм.

Ирэх жилийн Өмнөговь аймгийн улсад төвлөрүүлэх орлогыг 1 тэрбум 700, 1 их наяд 700 тэрбум болгоод өсгөчихсөн. Уг нь бол энэ жил төсвийн тодотголоор хамаг үлдсэн мөнгийг нь татчихаагүй бол энэ станцын эхлэл тавигдах байсан гэж тийм тооцоотой явж байсан.Тэгээд Засгийн газраас энэ бондыг дэмжих юм байна гэдэгт итгэж байна. Одоо төсвийн ирэх оны төсвийн улсад төвлөрүүлэх орлого ингээд нэмэгдэхээр төрийн албан хаагчдын бүх цалингийн нэмэгдлүүд, нутгийн дэм гээд цалингийн нэмэгдлүүд бүгд үргэлжлэх үү? Энэ дээр ямар нэгэн асуудал байхгүй биз дээ? Энэ говийн бүсийн Замын-Үүд Улаанбаатарын хос замын ажил явах уу? Мөн хоёр дахь, улсдаа чадлаараа хоёрт орох Улаанбаатар-Мандалговь Даланзадгадын чиглэлийн энэ хос замын зураг төслийн мөнгө төгрөг энд тавигдсан байгаа юу тэгээд?

Бүсчилсэн хөгжил гэдэг бол бид нар энэ эрэмбэлж аваад хамгийн их, хамгийн Монгол Улсад шаардлагатай байгаа энэ хөрөнгө оруулалтуудыг хийнэ гэж ойлгож байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн хариулт өгөөч.

Дээрээс нь Шинэ сум төсөл дээр хэдэн сумыг хамруулж байгаа бол? Говийн бүсэд хэдэн сумыг хамруулж байгаа бол? Мөн энэ Ерөнхий сайдын дэмжиж байгаа, Засгийн газрын үндсэн чиглэлд орчихсон байгаа энэ усны төсөл дээр яг хэдэн төгрөг тавиад байгаа вэ? Тэгээд энэ дээр ахиц, дэвшил тодорхой 25 оноос ажил эхэлнэ гэж итгэж байгаа зөв үү гэсэн ийм асуултууд байна.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Сэддорж гишүүний асуултад хариулья.

Говийн бүс тэр дундаа Өмнөговь аймаг дээр цахилгаан станц нэмэлт эх үүсвэрүүдийг барих асуудал бол бас тулгамдсан асуудлуудын нэг. Тэгээд ч Өмнөговь аймаг, говийн бүсүүдийн аймаг бүтээн байгуулалт манай гол түүхий эдүүдийн экспорт дээр онцгой үүрэг гүйцэтгэж байгаа ийм бүс нутаг. Тэр ч хэмжээгээр тэнд хөрөнгө оруулалтууд эргээд бас бий болох нь. Энэ бол зөв бас шударга зарчимд нийцсэн зүйл гэж харж байгаа. Ерөнхий сайдын хувьд ч бидэнд бас чиглэл өгсөн.

Тэгэхээр станцыг бол барих нь бол ойрын хугацаанд тодорхой. Харин ямар эх үүсвэрээр барих вэ? Улсын төсвөөр барих уу? Тэгэхдээ улсын төсөв мэдээж Өмнөговь аймгаас татах, төсвийн орлогын бүрдүүлэлтээс эргээд хуваарилах л ийм зарчмаар хийгдэх үү, эсвэл үнэт цаас гаргах замаар явах уу, эсвэл аймгийнх нь суурь зардал дээр тавих уу гээд хэд хэдэн хувилбарууд байгаа.

Эндээс аль болох төлбөрийн тэнцэл дээр гэмтэл багатай, сөрөг ачаалал багатай ямар хувилбар байна энэ дээрээ бид тооцоолуудаа хэдүүлээ суух хэрэгтэй. Би өмнө нь бас танд хэлж байсан энэ дээр. Уг нь бол тооцоолол эхний бэлтгэл ажлуудаа аймаг өөрөө хийгээд төсвийн жил эхлэхээс 4 сарын өмнө Засгийн газарт хүргүүлэх ёстой байсан. Энэ жилийн хувьд бас та нар, та бүхэн бэлтгэлд тулгамдсан ч байх.

Тийм учраас зөвшөөрөл гэдэг асуудал харахандаа эрт шүү Сэддорж гишүүнээ. Ер нь эцсийн зөвшөөрөл энд, Их Хурал дээр зөвшөөрөл гарна. Засгийн газар дээр бид нар бэлтгэл ажлаа хангаад энд бол өргөн баригдаад яригдаад явах юм байгаа юм.

Тийм учраас би танд хэлж байсанчлан ер нь Засгийн газар, Сангийн яам орон нутаг хэрвээ үнэхээр тэгээд шийдсэн байгаа бол шууд хамтарч суугаад бид бас чадлаар туслаад энэ бэлтгэл ажлаа хангаад урагшлаад явах нь зөв болов уу? Хугацаа алдахгүй байх үүднээс. Би одоогоор танд ийм л хариулт хэлье.

Одонтуяа сайд тэр усны төсөл дээр та хэлчих үү? Бэлтгэл ажил, ТЭЗҮ хийгдэж байгаа шүү дээ. Тийм. Энэ Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төсөл маань ямар шатандаа байгаа вэ, хэдэн төгрөг явж байгаа вэ, ямар ямар шатанд, хэдэн оноос урагшлах вэ гэж байна. Шинэ сум төслүүд дээр мөн манайхан мэдээлэл өгчхөөрэй.

Б.Пүрэвдорж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа хариулна. Батсуурь сайдыг дуудаарай.

С.Одонтуяа: Тэгэхээр Хэрлэн-Тооно төслийн хувьд “Оюу толгой” компани ТЭЗҮ хийж байгаа. Тэгэхээр ТЭЗҮ-г зарлаад сонгон шалгаруулалт бол зарласан. Энэ ТЭЗҮ-гээр бол 2025 оны бараг эцэст ТЭЗҮ-гийн ерөнхийдөө дүн гарна.

Энэ Хэрлэн-Тооно төслөөр ерөнхийдөө 235км-т ус дамжуулах далд шугам хоолой барина гэсэн ийм зүйл байдаг. Гэхдээ бид энэ яг ТЭЗҮ, эцсийн юуг харж бас шийдвэрээ гаргах хэрэгтэй байгаа. Энэ Хэрлэн-Тооно төсөл дээр нэг хүндрэлтэй асуудал гэвэл сая хилийн усны хэлэлцээр болсон. Тэгэхээр энэ Хэрлэн голын асуудал, энэ хил дам.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Өдөр хурал эхлэхэд Их Хурлын дарга энэ чуулганы хугацааг сунгаж хуралдахаар санал хураалгаж шийдсэн байгаа. Тэгэхээр дахиад 2 цаг орчим сунаж хуралдах юм шиг байна.

Одоо Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Оройн мэндийг хүргэе. Төсвийн төслийг ерөнхийд нь бол дэмжиж байна. 2, 3 логикийн алдаатай хэдэн асуултуудад, алдаанууд дээр хэдэн асуулт байна.

Эхнийх нь болохлоор олон улсын жишгээс харахад төсвийг дунд хугацаанд төсөвлөөд тэгж байж улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн бодлого төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаад явах боломжтой болдог. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулиар бол 9 төрлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг л тодорхойлж байгаа. Энэ төсвийг дунд хугацаандаа төсөвлөөд, хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлээд ийм шинэчлэлээ хийхгүй бол нийгэм, дэд бүтэц, эдийн засгийн суурь асуудлуудаа шийдэж чадахгүй болов уу. Энэ 14 мега төслүүдийг тогтвортой, амжилттай хэрэгжих боломжгүй гэж бодож байна. Манай улс тэргүүлэх чиглэл, салбар төслүүдээ тодорхойлоод түүнийгээ хэрэгжүүлэх дунд хугацааны төсөлт хийдэг болох цаг хугацаа болсон болов уу гэж бодож байна. Энэ ажлыг хийх үү?

Хоёрдугаарт нь олон улсын төсвийн нээлттэй байдлын судалгаа харлаа л даа тэгээд Монгол Улсын төсвийн хяналт 100-аас 80 оноо, ил тод байдал нь 100-аас 62 оноо, олон нийтийн оролцоо нь болохлоор 100-аас 19-хөн оноо байгаад байгаа юм. Төсвийн төслийг боловсруулахдаа олон нийтийн оролцоог хэрхэн хангасан бэ? Цаашдаа ямар шинэчлэлт хийх гэж зорьж байгаа вэ гэдгийг асуумаар байна?

Гуравдугаарт нь болохлоор төсөл, арга хэмжээ, урсгал зардлаар ямар хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулаад, ямар үр дүнд хүрэх гэж байгаагаа оновчтой тодорхойлох хэрэгтэй байгаад байгаа юм. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хариуцаж буй хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд нь зорилт байдлаар, эсвэл үзүүлэх үйлчилгээний тоо, хэмжээ байдлаар, эсвэл бүр логикийн хувьд алдаатай тодорхойлсон ийм шалгуур үзүүлэлтүүд нэлээн харагдаж байна л даа. Жишээ нь, хавсралт 1-ийн хөтөлбөр 71406, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол гэсэн зорилт байна л даа. Энэний 22.6.1.1-д Улаанбаатар хотын агаар дахь Пи Эм 2.5 тоосонцрын агууламжийг бууруулна гэсэн чанарын ганцхан шалгуур үзүүлэлт байгаад байгаа юм. Пи Эм 10 гээд бас бусад төрлийн бохирдуулагч бодис байгаа. Тэд нарыгаа хэмжихгүй юм уу?

Дээрээс нь нэмээд Дархан, Эрдэнэт, аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг хэмжээд тэрнийгээ бууруулах зорилт тавихгүй юм уу? Ер нь үр дүнд суурилсан төсөлд яг хэзээнээс хийж эхэлдэг болох вэ гэсэн төсвийн холбогдолтой ийм асуулт байна.

Үүн дээр бас бусад гишүүддээ уриалж хэлэх нэг зүйл байна. Та өөрийнхөө мэргэшсэн салбар эсвэл анхаарч байгаа салбарынхаа зорилт, шалгуур үзүүлэлтүүдээ энэ хүрэх үр дүнгийн нэгдүгээр хавсралтаас нь хараад хяналт тавиад, үр дүн нэхээд явахыг хүсэж байна. Ер нь хэмжиж чадахгүй бол амжилтад хүрч чадахгүй гэж хэлдэг болохлоор зөв шалгуур үзүүлэлтийг тавиад, зөв хэмжээд, үр дүн гаргахаар зорьж ажиллавал энэ шинэ 30 жилийн эхлэл зөв тавигдах юм болов уу гэж бодож байна.

Нийгмийн даатгалтай холбоотой дахиад нэг асуулт байна. Би 88 оны шороон луу жилд төрсөн. Ер нь бол 40 нас хаяанд ирээд зарим дүү нар эхнээсээ ахмадын баярын мэнд хүргээд, дотуур өмдөндөө ороод жоохон айдас хүйдэстэй л байна л даа. Хууль хүчний байгууллагад ажилладаг зарим найзууд тэтгэвэрт гарах жилээ ингээд л тоолоод л сууж байна. Ер нь тэтгэвэрт гарах нас ойрхон санагддаг болчхоод байгаа юм.

Дээр нь хүн амын суваргаар харахад бол манай үеийнхэн хамгийн олуулаа. Тэгээд 20-иод жилийн дараа биднээс хамаагүй цөөхөн доод үе буюу Gen-Z нарын энэ төлсөн нийгмийн даатгалын шимтгэлээр бид нар амь зуух болчихоод байна л даа. Тэгж бодохлоор бас дахиад жоохон айдас хүйдэс нэмэгдээд байгаа юм.

Ер нь төсвийн төсөлд харахад ирэх жилд нийгмийн даатгалын сан 1.4 их наядын алдагдалтай байхаар буюу 21 оноос хойш нийтдээ 5 их наядын алдагдалтай болж байна л даа. Манай нийгмийн даатгалын тогтолцоо нь өөрөө сайн сайхан ирээдүйн баталгаа биш дарамт болчихоод байна. Энэ хамтарсан засгийн үедээ нийгмийн даатгалын реформыг хийх үү гэсэн асуулт байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Лувсанжамц гишүүний асуултад би хариулаад эхэлбэ.

Үр дүнд суурилсан төсвийн санхүүжилтийн асуудлыг хөндлөө. Төсвийн төвлөрсөн санхүүжилттэй энэ тогтолцооноосоо энэ гүйцэтгэлд суурилсан, үр дүнд суурилсан энэ санхүүжилт рүү бид өмнөх парламентын үед орсон байдаг, эхлүүлсэн байдаг 2019 онд. Ингээд 20, 21 онуудад эрүүл мэндийн салбараас эхлээд бид үр дүнд суурилсан санхүүжилтийн хэлбэр рүү шилжиж эхэлсэн. Яг салбараар нь ярих юм бол, гүйцэтгэлээр нь ярих юм бол. Ингээд араас нь боловсролын салбар, ингээд бусад соёл, спорт, нийгмийн салбарууд гээд төсвийн гол, том санхүүжилт хийгддэг ерөнхийлөн захирагчид маань үндсэндээ бүгд орсон гэсэн үг. Төсвийн урсгал зардал дээрээс харах юм бол ер нь 90 хувь нь үр дүнд суурилсан энэ санхүүжилтийгээ төсөл рүү бүрэн шилжсэн.

Энэ бол бид нэлээн том Засгийн газрын том төсөв дагасан реформын том шилжилт болж байгаа. Энэ дээр онож байгаа зүйл ч байна, алдаж байгаа зүйлүүд ч байна. Цаашдаа дахиж засвар хийгээд, тохиргоонууд хийгдээд явах асуудлууд байгаа.

Ялангуяа манай урсгал зардлын хамгийн томоохон бараг 80 гаран хувийг эзэлж байгаа 3 салбар байна. Боловсролын салбар, эрүүл мэндийн салбар, нийгэм халамжийн салбар гээд. Эдгээр салбарууд дээрээ бид цаашид энэ бодлогоосоо хэрхэвч алхам ч ухрахгүй цаашаагаа улам сайжруулаад, нэмэлт тохиргоонуудаа хийгээд, алдсан зүйлүүдээ сайжруулаад, засаж янзлаад ингээд үргэлжлээд явна гэдгийгээ дуулгая. Ингэсний үр дүнд юунд хүрэв гэдэг хэмжих нэгжтэй байх ёстой гэдэг маш зөв. Та энэ дээр яг хэллээ.

Тэгэхээр үр дүнд суурилсан санхүүжилт маань дэд бүтцийн яамнуудаас арай өөр энэ суурь нийгмийн зөөлөн дэд бүтцүүдийн энэ салбарууд дээр хийгдэж байгаа ийм зүйл юм.

Тэгэхээр дэд бүтцийн салбарын 100 төгрөгийн хөрөнгө оруулалтын өгөөжийг би түрүүн хэлсэн.1.5-аас бараг 4 дахин илүү ийм богино хугацаанд үр дүнгээ өгдөг нийгмийн энэ суурь боловсрол, эрүүл мэндийн салбар, нийгмийн халамжийн салбарууд бол урт хугацаанд тогтвортой дараагийн баялаг бүтээгчийг бий болгодог, баялаг бүтээгчийг бий болгодог учраас энэ салбар маань жишээ нь боловсролын салбарын дотоодын бүтээгдэхүүн жилийн дараа өгөх өгөөж нь бол 0.5 хувь байдаг, 0.5 хувь жилийн дараа. 10 жилийн дараа, 20 жилийн дараа хүрэх үр дүн нь энэнээс илүү том үр дүнтэй байх жишээтэй. Ингэж яг салбар бүрээр нь бид ингэж.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Их чухал асуудал хөндлөө. Тэгэхээр энэ 2025 оны төсөвт агаар орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ гэж байгаа. Энэ дээр хоёуланг нь хэмжинэ, хоёулангынх нь хэмжилтийг тэдээс тэдэн хувь бууруулна гээд орчихсон байгаа. Яг энэ том ном дээр та зөвхөн нэгийг нь ингээд харчхаж. Энэ дээр жишээлэхэд Улаанбаатар хотод Пи Эм 2.5-ыг нь бол 41 байхаас 31 болгоно, Пи Эм 10-ыг нь 82-оос 66 болгоно гээд энэ төсөл, арга хэмжээ нийтэд 31 тэрбум төгрөг зарцуулна гэсэн юм.

Хөдөө орон нутагт бол технологийн нэг хүндрэл маш их байна. Жишээлэхэд маш олон аймагт, 8 аймагт гэхэд л дандаа Оросын бүүр 80-аад оны төхөөрөмж. Тэгэхээр бид нар энэ технологийн шинэчлэлийг яаралтай хийх хэрэгтэй байгаа. Нийт 41 агаарын чанарыг хянах станц байдгаас 16 нь Улаанбаатарт байдаг. Ер нь бид нар зөвхөн энэ агаарын бохирдол, бас энэ машины утаа хаанаас маш их үүсээд байгаа. Тэгээд сая би бас.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж хариулья.

С.Одонтуяа: Тэгэхээр би сая албан даалгавар гаргасан. Евро 5 шатахуун руу яаралтай шилжье гэж. Гэхдээ мэдээж иргэд бол бас хүндрэл байгаа учраас эхлээд төрийн байгууллагын манайд 2 мянган машин, нийтийн тээврийн 1100 машин байгаа. Энэ 3 мянган машиныг оруулахад бид нар энэ тоосонцрын хэмжээг бараг 95 хувиар бууруулж чадах гээд байгаа гэх мэтчилэн ийм бас олон талын л ийм арга хэмжээнүүдийг авч байгаа. Жишээлэхэд Даланзадгад, Дархан, Ховд, Эрдэнэт, Баруун-Урт гээд аймгууд тоосонцор, энэ хүхэрлэг хийн нь ерөөсөө стандартаас хэтэрчихсэн ийм үзүүлэлтүүд байдаг.

Б.Пүрэвдорж: Одонтуяа сайдаа тэр хуурамч шатахуун чинь бохирдлыг хамгийн их авчирч байгаа шүү. Тэр дээрээ та санаачилгатай ажиллаарай гэж хэлмээр байна.

Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: Энэ хариулт дээр 1 минут уу?

Та хүссэнээрээ авна.

Тийм, энэ ч бас тийм том асуудал асууж байгаа учраас яг 1 минутад тогтолцооны шинэчлэлийн асуудлыг тайлбарлана гэдэг их хэцүү зүйл л дээ. Манай Лууяа гишүүн маань залуу хүний төлөөлөл болж орж ирсэн учраас энэ ирээдүйгийнхээ төлөө, энэ үеийнхнийхээ төлөө Монгол Улс тэтгэврийн сантай байх уу, байхгүй юу гэдэг асуудлыг хөндөж тавьж байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ манай иргэдийн дунд явж байгаа нэг ойлголт гэдэг юм уу, нийгмийн даатгалын сангийн мөнгө 160 тэрбум төгрөгийг ингээд банканд алдаад тэгээд нийгмийн даатгалын сан дампуурчхаад байгаа юм шиг ийм буруу ойлголт явдаг юм байна.

Бид нарын өнгөрсөн 10 жилийн дотор, өнгөрсөн 15 жилийн дотор гаргасан улс төрчдийн санаачилсан хууль, парламентын баталсан хуулиас шалтгаалж энэ үр дүнгээс шалтгаалж нийгмийн даатгалын сан дээр 4.7 их наядын алдагдал үүссэн байна. 4.7 их наяд. Энэ бол банканд алдах 160 тэрбумын дэргэд бол тэмээ шиг том тооны тухай бид нар ярьж байна шүү дээ.

Тэгээд 95 оноос хойш бид нар ингээд иргэдийн данс дээр, данс хий ингээд бичилтүүд хийгээд ингээд явчихсан. Энэний дүн чинь өнөөдөр бараг үндсэндээ 29 их наядын хэмжээнд хүрчхэж байгаа юм гэх мэтчилнээр ингээд бид нар энэ нийгмийн даатгалынхаа тогтолцоон дээр энэ тогтолцооны шинэчлэлийн асуудлыг энэ хамтарсан Засгийн газар яг энэ 126-тай парламенттай байгаа энэ үедээ л хийж авахгүй бол одоо цаашаа бид нар энэ маягаар цаашаа явахаа больсон. Цаашаа 2, 3 жилийн дараа бол яг ийм маягаар үнэхээр явах юм бол ирээдүйд тэтгэврийн сангүй болох ийм бодитой эрсдэл бид нарт өнөөдөр нүүрлэж байгаа ийм байгаад байгаа юм.

Тэгэхээр мэдээж тогтолцооны шинэчлэл хийнэ гэдэг бол нийгмийг доргиосон маш том шийдэл. Саяхан хүртэл Францад бол Парисаа шатаах дөхөж байж л засаг төр нь, парламент нь тэтгэврийнхээ тогтолцоог ингэж авч гарч чадаж байна.

Цаашдаа бид нар үндсэндээ бол энэ тэтгэврийн тогтолцоог, нийгмийн даатгалын тогтолцоог, тэтгэврийн тогтолцооны маш том шинэчлэл хийх ёстой. Ер нь манай энэ Засгийн газарт хамтарсан улс төрийн намуудын хүлээх үүрэг, бид нарын ард түмнээсээ сонгогдсон 126 гишүүний хамгийн том хийх ажил бол, хамгийн том шинэчлэл бол энэ тэтгэврийн тогтолцооны шинэчлэл реформ байх болов уу гэж бас би бодож байгаа, хүлээж байгаа.

Тэгээд энэ чиглэлээр бас ойрын үед бас Байнгын хороон дээрээ мэргэжлийнхээ Байнгын хороон дээр бас Улсын Их Хурлын гишүүдэд өнгөрсөн хугацаанд үүссэн энэ нөхцөл байдал дээр хийсэн дүн шинжилгээнүүдийг бас танилцуулахаар бэлдэж байна. Ер нь Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн банк гээд хангалттай их зөвлөхүүд авсан юм байна лээ. Хангалттай их бодлогын зөвлөмжүүд хийж өгсөн юм байна лээ.

Харамсалтай нь яг энэ тэтгэврийн энэ тогтолцоог яг тогтолцоогоор нь шинэчлэх тэр улс төрийн эр зориг, нөхцөл байдлууд бид нарын өмнө өмнөх он жилүүдэд ийм нөхцөл байдлууд байгаагүй учраас магадгүй ийм алтан боломжуудыг ашиглаж, энэ тэтгэврийн реформ шинэчлэлээ хийх л хамгийн гол зорилт байх болов уу л гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд. Тэгэхээр 6 сард, 6 сарын 24-нөөс, 7 сарын 1-нээс хэрэгжих ёстой Малчны тухай хууль энэ хуулийн дагуу бас тодорхой хэмжээний нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх боломжийг малчдад өгч байгаа. Тэгээд энэ хуулийн дагуу та журам гаргах ёстой. Тэр журмаа гаргах тэр ажлыг хэрэгжүүлж энэ 25 оны 12 сарын 31 хүртэл энэ хууль хэрэгжих ёстой. Таны журам байхгүйгээс болоод 2, 3 сар алдчихлаа.

Тийм учраас энэ хууль нэгэнт гарсан. Тийм учраас хуулийн дагуу журмыг хэрэгжүүлэх тэр ажлыг та хийх ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тодорхой, дэлгэрэнгүй хариулсанд баярлалаа. Сангийн сайдаас төсвийн төсөлтэй холбоотой дахиад 2 асуулт асуусан юм. Эхнийх нь болохлоор дунд хугацааны төсөвлөлтийг ер нь хэзээнээс хийдэг болох вэ бид нар?

Хоёр дахь нь төсвийн төслийг бэлтгэхдээ олон нийтийн оролцоог хэрхэн хангасан бэ, цаашдаа яаж энэ тал дээр сайжруулах арга хэмжээ авах вэ гэсэн 2 асуулт байна.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Сүүлийн асуултаас эхэлбэ. Төсвийн төлөвлөлт бол тухайн жилийн төсөв батлагдсаны маргаашаас үндсэндээ тухайн жилийн 11 сарын 16-ны өдрөөс эхлээд л бид ингээд явдаг ийм хуультай байгаа юм. Ингээд өөрөөр хэлбэл, 9 сарын 1 хүртэл буюу яг төсөв төлөвлөөд төсвийн ерөнхийлөн захирагч нараас санал, судалгаануудаа аваад нэгтгэх явцад 8 сарын, 8 дугаар сарын цаг хугацааны хувьд яг тэр үеэр олон нийтэд танилцуулах, санал бодлыг нь сонсох энэ хэлэлцүүлгийг хийж байх ийм бид нар шинэ зохицуулалттай болсон.

Ирэх жилээс ер нь энэ нэлээн ингээд жигдрээд явах болов уу гэж ингэж бодож байна. 9 сарын 1-нд өргөн барьснаас хойш мөн хэлэлцүүлгүүдийг хийх бас ийм үүрэг нь Улсын Их Хурал дээр ирсэн байгаа. Энэ дээр мэдээж Засгийн газар хамтраад энэ дээр явдаг бас ийм шинэ цаглавар руу орсон байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмж өгбэ.

Б.Жавхлан: Энэ жилийн хувьд бол эхний жил байлаа. Дутуу хийсэн зүйлүүд ч байгаа болов уу гэж ингэж харагдаж байна одоо. Тийм учраас ирэх жилүүд дээр энийг онцгой анхаараад явна. Тэгэхээр мэдээж олон нийтийн идэвх энэ дээр илүү их сэргэх болов уу, оролцоо нь чилүү байх болов уу гэж найдаж байна.

Дунд хугацааны төлөвлөлт дээр бид одоо яг өргөн барих яг төсвийн хувьд бол ирэх жилийн төсөв, дараагийн 2 жилийн төсвийн хүрээний төсөөлөл гэж ийм 3 жилийн заагтай цаглавартаа ордог ийм хуультайгаа байгаа. Төлөвлөгөөний хувьд бол урт хугацаанд, дунд хугацаанд 4 жилээрээ явдаг ийм л хуультай байгаа.

Тийм учраас энэ бид төлөвлөгөө төсөв хоёрыг уялдаатай л төлөвлөгөөгөө батлаад, төсөв нь өөрөө төлөвлөгөөгөө биелүүлэхэд чиглэсэн байх ийм зарчмаар төлөвлөөд төсөвлөөд явдаг ийм шинэ зарчим руугаа шилжсэн байгаа одоогоор бол.

Б.Пүрэвдорж: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Золжаргал: Хүмүүсийн дундаа цуглуулсан мөнгийг юунд зарцуулах вэ гэдгийг хүмүүсийн төлөөлөл болсон хүмүүс ярилцаж байгаа. Нэг сонирхолтой юм нь төсөв хянаад ингээд явах үүрэгтэй боловч нууц энэ бол аймаар нарийн юм байгаа. Ойлгоход хэцүү иймэрхүү хандлага нэлээн түгээмэл байна. Тэгээд энэ төсөв дээрх тоонууд бас зарим нь их бүрхэг байгаа. Тийм болохоор төрийн байгууллагуудаар явах зарим чиглэлээр ингээд сонсгол хиймэл дагуулын чиглэлээр, мэдээллийн аюулгүй байдал гэх мэтчилэн иймэрхүү арга хэмжээ аваад л бид нар явж байгаа юм.

Ер нь цаашдаа нууц гэдэг ангилал дээр юуг хамруулах вэ, хамруулахгүй вэ гэдэг дээр энэ төсөв энэ тэр яригдаад дууссаны дараа ажиллах шаардлагатай юм байна гэж дүгнэж байна.

Асуулт тоног төхөөрөмжүүд гэсэн ангилал байгаа. Бүх салбар дээр, бүх яаман дээр. Зөвхөн арай том дүнтэйг нь ялгаж аваад нийлбэр дүн нь 370-аад тэрбум төгрөг болж байгаа. Энэ Сангийн яаманд хүсэлт тавиад, задаргаа хүссэн хариу авсан. Одоо энэ тоног төхөөрөмж гэдгийн цаана мэдээллийн технологийн системүүд байгаа. Эдгээр ажлууд Нийтийн мэдээллийн тухай хуулийн 29 дүгээр заалт буюу үр ашигтай системүүд үү,

давхардал байна уу, харилцан уялдаатай байна уу гэдгийг салбарынхаа яамнаас зөвлөмж, дүгнэлт авах ёстой. Энэ дүгнэлт эдгээр ажлууд дээр хийгдсэн үү? 5-аас эхлээд 20, 30, 40 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжүүд гэсэн ийм зүйлс байгаа. Үүнийг би Баатархүү сайдаас асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт нь Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр ярьж байх үед асууж байсан одоо энэ сургуулиудын чинь талаас илүү нь интернэтийн хурд байхгүй байна. Ямар нэгэн боловсрол цахим шилжилт ярих боломж байхгүй 400-гаад сургууль.

Тэгэхээр эд нарыгаа бид нар энэ төсөв дээрээ тусгасан байгаа юм уу? Интернэтийн хурдыг нь сайжруулах гэж байгаа юм уу? Үүнтэй холбоотой нэмэлт асуулт сонгуулийн үеэр бүх санал асуулга хэсгүүдэд, алслагдсан сумдууд Старлингк интернэтийн төхөөрөмжид аваачиж суурилуулсан мэдээлэл авсан. Миний төсөөллөөр нэлээн хэдэн 100 ширхэг байгаа. Энэ төхөөрөмжүүд дараа нь хаачих вэ, эдгээрийг эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, сургууль дээр ашиглах уу гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаар зүйл нь Улаанбаатар хотын энэ насжилт нь хуучирчихсан хуучны орон сууцыг дулаалах асуудал байгаа. Ямар нэгэн байдлаар тодорхой хэмжээний түлхэц өгөхгүй бол цэвэр гаднын төслөөр явж өгөхгүй байна. Төсөв дээр жоохон тусгаад өгье гэдэг асуудал яригдаад дийлээгүй байгаа. Харин өчигдөр тэр зарчмын зөрүүтэй саналаар Орон нутгийн хөгжлийн сангаас гэсэн тийм юм орж ирсэн. Энэ чинь зөвхөн хувийн айлын дулаалах гэж байгаа юм биш. Энийг дулаалбал дулааны алдагдал 30 хувь буурахад цаана нь олон тэрбум их мөнгөөр барих гэж байгаа дулааны шугам сүлжээний ажлаас хэд дахин бага мөнгөөр илүүдэл дулаан гаргаж аваад тэрүүгээрээ нэмэлт шинээр барих гээд байгаа орон сууцууд, гэр хороололд нийлүүлэх боломж гарч ирэх юм. Тэгэхээр энэ дээр ийм жижигхэн хэмжээний түлхэц өгөх хөшүүргийн төсвийг нэмж болохгүй юм уу гэж Барилга, хот байгуулалтын яамны салбарынхнаасаа асуумаар байна.

Дахиад нэг асуулт байна. Энэ Шинэ Хархорум төсөл 20 тэрбум, Хөшигийн хөндий инженерийн байгууллагын дэд төсөл 34 гээд эд нар миний ойлгож байгаагаар төлөвлөгөөний шатны юмнууд. Тэгэхээр хүнгүй газар байх гээд байгаа тэр их мөнгөөрөө гэр хороолол дээр хэтэрхий бага тавигдчихаад байгаа шүү дээ, эсвэл энэ хүн ам ихтэй газрынхаа дэд бүтэц, инженерийн сүлжээгээ сайжруулахдаа зарцуулах юм биш үү? 2, 3 тэрбум дээр их хэцүү хэрүүл болдог. Тэгэхдээ энэ цаана.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Наранбаяраас сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр бас энэ сургуулиудад хэрэглэгдэж байгаа интернэтийн хурдын асуудлыг хөндсөнд баярлалаа. Өнөөдөр ерөөсөө ер нь 391 багийн сургуулиуд дундаж хурд нь ер нь 4-10 мегабайтын секундйн хурдтай. Ер нь улс орон даяар 15.2-той ингээд байж байгаа.

Цаашдаа ер нь ингээд зайн дарангуйллаас гарахын тулд цахим ийм мэдлээ гэх мэт ийм сургуулиудын үйл ажиллагаа, одоо хичээл дээр хэрэглэгдэж байгаа Англи хэл болоод математикийн ийм хэрэглэгдэхүүнүүдийг хэрэглэхэд интернэт хурдыг одоо байгаагаас нь дор хаяж 1 2 дахин нэмэх ийм хэрэгцээ байгаад байгаа.

Тэгэхээрээ бид бол энэ төсөвт оруулж ирээд Сангийн яаманд тавьсан саналаар энэ ер нь 10-аас дээш, 10-аад жил хэрэглэхсэн энэ тоног төхөөрөмжийг нь шинэчлэхгүйгээр энэ хурдаа нэмэх ямар ч боломжгүй юм байна лээ. Энэ 15 тэрбум төгрөгөөр бас ингэж

шинэчлэх шаардлагатай гэж ийм хүсэлтээ тавьсан. Харамсалтай нь бас энэ удаад орж амжаагүй.

Цаашдаа бид нар ер нь энэ өнөөдөр 24 оны байдлаар 784 сургуулийг бас интернэтэд холбоод 7 Гегабайтын интернэтийн гадаад урсгалд 3.7 тэрбум төгрөгийн ийм төлбөрийг төлж байгаа ийм байдалтай байгаа. Яг одоо зарим нэг яачаад Старлинкийн асуудал ярьж байна. 57 ийм байршил дээр Старлинкийг оруулаад ирвэл бас их шийдэж болох боломжтой байна гэсэн ийм ийм судалгаа байдаг. Гэхдээ нэг зүйлийг бид тооцох ёстой. Яг энэ хилийн зурвас дагууд 20 орчим километр гэдэг байх, магадгүй 50км, тэр хилийн зурвас дагуу газарт Старлинкийг хэрэглэх ямар ч боломжгүй. Тэр хаалттай байдаг, хаачихсан байдаг.

Тэгэхээр зэрэг энэ шийдлийг бас арай өөрөөр шийдэхгүй бол тэнд болохгүй байгаа. Бусад газруудад хэрвээ боломжтой бол олон хүнд хувааж хэрэглэх юм бол бас харьцангуй гайгүй ийм боломж бас харагдаад байна гэж харж байгаа. Тэгээд эрхэм гишүүний хэлсэн үгэн дотор байсан тэр сая сонгуулийн үед хэрэглэгдсэн Старлинкүүдийг эмнэлэг, сургуулийн хэрэгцээнд ашиглах тийм боломж, бололцоо байдаг бол бид ч гэсэн Сонгуулийн ерөнхий хороонд хандаж бас ярилцаж үзье. Үнэхээрийн хэрэглээд энийгээ хэрэглэх замаар интернэтийнхээ хурдыг бид нэмж чадах юм бол бас асуудлуудыг шийдэх ийм шийдэл гарц байна гэж харж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Барилга хот, орон сууцжуулалтын яамны сайд Батсуурь хариулна. Дараа нь.

Ж.Батсуурь: Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Шинэ Хөшигийн хөндийг төлөвлөлтийн шатдаа гэж байх шиг байна. Яг үнэндээ төлөвлөлтийн биш, энэ бүтээн байгуулалтын шатдаа шууд орж байгаа Шинэ Зуунмод хот. Асуудал юу вэ гэхлээр Улаанбаатар хотод дөрвөн уулын дунд тав, зургаан мянган хүн л амьдрахаар ийм хот байсан. Одоо 3, 4, 5 дахин ачаалал нь нэмэгдчихсэн. Зүйрлүүлж хэлэх юм бол төмпөнд хивс угааж болохгүйтэй л адилхан болчихсон.

Тийм учраас шинэ хот барихаас өөр арга байхгүй. Ер нь таны хэлдгээр тэрийг хойшлуулаад ойр зуурынхаа ажлыг хийж болохгүй юм уу гэсэн хойшлуулах ямар ч боломж байхгүй. Бид нар хотоо тэлэхээс, шинэ хот бариад тэр рүүгээ энэ туннелээ, энэ ганд татлагат гүүрээ, мөн Засгийн газраа энэ Улаанбаатар хотоосоо гарч, Улаанбаатар хотоо бизнес хот болгох ийм том хэмжээний алсыг харсан ийм өөрчлөлт реформ хийхгүй юм бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмээд хариулчих уу?

Ж.Батсуурь: Зөвхөн Улаанбаатар хоттойгоо ноцолдоод бид нар амжилтад хүрэхгүй гэдгийг өнгөрсөн 20, 30-аад жилийн үйл явц харуулж байна. Тийм учраас бид бүхэн таны хэлдгээр энэ Хөшигийн хөндий буюу Шинэ Зуунмод хотын захирагчийг томилсон, захиргааны албыг бий болгочихсон, мөн тэр Шинэ Зуунмод хотдоо өнөөдрийн Улаанбаатар, Эрдэнэт, Дарханд гарсан алдааг гарахгүй байх ёстой. Яагаад вэ гэхлээр өнөөдрийн Улаанбаатар Дархан хуучин хувийн өмчгүй байх үеийн социализмын үеийн хот. Тийм учраас ийм зам нь нарийхан, зогсоол байхгүй ийм. Тийм учраас шинэ үеийн олон улсын дэлхийн стандартад нийцсэн ийм хотыг бий болж байж явна.

Дээр нь бид нар миний анхны байр, миний түрээсийн орон сууц, миний амины орон сууц, миний сонголт орон нутаг, миний сонголт нийтийн алба гэсэн байр сууринаас бүх дэмжлэгүүдийг үзүүлж явна. гэж. Миний минут дуусаж байна.

Б.Пүрэвдорж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Баатархүү асуултад хариулна.

Ц.Баатархүү: Золжаргал гишүүний асуултад хариулья.

Маш зөв зүйтэй юмыг хөндөж байна. Цахим шилжилт нэртэйгээр төрийн байгууллага, төрийн захиргааны байгууллага болгон цахим системүүдийг өнгөрсөн хугацаанд хөгжүүлсээр ирсэн. Хамгийн сайжруулах, анхаарах ёстой зүйл юу байсан бэ гэхээр энэ цахим системүүд бие биеийгээ дэмждэг, интеграцид ордог, холбогддог энэ байдал хангалттай байж чадаагүй. Ийм, өнгөрсөн жилүүдэд төр захиргааны байгууллагууд 900 тэрбум төгрөг орчмоор цахим систем хөгжүүлэх захиалгыг өгсөн юм байна лээ. Тийм худалдан авалт хийсэн. Одоо бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам энэ хөгжүүлсэн цахим системүүдийг нэгтгэх энэ ажлыг Засгийн газрын 100 хоногийн хүрээнд хийгдсэн. Монгол Улсын Засгийн газар 16 яам, 43 агентлаг, 21 аймгийг нэгтгээд нэг цонх буюу нэг энэ веб сайтаар иргэддээ мэдээллээ өг.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Баатархүү сайд нэмж хариулья.

Ц.Баатархүү: Ингээд Монгол Улсын Засгийн газрын 100 хоногт төрийн энэ байгууллагууд өөрсдөөсөө манлайлаад, төр захиргааны байгууллагууд, 43 агентлаг, яамнууд, 21 аймаг нийлээд 80 гаран цахим системийг бид нар нэгтгэж байна. Цаашдаа Монголын төр татвар төлөгчдийн мөнгөөр ямар нэгэн код худалдаж авах энэ ажлыг хийхгүй. Монголын мэдээлэл технологийн үйлдвэрлэгч, үйлдвэрлэгчдийн бүтээсэн, бичсэн тэр кодыг яг хуулийн дагуу түрээслэх энэ ажлыг хийнэ гэдгийг албан ёсоор хэлье.

Хоёрдугаарт нь одоо байгаа хөгжүүлсэн системүүдийг нэгтгэх, уялдуулах ажил дээр гол анхаарлаа хандуулж байна. Тухайлах юм бол, шүүх, цагдаа, прокурор бүгд тусдаа системтэй, хоорондоо уялддаггүй. Энэ нь иргэдэд эргээд маш их чирэгдэл учруулж байна. Тийм учраас энийг нийлүүлэх, нэгтгэх ажлыг хийнэ.

Гуравдугаарт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д төрийн байгууллагууд цахим системийг хөгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагаас дүгнэлт авна.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Сонгобайн Замира гишүүн асуулт асууна.

Уучлаарай Золжаргал гишүүн тодруул.

Ж.Золжаргал: Сая тодруулга асуучихъя. Баатархүү сайд яг гол асуултаа хариулж байсан цаг нь дуусаад хаагдчихлаа. 29 дүгээр зүйл, заалт эдгээр төсөл дээр хэрэгжсэн болов уу гэж.

Хоёрдугаарт нь Барилга8 хот байгуулалтын чиглэлээр энэ фасад дулаалга дээр та бас хариулж амжсангүй. Энэ хоёрыг асуучихъя. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баатархүү сайд хариулья.

Ц.Баатархүү: Төрийн байгууллагууд цахим системийг улсын төсвөөр ч юм уу, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар хийхдээ яг мэргэжлийн энэ яамнаасаа зөвлөмж авах ийм хуулийн заалттай. Энэ хуулийн заалтын хэрэгжилтийг бид нар илүү сайжруулах шаардлага үүсээд байгаа.

Хоёрдугаарт нь кибер аюулгүй байдал гэдэг шинэ маш том ойлголт дэлхий даяар гарсан. Цахим системүүдийг хөгжүүлдэг, нөгөө талдаа энэ кибер аюулгүй байдлын хамгаалалтыг нь сайжруулах ийм шаардлага үүсэж байгаа.

Тийм учраас кибер аюулгүй байдлын талаас нь бол мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг манай яам одоо ингээд хийж хариуцаж ажиллаж байгаа.

Нэг зүйлийг Улсын Их Хурлын гишүүддээ ойлгуулахад улсын төсөв дээр мэдээллийн технологийн зардал гээд нэртэй ингээд зардал дотор бүх юмаа тавьчихдаг. Цаашдаа зардлын зүйл анги дээр кибер аюулгүй байдлын зардал гэж хүртэл гэж оруулах л шаардлагатай юм байна гэдгийг нэмээд бас хэлчихье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Сонгобайн Замира гишүүн асуулт асууна.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн оройн мэнд хүргэе. энэ төсвийн төслийг дэмжиж байна. Маш том яг төслүүд хэрэгжих гэж байна. Тэгэхдээ хоёр, гурван асуулт асуумаар байна.

Нэгдүгээрт, энэ эдийн засаг, Монгол Улсын эдийн засаг хөгжихийн төлөө дотоодын ЖДҮ-үүд, дотоодын дунд давхаргын бизнесийн үйл ажиллагаа сэргэх ёстой гэж би боддог юм. Тэгэхээр яг энэ чиглэл дээр ер нь энэ төсөв дээр тусгасан юм байна уу? Ялангуяа энэ үйл ажиллагааг явуулахад хамгийн гол нь банкны хүү нөлөөлдөг. Тэгэхээр зэрэг энэ дээр ямар санхүүжилтээр энэ дунд давхаргыг, ЖДҮ-г дэмжиж хөгжүүлэх гээд байна. Энийг асуумаар байна.

Хоёрдугаарт болохоор зэрэг нөгөө цахилгаан, дулааны үнэ нэмэгдэхээс өөр аргагүй байдалд хүрсэн байна л даа монгол оронд. Тэгэхээр зэрэг энэ үнэ нь нэмэгдэнэ гэхэд дагаж цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэх ёстой юм болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол ард түмний байдал хэцүүднэ шүү дээ.

Гуравдугаарт, энэ маш их цэцэрлэг, сургууль баригдана гээд төсөвт тусгасан байна. Энэ маш сайшаалтай хэрэг. Тэгэхдээ энэ хөгжлийн бэрхшээлтэй, аутизмтай хүүхдүүд гээд нийгмээс тусгаарлагдсан хэсэг, нэлээд хүүхдүүдийн юу бий болсон байна. Энэ хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг, сургууль баригдах уу? Энэ цэцэрлэг сургууль дунд энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан юу байна уу гэж арга хэмжээ авах боломж байгаа юу гэж. Энийг Боловсролын сайдаас асуух гэсэн юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд эхний асуултуудад хариулъя.

Б.Жавхлан: Замира гишүүний асуултад хариулъя.

ЖДҮ-лэлийн салбар бол бид заавал төрийн бодлогын бас бодлогын төвд байх ёстой, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд багтаад явдаг ийм салбар юм байгаа юм. Түүрүүн гишүүн хэлж байсан ЖДҮ-лэл төсвийн орлогын 50 хувийг бүрдүүлдэг гээд яах вэ том татвар төлөгч нарыгаа бас яг үгүйсгэсэн ийм статистик түүрүүн ингээд хэлчих шиг боллоо. Ер нь бол 100 аж ахуйн нэгж маань төсвийн орлогын 90 хувийг бүрдүүлдэг. Бусад аж ахуйн нэгж, ер нь 50 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй

байдаг, 10 мянган аж ахуйн нэгж тайлангаа бүртгүүлж татварт хамрагддаг, төлдөг ийм, бүрдүүлдэг ийм юм байгаа юмб

Гэтэл яг ажлын байр нийлүүлж байгаа, ажлын байр бий болгож байгаагаа эсрэгээрээ нөгөө төсвийн орлогын 10-хан хувийг бүрдүүлж байгаа олон тооны аж ахуйн нэгжүүд маань хамгийн их ажлын байрыг бүрдүүлж байдаг гэхээрээ өндөр ач холбогдолтой байдаг ЖДҮ-ийн салбар өөрөө.Тийм учраас төрөөс заавал одоо бодлогоор дэмжиж авч явж байх ёстой ийм салбар юм.

Тэгээд мэдээж энэ дотор дэмжлэг болох зүйлүүдийн нэг суваг нь бол таны хэлж байгаа тэр банкны хүүгийн зардал ингээд Цагаан алт, энэ хоршоо, Хүнсний хувьсгал гээд эдгээр бүх үндэсний хөтөлбөрүүдийн хэмжээнд хүүгийн татаасаар хүүгийн зардлыг нь хямдруулж өгч байгаа хөтөлбөрүүд дотор ЖДҮ-лэлүүд бас хамрагдаж байгаа. Энэ статистик тоонуудыг Хөдөө аж ахуйн яамнаас бас гаргах болов уу гэж бодож байна. Тэгэхээр энэ бодлогууд цаашаагаа ингээд үргэлжлээд явна.

Дээрээс нь энэ ЖДҮ-лэлийг дэмжих хамгийн том төрийн оролцоо энэ зохион байгуулалтын асуудал байгаад байна. Өөрөөр хэлбэл, Худалдаа аж үйлдвэрийн танхим ч юм уу, бусад энэ төрийн бус байгууллагуудтай хамтраад ЖДҮ-үүдийг яг хэрэглэгчидтэй нь холбож өгөх тэр зуучлалын ажлыг төр оролцож энэ дээр нэлээн санаачилга гаргаж, хувийн хэвшлийг дэмжиж ийм ажлуудыг зохион байгуулах нь илүү их үр дүнтэй ийм байдаг. Энэ дээрээ ч нэлээн анхаарна гэж одоо хариуцсан сайд нар бас энэ талаар хэлэх болов уу гэж бодож байна.

Банкны тэгээд ерөнхий хүүгийн түвшнийг бас та нэмж асууж байна. Тэгэхээр өчигдөрхөн Монголбанкны үндсэн чиглэлийг баталлаа. Тэн дээр зорилгод онилж байгаа түвшнээ 6-аас 5 болгож голчийг нь буулгасан байна лээ. Тэгэхээр энийг дагаад ерөнхий арилжааны банк зээл гаргадаг, зээлийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн санхүүгийн байгууллагуудын өртөг багасаад зээлийн хүү буурах ийм мөчлөг рүүгээ орно гэсэн ийм хүлээлт бий болж байна.

Сургууль, цэцэрлэгийн хувьд Наранбаяр сайд бас нэмээд хариулна биз. Зүгээр надад байгаа мэдээллийн хүрээнд нэг зүйл.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одоо болно. Энх-Амгалан сайд хариульяб

Л.Энх-Амгалан: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудал их эмзэг асуудал Замира гишүүн ээ бас би таныг энэ асуудлыг хөндөж байгаад их туйлын их талархаж байна. Тэгээд Монгол Улсад өнөөдөр12700 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгаад байгаа юм. Наранбаяр сайд бид хоёрын л хамтын энэ уялдаа холбоо сайжирч байж энэ хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх л ийм шаардлага үүсэж байгаа юм.

Тэгэхээр эндээс 25 оны төсвийг бид нар онцолж энэ хүнд төлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүүгээ чиглүүлсэн ийм хөрөнгө оруулалтуудыг, энэ орчныг бий болгоё гэж зорьж байгаа. Энэ бол манай 25 оны төсвийн онцлог. Тэгэхээр хүнд хэлбэрийн хүүхдүүдийн авч байгаа асаргаа, сувилгааны зардлыг бид нар чинь 6 хувь дээр нэмээд дахиад дээрээс нь 30 хувь нэмж байгаа. Хүнд хэлбэрийн хүүхдүүд дээр. Дахиад дээрээс нь бид нар бас энэ живхний мөнгийг нь 600 мянган төгрөгийн живхний мөнгийг нь төрөөс олгодог болсон гэх мэтчилнээр яг энэ хүнд хэлбэрийн хүүхдүүдтэй байгаа эцэг эхчүүд, гэр бүл рүү чиглэсэн нэлээн ийм бодлого бас явах юм байгаа юм. Тэгээд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Аан за 1 5 секундээ нөхөж авъя гэж. Энэ ялт ч, Наранбаяр сайд хариулмаар байх шиг байна шүү дээ.

Ямар ч байсан энэ иргэд, аж ахуйн нэгж бизнесийнхний хөлс хүч, хөдөлмөрөө шавхан байж төлдөг энэ татварын мөнгөөр бүрддэг төсвийн зарцуулалтыг маш оновчтой, үр өгөөжтэй төлөвлөх, зарцуулах энэ шийдвэрийг гаргах ёстой энэ Их Хурлын гишүүд бай байгаа учраас энэ асуудалд маш их ач холбогдол өгч хандаж байгаа юм.

Тэгэхээр өдөржингөө энэ төсвийн төсөлтэй холбоотой асуултуудыг гишүүд маань асуулаа. Тэгээд яг энэ төсвийн баланс шийт/*balance sheet*/ гэж байгаа шүү дээ. Нэг талдаа төсвийн орлогыг бүрдүүлж байгаа татварын орлого. Татварын орлого бол төсвийн орлогын Пүрэвдорж даргаа зэрэг яриад байхаар нээрээ самуурдаг юм байна шүү. Тэгээд нэг талдаа төсвийн орлогын 80 хувь орчмыг бүрдүүлж байгаа татварын орлого дээр гишүүд маань бас их шүүмжлэлтэй хандаж байна. Өөрөөр хэлэх юм бол татварын бааз суурь нэмэгдэхгүй байна, татварын ачаалал их хэвээр байна гээд.

Нөгөө талдаа зөвхөн хөнгөлөлт, чөлөөлөлтөөр биш татварын цогц бодлогоор бизнес, аж ахуйн нэгжүүдээ дэмжье гэсэн ийм санаачилга гарч байгаа тэрийг дэмжиж байгаа.

Нөгөө талдаа бас төсвийн орлогыг бүрдүүлэх нэг гол эх үүсвэр нь төрийн өмчит үйлдвэрийн газруудын ашигт ажиллагаа, тэд нарын төлөх татварын орлого байх ёстой. Энэ дээр бас хэр, энэ дээр их тийм том дүнтэй орлогын юу эх үүсвэр харагдахгүй байна. Энэ дээр бас анхаарах ёстой юм болов уу?

Нөгөө талдаа гол баланс шит/*balance sheet*/-ийн гол зарлагын тал урсгал зардал зөндөө ярьцгаачихсан. 2 дугаар хэсэг бол хөрөнгө оруулалтын зардал. Тэр дээр би өмнөх гишүүдийн хэлж байгаа санал болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, энэ Үндэсний аудитын газрын хийсэн үнэлэлт, дүгнэлттэй санал нэг байна. Өөрөөр хэлэх юм бол хөрөнгө оруулалтын төслүүдийг хэдийгээр өмнө нь гаргасан 16 үзүүлэлтээр биш юм шиг байгаа юм. Гол 4 шалгуур үзүүлэлтээр эрэмбэлж байгаа ч гэсэн асуудал бас байна.

Тухайлбал, бид нар сая ирэх оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж байхад нэлээн олон төсөв нь зоогдоогүй ийм төслүүд орж ирж байгаа хөрөнгө оруулалтын. Жишээлбэл, Энхцэцэг гишүүн эрчим хүчний реформ дээр хэд хэдэн санал гаргаад Баянхонгор, Архангай, Өвөрхангайн цахилгаан станцын төслийг оруулж ирсэн. Төсөв нь батлагдаагүй өмнө нь нөгөө яамнуудаас нь орж ирээгүй учраас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барья гэсэн ийм саналтайгаар орж ирээд дэмжигдсэн гэх мэт. Энэ юуг харуулаад байна вэ гэхээр мэдээллийн цоорхой байна, мөн талдаа эрэмбэ, дэс дараал, координацын бас асуудал байна гэж харж байгаа. Энийг илэрхийлээд байна гэж бодоод байгаа юм.

Тэгээд энэ дээр яах вэ ерөнхийдөө их тайлбарлачихсан учраас би их хариулт нэг их авах юугүй байна л даа. Зүгээр яг тодорхой хоёр асуулт юу вэ гэхээр аль болохоор энэ төсвийн алдагдлыг багасгаж оруулж ирэхээс өөр аргагүй. Нөгөө талдаа 14 том мега төсөл хэрэгжүүлэх гэж байгааг дэмжиж байгаа.

Гэхдээ төсвийн алдагдлыг аль болох багасгах. Хэрвээ таамаглаж байгаа тооцож байгаа төсвийн орлого орж ирээгүй бол нөгөө алдагдал чинь давах ийм эрсдэлтэй байдаг учраас тухайлбал хоёр зүйл харъя, харлаа тодорхой асуулт, 16 аймаг руу санхүүгийн татаас өгөх юм байна 528 тэрбум төгрөг, бүсчилсэн хөгжлийн бодлого гэж гаргаж байгаа. Тэгэхээр энэ байдал цаашдаа ингээд үргэлжлэх үү? Санхүүгийн татаасгүй явах потенциал хэр.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: 1 минут өгчихье.

Б.Мөнхсоёл: Ангилал юу байсан бэ гэхээр төрийн албан хаагчдын өөрсдийнх нь буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн нөхөн төлбөр 24 онд 4.3 их наяд, юу тэрбум төгрөг байсан, ирэх онд 17.2 тэрбум төгрөг гээд ингээд 4 дахин ихэсчихсэн байгаа байхгүй юу тооцооллоор. Энэ яагаад ийм болчхов оо гэдгийг асуумаар байна.

Гуравдугаарт, тэр Үндэсний бодлогын хороо билүү тэгээд Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хурдасгуур төв гээд энэ хоёр байгууллага, агентлагийн үйл ажиллагааны ялгаа юу байдаг юм бол зорилгын ялгаа? Яагаад гэхээр хоёулаа бас хөөрхөн төсөвтэй байгаа байхгүй юу гэх мэт ингээд хумьчихмаар бас зарлагын зүйл ангиуд харагдаад байна шүү л гэдгийг хэлмээр байна.

Дараа нь хэлэх үгэн дээрээ дүгнэлтээ хэлсэн нь дээр юм байна. Хугацаа дуусаад байгаа юм байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Эхний саналуудтай Мөнхсоёл гишүүнтэй 100 хувь санал нийлж байна. Тийм, цаашдаа бид нар өмнө нь ч бид нар бас нэлээн хичээж хийж хэрэгжүүлж ирж байгаа ажлууд, цаашаа ч энийг тасалдалгүй үргэлжлүүлэх ёстой бодлогын асуудлууд, татварын шинэчлэл, ер нь төсвийн шинэчлэлийн хүрээнд хийгдэх ёстой асуудлуудыг хөндлөө. Баярлалаа.

16 аймаг татаастай байгаа нь үнэн. 16 ч биш 7 аймаг болчихоор энэ чинь 14 аймаг татаастай явж байна. Уг нь Төв аймаг нэмэгдэхээ шахааж байсан чинь ирэх жилийн одоо эрчим хүчний шинэчлэлтэй холбоотой юу болох нь тэрнээс болох байх аймгийн хувьд наана цаана орно гээд.

Тэгэхээр мэдээж Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бас нэг хүрэх үр дүнгийн нэг үзүүлэлт нь энэ байх болно. Өөрөөр хэлбэл аймгууд маань бүгдээрээ тэргүүлэх чиглэлээ амжилттай явуулснаар эдийн засаг, нийгмийн хөгжил дээр нь бол тодорхой ахиц гарснаар төсвийн хувьд бие даасан ийм хэлбэр рүү орох бас зорилго үзүүлэлт энэ байх болно. Төрийн нарийн бичгийн дарга хаашаа гараад явчав? Энэ юуг тэр төрийн албан хаагч нарын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй тэр 17 тэрбум төгрөгийн талаар аль яам нь хариулах ёстой юм бэ? Манай дээр мэдээллүүд нь байна уу? Айн Хууль зүйн яамнаас хариу өгөх юм байна. Тэрийг өгчхөөрэй.

Энэ Үндэсний хороонд бол энэ чинь байнгын ажиллагаатай бүтэц биш шүү Үндэсний хороо бол. Тийм, тэгэхээр сайдууд давхар Үндэсний Хороо бодлогоо нийлүүлдэг өөрөөр хэлбэл, салбар дундын зохицуулалтуудыг албажуулсан л хэлбэр. Салбар дундын хамтын ажиллагааг.

Харин хурдасгуур төв бол байнгын ажиллагаатай байнгын тэнд нь төрийн албан хаагч нар ажиллаж байгаа ийм Засгийн газрын бүтэц, Ерөнхий сайдын дэргэд ажилладаг ийм зүйл.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан гишүүн алга байна.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Бид нар 33 их наядын орлоготой төсөв ярилцаж байна, хэлэлцэж байна. Төсөв томорлоо, ДНБ нэмэгдлээ гээд байдаг. Яг үнэнээ хэлэхэд уурхай дагасан, нүүрс дагасан л төсөв шүү. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд чинь ерөөсөө хөл дээрээ босож сэргэж чадахгүй байгаа. Банкны зээлийн хүүгээс хүүгийн хооронд. Тэгэхээр энэ Филиппин улс Пүрэвдорж дарга бид нар хавар явсан даа татварын шинэчлэлийн асуудлаар. Сангийн яам энэ дээр ямар байр суурьтай байна? Тэр улс бол татварын реформ хийсэн байна. Ингээд жижиг, дунд бизнес эрхлэгчдэдээ зориулж татварын хувь хэмжээг зоригтой бууруулж, ингэснээрээ татвар төлөгчдийн бааз суурь нэмэгдэж, татвараа үнэн, зөв мэдүүлдэг, тайлагнадаг. Ингэснээр төсвийн орлого нэмэгдсэн гэсэн ийм эерэг дүн гарсан гэсэн ийм зүйлийг бид нарт ярьсан.

Сангийн яам мэдээж энэ олон жил явсан, тогтсон тогтолцоогоо эвдэхийг хүсэхгүй байгаа байх. Айх байх, эмээх байх. Гэхдээ ер нь энэ аж ахуйн нэгж, бизнес эрхэлдэг жижиг, дунд бизнес эрхлэгчтэй ярихаар ерөөсөө энэ татвараас, нийгмийн даатгалын шимтгэлээс үнэхээр үнэхээр өндийхгүй байна л гэж байгаа юм. Тэгээд энэ татварын орлогын чинь 90 хувь нь хэдхэн тооны аж ахуйн нэгжүүдээс, том аж ахуйн нэгжүүдээс бүрдэж байна. Тэр 90 хувийг бүрдүүлж байгаа тэр энэ жижиг, дунд бизнес эрхлэгч рүү л энэ зоригтой шинэчлэл хийж, манай улсад өнөөдөр далд эдийн засаг асар их байна шүү. 50 хувьтай тэнцэхүйц хэмжээний далд эдийн засаг байна гэсэн тооцоо, судалгаа байдаг.

Энэ далд эдийн засгийг ил болгохын тулд орлогоо үнэн, зөв мэдүүлдэг байхын тулд, татвараа тайлагнадаг байхын тулд ийм шинэчлэл хийхгүй ийм дарамттай байгаа учраас аж ахуйн нэгжүүд үнэн, зөв тайлан баланс гаргахгүй. Хоёр тайлан баланс гаргаж байна. Татвараас бултаж байна, зугтаж байна. Тийм учраас энэ цаашдаа татварын эрх зүйн шинэчлэл хийх асуудал дээр та бас ямар ажил, арга хэмжээ хийх вэ гэж?

Ирэх жилийн төсөв дээр нэг харин гэрэлтэй, гэгээтэй сайн мэдээ байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай холбогдуулж бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг ирэх жил хэрэгжүүлэх гэж байна. 20 нэр төрлийн татварыг бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоох боломжийг энэ ондоо багтааж та бүхэн хийх гэж байгаа юм байна. Хийх гэж байгаа юм байна. Энэ бол маш таатай мэдээ. Бүсүүдийн онцлогоос хамаарч зах зээл, эдийн засгийнх нь хүрээ, тэр боломжоос нь хамаарч татварыг ялгаатай тогтоох энэ бололцоо боломжийг та бүхэн удахгүй энэ Засгийн газраар оруулж батлуулах юм байна. Нийслэлийн бүс дээр алслагдсан 3 дүүргийг бас тусад нь авч үздэг байгаарай. Тэгэхгүй бол Улаанбаатар хотын бүс гээд хүн ам цөөтэй, зах зээл багатай аж ахуйн нэгжүүд дээр энэ бодлого чинь явахгүй, гээгдээд дунд нь хаягдахаар байгаа юм. Тэгэхээр Сангийн яам энэ дээр манай алслагдсан 3 дүүргийг онцгой анхаарч, энэ ялгаатай татварын тогтолцооныхоо бодлогод оруулж өгөх, орон нутгийн аж ахуйн нэгжийн, орон нутгийн төр, захиргааны байгууллагын саналыг харгалзаж үзэж энэ шийдвэрийг гаргах тал дээрээ бас анхаарч өгөөрэй гэж хэлэх гэж байгаа юм.

Дараагийн нэг нь ирэх жилийн улсын төсөв дээр энэ хөнгөлөлттэй эм дээр хэдэн төгрөг суусан бэ? Одоо энэ сүүлийн үед цаг хугацааны асуудлаар энэ эмийг жороор

олгодог болсонтой холбогдуулж ард иргэд үнэхээр бухимдалтай болсон байна. Яаралтайгаар өвдлөө гэхэд эмийн эмийн сангаас эмээ авч чадахгүй асуудал үүсэж байна. Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сан чинь хүндэрчхээд ийм байдал руу орж байна уу, эсвэл цаашдаа үнэхээр эмчийн жороор заавал эм өгдөг байх ийм тогтолцоо руу орж байгаа юм уу? Энэ дээр ер нь ямар бодлого барьж ажиллаж байгаа юм бэ гэдэг дээр ийм 3 асуултад хариулт өгөөч.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Сандаг-Очирын гишүүний асуултад хариулья.

2020 онд татварын багц шинэчлэл хийгдсэн байгаа. Тэр хүрээнд хамгийн хөнгөлөлттэй байгаа ангилал ЖДҮ-лэл байгаа. Аж ахуйн нэгжийн 1 хувь болсон байгаа шүү дээ 2020 оноос хойш. Тэгэхээр өөрөөр хэлбэл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс хамгийн хөнгөлөлттэй байгаа хэсэг маань ЖДҮ-лэл юм. Энэ бол байгаа онож, үр дүнгээ өгч байгаа гэдэгт эргэлзэх зүйл алга байна.

Ер нь бусад бүх төрлийн үл хөдлөх ч гэдэг юм уу бусад бүх төрлийн татваруудыг нэмээд ингээд энэ бүртгэлтэй байгаа 153 мянган аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг нь харах юм бол 10.1 хувь нь дундаж, энэ дотроос бичилүүд нь гэхэд буюу хамгийн жижгүүд нь 5.5 хувь, жижиг, дунд бол 6.3 хувь байдаг. Энэ нийгмийн даатгалын шимтгэл ороогүй асуудал шүү. нийгмийн даатгалын шимтгэлийн юу гэдэг юм хөнгөлөлт, чөлөөлөлт багасгах хувь хэмжээ гэдэг бол энэ тусдаа бүүр нийгмийн даатгалын тогтолцооны асуудал яригдана. Энэ дээр түрүүн бас Энх-Амгалан сайд хэллээ. Мөн энэ төсвийн бодлоготой маш уялдаатай явах ёстой. Үнэхээр шинэчлэл хийхгүй бол энэ нийгмийн даатгалын салбар энэ байдлаараа явах юм бол цаашдаа төсөв өөрөө дийлэхгүй, хуримтлалын сан маань улам л алсрах ийм үр дүнтэй маш эрсдэлд орсон, маш том сорилтод орсон ийм тогтолцоо болсон шүү гэдгийг хэлье. Өөрөөр хэлбэл, тусдаа асуудал шүү.

Алслагдсан сум дүүргүүд гэж энэ энэ дээр ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэдгийг энэ бүс өөрөө санаачилгатай судалгаагаа хийгээд, тэгээд Засгийн газарт танилцуулах ийм дарааллаар явна. Тэгэхээр та бас өөрийнхөө тойрог руу энийг бас анхаарч тэндээ энэ судалгаа, санаачилгатай оролцвол илүү их юу болоод явах байх, үр дүнтэй яваад болоод явах болов уу гэж ингэж харж байна. Тэрийг салбарын сайдад хариулах уу?

Б.Пүрэвдорж: Салбарын сайд алга байна. Одоо Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууна.

Б.Найдалаа: 14 мега төсөл гэж хэрэгжүүлнэ гэж байгаа. Үнэхээр хэрэгжүүлчихмээр сайхан байгаа. Гэхдээ Монгол Улс мега төсөл хэрэгжүүлсэн түүх нь юу билээ, туршлага нь юу билээ, 5 дахь цахилгаан станцаа ч барьж чадаагүй л байгаа. Зүгээр санаа зовж байгаа юм энэ мега төслийг яг хариуцаж байгаа, уг нь Ерөнхий сайдаас асуух асуулт л байна л даа. Хариуцаж байгаа сайд, албан тушаалтан нь яг хэн бэ гэдгийг хуваарилж хармаар байна. Хэн нэгэн албан тушаалтан эхнээс нь дуустал хариуцмаар байна. Энийг л сонсмоор байгаа юм.

Хоёрдугаарт энэ өмнөх төслүүдээс юугаараа өөр байх юм бэ гэдэг ямар аргачлалын, менежментийн хувьд, хяналтын хувьд юугаараа өөр байх юм бэ? Хэрвээ өөр байж чадахгүй юм бол бид нар 14 байтугай 1 ч үгүй сууна. Энэ дээр хариулт хүсэж байна.

Хоёр дахь нь ер нь зүгээр жилд 20 мянган хүүхэд шинээр сургуульд орж байгаа юм байна л даа. Бид нарын сурах ёстой хүүхэд 20 мянгаар нэмэгдэж байгаа. Сургууль бол хүрэлцээгүй байгаа, 3 ээлжээр хичээллэж байгаа бүгдээрээ мэдэж байгаа. Гэхдээ энэ жил 1 ч сургуулийг нэмж барихааргүй төсөвлөсөн. Ирэх 4 жил энэ сургуулийн хэрэгцээг яаж хангах гэж байгаа вэ? Дараа жил нөхөөд тавиад тавиад явчих юм уу? Эсвэл ингээд дутагдалтай ингээд дэн дун яваад байх юм уу? Энэ дээр хариулт өгөөч. Ямар бодлого барих юм бэ хүүхдүүдээ сургуультай болгох талаар? Бараг 1 их наяд төгрөгөөр засгийн конторын барилга барих гэж байгаа хүмүүс шүү дээ. Мега төсөл болгочихсон. Тэгсэн хэр нь хүүхдүүдээ, сургуулиа хаячихсан явж байгаа. Энэ дээр ямар бодлого барих юм бэ? Болохгүй юм байхгүй. Зүгээр ямар бодлого байгаа юм? Ямар дараалал байгаа юм?

Гуравт нь хуультай холбоотой асуудал байна. Энд Тогтвортой байдлын зөвлөлийнхөн байгаа юу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгаа тээ? Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуумаар байна. Төсвийн тухай хуулийн 27.1.2 дээр Тогтворт төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн төлөв, байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх гэнэ. Энэ бол хууль шүү хууль. Төсвийг боловсруулахдаа . Энийг сангийн яам төсөв боловсруулахдаа үндэслэсэн үү, хууль дагасан уу? Дагаагүй бол энэ яах вэ, энийг яг заавал хүрээнд нь байх албагүй л дээ. Гэхдээ ямар нэгэн нөгөө дагасан болон, дагаагүй тайлбар, үндэслэлээ гаргасан байх ёстой байх. Тэр нь байгаа юу? Төсвийн тогтвортой байдлаас яг энэ юугаа өгсөн юм уу, хариу авсан юм уу? Би энийг яагаад асууж байна гэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол Улсын Их Хурлын институт байхгүй юу. Улсын Их Хурал Улсын төсөв дээр оролцож байгаа ганц институт нь, гишүүдээсээ гадна.

Тэгэхээр энэ институтийг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Тэгээд энэ дээр ямар нэгэн байдлаар яаж ажилласнаа Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн хариулна уу. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Эхний асуултуудад Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Энэ их энгийн асуулт тэр 14 мега төслийг аль аль сайд нар яах би танд бүр яг нэг бүрчлэн хэлбэ.

Эрдэнэбүрэн усан цахилгаан станц Чойжилсүрэн сайд, Үндэсний хиймэл дагуул Учрал сайд, Газрын тос боловсруулах үйлдвэр Туваан сайд, энэ боомтууд байгаа энэ Боомтын сайд Тулга сайд, Тавантолгой 450мвт энэ Чойжилсүрэн сайд, нүүрс хими кокс химийн цогцолбор үйлдвэрийн Тавантолгой, энэ Тавантолгой, ”Эрдэнэс Тавантолгой” ТӨҮГ-ын харьяалах сайд нь Туваан сайд, Хэрэг эрхлэхийн сайд. Зэс боловсруулах үйлдвэр, Эрдэнэт үйлдвэр мөн чиглэлийн сайд Туваан сайд энэ дээр хариуцсан. Эгийн голын 310мвт усан цахилгаан станц энэ Чойжилсүрэн сайд, сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр мөн Чойжилсүрэн сайд, Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах анги Одонтуяа сайд, Эрээнцав Чойжбалсан-Баруун-Урт-Бичигт чиглэлийн босоо чингэлгийн Төмөр зам Дэлгэрсайхан сайд. Монгол Францын хамтарсан ураны төсөл Учрал сайд. гангийн үйлдвэр. Туваан сайд, Алт цэвэршүүлэх үйлдвэр Туваан сайд ийм төсвийн ерөнхийлөн захирагч нартай сайд нарын оролцоотойгоор энэ төслүүд цаашаа үргэлжлээд ингээд явах ёстой.

Сургууль, цэцэрлэгийн хувьд бүх төсөл зогсож байна гэсэн тиймэрхүү ойлголт өгөхөөр та хэлчихлээ. Сүүлийн 10 жилийн хугацаанд 600 гаруй, 600+ шүү сургууль, 700+

гаруй цэцэрлэг баригдсан байдаг юм. Ирэх жил зөвхөн улсын төсвөөс 90 сургууль үргэлжилнэ. Ашиглалтад орох төслүүд их их нэлээд байгаа.

Дээрээс нь нийслэл өөрийнхөө төсвөөр 37 сургууль, ингээд 127 сургууль улс орон даяар ингээд ашиглалтад орох нь ороод үргэлжлэх нь үргэлжлээд явна. Тэгэхээр энэ бага тоо биш. Энийг ашиглалтад оруулсны үр дүнд хамран сургалт болон ээлжийн коэффициент хэд болохыг Наранбаяр сайд хэлчих болов уу гэж бодож байна.

Ер нь дунджаар 2 хувиар Улаанбаатар дөхнө, орон нутагт 2 хувиас доошоогоо 1.5 руу дөхөж очиж байгаа. Тэгэхээр энэ маш сайн үр дүн гэж ингэж хэлж болно. Тэгэхээр энэ салбарын хөрөнгө оруулалт зогсчхож байна гэсэн тийм буруу ойлголт олон нийтэд бас өгөх нь хэт өрөөсгөл шүү.

Б.Пүрэвдорж: Наранбаяр сайд хариулна.

П.Наранбаяр: Товчхон хариулъя. Тэгэхээр энэ, энэ жилийн тухайд шинээр тавигдаагүй боловч түрүүнд Жавхлан сайдын хэлсэнчлэн 90 сургууль, 62 цэцэрлэг, түүн дээр нэмэх нь нийслэлийн төсөвлөсөн бас төсөв дээр суусан сургуулиуд байгаа. Эдгээр нь ингээд ашиглалтад ороод ингэх юм бол нэлээн олон суудлыг бид нар ингээд аваад явчхаж болно.

Тэгээд ер нь зүгээр 4 жилийн хугацаагаар нь ингээд харах юм бол нийтдээ 23250 орчим хүүхэд, ор бүхий ийм 212 цэцэрлэг, тэгээд 131812 суудал бүхий 241 сургуулийн барилга юунууд хэрэг болох юм. Тэгэхгүй жил жилдээ 20-оод мянган хүүхэд шинээр нэмэгдэж байгаа. Хэдийгээр 2027 оноос эхлээд 6 насны элсэлт ингээд тогтвортой болж, аажмаар буурах боловч яг тэр орчихсон хүүхдүүдийнх нь тоо нь 2030. 2040 он хүртэл өсөхөөр ийм байдалтай байгаад байгаа. Тэгэхээр бид бол энэ.../минут дуусав./

Б.Жавхлан: Нэмж хариулъя.

П.Наранбаяр: Бид тэгээд энэ сургууль, цэцэрлэгийн бас энэ хүрэлцээг нэмэгдүүлэхийн тулд Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банк, санхүүгийн түрээс гэх мэт олон ийм байгууллагуудтай ярилцаж, санхүүгийн түрээс гэх мэт ийм олон арга хэлбэрээр ярилцаж байгаа. Тэгээд тухайлах юм бол Дэлхийн Банктай ярилцаж байхад 50 сая долларын хөнгөлөлттэй зээлийг ингээд орлох юм бол энэ асуудлыг бас шийдвэрлэхэд нэлээн их хэмжээнд бас нэмэр болохоор байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ асуудлаар бас бид нар Сангийн яамтайгаа ярилцаж, Эдийн засаг хөгжлийн яамтайгаа ярилцаж тэднийд тавьсан бодлогын саналуудыг бодлогыг боловсруулах ингээд шийдвэр гаргах түвшинд бас ийм ярилцах ийм бодолтой байгаа.

Ер нь энэ жил орсон энэ, яг 25 ондоо яг энэ төсөвлөснөөрөө оруулж чадах юм бол бас асуудлыг бас нэлээн сайн шийдвэрлэчхэж чадна гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: 5 номер Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат. 7 номер.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам бол өмнө нь Засгийн газрын бүтэц өөрчлөгдөөгүй байхад, Эдийн засгийн яам байгуулагдаагүй байхад Сангийн яаман дээр Макро эдийн засгийн бодлогын Эдийн засгийн бодлогын газар гэж байдаг байсан. Тэр үед Эдийн засгийн бодлогын газар

дээр макро төсөөллүүдийг Сангийн яам тооцож, тэр тооцоон дээр үндэслэж төсөв тооцдог байсан. Үүний дараа Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсантай холбогдуулан Сангийн яамнаас Эдийн засгийн бодлогын газарт Макро эдийн засгийн бодлогын газрын чиг үүрэг үндсэн бүтэц яг тэр газар бүрэн бүрэлдэхүүнээр Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжсэн байгаа.

Үүнээс хойш Сангийн яам төсвийн төсөл боловсруулахдаа Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн макро тооцоон дээр үндэслэж бид төсвийн төслийг боловсруулдаг ийм байгаа юм. Хуулиараа төсвийн тухай хууль дээр төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага дээр сүүлд нэмэлт, өөрчлөлт оруулаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан Макро.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Дэлгэрсайхан индрийн 1 номер найдлаа.

Ж.Дэлгэрсайхан: Гишүүний асуултад хариулья. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд яах аргагүй энэ манай гаргаж өгсөн макро эдийн засгийн төсөөллийг баримтална. Хэрвээ баримтлаагүй бол түүний тайлбар дүгнэлтийг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт өргөн мэдүүлнэ гэсэн. Тэгэхээр энэ заалтыг бид нар хавар 3 сарын 15-нд хуулийн дагуу, үүргийнхээ хүрээнд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ашиглах макро эдийн засгийн тоонуудыг гаргаж өгсөн.

6 сарын 5-нд батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл дээр ч гэсэн энэ бидний баримт тоо өөрчлөгдсөн. Сая бас өөрчлөгдөөд ороод ирсэн. Тэгэхдээ сая Найдалаа гишүүний хэлсэн энэ хуулийн заалтын дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр ямар нэгэн тайлбар, дүгнэлт орж ирээгүй байгаа. Тэгэхээр бид нар энийгээ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой хуулийн дүгнэлтдээ тусгаж өгсөн. Энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна гэдэг агуулгаар бид бид нарын дүгнэлт.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Найдалаа гишүүн тодруулья.

Б.Найдалаа: Тэгэхээр энэ ингээд тов тодорхой хууль байгаа байхгүй юу. Тэр цаад агуулга нь бол яах вэ, төсөл боловсруулахад заавал мөрдөх ёстой төсвийн хүрээний мэдэгдэл биш шүү дээ. Энэ чинь зүгээр үндэслэнэ л гэж байгаа юм.

Тэгэхээр яг энэ хууль юмыг чинь, нэгэнт баталчихсан юмыг чинь бүгдээрээ дээр, дооргүй мөрдөх ёстой. Сангийн яам байна уу, Эдийн засгийн хөгжлийн яам байна уу заасан юм чинь мөрдөх л ёстой. Мөрдөж байж энэ төсвийн Тогтвортой байдлын зөвлөл чинь, энэ институт чинь өөрөө чадавхажна, зүгширнэ. Тэгж байж бас Их Хурал өөрөө төсвийн боловсруулах., батлах, хянах процесст илүү оролцож эхлэх юм. Тэгэхээр энэ институтээ цаашдаа илүү хариуцлагатайгаар ...-гаар ажиллуулаасай гэж бодож байна. Тэгээд Ганбат дарга бас саяынхаа гүйцээгээд хэлчих үү тээ хариултаа.

Б.Пүрэвдорж: Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат 7 номер.

Ж.Ганбат: Гол макро тооцооллыг яах вэ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр боловсруулдаг байгаа. Сая Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ хууль дээр ирсэн байгаа 3 сарын 15-нд Эдийн засаг, хөгжлийн яаманд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс макро тоонуудыг өгч байгаа. Түүнээс 3 сарын 15-нд өгсөн тоон дээр Эдийн засаг, хөгжлийн яам ажлаад бид 9 сарын 1-нд төсөв өргөн барихад зарим тоонуудыг нь

Эдийн засаг, хөгжлийн яам бас тухайн цаг үедээ болон төсөөлөл, бас гадаад, дотоод хүчин зүйл дээрээ тооцоод ингээд бас макро эдийн засгийн тоог эцэслэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлээд, бид үүн дээр нь үндэслэж тооцоо хийдэг байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яамнаасаа гол гол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн тоо юун юун дээр нэмээд өөрчлөгдсөн гэдгийг нь хэлээд өгчихье тээ.

Б.Пүрэвдорж: Одоо Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асууна.

Г.Уянгахишиг: Ер нь бол төсөв өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа нийцэж байх ёстой, хуулийнхаа дагуу өргөн баригдаж байх ёстой. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.3 дээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр төсвийн хүрээний, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа буюу 24 оны 6 сарын 5-нд батлагдсан хуулиар нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 31 их наяд гэж байгаа. Тэгвэл өнөөдөр оруулаад ирчихсэн төсвийн маань үзүүлэлтийг харахаар нийт зарлагын хэмжээ 35, 31.8 их наяд буюу энэ төсвийн хүрээ дунд хугацааны төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг тусгай шаардлагаа зөрччихсэн байгаад байгаа.

Тэгэхээр өнөөдөр Засгийн газраас төсвөө оруулж ирэхдээ хуулиа зөрчөөд оруулаад ирчихдэг юм байжээ. Төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд нийцүүлдэггүй юм байж. Нөгөө талаасаа энэ тоондоо нийцүүлээд төсвийн хүрээний мэдэгдлээ давхар нэмэлт, өөрчлөлт оруулна гээд оруулаад ирчихсэн байна. Гэтэл өнөөдөр ч гэсэн энэ яригдаж байна шүү дээ Төсвийн хүрээний мэдэгдэл чинь өөрөө батлагдах эсэх нь ч эргэлзээтэй.

Тэгэхээр одоо өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа дэгийн тухай хуулиараа яг өнөөдөр бид нар ямар санал өгөх ёстой вэ гэхээр энэ өргөн мэдүүлсэн төсвийн хууль чинь өөрөө, төсөв чинь өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа нийцэж байна уу, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлдээ нийцэж байна уу гэдэг дээр бид нар санал өгөх ёстой.

Тэгэхээр хэрэв Засгийн газар хуулиа зөрчөөд ороод ирдэг юм байж. Тэгвэл Их Хурал энийг дагаад, дэмжээд, батлаад явах юм өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон чуулганы дэгийнхээ тухай хуулийг зөрчих гээд байна. Тийм учраас энэ дэгийн тухай хуулийн дагуу хэрвээ Их Хурлаас дэмжигдээгүй тохиолдолд 70.7-гийн дагуу олонх дэмжээгүй бол төсвийн төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана гэсэн хуулийн зохицуулалттай.

Тэгэхээр Засгийн газраас тухайн төслөө өнөөдрийн төсвийн төслөө өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульдаа нийцүүлчхээд, хуулийнхаа хугацаанд батлуулчхаад, харин тэр дараа нь төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг тэр макро эдийн засгийнх байдаг юм уу, өөрсдийнхөө үйл ажиллагаандаа нийцүүлээд өөрчлөлтөө Их Хурлаараа батлуулчих. Энэний дараа магадгүй тэр төсвийн тодотголоороо дахиж хэлэлцүүлж болно шүү дээ. Тэгэхээр анхнаасаа Их Хурал өөрөө хууль тогтоогч байгууллагын хувьд ингэж яг ингээд цагаан дээр хараар биччихсэн хуулиа зөрчөөд явахгүй байх гэдэгт бол итгэж байна.

Энэ нь өөрөө хэрвээ бид нар өнөөдөр хуулиа зөрчөөд энэ нэгдүгээр хэлэлцүүлгийг санал хураалтыг дэмжээд явуулчих юм бол хуулиа зөрчихсөн байгаа төсвийн төсөөлөл, төсвийн төслийг Тогтвортой байдлын, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа нийцсэн байна гэдэг энэ санал, дүгнэлтийг гаргачих гээд байна шүү гишүүд ээ. Тэгээд энийг анхааруулж хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: гишүүн хариулъя.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүний санал дээр би тайлбар хэлье. Ерөнхий зарчимтай санал нийлж байна. Тэгээд шинэ, хуульд орсон шинэ зохицуулалтаар бол цаашдаа бид нар энийгээ маш сайн бариад явах бас ийм боломжууд бүрдэж байгаа.

Тийм учраас ер нь бол бид маш сайн төлөвлөж, ер нь дахин ер нь тодотгол хийхгүй байхаар л ийм төсвийг батлах шаардлагатай болж ирж байгаа цаашдаа бол. Ер нь бол юу ч болж магадгүй тийм ээ ер нь геополитикийн хувьд ч тэр, ер нь ийм ээдрээтэй үед. Тэр үед бид төсвийн хувьд маневр хийх боломж маш хязгаарлагдмал болж ирж байгаа шинэ зохицуулалтуудаар. Нэг.

Хоёрдугаарт, таны хэлж байгаа энэ дотор та нэг юм орхичхоод байх шиг байна 6 сарын 5-нд батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэл бол өнгөрсөн 2023 оны суурин дээр хийж байгаа юм. Сая гэтэл бид энэ чинь тодотгол хийчихсэн. Өөрөөр хэлбэл, 24 оны суурь өөрчлөгдчихсэн. Одоо бид нар 25 оны төсөв ярьж байна. 6 сарын 5-ны суурь саяын тодотгол хийсний дараах 24 оны суурь 2 чинь өөр болчихсон байгаа учраас бид нар 25 оныхоо төсвийн хүрээний мэдэгдлийг шинэ суурин дээрээсээ өөрчлөхөөс өөр арга байхгүй. Хэрвээ тодотгол хийгдээгүй байсан бол Төсвийн хүрээний 25 оны мэдэгдлийг өөрчлөх шаардлагагүй байсан байж болно. Тодотгол хийчихсэн учраас суурь нь өөр болчихсон, 25 оныхыг өөрчлөхөөс өөр арга байхгүй. Ингээд 25 оныхоо төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилъе, хэлэлцэх эсэхээ гээд шийдчихсэн. Одоо хэдүүлээ төсвөө хэлэлцэх эсэхээ шийдээд, ингээд зэрэгцүүлээд яваад ингээд явахад энэ дээр хууль зөрчдөг юм үүсэхгүй гэж би танд тайлбарлая.

Б.Пүрэвдорж: Та асуулт асуугаагүй шүү дээ тэгэхээр. Тодруулъя.

Г.Уянгахишиг: Тийм, тэгэхээр яах вэ? Мэдээж ингээд асуудалтай болоод оруулж ирж байгааг ойлгож байна. Гэхдээ бид нар өнөөдрийнхөө яг байгаа хууль тогтоомжийнхоо дагуу л явах ёстой шүү дээ. Тэгэхээр өнөөдрийн төсвийн хүрээний, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тоо чинь ямар байгаа юм бэ гэдэг чинь маш тодорхой байгаа тийм үү? 6 сарын 5-ны хууль чинь хүчин төгөлдөр үйлчилж байгаа, одоо өөрчлөгдөөгүй байгаа.

Тэгэхээр энэ хуульдаа нийцэж байгаа юм уу гээд асуухаар энэ чинь нийцэхгүй байна тоонууд нь зөрөөд байна. Тэгэхээр хэрвээ нийцэхгүй байгаа бол яагаад Их Хурал нийцэж байна гэдэг дүгнэлтийг гаргах ёстой юм бэ? Тэгээд Үндэсний аудитын газар ч гэсэн нийцээгүй байна гэдгийг чинь тодорхойлчихсон байна, Төсвийн тогтвортой байдлын дүгнэлт дээр, Тогтвортой байдлын зөвлөлийнх дээр байж байна. Тэгэхээр энэ бүх юм чинь цаашдаа яах вэ болноо, өнөөдөр ийм нөхцөл байдалтай байна гээд бид нар ингээд батлагдчихсан хуулиа зөрчөөд яваад байх юм бол ерөөсөө хууль батлах ямар хэрэг байдаг юм. Тэгээд Засгийн газраа сонгочхоод Засгийн газраа байгуулчхангуутаа тэгвэл Их Хурлын гишүүдэд хийх ажил юу байгаа юм? Тэгэхээр.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Санал хэллээ.

Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Бүгдэд нь оройн мэнд хүргэе.

Тэгэхлээр бид 2025 оны төсвийн асуудлыг хэлэлцэж байгаа. Төсөв бол тухайн жилийн нийт орлого, зарлагынхаа асуудлыг нарийн тооцдог. Мэдээж улсын төсөв яригдаж байгаа үед мэдээж энэ орлого, зарлагын тооцоонд айл өрхийн орлого зарлагын тооцоо бас давхар тооцогдсон байх нь ойлгомжтой. Тэгэхлээр төсвийн бодлогоор л, төсвийн бодлогоор дамжиж хамгийн гол нь энэ ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажил эргэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор өрхийн орлого нэмэгдэх, өрхийн орлого нэмэгдсэнээр эдийн засгийн эрэлтийг бий болгож, тэр эрэлтийг хангах үүднээс нийлүүлэлтийг бий болгох үүднээс үйлдвэрлэлүүд хөгждөг ийм л үндсэн онолтой.

Энэ жил 2025 онд Монгол Улсын төсөв бол урд, хожид байгаагүйгээр их төсөв явж орж ирж байгаа. Зарлагын хувьд ч, орлогын хувьд ч, эдийн засгийн нийт хэмжээний хувьд ч үндсэндээ 95 их наядын эдийн засагтай болно гэж бид нар ингэж ярьж байгаа. Төсвийн энэ их тэлэлтийг дагаад онол бас бий. “The Crowding Out Effect” гээд өөрөөр хэлбэл, энэ төсвийн орлого, төсвийн тэлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор хувийн хэвшил боомилогддог. Өөрөөр хэлбэл, Засгийн газар энэ их хэмжээний тэлэлтийг, төсвийн тэлэлтийг бий болгохын тулд нөгөө талдаа орлого олох зайлшгүй шаардлагатай. Ингээд энэ орлогоо олохын тулд татвар хэлбэрээр дотооддоо, дотоодоосоо энэ орлогыг бүрдүүлэхийн тулд бүх ажиллагаагаа идэвхжүүлдэг. Ингээд Засгийн газрынхаа зарлагынхаа хэмжээг хангаж чадахгүй бол зээл, тусламж, бонд гаргах гэх мэтчилэн Засгийн газрынхаа өрийг нэмэгдүүлдэг ийм л хэлбэр рүү орно гэсэн ийм онол бий.

Тэгэхлээр энэ онолын энэ хариу болгож манай энэ төсвийг боловсруулж орж ирж байгаа манай Засгийн газрынхан маань ямар бодлого байгаа юм болоо гэдэг дээр нэгдүгээрт асуулт байгаа юм.

Хоёрдугаарт, нь энэ төсвийн их тэлэлт бол импортыг нэмэгдүүлж байна. Импорт нэмэгдсэнтэй, нэмэгдсэн нь өнгөрсөн 3 сарын статистик мэдээ өнөөдөр өглөө жишээлбэл үндэсний статистикийн газраас гаргасан байна л даа. Ингээд аваад үзэхэд өнгөрсөн оны мөн үеэс эхний 3 сарын, 3 улирлын байдлаар экспорт 4.3 хувиар өссөн. Гэтэл нөгөө талдаа импорт нь 27.5 хувиар өсчихсөн. Энэ нь эргээд импорт өсөж байна гэдэг бол гадаад валютын нөөц багасаж байгаа гэсэн үг. Энэ нь эргээд ханшид асуудал үүснэ.

Төсвийн тэлэлт бол импортыг нэмэгдүүлдэг учраас энэ нь дагаад импортыг оруулж ирэхтэй холбоотой ложистикийн асуудал манай дээр ямар байдаг билээ 25 онд бас мега төслүүдийг хэрэгжүүлнэ. Энэнтэй холбоотойгоор импорт бас нэлээдгүй нэмэгдэнэ. Ингээд том төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой орж ирж байгаа импорт, энгийн өнөөдрийн жирийн түвшинд явж байгаа бизнесүүдийн орж ирдэг ачаа тээвэр, ложистик дээр асуудал үүснэ. Энэ нь эргээд барааны хомсдол, нийлүүлэлтийн хомсдол үүсгээд эргээд инфляц үүсэх ийм хүндрэлтэй байдлыг үүсгэж байгаа.

Засгийн газар энийгээ бас тооцож орж ирэхдээ 6 хувь гэгчхээд сая бол ингээд төсвийн хүрээний мэдэгдэл дээр нэмээд 7.5 гээд ороод ирсэн. Хэрэв зээ саяын миний ярьсан асуудал үүсэх юм бол энэ нь инфляц дахиад дээшээ нэмэх боломжтой.

Гэтэл 2025 оны төсөв дээр энэ төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын хэмжээтэй буюу 6 хувиар нэмэгдүүлнэ гээд ингээд ороод ирчихсэн байгаа. 6

хувиар нэмэгдүүлнэ. Хэрвээ инфляц 10 хувь бол бас энэ чигээрээ нэмэгдүүлэх үү гэдэг ийм хоёр дахь асуулт.

Гурав дахь нь 25 оны эдийн засгийг 8 хувиар тооцож оруулж ирсэн байгаа. Гэтэл олон улсын байгууллагууд Монгол Улсын эдийн засгийг 6 хувь гэж тооцоод байдаг. Яагаад 2 хувиар нэмэгдүүлж тооцох болсон бэ гэдэгтэй холбоотой бас хариулт өгөөч. Энэ дээр төсвийн бодлогын, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл арай өөр дүгнэлтийг бас оруулж ирсэн байгаа. Тэр нарийн асуудлуудыг би бас Байнгын хорооны хурлууд дээр асуудлыг ярина.

8 хувийн өсөлт нь аль аль салбарууд дээр гарах вэ? Аль аль салбарууд дээр гарах вэ? Хэчнээн ажлын байр нэмэгдэх вэ? Хэчнээн айл өрхийн орло.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Жавхлан хариулья.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулья.

Татварын орлого бүрдүүлэлт, төсвийн орлого талын гарч байгаа энэ өөрчлөлтүүд ийн хувьд сүүлийн 7-8 жилийн энэ орлого бүрдүүлэлтийн институтийг толгойлж байсан хүний хувьд та энийг хэрхэн яаж бүрдүүлдгийг танаас илүү сайн мэдэх, тайлбарлах хүн энд байхгүй. Энэ хугацаанд 1 ч татварын хувь, хэмжээ нэмэгдээгүй. Гэсэн хэдий ч орлогын хэмжээ нэмэгдэж байна гэдэг маань татварын суурь бодлогын үр дүнд сайн тэлсэн байна гэсэн үг.

Тэгэхээр энэ орлого бүрдүүлэлт дээр бол бид, бидний оролцоог бид хамтдаа хэрэгжүүлж байсан сууриа тэлэх. Ер нь бол яах вэ, татварын орчныг сайжруулна гэдэг маань зөвхөн хөнгөлөлт, чөлөөлөлт гэхээсээ илүү энэ татварын систем маань өөрөө орлого бүрдүүлж байгаа тэр процесс, ил тод байх, цахимжих, их ойлгомжтой байх, татвар хураалт нь өөрөө энгийн, хялбар байх гээд, тайлагналт нь өөрөө хялбар байх гээд маш олон зүйлүүдээс энэ өөрөө бүрддэг ийм бодлогын цогц асуудлууд байдаг.

Таны хувьд ч гэсэн сүүлийн энэ 7, 8 жилийн хугацаанд энэ татварын ялангуяа орлого бүрдүүлэлтийг цахимжуулах энэ шинэчлэл маш сайн хийгдсэн. Тэрний хүрээнд ч энэ орлого бүрдүүлэлт нэмэгдэж байгаа нь гол нөлөөлөл нь бас тэр хэсэг дээрээ байгаа.

Тийм учраас цаашдаа бид аль болох татварын хувь, хэмжээг өөрчлөхгүйгээр, нэмэхгүйгээр бусад өөр саяын миний хэлдэг энэ бодлогуудаа үргэлжлүүлээд явах юм байгаа юм. Сүүлийн энэ 2020 онд татварын багц хуульд өөрчлөлт орсноос хойш татварын хувь, хэмжээ ганц ч нэмэгдээгүй, харин маш олон салбар, маш олон зорилтот стратегийн бүтээгдэхүүнүүд дээр хөнгөлөлт, чөлөөлөлтүүд маш их хийгдсэн байгаа.

Тэгэхээр яг Монгол Улсын хувьд бол энэ татварын орчин бол татварын хувь хэмжээний хувьд бол бас тийм хүнд, илүү их дарамттай ийм улсын хэмжээнд ордоггүй. Харин ч илүү их ээлтэй татварын таатай орчны хувь, хэмжээтэй байдаг гэдгийг хэлье.

Мэдээж эдийн засаг өсөх, тэлэх хэрээр нөгөө талд эрсдэл гарч ирдэг. Энэ мэдээж энэ өсөлтийн, тэлэлтийн үр өгөөж тодорхой хэмжээнд очоод эрсдэл гардаг, буурдаг ийм зүйлүүд байгаа. Энэ дээр бид маш эдийн засгийнхаа орцуудыг хэзээ, хаана, ямар хэмжээгээр алийг нь төлөх вэ, алийг нь татах вэ гэдгээ маш сайн тооцоолох ёстой. Энэ маань Эдийн засаг, хөгжлийн яаман дээр хийгдээд явдаг болсон байгаа.

Инфляцын хувьд бодит инфляц, инфляцын онилох зорилтот түвшин, бодлогын зорилтот түв
.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулья.

Б.Жавхлан: Энэ хоёр өөр ойлголт байдаг. Ирэх жил бид Нийгмийн даатгалын тухай хууль, Тэтгэврийн тухай хууль, Төрийн албан хаагч нарын хуульд оруулсан өөрчлөлтөөр шууд бид үнийн өсөлттэй уялдуулж зардлаа тавьсан байгаа өсгөхөөр. Тэр нь Монголбанкны үндсэн чиглэл дотор өмнө нь бол энэ 6 хувийн голчтой нэмэх, хасах 2 хувь байсан. Тэр 6-гаар нь бид нар шидээд оруулсан. Хэрвээ 8 гэж оруулах юм бол хамгийн зорилтот түвшнээсээ эрсдэлтэй 8-ыг бид нар хүлээн зөвшөөрч байна гэсэн үг. Ингэж мөнгөний бодлогоосоо бид зөрж болохгүй. Тэгэхээр голч руу нь чиглэсэн тэр хэмжээнд бид цалингийн нэмэгдлээ оруулсан байгаа. Тэр нь бол 6 хувь гэсэн үг.

Инфляц өсөлттэй холбоотой асуудлуудыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулчих уу.

Ер нь Дэлхийн банк болон бусад байгууллагуудаас урьдчилж гаргасан тооцоогоор 5, 6 хувь гээд янз янз л байдаг. Тэр дээр суурилж бид.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Батхүү дарга 8 номер Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

И.Батхүү: Заяабал гишүүний асуултад хариулья. Таны асуусан “The Crowding Out Effect”-тэй холбоотой энэ бол төрийн зардлын өсөлттэй холбоотой хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийх, зээл авах боломж багасдаг гэсэн үзэгдэл байгаа. Энийг та бас сонссон байх саяхан Монгол Улсын зээлжих зэрэглэл сая хоёр ч байгууллагын үнэлгээ сайжирсан. Энийг дагаад олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татах, санхүүжилт босгох өртөг буурч байгаа. Дээр нь нэмээд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогын хэрэгжилтүүд маш сайн явж байгаа. Эдийн засгийн үзүүлэлтүүд их сайн байгаа. Энийгээ дагаад хөрөнгө оруулалтын орчин зах зээл сайжирна гэж үзэж байгаа.

Уул уурхайн бус салбарын хөрөнгө оруулалтын зах зээлийг тэлэх зорилгоор гадаад улс орнуудтай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг эрчтэй явуулж байгаа. Эдийн засгийн өсөлтийг 8 хувь гэж Эдийн засаг, хөгжлийн яамнаас тооцоолон гаргасан байгаа. Энэ бол бусад олон улсын байгууллагуудынхаас харьцуулахад жоохон өндөр байгаа.

Гэхдээ энэ олон улсын байгууллагууд ер нь эдийн зас.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Заяабал гишүүн тодруулья.

Б.Заяабал: Тийм, би тэгээд энэ өрх рүү чиглэсэн энэ орлогын асуудлуудыг яриад байгаа юм. Тэгэхлээр энэ өрхийн чинь орлогыг дагаад маш их олон нийгмийн асуудлууд явдаг. Сая Хууль зүйн сайд энд сууж байсан гараад явчихсан юм уу? Энэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ бүртгэгдсэн регистред крайм /registered crime/ бүртгэгдсэн гэмт хэрэг гээд энэ дээр жишээлбэл 17 хувиар өсчихсөн байгаад байгаа юм. Өнөөдөр бид нар эдийн засгийн өсөлт 6 хувьтай, инфляц 6 хувьтай ингээд бага түвшинд явж байгаа л гээд байдаг. Эдийн засгийн энэ энэ өсөлт, иргэдийн орлого энэ гэмт хэрэгтэй чинь урвуу

хамааралтай байх ёстой. Гэтэл 17 хувиар энэ өсчихсөн байж байгаа. Тэр боловсрол дээр бас гарч ирж байгаа. Наранбаяр сайд байж байна. Өрхийн орлого нэмэгдэхээр хүүхдийн боловсролын түвшин сайжирдаг, боловсролын хүртээмж нэмэгддэг. Гэтэл энэ өрхийн чинь орлогыг дагаад маш их олон нийгмийн асуудлууд байдаг учраас энэ дээр би тодорхой асуугаад байгаа юм. Тэгээд Сангийн яамны.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Сангийн сайд хариулъя. Боловсролын яам Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Өрхийн орлого нэмэгдэхэд бас боловсролын бас чанар боловсролын үзүүлж байгаа үйлчилгээ, авч байгаа үр нөлөө нь нэмэгддэг нь үнэн. Тэгэхээр зэрэг бид бас энэ сая PISA-гийн шалгалтаар ч гэсэн тэрийг харсан шүү дээ. Тэр яг тэр юугаар гарч ирсэн л ийм байгаа. Цаашдаа ер нь боловсрол нь өөрөө бас эдийн засгийнхаа өсөлтийг дэмжиж байдаг гээд. Түрүүнд бас Жавхлан сайд хэлээд байна лээ 0.5 хувиар ингээд дээшлээд жил болгондоо явдаг гээд. Урт хугацаандаа өндөр үр дүн өгч байдаг ийм л байгаа. Тэгэхээр зэрэг энэ хоёрыг салшгүй гэж ойлгож байгаа. Эдийн засгийн өсөлт бол тэнцүү, сайн боловсрол, тэгш хүртээмж нэмэгдэнэ. Сайн боловсрол нь өөрөө эдийн засгийнхаа өсөлтийг бий болгож байдаг л гэж харж байгаа. Баярлалааб

Б.Пүрэвдорж: Одоо Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Оройн мэнд.

Бид нар ч өчигдөр Мөнгөний бодлого, өнөөдөр төсвийн бодлогоо хэлэлцэж байна. Улс орны эдийн засгийг удирдан чиглүүлж явдаг хоёр том бодлогоо хэлэлцэж байна. Хамгийн сүүлд ярьж байгаа хүний хувьд бас жоохон ярья гэж бодож байна. Сүүлийн тэмээний ачаа хүнд гэдэг шиг.

Ер нь ингээд хараад байхад иргэд, аж ахуйн нэгжүүд ингээд л илжиг шиг зүтгээд л байдаг, тэгээд л улам л амьдрал нь доройтоод л, улс орон уруудаад л. Ерөөсөө шалтгаан нь улс төрчид бид нарт л байгаа юм байна шүү дээ. Ялангуяа өмнөх улс төрчдөд. Ер нь энэ ерөөсөө төсвийнхөө төсвийн бодлого хэлэлцэж байхад нэн тэргүүнд юу нь чухал вэ гэдгийг бид ерөөсөө эрэмбэлдэггүй юм биш үү. Энийг ингээд хараад байж байхад. Өөр өөрсдийнхөө явцуу эрх ашиг, сонирхлын дагуу л энэ улс, орны төсвийн бодлогыг хэдэн тийш нь татсаар байж байгаад өнөөдрийн байгаа царай маань л энэ юм байна.

Дээрээс нь нэлээн дээхэн үед Алтанхуяг дарга бас Ерөнхий сайд байхдаа авлигал шингэсэн төсөв гээд яриад байсан. Зарим төсөв нь үнэхээрийн гайхалтай байна шүү дээ. Өнөөдөр та нар харж байгаа байх Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн газрын дарга эмэгтэй ярьж байсан. Түрүүнд хамгийн сүүлд ярьж байгаа болохлоор элдэв социал заваараа харж л байх юм. Тэнд үзлэгийн бээлий, эмэгтэйчүүдийн эмч үзлэгийн бээлий байж байхгүй бол бид нар хэдэн их наядаар нь энд яриад л сууж л байна. Яг бодит амьдрал ийм л байна шүү дээ.

Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, энэ хөдөө аж ахуйн сайд байхгүй байх шиг байна тээ? Хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт нь сая бид нар чинь 8 сарын 14-нөөс 28-ны хооронд төсвийн тодотгол ярьж байх үед бид нарт тараагдсан материал дээр тэр үндэсний хиймэл дагуул чинь 15 хувь буюу 68.8 тэрбум төгрөг гэж орж ирсэн. Үүнийг чинь хэрвээ 68.8 тэрбум нь 15 хувь

нь юм бол би тоо, буруу тоо бодоогүй бол энэ чинь 458, тийм 458 тэрбум төгрөг шүү дээ. Одоо юу болоод 829.4 тэрбум төгрөг болоод ороод ирэв ээ? Энд ямар учир байна?

Хоёр дахь нь яг адилхан нэг цаг хугацаанд 24-26 онд хийгдэх 320 хүүхдийн сургууль, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум дээр хийгдэх 1 дүгээр сургууль, 5 дугаар сургууль нэг нь яагаад 7.8 тэрбумын өртөгтэй, төсөвт өртөгтэй байхад нөгөөдөх нь яагаад 12.8 тэрбум төгрөгийн өртөгтэй байна вэ? Газар, орон нутгийн хувьд өөр байсан бол энийг ойлгоно гэсэн. Яг нэг газар, нэг цаг үед хэрэгжих төсөв яагаад ийм ялгаатай байгаа юм. Бүхэл бүтэн 5 тэрбум төгрөгийн зөрүүтэй.

Эрүүл мэндийн сайдаас Эрүүл мэндийн даатгалын санг Эрүүл мэндийн яаман дээр авсан чинь маш том бодлогын алдаа болсон байна. Хөдөө орон нутагт тойргуудаар, сумдад ажиллаж явж байхад Улаанбаатар хот бол төв суурин газар өөр байна. Сумдын гүйцэтгэлээрээ санхүүж байгаа санхүүжилт чинь үнэхээрийн хүнд болж. Ер нь цаашдаа манай эрүүл мэндийн бодлого, эрүүл, урьдчилан сэргийлэх чиглэл рүүгээ явах юм уу, аль эсвэл өвдөөд бай, бушуухан эмчлээд бай гэдэг энэ зарчим руугаа явах юм уу. Үүнээс болж энэ алдагдал орон нутагт ажиллаж байгаа өрөнд орсон Эрүүл мэндийн төвүүд, одоо энэ бага дээрээ энэ алдаагаа засаж, нэгдсэн тогтолцоонд оруулахгүй бол энэ чинь биш болоод байна шүү. Амьдрал дээр болохгүй байна.

Хоёрт нь Дорноговь аймгийн Иххэт сумд явж байхад өндөр настан Дашдаваа гуай надад түрүүнд Эрүүл мэндийн сайд хэлж байсан энэ хөнгөлөлттэй эм дээр тавьж байгаа төсөв, санхүүжилт өсгөх тухай ярьж байгаа байхгүй юу. Гэтэл иргэн Дашдаваагийн хөнгөлөлттэй эмийг Дундговь аймгийн Луус суманд 1 хүн, Говьсүмбэр аймгийн Шивээговьд өөр хүн авчихсан байгаа байхгүй юу. Хурууны хээгээр уншуулдаг байсан юмыг нь болиулаад, өөрөөр хэлбэл хөнгөлөлттэй эм гэдэг орон нутагт бодит байдал дээр ийм байна. Тэгэхлээр Эрүүл мэндийн сайд энэ дээр хариулах хэрэгтэй.

Дараагийнх нь асуудал Хөдөө аж ахуйн.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга тэр хиймэл дагуулын асуудалб

Н.Учрал: Энэ 14 энэ мега төсөл бол санхүүжилт нь зүгээр 3 төрөл л байгаа юм. Нэгд гадаад зээл, хоёрт нь бол мэдээж “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой” компани төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс санхүүжүүлнэ. Гуравт нь бол мэдээж хувийн хэвшил бусад эх үүсвэрийг ашиглана л гэж байгаа юм.

Тэгэхээр гадаад зээлээр санхүүжих бол мэдээж төсөвт хамаарч байгаа учраас Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, энэ газрын тос боловсруулах үйлдвэр, тэгээд үндэсний хиймэл дагуулын төсөл гээд ингээд хамаараад явж байгаа

Ер нь бол түрүүн би нэлээд тайлбарлаж байна л даа. Үндэсний хиймэл дагуул бол Францын 100 хувь 15 жилийн хөнгөлөлттэй зээлээр санхүүжихээр Францын Засгийн газар Монголын Засгийн газар өнгөрсөн хугацаанд тохиролцсон юм.

Францын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлах үеэр олон жил Монгол Улс хиймэл дагуултай болох асуудлаар бол санал, хүсэлтүүдийг тавьдаг байсан. Францын төрийн өмчит энэ Талес Алейна Спэйс компани 10 гаруй жилийн хугацаанд бас энэ саналуудыг харилцан ярилцаж байсан хэдий ч санхүүжилтийг нь бол шийдвэрлэж байгаагүй. Яагаад

гэвэл дэлхий дахинд яг ингэж хөнгөлөлттэй зээлээр аль нэг улсын хиймэл дагуулыг бүтээж байсан тохиолдол ерөөсөө байдаггүй.

Тэгэхээр энэ нэлээн том санхүүжилт, цаанаа мэдээж энэ гурав дахь хөршийн том хөрөнгө оруулалт, хоёр орны ийм хамтын ажиллагаа байгаа учраас бид бол энэ 15 жилийн энэ хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлэе гэдгээ өнгөрсөн хугацаанд шийдсэн.

Төсвийн тодотголоор бид яагаад 15 хувьд нь тэр 68 тэрбум төгрөгийг тодотгол хийсэн юм бэ гэхээр ямар ч тохиолдолд 100 хувь санхүүжүүлсэн ч бай тэр OECD-гийн шаардлагаар 15 хувийг заавал нөгөө зээлдэгч тал баталгаа гаргаж байхыг шаарддаг. Ялангуяа гаднын зээл дээр. Тийм учраас тэр 15 хувь. Тэрнээс биш ер нь энэ 100 хувийг ийм зээлье гэсэн үг.

Үүний тулд бол ирэх 15 жилд 356 сая доллар бид нар бол дотоодын компаниуд төлнө гаднын хиймэл дагуулуудад. Энэ хэрэглээ 2.5 дахин бол 2 жилийн дараа шууд өснө гэсэн ийм тооцоолол гарсан. Тэгэхээр гадагшаа урсаж байгаа валютын урсгалыг зогсоогоод, 15 жилийн хугацаанд энэ зардлаа шууд нөхөх ийм төсөл юм гэдгийг ТЭЗҮ дээр бичсэн. ТЭЗҮ нь Японы “ПАДЕКО” гэдэг компани 13 онд хийсэн ТЭЗҮ шинэчлэгдэж байгаад сая Сансрын зөвлөлөөр мэргэжлийн экспертүүд нь ороод баталсан. Тэгэхээр энэ бол өөрөө нэг талаасаа бол зардлаа нөхөх төсөл, нөгөө талаасаа бол энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой, онцгой байдал, гамшиг, хил хамгаалах, алслагдсан боомт гээд маш өндөр ач холбогдолтой. Ер нь тэгээд л.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Гомбын Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Үгүй ээ Учрал сайдаа би ойлгож байна л даа. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тэр чухал энэ тэр. Хэрвээ та нар өөрсдөө мэдээллээ бууруул гэвэл 15 хувь нь 68.8 тэрбум юм бол энэ чинь 458 тэрбум биз дээ 15 хувь нь л? Тэр OECD-гийн шаардлагаар 15 хувийг нь үгүй тэгээд яагаад 829.4 тэрбум болчихсон юм байхгүй байна. Хэрвээ 829.4 тэрбум чинь 15 хувь шал өөр тоо гарна шүү дээ.

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Энэ ийм юм, нийт санхүүжилт чинь энэ чинь 220-оод сая байхгүй юу. Тэрний, энэ чинь хоёр хэсгээс юм. Нэг хэсэг нь 82 сая доллар нь бол Францын яг Засгийн газраас өгч байгаа нэн хөнгөлөлттэй зээл, нэн хөнгөлөлттэй, 124 сая нь 2 банк оролцоод өгч байгаа ер нь урт хугацаатай ийм арилжааны зээл, шууд Засгийн газрын хоёр талд биш, 2 талд биш. Тэгэхээр Засгийн газар нь бас өгч байгаа нэн хөнгөлөлттэй зээл дээр 15 хувийн урьдчилгаа шаарддаггүй. 124 дээрээ 15 хувь шаардаж байгаа. Тэр дүн нь монгол төгрөгөөр илэрхийлэхээр 68 тэрбум болж байгаа байхгүй юу. Тэгээд ийм ялгаатай юм шүү.

Тэр хэн, Батсуурь сайд хариулчих уу? Энэ магадлангийн дүн асуугаад байна. Тэр нэг дор баригдаж байгаа 2 цэцэрлэгийн нэг нь 7.8 тэрбум, нөгөөдөх нь 12.8 тэрбум гээд. Бодвол энэ нэг нь нэлээн хуучин магадлангийн дүн байх, нэг нь сүүлийн жилүүд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Энэ ч тэгээд өнгөрсөн жилийн төсвөөр шийдэгдсэн асуудал байна. Энэ дээр Батсуурь гишүүн, сайд тайлбарлаад хэрэггүй дээ.

Бүх гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Тасаллаа. Сая энэ Уянгахишиг гишүүн энд байсан дуудаадхаач. Өлзийхүүгийн Шижир гишүүн үг хэлнэ.

Ө.Шижир: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. 2025 оны энэ улсын төсөв 2024 оноос шилжиж орж ирж байгаа 140 ширхэг төсөл, хөтөлбөр байна. Энэ 140 ширхэг төсөл, төлбөр маань өөрөө бүгдийнх нь төсөвт өртөг нь нэмэгдсэн гэсэн үг. Нийтдээ 140 ширхэг төсөл, төлбөр нэмэгдэхдээ 992 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн буюу 140 төсөл, төлбөр өөрөө ойролцоогоор 1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Бид нарын гайхаад байгаа төсвийн зардал, төсвийн тэлэлт, урсгал зардлын нэмэгдэл чинь өөр энэ дээр байна л даа. Та нар бод доо 140 цэцэрлэг дээр 992 тэрбум руу нэмэгдсэн.

Энэ 140 төсөл, хөтөлбөр хамгийн ихдээ 14 жил үргэлжилж байна. Хамгийн багадаа 2-3 жил үргэлжилж байна. 2-3 жил үргэлжилж байгаа төсөл, хөтөлбөрүүд нь ямар төслүүд байна вэ гэхээр 50 хүүхдийн ортой сургууль, 50 хүүхдийн ортой цэцэрлэг, 50-хан хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгыг 1-хэн жилийн дотор барьж чадахгүй бол бид нар улс бас байгаад яах юм. Улсын төсөв гэж батлаад яах юм. 50-хан хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгыг бид нар 3 жил дараалж барихдаа төсөвт өртөг нь багадаа 96.5 хувиар нэмэгдүүлж орж ирж байна. Одоо энэ 140 төсөл хөтөлбөр 992 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаагийн нийт бүх төслийнх нь дундаж төсвийн анхны төсвийнх нь зардал нь 96.5 тэрбум төгрөг байна. Хамгийн багадаа 10.8 тэрбум, хамгийн ихдээ 633 хувиар өссөн байна. Тэгэхээр энэ ямар учиртай гэдгийг Үндэсний аудитын газар дараа жилийн мөн ирэх жилийн төсвийн тайлан дээрээ маш тодорхой оруулж ирмээр байна. Ерөөсөө бүх төсөвт өртөг нь анхны төслөөсөө өсөж байна. 1 их наядар өнгөрсөн жилээс.

2024 оны улсын төсвийн тодотголд хэлэлцэж байхад зөвхөн Боловсролын сайдын багц дээр 252 барилга байгууламж байсан. Төсөвт өртөг нэмэгдсэн. Тэгэхээр бид нар энэ төсөвт өртөг нэмэгддэг байдлаа бүрэн цаашдаа болимоор байна. 150 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгыг 1 жилдээ барьдаг болмоор байна. 250 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгыг, цэцэрлэгийн барилгыг 1 жилдээ барьдаг болмоор байна. Тэгэхгүй бол энэ өөрөө ямар үр дүнг дагуулаад байна вэ гэхээр хичээл, сургуулийн хүрэлцээгүй байдлыг хүлээж байгаа хүүхдүүдийн хичээл сургуулийн хүртээмжтэй, тааламжтай байдлыг бид нар хамгийн багадаа 2-3 жилээр хойшлуулаад байгаа юм.

Ер нь би бас Их Хурлын гишүүддээ уриалж хандмаар байгаа юм. Бид нар ингээд амсуулаад тавьдаг, эсвэл ингээд дөнгөж дусаагаад өнгөрдөг энэ байдлуудыг бас болимоор байна. Тэгэхгүй бол алдагдсан боломжийн өртөг чинь зөвхөн энэ 140 төсөл дээр 1 их наяд төгрөг байна шүү. Зөвхөн өөрсөд, өөрсдийнхөө төрсөн сум. эсвэл төгссөн сургууль, эсвэл амьдарч байсан орчин, эсвэл сонгогдсон тойргийнхоо төсвийг хараад улсын төсвийн нэгдсэн байдлаар нийт байдлаар нь харахгүй өнөөдрийг хүртэл дусааж явсаар байгаад ийм байдалд хүрчихлээ. Энд бид нарын алдагдсан боломжийн өртөг, хүлээгдэж байгаа, бас хүлээгдэж буй алдагдах боломжууд, мөн төсөвт өртөг нь хүрч байгаа энэ мөнгөнүүд чинь хайран байдаггүй юм уу? Тэгэхээр бид нар энэ цаашдаа энэ бүх улсын төсвийн юунууд дээр анхаарах хэрэгтэй. Энэ 14 жил үргэлжилж байгаа төсөл 3, 4 жил үргэлжилж байгаа сургууль, цэцэрлэгийн барилгуудыг Наранбаяр сайд анхааралдаа аваад энэ жил 25 ондоо дуусгамаар байна.

Ингээд саяын 140 барилга, байгууламжийн төсөвт өртгүүд хаана нь хамгийн их өссөн юм бэ гэхээр Хэнтий аймагт 60 тэрбум, Говь-Алтай аймагт 23 тэрбум, Дархан аймагт 15 тэрбум гэх. Тэгээд яагаад заавал энэ сайд дарга нарын тойрог дээр, сайд дарга

нарын төсөв дээр улсын төсөв хамгийн ихээр нэмэгдээд байгаа юм? Бид нар энийг бас цаашдаа заавал анхаарах хэрэгтэй. Тэгэхгүй бол иргэдийн татвараар цуглаж байгаа энэ мөнгө улсын төсөв дээр тодорхой хэмжээгээр суулгаад, гарын салаагаар урсаад өнөөдөр бид нар зөвхөн 140 төсөл дээр 1 их наяд төгрөгийн төсөвт өртөг нэмэгдэж байна шүү Их Хурлын гишүүд ээ. Энийг 25 ондоо хэдүүлээ цаашид, түүнээс цааш төслүүд дээр зайлшгүй анхаардаг байя.

Мөн 50 хүүхдийн цэцэрлэг, 150 хүүхдийн сургууль, 250 хүүхдийн дотуур байрыг 1 жил барьж чаддаг улс болъё тэгэх үү. Энэ чинь арай ичгэвтэр байна шүү дээ 50 хүүхдийн сургууль 3 жил барина гэж юу байсан юм бэ, 50 хүүхдийн цэцэрлэгийг 3 жил барина гэж юу байдаг юм. Тэгэхээр энийгээ ер

Б.Пүрэвдорж: Одоо Баярмагнайн Баярбаатар гишүүн үг хэлнэ.

Б.Баярбаатар: Оройн мэнд хүргэе.

Төсвийг дэмжиж байгаа. 123, 126 гишүүнтэй, 126 гишүүнтэй парламент, 126 гишүүнтэй парламент бүрдээд анхны төсөв орж байна. Тэгээд Ерөнхий сайдын танилцуулснаар төсвийн реформ хийнэ гээд өмнө нь яг Шижир гишүүний хэлснээр жил жил дамнаж барилга байгууламжаа тавьдаг, дараа жил нь төсөвлөсөн төсвөөсөө үнийн өсөлттэй холбогдуулаад нэлээн өндөр өртөг орж ирдэг, тэр мөнгө болгон нь татвар төлөгчдийн кармагаас төлөгддөг. Тэгээд сүүлд нь барилга нь чанаргүй. Одоо 5 жил болж байгаа, ашиглалтад ороод 5 жил болж байгаа цэцэрлэг шал нь цөмөрлөө гээд өчигдөр мөнгөний бодлого дээр бас ярьж л байсан.

Тэгэхээр манай энэ парламент энэ алдааг л засах ёстой реформ болов уу гэж би ойлгож байгаа. Тэгээд энэ удаад бид нар 1.2 их наядаар зам, барилга явна гээд төсөвлөөд орж ирж байгаа. Мэдээллээс үзэхэд зам барилгын 30 гаруй компани байдаг гэсэн сураг сонсогдсон. Тэгээд ирэх жил яг өдийд бид нар төсвийн гүйцэтгэл хэлэлцэх цаг үе дээр 1.2 их наядаас яг хэдэн хувийн гүйцэтгэлтэй байх гэдэг дээр энэ бүтээн байгуулалтынхаа энэ бэлтгэл ажил нь өөрөө хэр зөв явах вэ гэдэг дээр нэлээн бэлтгэл хангаж ажилламаар санагдсан. Тэгээд сүүлд нь гүйцэтгэл дутуу гээд нөгөөдөх нь дахиад он дамнах ажил руу орчихдог, эс үгүй бол тэгээд мөнгө нь буцаагаад татагддаг. Хэрвээ тийм байдалтай байх юм бол бид нар тэр буцаад татагдаж байгаа мөнгөө анхнаас нь өөр юманд зарцуулаад явах нь зөв байхгүй юу төсөвлөөд. Зураг, төсөл нь бэлэн болчихсон ажлууд дээр.

Дээр нь энэ хиймэл дагуултай холбоотой асуудал нэлээн бас олны анхаарал татаж байх шиг байна. Гишүүн болгон л асууж байх шиг байна. Энэ дээр манай Хэрэг эрхлэхийн сайд бүр тодорхой мэдээллийг гишүүддээ өгчихмөөр байгаа юм. Тэгээд 1 гишүүн асууна, дараа нь дахиад л бүгд асуугаад яваад байхаар бас. Анх удаа хиймэл дагуул хөөргөх гэж байгаа бол бас тэгээд энэ дээрээ бид нар бас нэгдмэл ойлголттой хөөргөчихвөл уг нь зүгээр юм болов уу гэж бодож байна. Олон улсын туршлагаас үзэхэд бол хамгийн олон 300 хэдэн хиймэл дагуултай манай урд хөрш байдаг юм байна лээ. Жилд л 60 гарныг хөөргөж байдаг. Тэгэхээр Монгол Улс анх удаа хиймэл дагуул хөөрөхөд бас энэ зөв мэдээлэлтэй, ингээд нэг ойлголттой явбал зөв юм болов уу гэж.

Дараагийн асуудал нь энэ эмийг энэ жороор олгож байгаа асуудал гээд сүүлийн үед нийгэмд нэлээн бухимдал дагуулж байна. Тэгээд би ойлгохдоо бол энийг хилээр орж ирж байгаа эмийн үнийг л шилэн болгоё гэж ойлгосон шүү дээ. Яг гаальд мэдүүлж байгаа үнийн дүнг л 1000 төгрөг бол 1000 төгрөг, 100 төгрөг бол 100 төгрөг гэдгээр нь л шилэн

болгоод ард түмэнд мэдээлчихье гэсэн. Тэгээд энэ нь энэ эмийн сангуудад л таалагдахгүй байх шиг байна л даа.

Өнөөдөр жишээлбэл нэг төрлийн эм Монос эмийн сан дээр 4 төрлийн өөр үнэтэй байж байгаа байхгүй юу. Тендерт зориулаад нэг өөр үнэтэй, бөөний худалдаан дээр нэг өөр үнэтэй, жижиглэн дээр дахиад нэг өөр үнэтэй яг адилхан нэг эм шүү дээ.

Тэгээд сүүлд нь ингээд эмийн сангууд нь бараг ингээд ард иргэдэд энэ жороор олгохгүй гээд ингээд жоргүй бол олгохгүй гээд ингээд бараг буруу ойлголтыг ингээд эмийн сангууд нь нэгдмэл ойлголтоор ингээд зохион байгуулалттайгаар тараагаад байгаа юм болов уу гэсэн ийм ойлголт байгаа. Тэгэхээр энэ дээр ч гэсэн бас энэ зөв ойлголт өгөөд, чанартай эмийг нь ард түмэн хэрэглэх нь зөв болов уу л гэсэн, иргэдэд хэрэглүүлэх нь зөв болов уу гэсэн л ийм хууль болов уу гэж ойлгож байгаа. Тэгэхээр ийм зөрүүтэй мэдээллүүдээ бас нэг болгоод авчих нь зөв болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үг хэлнэ.

Х.Баасанжаргал: Дэгийн тухай хууль, Төсвийн тухай хуультай холбоотой үг хэлэх гэсэн юм. Уг нь бол энэ удаагийн бид нарын хэл, би үг хэлье хоёроо.

Яах вэ, би ойлгохдоо хуулиа уншаад ойлгохоор бид нар энэ төсвийг хэлэлцэх эсэхийг шийдэж байгаа, асуулт ч гэсэн тийшээгээ чиглэх ёстой болов уу гэж, хэрвээ хуулиа мөрддөг бол тийм болов уу гэж ойлгосон. Гэвч гишүүд маань бүүр төсвийн нарийн детальный дүн рүү бас ороод дараа дараагийн хэлэлцүүлгийнхээ шатан дээр асуух ёстой юмнуудаа ингээд асуугаад бие биеийнхээ ч цагийг үрж байна. Нөгөө талаар бид нар ерөөсөө манай Их Хурал шинэ батлагдсан Дэгийн тухай хуулиа мөрдөх тал дээр хэдүүлээ ер нь хаа хаанаа анхаарвал гэсэн ийм саналтай байна.

Хоёрдугаарт гэвэл яг энэ шинэ батлагдсан Дэгийн тухай хуулиар, Төсвийн тухай хуулиар ч гэсэндээ яг ингээд хууль зөрчиж орж ирж байгаа ийм төсөв байвал бид нар тэр хууль ёсны дагуу байна уу, үгүй юү эсэх дээр л ярих ёстой. Тэгэхээр түүн дээр яг анхаарал татаж байгаа нэг гол зүйл энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв байгаа. Уг нь бол хуулиараа Байнгын хороо хэлэлцээд баталчихсан дүнгээс буулгахгүйгээр төсөв маань орж ирэх ёстой байтал 100 гаруй тэрбум төгрөгөөр буураад ороод ирсэн. Ингээд хууль зөрчсөн. Өрөөр хэлбэл, Шүүхийн тухай хуулийг зөрчсөн ийм төсөв орж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр дараа дараагийн хэлэлцүүлэг дээр анхаараад явах болов уу гэж бодож байна.

Цаашид бас би Уянгахишиг гишүүний гаргасан саналтай бас яг санал нэг байна. Аль болох яг хуулиараа, дэгийнхээ тухай хуулиараа яг энэ хүрээндээ асуултаа асуугаад, хэлэлцүүлгээ өрнүүлээд ингээд яг хуулиа мөрдөж л ажилламаар байна.

Тэгэхгүй бол микрофон олдсон дээр гэсэн шиг ийм сэргэлэн завшаад байдаг ч юм шиг ийм байдалтай манай шинэ парламент баймааргүй байна гэдэг ийм саналтай байна.

Б.Пүрэвдорж: Одоо Батбаярын Жаргалан гишүүн үг хэлнэ.

Б.Жаргалан: Бид өнөөдөр улсын төсөв хэлэлцэж байгаа. Тэгэхдээ түүнээс гадна манай улсын хувьд болохлоор ийм төсвийн гадуурх төсвийн шинж чанартай зардлууд бол маш өндөр байгаа.Үүнд бол ТӨК-удын бас зардлууд, хөрөнгө оруулалтууд, тэгээд өнөөдөр батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ТӨК-удаар хөрөнгө

оруулах, дотоодын хөрөнгө оруулалт гэсэн нэртэй маш том том дүнгүүд бол төлөвлөгөөнд орсон байж байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл, манай ийм төсвийн гадуурх төсвийн шинжтэй зардлууд маш их нэмэгдсэнээр ер нь л энэ эдийн засагт байгаа төрийн оролцоо нэмэгдээд байгаа. Тэр хэрээр хувийн хэвшлийн оролцоо бас ингээд зах зээлээс шахагдаж байгаа үйл ажиллагаа явагдаж байна. Тэгэхээр энэ дээр бид нар бас цаашдаа анхааралтай байх ёстой. Хувийн хөрөнгө оруулалтыг энэ төрийн хөрөнгө оруулалт шахаж гаргах үзэгдэл бол газар авч байна. Үүнтэй бас холбоотойгоор бид нар дотоодын аж ахуйн нэгжүүдээ бодлогоор дэмжинэ гэж ярьж байгаа боловчиг бас энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд бас хэт хавтгайрсан талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтэд дурдсан байж байгаа.

Тэгэхээр дэмжиж байгаа нэрийдлээр тодорхой цөөн тооны салбарууд юм уу, эсвэл тодорхой цөөн тооны мэдээлэлд ойрхон ч гэдэг юм уу тийм аж ахуйн нэгжүүдээ илүү татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд олгох замаар ингээд л энэ зах зээлийнхээ ийм чөлөөт өрсөлдөөнийг үндсэн зах зээлийн зарчмаасаа бас их гажуудаад байгаа. Тэгэхээр энэ дээр цааш цаашдаа бид нар энэ төсвийн хэлэлцүүлгийн хүрээнд маш их анхаарах ёстой гэж харж байгаа юм. Эс бөгөөс бид нар ерөнхийдөө цаашдаа ийм хувийн хэвшилгүй, дан төрийн оролцоонд суурилсан ийм эдийн засагтай болох байдал улам л ужгирах шинжтэй. Тэгэхээр бид нарын үзэл баримтлалын хувьд яриад байгаа зүйлүүд яг үндсэн батлагдаад байгаа бодлогын баримт бичгүүдтэй чинь бас ингээд зөрчилдөөд байна гэдгийг л хэлэхийг хүссэн юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хоёр хүний дараа санал хураалт явагдана. Хэрвээ ирц бүрдэхгүй бол нэг дэх өдөр, хоёр дахь өдөр чуулган дахиж хуралдах зайлшгүй шаардлага гарч ирнэ. Яагаад гэвэл энэ төсвийн хэлэлцүүлэг 4 үе шаттай. Тийм учраас энэ 11 сарын 15-ны дотор төсвөө батлах ёстой. Тэгэх ээр энд байгаа бүлгийн дэд дарга нар дарга нарыгаа дуудаад, дээрээс нь гишүүдийнхээ ирцийг сайжруулаарай. Жаргалан гишүүн, Ариунзаяа гишүүн. Дэд дарга нь хаачихсан? Тэр тус тусынхаа бүлгийн групп дээр ирцээ сайжруулах талаар ажиллаарай.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Тэгэхээр төрийн оролцоог багасгах, төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, ер нь иргэд төдийгүй Улсын Их Хурлын гишүүдийг бас энэ төсвийнхөө талаарх мэдлэг мэдээллээр хангах ийм зайлшгүй шаардлага бас энэ өдөржингийн хэлэлцүүлгийн дараа харагдаж байна гэж бодож байна. Тэгээд Сангийн сайд Жавхлан өөрөө бас дэмжиж байгаа юм байна. Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг бас тусад нь гаргаж боловсруулах, тийм дотроо яг тендертэй холбоотой аливаа барилга, байгууламжийг захиалах, гүйцэтгэх асуудлыг тусад нь хариуцах хөрөнгө оруулалтын тусгай агентлаг юм уу, корпорац тэр хуулиар зохицуулах ёстой гэсэн энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан саналыг дэмжиж байгаагаа бас үүгээр дамжуулж хэлмээр байна.

Яагаад гэвэл гол асуудал дандаа хөрөнгө оруулалтын төслүүд, түүний эрэмбэ, мөн координацын асуудалтай маш их холбогдож гарлаа гэж харж байна.

Түрүүнд бас бас гол асуулт асуусан төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны үр дүнгээс үүссэн нөхөн төлбөрийн хэмжээ 4 дахин өсөөд 17.2 их наяд, юу тэрбум төгрөг байна гэсэн чинь бүр эсрэгээрээ 34 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөнийг

Алтангэрэл сайд хэлж байна. Тэгээд энэ мэтчилэн эргэж харах төсвийн алдагдлыг бууруулах боломж байна шүү. Энэ дээр бас харьяа, холбогдох сайд нар болов уу тийм бусад хүмүүс анхаарч ажиллах байх гэж бодож байна.

Пүрэвдорж дарга түрүүн асуултын хариулт өгөөгүй учраас ингээд байн байн бүдрээд байна шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Найдалаа гишүүн үг хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа, тэгээд баярлалаа. Сая түрүүн асуулт дээр, асуулт дээр миний хэлж байсан санааг сая хэлэлцүүлэг бас гарлаа л даа. Жишээлбэл, 14 мега төсөл байна. 14 асар олон байхгүй юу. Тэгээд би хариуцах эзэн нь хэн бэ гээд мэдээж хэрэг төсвийн захиран зарцуулагч байгаа. Тэгэхдээ төслийн эзэн бол төсвийн захиран зарцуулах биш, яг хариуцаж байгаа сайд нь, улс төрч нь байхгүй юу.

Жишээлбэл, хиймэл дагуулын төслийг аваад үзье. Учрал сайд хариулаад, хариуцаад байгаа юм шиг яваад байгаа байхгүй юу. Яг үнэндээ хэн юм? Цахим хөгжлийн Баатархүү сайд шүү дээ. Баатархүү сайд үүгээрээ эцсийн эцэст дүндээ хариуцахыг нь хариуцаад, өөрөө бодоод, яриад, хариулаад явах ёстой.

Тэгээд Төсвийн байнгын хороон дээр уг нь хувийн байгууллага яадаг юм ийм төслийг хийхийн тулд бүх юмыг хэмжиж, үр ашиг, эрсдэл, ашиг, орлого, оноо бүгдийг нь ярьж байгаад баталдаг биз дээ? Бид нар бол зөвхөн гарчиг батлах гэж байна шүү дээ. Тэгээд энийг ингээд Төсвийн байнгын хороон дээр уг нь бараг тэгээд хариуцаж байгаа, эзэмшиж байгаа, нэр төрөөрөө хариуцах улс төрч нь, сайд нь яг тэр тооцоог нь хийгээд, эцсийн үр дүнтэй нь хариулах ёстой. Бид нар тэрийг нь уг нь батлах ёстой юм. Уг нь Төсвийн байнгын хороо ингэж хийвэл их сайн байна.

Хоёрт нь өнөөдрийн энэ дүгнэлтээс болон төсвийн төсөл сая хэлэлцүүлэг, түрүүн миний асуулттай холбоотой нэг дүгнэлт байна л даа. Ямар ч байсан Улсын Их Хурал, парламент ялангуяа энэ шинэ парламент төсөв боловсруулах, батлах, хянах, эргэх холбоо бий болгох, энэ институтээ, чадавхаа сайжруулахгүй бол Засгийн газраасаа цаашлах юм бол яг төсөв боловсруулж байгаа тухайн яамнаасаа хэтэрхий хамааралтай, хэтэрхий хүчгүй байгаад байна.

Тийм болохоор Улсын Их Хурлын дэргэдэх, парламентын дэргэдэх төсвийн бодлогыг оролцдог, боловсруулах, хянах, батлах энэ процесс дээр нь бүгдэд нь оролцдог ийм институтийн чадавхыг сайжруулах эрс шаардлага байгаа юм байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

Найдалаа гишүүн ийм учиртай шүү. Төсөв өргөн барьж байгаа хугацаа өөрөө энэ хуулиар зохицуулагдаж байгаа. Өргөн барьснаас хойших хугацаанд Улсын Их Хурлын мэргэжлийн Байнгын хороо ажиллаж энэ дээр дүгнэлт гаргах учиртай байдаг. Тэр Улсын Их Хурал дэргэдээ Засгийн газар шиг бас бүтэц байгуулах ямар ч боломжгүй.

Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороо энэ асуудлыг мэргэжлийн түвшинд авч, үзэж, өргөн барьсан Засгийн газар, холбогдох яамнуудтай энэ асуудлыг хэлэлцэж байх тийм учиртай байдаг гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх.

Түүнээс Их Хурал ахиад дэргэдээ том бүтцүүд байгуулаад эхэлбэл тэгээд Засгийн газраас ялгаагүй хэлбэр рүү шилжих тийм талтай гэдгийг бас хэлье.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн далдугаар зүйлийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тусгай шаардлага улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалтыг явуулахаар байгаа.

Мэдээж зарим Улсын Их Хурлын гишүүдээс бас энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцэхгүй байна гэдэг асуудлуудыг бас ярьсан.

Гэхдээ энэ өөрөө энэ онд орсон хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хэрэгжиж эхлэх хугацаа гэдэг бас их чухал байгаа. Жишээлбэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлж батлахыг хориглоно гэхчхэн байгаа юм.

Энэ хэсгийг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гээд бас мөрдөж эхлэх хугацаа өөрөө энэчээ бас чухал байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Ингээд санал хураалт явагдана. Төсвийн анхны хэлэлцүүлэг явагдаж байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалтыг эхлээд явуулъя. Санал хураалт.

Ингээд үндсэн санал хураалтыг явуулъя. Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалтыг явуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт.

Байз гацчихлаа. Энэ санал хураалтыг хүчингүй болгоё. Төхөөрөмж гацчихлаа. Санал хураалт.

51 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад байнгын хороод, мөн Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудал дуссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

20.31 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*